



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.05.03 № 35-1/73
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл
өргөн мэдүүлэх тухай

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



 Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244001987



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.05.03 № Х07/903
танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 3/4 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245009806

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэлд:

“26.ХЭЛЭЛЦСЭН нь: Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.05.01 № 1/2267

танай 2024.05.01 ны № 01/950 -т

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД Н.УЧРАЛ
ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл, хамт боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

Дос. утг. а5.2024
1-1501380



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.05.02 № 0113404

танай _____-ны № _____-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД Н.УЧРАЛ ТАНАА

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001353

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

БАТЛАВ
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ
ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙД

Н.УЧРАЛ

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д 1 дүгээр үе шат буюу 2021-2030 онуудад эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 10 үр дүнг жагсаасны 5 дугаарт “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна” гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.29-д “Мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх институцийн тогтолцоог бүрдүүлнэ.” гэж, 4.2.31-д “Мэдээллийн технологийн кластерыг хөгжүүлж, гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлнэ.” гэж, 4.2.33-т “Мэдээллийн технологи болон цахим худалдааны салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, хөрөнгө оруулагчдын санаачилгыг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын дор эдийн засгийн тэргүүлэх 16 чиглэлийг тодорхойлсны “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурал 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1.9-д “Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.” гэж тодорхойлсон.

2.Монгол Улс нь НҮБ-аас 2 жил тутамд шинэчлэн гаргадаг “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ээр 2018, 2020 онуудад тус байгууллагын гишүүн 193 орноос 92 дугаар байранд орж байсан бол 2022 онд энэ байр урагшилж 74 дүгээр байранд орж, цахим засаглалын хөгжлийн индексээр 18 байр урагшилсан. Мөн үндэсний болон бүс нутгийн түвшинд бизнес эрхлэлтийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийг бодитойгоор хэмждэг Дэлхийн банкны “Doing business” буюу “Бизнес эрхлэлт”-ийн 2020 оны тайланд дурдсанаар манай улс 81 дүгээр байранд жагсжээ.

Түүнчлэн Дэлхийн өрсөлдөх чадварын төв болон эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан-2023”-т Монгол улс өрсөлдөх чадварын үзүүлэлтээр тайланд хамрагдсан 64 улсаас 62 дугаарт эрэмбэлэгдэж, өмнөх оноос 0.64 оноогоор буурч 1 байр ухарсан үзүүлэлттэй байна. Үзүүлэлтийг эрэмбэлэн гаргахдаа эдийн засгийн, засаглалын үр ашиг, бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа, дэд бүтэц гэсэн үндсэн 4 хүчин зүйл, 20 дэд бүлэг, нийт 335 шалгуур үзүүлэлтийн хүрээнд нарийвчилсан үзүүлэлтээр харьцуулан хэмжиж дэлгэрэнгүй гаргаж улс бүрийн өрсөлдөх чадварыг тодорхойлдог.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг улс орнуудын инновацын чадавх, амжилтаар нь эрэмбэлдэг “Дэлхийн инновацын индекс”-ээр 2022 онд 71 дүгээр байр эзэлж өмнөх онуудаас 10 гаруй байраар хойшилсон бол 2023 онд 132 улсаас 68 дугаар байранд жагсаж, 3 байр урагшилсан. Инновацын дүр зургийг аль болох бүрэн дүүрэн гаргахаар төлөвлөдөг тус индекс нь эдийн засаг бүрийн улс төрийн орчин, боловсрол, дэд бүтэц, мэдлэгийн бүтээн байгуулалт зэрэг 80 орчим үзүүлэлтийг багтаасан байдаг ба манай улсын хувьд хүмүүн капитал, дэд бүтэц, бизнесийн боловсронгуй байдал зэрэг үзүүлэлтээрээ дундаж байгаа хэдий ч хамгийн доогуур жагсаж буй үзүүлэлт нь зах зээлийн боловсронгуй байдал буюу зээл, хөрөнгө оруулалт, худалдаа, төрөлжилт, зах зээлийн цар хүрээгээрээ 101 дүгээрт жагсаж байна. Энэ нь манай улсад инновац, нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын талаарх хууль, эрх зүйн таатай орчин бүрдээгүй байгаатай холбон тайлбарлаж болно.

3.Өнөөгийн эдийн засагт инновац болон мэдээллийн технологийн үйлдвэрлэл нь улс орны эдийн засгийн хөгжлийн тулгуур болж байна. Мэдээллийн технологийн хөгжил нь инновацыг идэвхжүүлж, тухайн салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ашиг тус, үр шимээ өгч цахим эдийн засгийг бий болгон, энэ нь нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, бүтээмжийг нэмэгдүүлэн өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийг авчирч байна. Тухайлбал, Азийн улс орнуудын мэдээллийн технологийн өөрчлөлт нь бүс нутгийн эдийн засагт асар их нөлөө үзүүлсэн талаарх түүхийг эргэн харвал, БНХАУ-ын цахим худалдааны зах зээлийн гүйлгээний хэмжээ 2013 онд 1.32 их наяд юань байсан бол 2016 онд 5.33 их наяд юань болж, 2017 онд 7.57 их наяд юань болж өссөн байна. Мөн санхүүгийн салбар дахь мэдээллийн технологи нь Ази тивд санхүүгийн үйлчилгээг хүргэх, ялангуяа төлбөр, зээлийг хөнгөвчлөх шинэ арга замыг бий болгож, энэ нь хөгжиж буй Азийн олон улс оронд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Түүнчлэн 2015 онд Ази дахь финтект суурилсан зээлийн хэмжээ 102.8 тэрбум ам.долларт хүрч, технологийн тархалт нь төлбөрийн системийн үр ашгийг улам дээшлүүлж, дэлхийн хамгийн том төлбөрийн зах зээлийг Ази тивд бий болгосон.¹

Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд 2000-аад оноос хойш мэдээллийн технологийн салбарт дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч ирсэн. “Дижитал Казахстан” улсын хэмжээний хөтөлбөрийг 2017 оноос хэрэгжүүлж 655 сая гаруй ам.долларын хөрөнгө зарцуулсан, мөн 2018 онд Засгийн газраас мэдээллийн технологийн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор 255 сая гаруй ам.долларыг төсөвлөж байсан зэргийг жишээ болгон дурдаж болно. Тус улс нь 2017 онд “Дижитал Казахстан” хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд мэдээлэл, харилцаа

¹ “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгааны тайлан” 2023 он

холбооны технологийн хөгжлийн түвшингээр 175 орноос 52 дугаарт жагссан. Цаашид Бүгд Найрамдах Казахстан Улсын 2025 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө нь шинэ эдийн засгийн тулгуур суурийг бий болгох, технологийн шинэчлэл, цахимжилтыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлоод байна.

Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос улсын мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар нь 2022 онд Солонгосын дотоодын нийт бүтээгдэхүүний 13.0 хувийг бүрдүүлж, улсын эдийн засгийн өсөлтийг тэргүүлж, тус салбарын нийт үйлдвэрлэл 560 их наяд вонд хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.1%-иар өссөн байна. 2022 онд мэдээллийн технологийн экспорт 233.32 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 80.85 тэрбум ам.доллар болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар дахь үйлдвэрлэл нь нийт экспортын 30-40 хувийг эзэлж улсын эдийн засгийн өсөлтөд томоохон хувь нэмрийг оруулж байна.

Бүгд Найрамдах Турк Улс нь 2023 онд “Үндэсний технологи, хүчирхэг үйлдвэрлэл” гэсэн алсын хараатай стратегийн баримт бичгийг боловсруулсан ба тус баримт бичиг нь (i) Өндөр технологи ба инновац, (ii) Дижитал шилжилт ба аж үйлдвэрийн хөдөлгөөн, (iii) Бизнес эрхлэлт, (iv) Хүмүүн капитал, (v) Дэд бүтэц гэсэн хэсгээс бүрдэж, Турк улс даяар программ хангамж хөгжүүлэгчдийн тоог 140 мянгаас 500 мянгад хүргэхээр, дор хаяж 23 ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээнд гарааны бизнес эрхлэгчид болон аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх төрийн дэмжлэгүүдээс ашиг хүртэх арга замыг “Технологийн хөгжлийн бүсийн тухай хууль”-д зохицуулж, “Технологийн хөгжлийн бүс”-д бүртгүүлж, уг бүсэд байрлаж үйл ажиллагаа явуулан, нэмэгдсэн өртгийн, орлогын болон аж ахуйн нэгжийн албан татвараас чөлөөлөгдөх, даатгалын шимтгэлийн дэмжлэг авах зэрэг олон тооны боломжийг олгосон.

Мэдээллийн технологийн салбарт жижиг, дунд бизнесийн гүйцэтгэх үүрэг чухал нөлөөтэй бөгөөд сүүлийн жилүүдэд технологид суурилсан гарааны бизнесүүд олноор төрөн гарч байна. Эдгээр нь дотоодын төдийгүй дэлхийн зах зээлд гарах томоохон компаниудын эхлэл байдгаараа онцлогтой ба жишээ болгон Google, Amazon, Alibaba зэрэг компаниудыг дурдаж болно. Гарааны бизнесүүдийн онцлог нь эрч хүчтэй, шинийг санаачлагч байж хөдөлмөрийн зах зээлд шинээр ажлын байр бий болгон бизнесийн орчинд эрчимтэй өрсөлдөөнийг үүсгэн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлдэг хэдий ч ихэнх улс орнуудад төрөөс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаагаа тогтворжуулах боломжийг олгодог байна.

Монгол улсын мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн талаар тодруулбал мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ихэнх нь дэлхийн бусад улс орны энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай харьцуулахад бүрэн төлөвшиж амжаагүй, бизнесийн орлого, хөрөнгө оруулалт, төрөөс үзүүлэх дэмжлэг хангалтгүй байгаагаас гарааны компани хэлбэртэй байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл нь дэлхий дахинд үндэстэн дамнасан том корпорацуудын бизнес болон хувирч, бусад орны орлого, хүний нөөцийг ихээр татан төвлөрүүлж байна. Хиймэл оюун ухааны хөгжил нь энэ хандлагыг улам бүр эрчимжүүлж, сүүлийн жилүүдэд ихэнх улс орнууд хиймэл оюун ухааны хөгжлийн гол түүхий эд болох өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж дотооддоо хөгжүүлэх, интернэт орчин нь өөрөө хил хязгааргүй, тээвэр ложистикийн зардал байхгүйгээс шууд дэлхийн хэрэглэгчдэд хүрдэг

онцлогийг харгалзан эдийн засагтаа оруулах мэдээллийн технологийн үйлдвэрлэл, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлэхээр суурь нөхцөлөө бүрдүүлж байна. Бүс нутгийн хэмжээнд Япон, Солонгос, Казахстан, Узбекистан, Киргизстан, Турк зэрэг улс орнууд мэдээллийн технологийн бизнес, финтекийг хөгжүүлэх зорилгоор гарааны бизнес хөгжүүлэх төвүүдийг байгуулж, төр хувийн хэвшлийн сангуудаар дамжуулан хөрөнгө оруулах, хөгжлийн эхэн үед нь төрөөс татварын болон татварын бус дэмжлэгийг өрсөлдөн үзүүлж байгаа нь манай улсын хүний нөөц, мэдлэг оюуныг татаж, цаашдаа энэ салбарын хөгжлийг сааруулах, зогсоох нөхцөлд хүргэж байна.

СтартапБлинкийн Гарааны бизнесийн экосистемийн дэлхийн индексээр 2023 оны Монгол Улс шилдэг 100-д багтаж 79-р байранд жагсаж 2 байраар урагшилсан (2020 оноос хойш 7 байраар урагшилсан) амжилтыг үзүүлсэн боловч Монгол Улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэхэд нэлээдгүй асуудлууд тулгарсаар байна. Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар:

- Гарааны бизнесийн экосистемийн хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй;
- Гарааны бизнес, мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой нэр томъёоны ойлголт зөрүүтэй;
- Гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй;
- Гарааны бизнесийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжилтийг хангах төрийн байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй;
- Инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй;
- Гарааны бизнесийг дэмжих татварын дэмжлэг тодорхойгүй гэж дурдсан байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк нь гарааны компаниудыг дэмжих чиглэлээр мэдээллийн технологийн салбарын шинэ санаа, санаачилгыг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ хэрэгцээг эрж олох, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниуд, бизнес эрхлэгчдэд урамшууллын таатай орчин бүрдүүлэн ололт амжилт, өсөлтийг нь хурдасгахад цаг хугацааны, хөрөнгө оруулалтын, менежментийн иж бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон, дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болгон бойжуулах зорилгоор программ хангамжийн чиглэлээр бизнес эрхлэгчдийг элсүүлэх бодлого барьж, “Мэдээллийн технологийн инкубаторт элсэх иргэн ба компаниудыг сонгон шалгаруулах журам” боловсруулан баталсан.

Тус журам батлагдсанаар анх 2003 оны 9 дүгээр сард инкубаторын анхны элсэлтийг зохион байгуулж, нийт 23 аж ахуйн нэгж, хувь хүн хүсэлт гаргаснаас, 11 аж ахуйн нэгж болон 2 иргэнийг сонгон шалгаруулж элсүүлсэн. 2022 оны байдлаар инкубаторт бойжиж буй 12 компанийн үйл ажиллагааны чиглэлийг тодруулбал, контент хөгжүүлэлт 58%, сошиал маркетинг 23%, аппликэйшн хөгжүүлэлт 10%, систем хөгжүүлэлт 9% байна. Монгол улсын гарааны бизнесийн экосистем нь харьцангуй залуу бөгөөд гарааны бизнес эрхлэгч нарын 63% нь сүүлийн 3 жилд үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Мөн гарааны бизнес эрхлэгч нараас нийт 137 оюуны өмч бүртгүүлснээс 10 нь олон улсад бүртгэгдсэн ба бүгд зах зээлд нэвтэрсэн байна.

4.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн баримт бичигт мэдээллийн технологи, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлт, мэдээллийн технологийн компани, дэвшилтэт технологийн талаарх ойлголт тодорхойгүй байгаагаас Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрөөс дэмжихээр заасан “мэдээллийн технологийн компаниуд”, “мэдээллийн технологийн энтрепренер”, “хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн үндэсний компани”, “кластер”, “сэндбокс орчин” зэргийг хэрхэн ойлгох, хэрэглэх хүрээ тодорхойгүй байна. Одоогоор Харилцаа холбооны тухай хуульд “мэдээллийн технологи” гэсэн нэр томъёог тодорхойлсон хэдий ч энэ төрлийн харилцааг цаашид дэлгэрүүлэн зохицуулаагүй, мөн “харилцаа холбоо” гэдэг нэр томъёоны агуулгад “мэдээллийн технологи” нь багтахгүй байгаа зэргээс тус хуулийн үйлчлэх хүрээнд хамааруулан зохицуулахад хүндрэлтэй байна.

Түүнчлэн Инновацийн тухай хууль, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиуд үйлчилж, зарим төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэгүүдийг бий болгосон хэдий ч хязгаарлагдмал хүрээтэй, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь заавал инновац бүтээх албагүй бөгөөд нөгөө талаас мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийг бодлогын түвшинд дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох, бодлогын удирдамжаар ханган ажиллах төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн талаарх зохицуулалт дутмаг байгаатай холбогдуулан цахим эдийн засгийг бий болгох арга зам нь ойлгомжгүй, зөвхөн уриалгын шинжтэй байгааг дурдах нь зүйтэй. Статистик тоон мэдээллээс харахад мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг тооцоолоход 0.24 хувьтай байна.

Иймд Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан мэдээллийн технологийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийг дэмжих зорилтын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг санаачлан боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилт нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар цахим эдийн засгийг дэмжихэд оршино.

Хуулийн төсөл нь дараах бүтэцтэй байна:

➤ Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэлд хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээг тогтоож, хуульд хэрэглэсэн нэр

томъёоны тодорхойлолт, тухайлбал, “мэдээллийн технологи”, “мэдээллийн технологийн үйлдвэрлэл”, “сэндбокс орчин”, “дэвшилтэт технологи” зэрэг нэр томъёоны агуулгыг тодорхойлно. Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, тэр дундаа мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах, үндэсний мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх дэмжлэг нь ил тод, шударга, нээлттэй байх зарчмыг тогтооно.

➤ Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газар, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх нийтлэг үүргийг тодорхойлох бөгөөд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбоотой бусад зохицуулалтыг тусгана.

Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохоос гадна мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр салбар хоорондын уялдаа холбоог хангах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, программ хангамжийн эх код эзэмших эрх, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих, салбарын хүний нөөцийг бэлтгэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх, бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулахтай холбоотой бусад байгууллагаас авах арга хэмжээний талаарх зохицуулалтыг тусгана.

Түүнчлэн мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн дэвшилтэт технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдэд зориулан инкубатор, хамтын оффис ажиллуулах, инкубаторт элсэх хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох, үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, гадаад аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагатай байхаар тусгана.

➤ Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэхэд тавигдах шаардлага, бүртгэлээс хасах үндэслэлийг тодорхойлно.

➤ Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг, дэмжлэгийн эх үүсвэрийн талаар тусгана.

➤ Хуулийн төслийн тавдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбоотой бусад зүйлийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дагавар гарна:

- Мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэн, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөж нэмэгдэнэ.
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс үзүүлэх дэмжлэг тодорхой болно.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, хүн, хуулийн этгээдээс дэвшилтэт технологи бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад түлхэц үзүүлнэ.
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь олон нийтэд ил тод, нээлттэй байх нөхцөл бүрдэнэ.
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлд хүн, хуулийн этгээд тэгш эрхтэй, чөлөөтэй оролцох нөхцөл бүрдэнэ.
- Мэдээллийн технологийн салбарт хөрөнгө оруулалт татах боломж сайжирч, олон улсын хамтын ажиллагаа нэмэгдэнэ.
- Хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байрууд нэмэгдэнэ.
- Мэдээллийн технологийн салбарын нэр томьёо нэг мөр тодорхойлогдож, ойлголтын зөрүүтэй байдал арилна.
- Мэдээллийн технологийн салбарын оролцогч талуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Уг хуулийн төсөлтэй уялдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад шаардлагатай хуулийн төслийг тус тус боловсруулна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д 1 дүгээр үе шат буюу 2021-2030 онуудад эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 10 үр дүнг жагсаасны 5 дугаарт “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна” гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.29-д “Мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх институцийн тогтолцоог бүрдүүлнэ.” гэж, 4.2.31-д “Мэдээллийн технологийн кластерыг хөгжүүлж, гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлнэ.” гэж, 4.2.33-т “Мэдээллийн технологи болон цахим худалдааны салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, хөрөнгө оруулагчдын санаачилгыг дэмжинэ.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын дор эдийн засгийн тэргүүлэх 16 чиглэлийг тодорхойлсны “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурал 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4.1.9-д “Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.” гэж тодорхойлсон.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2 жил тутам шинэчлэн гаргадаг “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ээр 2018, 2020 онуудад тус байгууллагын гишүүн 193 орноос 92 дугаар байранд орж байсан бол 2022 онд 74 дүгээр байранд орж, 18 байр урагшилсан. Мөн үндэсний болон бүс нутгийн түвшинд бизнес эрхлэлтийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийг бодитойгоор хэмждэг Дэлхийн банкны “Doing business” буюу “Бизнес эрхлэлт”-ийн 2020 оны тайланд дурдсанаар манай улс 81 дүгээр байранд жагсжээ.

Түүнчлэн Дэлхийн өрсөлдөх чадварын төв болон эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан-2023”-т Монгол Улс өрсөлдөх чадварын үзүүлэлтээр тайланд хамрагдсан 64 улсаас 62 дугаарт эрэмбэлэгдэж, өмнөх оноос 0.64 оноогоор буурч 1 байр ухарсан үзүүлэлттэй байна. Үзүүлэлтийг эрэмбэлэн гаргахдаа эдийн засаг, засаглалын үр ашиг, бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа, дэд бүтэц гэсэн үндсэн 4 хүчин зүйл, 20 дэд бүлэг, нийт 335 шалгуур үзүүлэлтийн хүрээнд нарийвчилсан үзүүлэлтээр харьцуулан хэмжиж дэлгэрэнгүй гаргаж улс бүрийн өрсөлдөх чадварыг тодорхойлдог.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг улс орнуудын инновацын чадавх, амжилтаар нь эрэмбэлдэг “Дэлхийн инновацын индекс”-ээр 2022 онд 71 дүгээр байр эзэлж өмнөх онуудаас 10 гаруй байраар хойшилсон бол

2023 онд 132 улсаас 68 дугаар байранд жагсаж, 3 байр урагшилсан. Инновацийн дүр зургийг аль болох бүрэн дүүрэн гаргахаар төлөвлөдөг тус индекс нь эдийн засаг бүрийн улс төрийн орчин, боловсрол, дэд бүтэц, мэдлэгийн бүтээн байгуулалт зэрэг 80 орчим үзүүлэлтийг багтаасан байдаг ба манай улсын хувьд хүмүүн капитал, дэд бүтэц, бизнесийн боловсронгуй байдал зэрэг үзүүлэлтээрээ дундаж байгаа хэдий ч хамгийн доогуур жагсаж буй үзүүлэлт нь зах зээлийн боловсронгуй байдал буюу зээл, хөрөнгө оруулалт, худалдаа, төрөлжилт, зах зээлийн цар хүрээгээрээ 101 дүгээрт жагсаж байна. Энэ нь манай улсад инновац, нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын талаарх хууль, эрх зүйн таатай орчин бүрдээгүй байгаатай холбон тайлбарлаж болно.

Өнөөгийн эдийн засагт инновац болон мэдээллийн технологийн үйлдвэрлэл нь улс орны эдийн засгийн хөгжлийн тулгуур болж байна. Мэдээллийн технологийн хөгжил нь инновацыг идэвхжүүлж, тухайн салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ашиг тус, үр шимээ өгч цахим эдийн засгийг бий болгон, энэ нь нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, бүтээмжийг нэмэгдүүлэн өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийг авчирч байна. Тухайлбал, Азийн улс орнуудын мэдээллийн технологийн өөрчлөлт нь бүс нутгийн эдийн засагт асар их нөлөө үзүүлсэн талаарх түүхийг эргэн харвал, БНХАУ-ын цахим худалдааны зах зээлийн гүйлгээний хэмжээ 2013 онд 1.32 их наяд юань байсан бол 2016 онд 5.33 их наяд юань, 2017 онд 7.57 их наяд юань болж өссөн байна. Мөн санхүүгийн салбар дахь мэдээллийн технологи нь Ази тивд санхүүгийн үйлчилгээг хүргэх, ялангуяа төлбөр, зээлийг хөнгөвчлөх шинэ арга замыг бий болгож, энэ нь хөгжиж буй Азийн олон улс оронд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Түүнчлэн 2015 онд Ази дахь финтект суурилсан зээлийн хэмжээ 102.8 тэрбум ам.долларт хүрч, технологийн тархалт нь төлбөрийн системийн үр ашгийг улам дээшлүүлж, дэлхийн хамгийн том төлбөрийн зах зээлийг Ази тивд бий болгосон.¹

Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд 2000-аад оноос хойш мэдээллийн технологийн салбарт дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч, “Дижитал Казахстан” улсын хэмжээний хөтөлбөрийг 2017 оноос хэрэгжүүлж 655 сая гаруй ам.долларын хөрөнгө зарцуулсан, 2018 онд Засгийн газраас мэдээллийн технологийн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор 255 сая гаруй ам.долларыг төсөвлөж байсан зэргийг жишээ болгон дурдаж болно. Тус улс нь 2017 онд “Дижитал Казахстан” хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн түвшингээр 175 орноос 52 дугаарт жагссан. Цаашид Бүгд Найрамдах Казахстан Улсын 2025 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө нь шинэ эдийн засгийн тулгуур суурийг бий болгох, технологийн шинэчлэл, цахимжилтыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлоод байна.

Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар нь 2022 онд Солонгосын дотоодын нийт бүтээгдэхүүний 13.0 хувийг бүрдүүлж, улсын эдийн засгийн өсөлтийг тэргүүлж, тус салбарын нийт үйлдвэрлэл 560 их наяд вонд хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.1 хувиар өссөн байна. 2022 онд мэдээллийн технологийн экспорт 233.32 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 80.85 тэрбум ам.доллар болж, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар дахь үйлдвэрлэл нь нийт экспортын 30-40 хувийг эзэлж улсын эдийн засгийн өсөлтөд томоохон хувь нэмрийг оруулж байна.

¹ “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгааны тайлан” 2023 он

Бүгд Найрамдах Турк Улс 2023 онд “Үндэсний технологи, хүчирхэг үйлдвэрлэл” гэсэн алсын хараатай стратегийн баримт бичгийг боловсруулсан ба тус баримт бичиг нь (i) Өндөр технологи ба инновац, (ii) Дижитал шилжилт ба аж үйлдвэрийн хөдөлгөөн, (iii) Бизнес эрхлэлт, (iv) Хүмүүн капитал, (v) Дэд бүтэц гэсэн хэсгээс бүрдэж, Турк улс даяар программ хангамж хөгжүүлэгчдийн тоог 140 мянгаас 500 мянгад хүргэхээр, дор хаяж 23 ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээнд гарааны бизнес эрхлэгчид болон аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх төрийн дэмжлэгүүдээс ашиг хүртэх арга замыг “Технологийн хөгжлийн бүсийн тухай хууль”-д зохицуулж, “Технологийн хөгжлийн бүс”-д бүртгүүлж, уг бүсэд байрлаж үйл ажиллагаа явуулан, нэмэгдсэн өртгийн, орлогын болон аж ахуйн нэгжийн албан татвараас чөлөөлөгдөх, даатгалын шимтгэлийн дэмжлэг авах зэрэг олон тооны боломжийг олгосон.

Мэдээллийн технологийн салбарт жижиг, дунд бизнесийн гүйцэтгэх үүрэг чухал нөлөөтэй бөгөөд сүүлийн жилүүдэд технологид суурилсан гарааны бизнесүүд олноор төрөн гарч байна. Эдгээр нь дотоодын төдийгүй дэлхийн зах зээлд гарах томоохон компаниудын эхлэл байдгаараа онцлогтой ба жишээ болгон Google, Amazon, Alibaba зэрэг компаниудыг дурдаж болно. Гарааны бизнесийн онцлог нь эрч хүчтэй, шинийг санаачлагч байж хөдөлмөрийн зах зээлд шинээр ажлын байр бий болгон бизнесийн орчинд эрчимтэй өрсөлдөөнийг үүсгэн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлдэг хэдий ч ихэнх улс орнуудад төрөөс тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаагаа тогтворжуулах боломжийг олгодог байна.

Монгол Улсын мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн талаар тодруулбал мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ихэнх нь дэлхийн бусад улс орны энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай харьцуулахад бүрэн төлөвшиж амжаагүй, бизнесийн орлого, хөрөнгө оруулалт, төрөөс үзүүлэх дэмжлэг хангалтгүй байгаагаас гарааны компани хэлбэртэй байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл нь дэлхий дахинд үндэстэн дамнасан том корпорацуудын бизнес болон хувирч, бусад орны орлого, хүний нөөцийг ихээр татан төвлөрүүлж байна. Хиймэл оюун ухааны хөгжил нь энэ хандлагыг улам бүр эрчимжүүлж, сүүлийн жилүүдэд ихэнх улс орнууд хиймэл оюун ухааны хөгжлийн гол түүхий эд болох өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж дотооддоо хөгжүүлэх, интернэт орчин нь өөрөө хил хязгааргүй, тээвэр ложистикийн зардал байхгүйгээс шууд дэлхийн хэрэглэгчдэд хүрдэг онцлогийг харгалзан эдийн засагтаа оруулах мэдээллийн технологийн үйлдвэрлэл, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлэхээр суурь нөхцөлөө бүрдүүлж байна. Бүс нутгийн хэмжээнд Япон, Солонгос, Казахстан, Узбекистан, Киргизстан, Турк зэрэг улс орнууд мэдээллийн технологийн бизнес, финтекийг хөгжүүлэх зорилгоор гарааны бизнес хөгжүүлэх төвүүдийг байгуулж, төр хувийн хэвшлийн сангуудаар дамжуулан хөрөнгө оруулах, хөгжлийн эхэн үед нь төрөөс татварын болон татварын бус дэмжлэгийг өрсөлдөн үзүүлж байгаа нь манай улсын хүний нөөц, мэдлэг оюуныг татаж, цаашдаа энэ салбарын хөгжлийг сааруулах, зогсоох нөхцөлд хүргэж байна.

СтартапБлинкийн Гарааны бизнесийн экосистемийн дэлхийн индексээр 2023 оны Монгол Улс шилдэг 100-д багтаж 79-р байранд жагсаж 2 байраар урагшилсан (2020 оноос хойш 7 байраар урагшилсан) амжилтыг үзүүлсэн боловч Монгол Улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн гарааны бизнесийн

экосистемийг бүрдүүлэхэд нэлээдгүй асуудлууд тулгарсаар байна. Японы олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллагын хийсэн судалгаагаар:

- Гарааны бизнесийн экосистемийн хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй;
- Гарааны бизнес, мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой нэр томъёоны ойлголт зөрүүтэй;
- Гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй;
- Гарааны бизнесийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжилтийг хангах төрийн байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй;
- Инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй;
- Гарааны бизнесийг дэмжих татварын дэмжлэг тодорхойгүй гэж дурдсан байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк нь гарааны компаниудыг дэмжих чиглэлээр мэдээллийн технологийн салбарын шинэ санаа, санаачилгыг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ хэрэгцээг эрж олох, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниуд, бизнес эрхлэгчдэд урамшууллын таатай орчин бүрдүүлэн ололт амжилт, өсөлтийг нь хурдасгахад цаг хугацааны, хөрөнгө оруулалтын, менежментийн иж бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон, дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болгон бойжуулах зорилгоор программ хангамжийн чиглэлээр бизнес эрхлэгчдийг элсүүлэх бодлого барьж, “Мэдээллийн технологийн инкубаторт элсэх иргэн ба компаниудыг сонгон шалгаруулах журам” боловсруулан баталсан.

Тус журам батлагдсанаар анх 2003 оны 9 дүгээр сард инкубаторын анхны элсэлтийг зохион байгуулж, нийт 23 аж ахуйн нэгж, хувь хүн хүсэлт гаргаснаас, 11 аж ахуйн нэгж болон 2 иргэнийг сонгон шалгаруулж элсүүлсэн. 2022 оны байдлаар инкубаторт бойжиж буй 12 компанийн үйл ажиллагааны чиглэлийг тодруулбал, контент хөгжүүлэлт 58%, сошиал маркетинг 23%, аппликэйшн хөгжүүлэлт 10%, систем хөгжүүлэлт 9% байна. Монгол улсын гарааны бизнесийн экосистем нь харьцангуй залуу бөгөөд гарааны бизнес эрхлэгч нарын 63% нь сүүлийн 3 жилд үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Мөн гарааны бизнес эрхлэгч нараас нийт 137 оюуны өмч бүртгүүлснээс 10 нь олон улсад бүртгэгдсэн ба бүгд зах зээлд нэвтэрсэн байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн баримт бичигт мэдээллийн технологи, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлт, мэдээллийн технологийн компани, дэвшилтэт технологийн талаарх ойлголт тодорхойгүй байгаагаас Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрөөс дэмжихээр заасан “мэдээллийн технологийн компаниуд”, “мэдээллийн технологийн энтрепренер”, “хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн үндэсний компани”, “кластер”, “сэндбокс орчин” зэргийг хэрхэн ойлгох, хэрэглэх хүрээ тодорхойгүй байна. Одоогоор Харилцаа холбооны тухай хуульд “мэдээллийн технологи” гэсэн нэр томъёог тодорхойлсон хэдий ч энэ төрлийн харилцааг цаашид дэлгэрүүлэн зохицуулаагүй, мөн “харилцаа холбоо” гэдэг нэр томъёоны агуулгад “мэдээллийн технологи” нь багтахгүй байгаа зэргээс тус хуулийн үйлчлэх хүрээнд хамааруулан зохицуулахад хүндрэлтэй байна.

Түүнчлэн Инновацийн тухай хууль, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиуд үйлчилж, зарим төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэгүүдийг

бий болгосон хэдий ч хязгаарлагдмал хүрээтэй, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь заавал инновац бүтээх албагүй бөгөөд нөгөө талаас мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийг бодлогын түвшинд дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох, бодлогын удирдамжаар ханган ажиллах төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийн талаарх зохицуулалт дутмаг байгаагаар холбогдуулан цахим эдийн засгийг бий болгох арга зам нь ойлгомжгүй, зөвхөн уриалгын шинжтэй байгааг дурдах нь зүйтэй. Статистик тоон мэдээллээс харахад мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг тооцоолоход 0.24 хувьтай байна.

Иймд Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан мэдээллийн технологийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийг дэмжих зорилтын хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн зорилт нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар цахим эдийн засгийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд:

➤ Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээг тогтоож, хуульд хэрэглэсэн нэр томьёоны тодорхойлолт, тухайлбал, “мэдээллийн технологи”, “мэдээллийн технологийн үйлдвэрлэл”, “сэндбокс орчин”, “дэвшилтэт технологи” зэрэг нэр томьёоны агуулгыг тодорхойлсон. Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, тэр дундаа мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах, үндэсний мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх дэмжлэг нь ил тод, шударга, нээлттэй байх зарчмыг тогтоов.

➤ Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газар, төрийн болон нутгийн өөрөөр удирдах байгууллагын хүлээх нийтлэг үүргийг тодорхойлох бөгөөд энэ хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах талаар тусгасан.

Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоох бөгөөд энэ хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр салбар хоорондын уялдаа холбоог хангах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, программ хангамжийн эх код эзэмших эрх, бодлогын судалгаа шинжилгээ хийх,

дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих, салбарын хүний нөөцийг бэлтгэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх, бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулах зэрэг харилцааг зохицуулсан.

Түүнчлэн мэдээлэл, технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн дэвшилтэт технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдэд зориулан инкубатор, хамтын оффис ажиллуулах, инкубаторт элсэх хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох, үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, гадаад аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага (цаашид “Мэдээлэл, технологийн үндэсний парк” гэх)-тай байхаар тусгав.

➤ Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэхэд тавигдах шаардлага, бүртгэлээс хасах үндэслэлийг тодорхойллоо.

➤ Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг, дэмжлэгийн эх үүсвэрийн талаар тусгасан.

➤ Хуулийн төслийн тавдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан хориглох зүйл, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагатай холбоотой бусад зүйлийг тусгалаа.


Мэдээллийн технологийн салбарыг дэмжих тухай хуулийн төслийг дагаж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Уг хуулийн төсөлд бүх яамд болон Мэдээлэл, технологийн үндэсний паркийн саналыг авч тусгасан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэгт зааснаар энэ хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны www.mddc.gov.mn албан ёсны цахим хуудсанд хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн хамт 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд байршуулсан бөгөөд олон нийтээс санал ирээгүй болно.

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Төслийн зохицуулалт	Тайлбар
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	
1 дүгээр зүйл.Хуулийн зорилт	
1.1.Энэ хуулийн зорилт нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар цахим эдийн засгийг дэмжихэд оршино.	Мэдээллийн салбар, ялангуяа мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар нь дижитал шилжилтийн үндэс суурь болдог. Энэ үзүүлэлт нь хөдөө аж ахуйн бус бизнесийн салбарын бусад үйл ажиллагаатай харьцуулахад мэдээллийн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг хэмждэг. Энэ нь эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвар, амьжиргааны түвшинд мэдээллийн салбаруудын харьцангуй нөлөөллийн үзүүлэлт юм. Улс орнууд энэхүү дижитал шилжилтээс ашиг хүртсээр байгаа ч дижитал эдийн засгийг ойлгох нь нарийн төвөгтэй байдлаасаа болоод бэрхшээлтэй хэвээр байна. Дижитал шилжилт нь зөвхөн их өгөгдөл, дижитал платформууд төдийгүй эдгээр дэвшилтэт технологийг инновац, шинэ бизнесийн загвар, процесс, ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээний боломжийг нэмэгдүүлэхийн тулд хэрхэн ашиглах тухай юм. Цаашлаад дижитал эдийн засаг нь зах зээлийг либералчлах, худалдааны саад тотгорыг багасгах урт хугацааны чиг хандлагын дагуу бүс нутгийн бизнесүүдэд орон нутгийн бизнесээс холдож, дэлхийн хэмжээнд шилжих боломжийг олгож байна. Монгол улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна. Дэлхийн Банкны “Бизнес эрхлэхүй – 2020” үзүүлэлтэд Монгол Улс 190 орноос 81 дүгээр байранд эрэмбэлэгдсэн бол цөөнх хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагчийн хамгаалалт 25, Татварын орчин 71, хил дамнасан худалдаа 143 дугаар байр гэх үзүүлэлтүүд гарсан байна. Тодруулбал, <i>График. Монгол Улсын бизнес эрхлэхэд ээлтэй, хялбар байдлын 11 шалгуур үзүүлэлт</i>

Rankings on Doing Business topics - Mongolia



Иймд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, бизнес эрхлэлтийг дэмжих замаар эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулах, тэр дундаа мэдээллийн технологийн үйлдвэрлэл буюу мэдээллийн технологийн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна. Энэ нь шинэ мэдлэг, технологийг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглах замаар нийгмийн баялаг бүтээх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа идэвхжин мэдээллийн технологийн гарааны бизнесийг олноор бий болж шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа сайжирч, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, Монгол Улсад ажлын байр шинээр бий болгох, судалгаа ба хөгжүүлэлт, инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэх юм. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх зорилтыг хангалттай дэвшүүлсэн. Мэдээллийн технологийн салбар нь мэдлэгт тулгуурласан, бүх шатны боловсролын чанар, тогтвортой санхүүгийн хүртээмж шаарддаг бөгөөд хөгжүүлэхэд бусад орны туршлага, хөрөнгө оруулалтыг татах замаар үсрэнгүй хөгжих боломжтой. Монгол дахь арилжааны банкны бизнесийн зээлийн дийлэнх хувь нь өндөр хүүтэй, барьцаа хөрөнгө шаарддаг, богино хугацааны зээлүүд байдаг тул үндэсний жижиг дунд, бичил бизнес эрхлэгчид өсөн дэвжихэд

	бэрхшээлтэй байна. Инновацийн тухай хууль, Жижиг, дунд, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулиудаар тодорхой хэмжээнд инновац үйлдвэрлэл, жижиг дунд бизнесийг дэмжсэн боловч хязгаарлагдмал хүрээтэй, нөгөө талаас мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, тэр дундаа үйлчилгээ нь заавал инновац бүтээх албагүй байдаг тул уг хуулийн хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй. Инновацийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжид олон улсад түгээмэл хэрэглэгдэж байгаа мэдээллийн технологийн салбар, гарааны бизнесийн хөгжлийн нэр томьёонууд тусаагүй эсвэл тухайн хууль тогтоомжийнхоо хүрээнд хязгаарлагдмал тодорхойлогдсон байгаа тул олон улсын жишгийн дагуу шинээр тодорхойлох шаардлагатай байна.
2 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж	
2.1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хууль эрх зүйн орчны хүрээнд хамаарах хууль тогтоомжийг энэхүү хэсэгт тоочиж дурдсан байна.
2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.	Улс хоорондын олон талт хамтын ажиллагаа, харилцан туслалцах, найрсгаар зэрэгцэн орших, маргаантай асуудлаа энхийн аргаар эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрхийг хангах арга зам нь олон улсын гэрээний эрх зүйн үндсэн асуудал мөн. Монгол Улс олон улсын гэрээний тухай хуульд заасны дагуу Үндсэн хуульд харшлаагүй олон улсын гэрээний зохицуулалт давуу эрхтэй байдаг тул энэ хуульд заасан нь олон улсын гэрээний зохицуулалттай зөрчилдөх тохиолдолд олон улсын гэрээг дагаж мөрдөхөөр зохицуулсан.
3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ	
3.1.Энэ хууль нь төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, зарчим, чиг үүргийг тодорхойлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрөөс бодлогоор дэмжих шаардлагатай байгааг бусад улсын туршлага, олон улсын байгууллагын зөвлөмж, судалгаанууд харуулж байна. Мэдээлэл, технологийн салбар нь бусад салбар буюу уул

холбоотой үйлчилнэ.	харилцаанд	уурхай, хөдөө аж ахуй зэргийг бодвол цоо шинэ салбар бөгөөд хэдийгээр хөрөнгө оруулалт, түүхий эд, дэд бүтэц бага шаардах боловч ур чадвартай хүний нөөц, тогтвортой ажиллах хүч, тусгай санхүүгийн дэмжлэг шаардлагатай. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай эрх зүйн орчны зохицуулалт нь дараах зорилготой байна, үүнд: ●Мэдээллийн технологи, гарааны бизнес, энтерпренёршип зэрэг салбарын онцлог холбоотой нэр томъёог агуулгын хувьд өөрөөр томъёолсныг дахин, олон улсын жишигт нийцүүлэн томъёолох; ●Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагаа, тогтолцоог төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөгжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, хэмжээг нэмэгдүүлэх ●Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, баталгаагаар хангах ●Ур чадвартай хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвортой ажиллахад таатай орчныг санхүүгийн болон бусад хэлбэрээр бүрдүүлэх ●Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаадын болон хамтарсан компани байгуулах, үйл ажиллагаа явуулахад таатай орчныг бүрдүүлэх, гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнүүд ирж ажиллах зэрэг үйл ажиллагааг хялбар, хүнд сурталгүй болгох ●Бизнес эрхлэх, компани байгуулах, өөрчлөх, татвар, нийгмийн даатгал, оюуны өмч болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахад цахимаар, хурдан шуурхай бүртгэх боломжийг бүрдүүлэх ●Мэдээллийн технологийн гарааны компанийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг нь зах зээлд нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт олоход дэмжлэг үзүүлэх боломжийг тусгах ●Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, гарааны бизнесийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа дундын оффис, инкубатор, санхүү, технологийн болон бусад зөвлөх үйлчилгээг дэмжих, эдгээр үйл ажиллагааг уялдуулан зохицуулах бүтцийг тогтоож өгөх. ●Хувь хүн, хуулийн этгээдийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, экспортын татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ялгаатай тогтоох замаар гарааны бизнес,
--------------------------------	-------------------	---

	мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид учрах санхүүгийн ачааллыг хөнгөвчлөх арга замыг тусгах.
4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	
4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:	Стартап гэдэг нэр томьёо нь үйл ажиллагааны эхний үе шатанд байгаа компанийг хэлдэг. Гарааны бизнесийг эрэлт байгаа гэж үзэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхийг хүсдэг нэг буюу хэд хэдэн бизнес эрхлэгчид үүсгэн байгуулдаг. Эдгээр компаниуд ихэвчлэн өндөр зардалтай, хязгаарлагдмал орлоготой ажилладаг тул венчур хөрөнгө оруулагчид гэх мэт янз бүрийн эх үүсвэрээс хөрөнгө хайж байдаг. (Investopedia толь бичиг)
4.1.1.“гарааны компани” гэж Инновацийн тухай хуулийн 3.1.8-д заасныг;	
4.1.2.“дэвшилтэт технологи” гэж шинжлэх ухааны судалгаа, мэдлэгт суурилсан мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх технологийг;	СтартапБлинкийн Гарааны Бизнесийн экосистемийн дэлхийн индексээр 2023 оны Монгол Улс шилдэг 100-д багтаж 79-р байранд жагсаж 2 байраар урагшилсан (2020 оноос хойш 7 байраар урагшилсан) амжилтыг үзүүлсэн боловч Монгол Улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэхэд нэлээдгүй асуудлууд тулгарсаар байна. Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар гарааны бизнесийн экосистемийн хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй, мөн гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй гэсэн дүгнэлт гарсан. Мэдээллийн технологийн салбарын өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай, технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг нэн чухал тул дэвшилтэт технологийн нэр томьёоны агуулгыг тодорхойлсон.
4.1.3.“мэдээллийн технологи” гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан тоон өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг;	“компьютерт суурилсан мэдээллийн системийг судлах, зохион бүтээх, хөгжүүлэх, хэрэглэх, хэрэгжүүлэх, дэмжих, удирдах” (Information Technology Association of America (Comptia)) Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль буюу Харилцаа холбооны тухай хуульд “3.1.14.“мэдээллийн технологи” гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан цахим өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг” ойлгохоор зохицуулсан. Үүнийг олон улсад нийтээр

	хүлээн зөвшөөрөгдсөн ойлголтыг дотоодод нутагшуулах зорилгоор тодорхойлсон.
4.1.4.“мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэж мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгох, хөгжүүлэх, түгээх, үйлчилгээ үзүүлэхийг;	Монгол улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна. Үүний нэг арга зам нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэл буюу мэдээллийн технологийн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн орчныг бий болгох бөгөөд энэ нь шинэ мэдлэг, технологийг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглах замаар нийгмийн баялаг бүтээх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа идэвхжин мэдээллийн технологийн гарааны бизнесийг олноор бий болж шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа сайжирч, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, Монгол Улсад ажлын байр шинээр бий болгох, судалгаа ба хөгжүүлэлт, инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэх юм. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “3.2 Эдийн засгийн аюулгүй байдал” болон “3.6.Мэдээллийн аюулгүй байдал” хэсгийн дараах зорилтуудыг хангах боломжийг бүрдүүлнэ. 3.2.1.2.Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. 3.2.1.5.Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий

бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ. 3.2.1.8.Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ. 3.6.1.9.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.” гэж тус тус тусгажээ. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Тус зорилгын хүрээнд 4.2 зорилтын 1-р үе шат буюу 2021-2030 онд онцлон хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгохоор 10 чиглэлийг “Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд” хэмээн тодорхойлсноос “5.Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.” гэж тусгажээ. Мөн түүнчлэн эдгээр 10 чиглэлд заасан салбаруудыг 2021 оноос 2030 оны хооронд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе гэж заасан. Харин 2.4-р зорилт нь “Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх алхмуудад: “1.Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна. 2. Шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд

	бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна.” тус тус хүрэх үр дүнг тодорхойлжээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх 2 дугаар үе шат буюу 2031 оноос 2040 оны хооронд үндэсний шинжлэх ухаан, инновацыг дэлхийн зах зээлд гаргах тогтолцоог бүрдүүлэх үе бөгөөд “1.Нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэнэ.” гэсэн үр дүнг дэвшүүлжээ. Зорилт 2.6-д “Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн байх үр дүнд “2.Олон улсад оюуны бүтээл, мэдээллийн технологийн болон зөвлөх үйлчилгээг дэмжих зуучлагч компани, төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.” гэж, Зорилт 7.5-д “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.” гэж заасан бөгөөд тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн байх үр дүнд “1.Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг хөгжүүлэн, инновац нэвтрүүлж, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжсөн байна.” гэж, 3 дугаар үе шат буюу 2041 оноос 2050 онд хүрэх үр дүнд “Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацыг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе.” гэж тус тус заажээ. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.9-д “Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.” хэмээн тусгасан
4.1.5.“мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс” гэж мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэсний үндсэн дээр энэ	Мэдээллийн технологийн салбарын хурдацтай хөгжиж, блокчэйн, виртуал хөрөнгө, метавэрс зэрэг шинэ тутам ойлголтууд бий болж улс орнуудад уян хатан бодлого, хурдтай зохицуулалтын орчин шаарддаг. Уламжлалт систем энэхүү технологийн өөрчлөлтийг цаг үед нь тохируулан шингээж, зохицуулахад хүндрэлтэй байна. Нөгөө талаас

хуульд заасан дэмжлэг үзүүлэх зорилготой албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг;	зохицуулалтгүй байлгах нь тухайн улс оронд болон иргэдэд санхүүгийн болоод мэдээллийн аюулгүй байдлын олон төрлийн шинэ эрсдэлүүд бий болгодог. Гэтэл мэдээллийн технологийн гарааны компаниуд оюуны чадавхаараа өрсөлдөж, өдөр бүр шинэ суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж байгаа нь зохицуулалтын цоо шинэ, уян хатан орчин хэрэгтэйг харуулж байна. Сүүлийн жилүүдэд цахим шилжилт эрчимжих тусам улс орнууд “IT – Specialized Zone” буюу мэдээллийн технологийн тусгай бүс үүсгэж, цахим орчинд үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэл эрхлэх, хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэхээр зохицуулсан.
4.1.6.“хуулийн этгээд” гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэгдсэн хуулийн этгээдийг;	Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т "Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ." гэж заасны дагуу эшлэл хэрэглэсэн
4.1.7.“сэндбокс орчин” гэж мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, бодит орчинд турших боломж олгох зорилго бүхий орчныг;	Технологийн дэвшлийн нөлөөгөөр зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэн, аливаа төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж байна. Сэндбокс зохицуулалт нь технологийн шийдвэрийг зохицуулах нэг төрлийн хэлбэр бөгөөд зах зээлд шинээр нэвтэрч буй технологийн дэвшил, бизнесийн санаануудыг ямар нэгэн хиймэл загвар, инкубатор бус бодит орчинд турших боломжийг олгодгоороо бизнес эрхлэгчдэд давуу талтай. Мөн сэндбоксын тусламжтайгаар байгууллагууд шинэ технологийн бүтээгдэхүүний шинж чанар, түүнд тохирсон зохицуулалтын хэлбэр, шинээр үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлдог. Олон улсын туршлагаас харахад 57 улс орон, үүнд Их Британи, Австрали, Хонг Конг, Сингапур зэрэг улс орнууд сэндбоксын зохицуулалтыг нэвтрүүлж, 73 сэндбокстой байна. Сэндбоксд туршигдаж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг төрлөөр нь харуулбал дижитал санхүүгийн үйлчилгээ 63%, блокчейн 10%, төлбөр тооцоо 8%, KYV/Дижитал ID 5% болон бусад гэсэн байна. Сэндбоксын зохицуулалтын амжилттай туршилтын үр дүнд хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, оролцогчийн бизнесийн загварыг өөрчлөх шаардлагатай зэрэг дүгнэлтүүд гарсан жишээнүүд байна. Иймд мэдээллийн

	технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарын үйлдвэрлэсэн технологийн дэвшлийг турших боломжийг бүрдүүлэх зорилгоор сэндбокс орчин байгуулж болохоор тусгасан.
5 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах зарчим	
5.1.Төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхэд дараах зарчмыг баримтлан ажиллана:	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар бүлгийн 3.3.1-т "хуулийн зарчим нь түүний зорилго, агуулгыг хэрэгжүүлэхэд нөлөөлдөг хөшүүрэг тул хуулийн зүйл, заалтыг хэрэглэхэд эргэлзээ гарсан тохиолдолд асуудлыг тухайн хуулийн зарчмын хүрээнд авч үздэг." , 3.3.2-т "хуулийн зарчим нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг тусгаж, тухайн чиглэлээр төрөөс баримтлах бодлогод нийцэж, уг хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн ухагдахуун болно.", 3.3.3-т "хуульд заасан зарчмууд нь хоорондоо харилцан холбоотой байдгийг үндэслэн эрх зүйн харилцаа болон түүнээс үүдэлтэй ямар нэгэн асуудлыг шийдвэрлэхэд эдгээр зарчмууд хамтдаа буюу зарим нь голлох нөлөөтэй үйлчилнэ." гэж тус тус заасныг үндэслэн зарчмыг уг хуульд зохицуулсан байна.
5.1.1.төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах;	Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна. Үүний нэг арга зам нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэл буюу мэдээллийн технологийн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн орчныг бий болгох бөгөөд энэ нь шинэ мэдлэг, технологийг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглах замаар нийгмийн баялаг бүтээх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа идэвхжин мэдээллийн технологийн гарааны бизнесийг олноор бий болж шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа сайжирч, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, Монгол Улсад ажлын

	байр шинээр бий болгох, судалгаа ба хөгжүүлэлт, инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэх юм. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “3.2 Эдийн засгийн аюулгүй байдал” болон “3.6.Мэдээллийн аюулгүй байдал” хэсгийн дараах зорилтуудыг хангах боломжийг бүрдүүлнэ. 3.2.1.2.Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. 3.2.1.5.Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ. 3.2.1.8.Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ. 3.6.1.9.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.” гэж тус тус тусгажээ. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Тус зорилгын хүрээнд 4.2 зорилтын 1-р үе шат буюу 2021-2030 онд онцлон хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгохоор 10
--	--

чиглэлийг “Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд” хэмээн тодорхойлсноос “5.Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.” гэж тусгажээ. Мөн түүнчлэн эдгээр 10 чиглэлд заасан салбаруудыг 2021 оноос 2030 оны хооронд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе гэж заасан. Харин 2.4-р зорилт нь “Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх алхмуудад: “1.Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна. 2. Шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна.” тус тус хүрэх үр дүнг тодорхойлжээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх 2 дугаар үе шат буюу 2031 оноос 2040 оны хооронд үндэсний шинжлэх ухаан, инновацыг дэлхийн зах зээлд гаргах тогтолцоог бүрдүүлэх үе бөгөөд “1.Нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэнэ.” гэсэн үр дүнг дэвшүүлжээ. Зорилт 2.6-д “Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн байх үр дүнд “2.Олон улсад оюуны бүтээл, мэдээллийн технологийн болон зөвлөх үйлчилгээг дэмжих зуучлагч компани, төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.” гэж, Зорилт 7.5-д “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.” гэж заасан бөгөөд тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн

	байх үр дүнд “1.Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг хөгжүүлэн, инновац нэвтрүүлж, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжсөн байна.” гэж, 3 дугаар үе шат буюу 2041 оноос 2050 онд хүрэх үр дүнд “Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацыг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе.” гэж тус тус заажээ.
5.1.2.төр мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т "Монгол Улсын гарал үүсэлтэй болон хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээд;", 10.1.2-т "50-иас доошгүй хувийг нь бие даан гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх тендер ирүүлсэн дараахь этгээд: 10.1.2.а.Монгол Улсын иргэн, хуулийн этгээд; 10.1.2.б.Монгол Улсад бүртгэлтэй, өмчийнх нь 50-иас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хувь хөрөнгөөс бүрдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд; 10.1.3.нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал, үзүүлж байгаа үйлчилгээг хамгийн ихээр ашигласан; 10.1.4.нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан. 10.1.5.хуулийн этгээдийн ажиллах хүчний 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх. 10.1.6.инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгж нарт худалдан авах ажиллагаанд давуу эрх олгохоор заасан.
5.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь олон нийтэд ил тод, нээлттэй, шударга, байх;	Хууль тогтоомжийн төгс бус байдал нь зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх, жишээлбэл, корпорацын худалдан авалтын үйл явцад илэрдэг. Хуулийн дагуу хамгийн хямд үнээр үйлчилгээ, бүтээгдэхүүнээ санал болгосон компаниуд тендерт ялдаг. Энэ тохиолдолд дотоодын компаниуд өрсөлдөх чадваргүй байдаг. Нэмж дурдахад хүнд суртал, авлига, боловсон хүчний солилцоо, менежерүүдийн байнгын өөрчлөлт зэрэг нь мэдлэгийн баазыг байхгүй болгох зэрэг хүсээгүй үзэгдлүүдийг бий болгодгийг тэмдэглэх нь зүйтэй. Шинэ менежерүүд шинэ санаануудыг гаргаж ирдэг бөгөөд энэ нь өмнөх удирдлагуудын бодлоготой зөрчилддөг.

	Мэдээллийн технологийн салбарын төрийн бодлогын синхрончлол сул, шийдвэр гаргах үйл явц дахь зөрчилдөөнтэй тэмцэх шаардлагатай гэж мэдээллийн технологийн мэргэжилтэн Байжан Канафин үзэж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд хууль тогтоомжийг сайжруулахад хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Тендер шалгаруулалтыг цэгцэлж, дотоодын мэдээллийн технологийн компаниудыг дэмжсэн хамгаалалтын бодлого явуулах шаардлагатай байна. Цаашлаад татварын ачааллыг бууруулж, дотоодын мэдээллийн технологийн компаниудад татварын хөнгөлөлт үзүүлэх нь нэн чухал алхам юм. Зайлшгүй арга хэмжээний нэг бол мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй, төлөвшсөн компаниуд, тэдгээрийн бүтээгдэхүүнийг дэмжих зорилтот хөтөлбөрийг бий болгож хэрэгжүүлэх явдал юм.
5.1.4.мэдээллийн технологийн үйлдвэрлэлд хүн, хуулийн этгээд тэгш эрхтэй, чөлөөтэй оролцох;	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь газар зүйн байрлал, далайд гарцтай эсэхээс үл хамааран олон улсын зах зээлд шууд хүрэх боломжтой нь давуу тал боловч, дэлхийн бүх улсад энэ боломж адилхан учраас өндөр өрсөлдөөнт зах зээл юм. Мэдээллийн технологийн салбар хөгжих нь тухайн салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжихээс гадна бусад салбарын хөгжлийг хурдасгаж, бүтээмжийг нэмэгдүүлдэг онцлог, давуу талтай.
5.1.5.мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.	Түүнчлэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлээс гадна мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрийн ангиллыг нарийн тогтоож өгөх шаардлагатай. Учир нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс тодорхой чиглэсэн орчин үеийн, нарийн мэргэжлийн дэд салбаруудыг сонгон дэмжих үзэгдэл олон улсад хүчтэй өрнөж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.9-д “Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.” хэмээн тусгасан.
ХОЁРДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ	

6 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах бүрэн эрхтэй байна:	Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах; 2/шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх; 3/салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;" гэж заасны дагуу хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцааны хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан.
6.1.1.энэ хуулийн 14.3.1, 14.3.2, 14.3.4, 14.3.5-д заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшуулал олгох, зээлийн батлан даалт гаргахад тавигдах шаардлага, грант, урамшуулал олгох, зээлийн батлан даалт гаргах, тэдгээрийг олгох, гаргахаас татгалзах нөхцөл, журмыг тогтоох;	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангана." гэж заасны дагуу энэхүү хуулийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журмыг батлах эрх олгосон зохицуулалт тусгасан. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан Захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлага нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх шаардлагатай байдаг. Иймд энэхүү хуулиар батлагдвал зохих захиргааны хэм хэмжээний актыг батлах хууль зүйн үндэслэлийг зохицуулсан.
6.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;	Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бусад улсын туршлагаас харвал тодорхой бүсийг сонгон авч, тус бүсэд онцгой дэглэм тогтоох замаар дэмжлэгийг хэрэгжүүлж, дотоодын зах зээл, чөлөөт өрсөлдөөнийг хамгаалж байна. Тодорхой бүс үүсгэх нь өндөр мэдлэг, ур чадвартай хүний нөөцийн төвлөрлийг бий болгож бизнес эрхлэгчид хамтрах, кластер болон хөгжихөд тустай. Гарааны бизнес буюу технологийн салбарын жижиг, дунд бизнесийг төрөөс дэмжих нь бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэхээс эхэлнэ. Өөрөөр хэлбэл компани байгуулах, компани

	өөрчлөх буюу хөрөнгө оруулагч нэмэх, хасах үйл ажиллагаа хялбар байхаас эхлээд холбогдох бүртгэл, зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, цуцлах зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээ хамгийн хялбар, шуурхай, хүнд сурталгүй, цахим хэлбэртэй байх шаардлагатай. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоос харвал: - Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Монгол Улсад чөлөөт бүс байгуулах, түүний байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааны чиглэл, төрлийг тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.” - Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Дагуул хотыг стратегийн ач холбогдол бүхий дараах нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулна.”, 38.1-д “Нийслэл хот нь эдийн засгийн тусгай бүс /цаашид “тусгай бүс” гэх/-тэй байж болно. Тусгай бүсийг дагуул хотод Засгийн газрын шийдвэрээр байгуулна.” гэж заасны дагуу тусгасан.
6.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тодорхойлох;	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд: “1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. 2.Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ. 3.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны

	хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, улсын төсвийн биелэлтийг хангах ажлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулна." гэж заасныг хэрэгжүүлэх, хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор дээрх зохицуулалтыг тусгасан
6.1.4.энэ хуулийн 4.1.7-д заасан дэвшилтэт технологийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;	Аль ч улсад мэдээллийн технологийн хамгийн том худалдан авагч нь төр байдаг. Төрийн дэмжлэгийн нэг хэлбэр нь төрийн худалдан авах ажиллагаа нь инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг аль болох худалдан авах, худалдан авах ажиллагаанд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг түлхүү дэмжих бодлоготой байх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмчийг үйлдвэрлэгчид хадгалуулах, мэдээллийн технологийн үйлчилгээг тогтвортой худалдан авах зэрэг байдаг. Улс орны хөгжил, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарын гол хөдөлгөгч, хурдасгагч хүч нь мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах, түүнд суурилсан инновацыг нэвтрүүлэхтэй холбоотой тул улс орнууд үүнд гол анхаарлаа хандуулж байна. Уул уурхайд түшиглэсэн уламжлалт эдийн засгаас технологи, инновацад суурилсан мэдлэг шингэсэн дижитал эдийн засагт шилжих шилжилт нь гарцаагүй бөгөөд магадгүй 21-р зуунд тухайн улс орон тэсэж үлдэх эсэхийг тодорхойлох хэмжээнд хүртэл яригдаж байна. Мэдээллийн технологи, интернэтийн ачаар "хавтгай" болон хувирсан дэлхийд Монгол Улсын тээвэр, логистикийн алслагдмал байдлыг даван мэдээллийн технологиор өрсөлдөж, хүний нөөц, хөрөнгө оруулалтыг бусад улс оронтой уралдан татахын тулд тэдгээр орнуудаас илүү, ядаж тэнцүү дэмжлэг, таатай орчныг бүрдүүлсэн нөхцөлд амжилтад хүрч, мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжих боломжтой.
6.1.5.бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах;	Цахим хөгжлийн багц хууль батлагдаж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэгт "Бүх нийтийн тоон

	бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүх салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болох” талаар зохицуулалтууд тусаж, мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц тоон технологид шилжиж, манай улсын нийт 330 сум шилэн кабелийн сүлжээгээр холбогдсон бөгөөд бүх сум суурин газарт интернэтийн үйлчилгээг хүргээд байна. Хэдий дээрх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаа ч Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнд бүх нийтийн цахим ур чадварын үзүүлэлт эрэгтэйд 30%, эмэгтэйд 32%, дундаж үзүүлэлтээр 31% гэж тодорхойлогджээ. Харин Үндэсний Статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ” судалгаанд оролцогчдын сүүлийн 3 сард ашигласан мэдээллийн технологийн хэрэглээнд тулгуурлан үр дүнг гаргасан. Нийт судалгаанд оролцогчдын 43.8% нь мэдээллийн ур чадвартай, 38.8% нь харилцаа холбооны ур чадвартай, 27% нь асуудал шийдвэрлэх ур чадвартай, 9.8% нь программ хангамжийн ур чадвартай, 6.4% нь аюулгүй байдлын ур чадвартай гэж үнэлэгдсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 42%-тай байна. Иймд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүх нийтийн мэдээллийн технологийн хэрэглээ, цахим ур чадварыг бодитойгоор үнэлж, олон нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, тоон хуваагдлыг бууруулах зорилгоор бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлахаар тусгасан.
6.1.6.хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксыг байгуулах, түүний журмыг батлах;	Технологийн дэвшлийн нөлөөгөөр зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэн, аливаа төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж байна. Сэндбокс зохицуулалт нь технологийн шийдвэрийг зохицуулах нэг төрлийн хэлбэр бөгөөд зах зээлд шинээр нэвтэрч буй технологийн дэвшил, бизнесийн санаануудыг ямар нэгэн хиймэл загвар, инкубатор бус бодит орчинд турших боломжийг олгодгоороо бизнес эрхлэгчдэд давуу талтай. Мөн сэндбоксын тусламжтайгаар байгууллагууд шинэ технологийн бүтээгдэхүүний

	шинж чанар, түүнд тохирсон зохицуулалтын хэлбэр, шинээр үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлдог. Олон улсын туршлагаас харахад 57 улс орон, үүнд Их Британи, Австрали, Хонг Конг, Сингапур зэрэг улс орнууд сэндбоксын зохицуулалтыг нэвтрүүлж, 73 сэндбокстой байна. Сэндбоксд туршигдаж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг төрлөөр нь харуулбал дижитал санхүүгийн үйлчилгээ 63%, блокчейн 10%, төлбөр тооцоо 8%, KYV/Дижитал ID 5% болон бусад гэсэн байна. Сэндбоксын зохицуулалтын амжилттай туршилтын үр дүнд хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, оролцогчийн бизнесийн загварыг өөрчлөх шаардлагатай зэрэг дүгнэлтүүд гарсан жишээнүүд байна. Иймд мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарын үйлдвэрлэсэн технологийн дэвшлийг турших боломжийг бүрдүүлэх зорилгоор сэндбокс орчин байгуулж, түүний журмыг батлахаар тусгасан.
6.1.7.хөгжлийн тэргүүлэх болон дэвшилтэт технологийн жагсаалтад багтсан чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил, төсөл, хөтөлбөрийг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгэх;	Сүүлийн жилүүдэд технологид суурилсан гарааны бизнесүүд олноор төрөн гарч байна. Эдгээр нь дижитал эриний аж ахуйн нэгжүүд бөгөөд дотоодын төдийгүй дэлхийд гарах томоохон компаниудын эхлэл байдгаараа онцлогтой. Жишээлбэл Google, Amazon, Alibaba гэх мэт. Гарааны бизнесүүдийн онцлог нь эрч хүчтэй, шинэлэгч байдаг. Тэд жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) болж үйл ажиллагаагаа үргэлжлүүлдэг боловч уламжлалт ЖДҮ-ээс ялгаатай тул засгийн газар болон бусад тоглогчдоос тодорхой дэмжлэг шаарддаг. Технологийн гарааны бизнес нь шинэ, шинэлэг технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргаж ирдэг залуу бизнес эрхлэгчид юм. Тэд хэрэглэгчид болон бизнесүүдэд шийдлийг санал болгодог ба ихэвчлэн бидний мэдэхгүй, анзаараагүй байсан асуудлууд руу ордог. Гаргаж ирсэн бизнесийн загвар нь ихэвчлэн өргөжүүлэх боломжтой байдаг тул бий болгосон шийдлүүдийг интернэтээр санал болгож, үйлчлүүлэгчдийн өргөн хүрээг хамарч чаддаг тул үйл ажиллагаа хурдан өргөжиж болно гэсэн үг юм. Австрийн эдийн засагч “Шумпетерийн хэллэг”-ээр бол гарааны бизнесүүд бүтээлч сэтгэлгээгээр хандаж шинэлэг үйлчилгээ, бизнесийн шинэ загваруудаар дамжуулан бизнесийн ертөнцийг хувьсган өөрчилдөг. Tesla, SpaceX зэрэг хувьсгал хийсэн гарааны бизнесийг эс

	тооцвол гарааны бизнесүүд нь биет бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй, харин илүү ур чадварт тулгуурласан, биет хөрөнгөгүй шахам байдаг. Гарааны бизнес эрхлэгчид үнэ цэнтэй ур чадвартай, сэргэлэн цовоо, шинийг санаачилж, аж ахуйн нэгжид үнэ цэнэ нэмэх боломжийг бүрдүүлдэг. Энтрепренёрууд буюу үүсгэн байгуулагчид нь том сэтгэж, санаагаа хөгжүүлэхийн төлөө тууштай байдаг. Гарааны бизнесүүд нь ЖДҮ эрхлэгчдийн маш бага хувийг бүрдүүлдэг. 2020 онд дэлхийн хэмжээнд 213 сая ЖДҮ үйл ажиллагаа явуулж байгаагаас 1.35 сая (1%-иас бага) нь технологийн гарааны бизнес байжээ. Гэсэн хэдий ч томрох боломж, авчирсан шинэлэг зүйлийнхээ ачаар тэд бодлого боловсруулагчдын анхаарлыг татдаг. Эдгээр нь уламжлалт ЖДҮ-ээс ялгаатай бөгөөд засгийн газар болон гарааны бизнесийн өргөн хүрээний экосистемээс тодорхой бодлого, хөтөлбөрийн дэмжлэг шаарддаг. Гарааны бизнесийн экосистем өндөр хөгжсөн улс болох АНУ, Англи, Сингапур, Герман, Израйль зэрэг улсууд гарааны бизнесийг татварын бодлогоор дэмжиж, амжилттай ажиллахад ихээхэн тусыг үзүүлж байна. Монгол Улсад мөн үүний эхлэл тавигдаж, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас гарааны бизнесийн хурдасгуур, хамтын оффис, технологи дамжуулах төвүүдээр дамжуулан инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж байгаа гарааны бизнесийн татварын хөнгөлөлт болон чөлөөлт олгохоор болсон. 2012 онд батлагдсан Монгол улсын “Инновацын тухай” хуульд “гарааны компани” гэсэн нэр томъёог тодорхойлсон ба Инновацын тухай хуулийн 16.4.1-д заасны дагуу технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид төрөөс татварын дэмжлэг үзүүлэх, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулах зорилгоор Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам"-ыг баталснаар гарааны бизнес эрхлэгчид доорх татварын хөнгөлөлт,
--	---

	чөлөөлөлт эдлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн.Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр батлагдсан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг улсын бүртгэлд бүртгүүлсэн ашиг олох зорилго бүхий дотоодын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид үйлчлэх бөгөөд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэнэ.Үндэсний статистикийн хорооноос 2022 онд эрхлэн гаргасан “Эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр 2021” тайланд дурдсанаар Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 2.1 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бий болгосон нь ДНБ-ий 5.5 хувийг бүрдүүлсэн байна. Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 2021 онд 493.4 тэрбум төгрөг болж, үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөгт ЖДҮ 3.1 хувийг эзэлж байна. Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 1353.0 тэрбум төгрөг болж, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөгт 8.7 хувийг эзэлж байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 621.0 тэрбум төгрөгийн бараа экспортолж, 1894.0 тэрбум төгрөгийн бараа импортолсон нь нийт барааны экспортын 2.4 хувь, импортын 9.7 хувийг эзэлж байна. Экспортын 89.2 хувийг БНХАУ-д гаргасан бол импортын 53.7 хувийг БНХАУ-аас оруулж ирсэн байна. Экспортын барааны 52.4 хувь нь мал, амьтны ноос, ноолуур, 29.4 хувь нь эрдэс бүтээгдэхүүн, 4.9 хувь нь мах, мал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн байна. Импортын барааны 18.5 хувь нь машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 15.2 хувь нь үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлс байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн 11.0 хувийг хөдөө аж ахуйн салбар, 23.8 хувийг үйлдвэрлэлийн салбар, 65.2 хувийг үйлчилгээний салбар тус тус эзэлж байна. Дээрх тоон мэдээлэл, бусад үзүүлэлтээс харвал Жижиг, дунд үйлдвэрлэлийн хууль тогтоомж, сангууд нь мэдээллийн
--	---

	технологийн гарааны бизнесийг мэдэгдэхүйц дэмжихгүй байна. Иймд мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэлж, эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд тэдгээрийг үнэлэх, мэргэшсэн шинжээч ажиллуулах шаардлага гарч байна.
7 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх үүрэг	
7.1.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь дараах нийтлэг үүрэг хүлээнэ:	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 2.4-т заасан "Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ." гэсний 1 дүгээр үе шат буюу 2021-2030 онд "Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх үе" байхаар, тус тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд "Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ." гэсэн зорилтыг хангах талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд зайлшгүй анхаарч өөрийн хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллах шаардлагатай.
7.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 3-т "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын талаар үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэхийг даалгасан тул уг бодлогын баримт бичигт тусгасан мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой бодлого, энэ хүрээнд Засгийн газраас баталсан болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын

	баримталж байгаа бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хариуцуулахаар тусгасан.
7.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.4.1-д "Төрөөс хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтыг бодлого, татварын орчноор дэмжинэ." гэж, 2.4.2-т "Хувийн хэвшлийн технологийн хөгжүүлэлтийг дэмжих тогтолцоо, бүтцийг оновчтой бүрдүүлж, хөтөлбөр хэрэгжүүлнэ." гэж, 2.4.4-т "Шинжлэх ухаан, инновацын салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ." гэж, 2.4.6-д "Мэдлэгийн үйлдвэрлэл дэх хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж, шинэ мэдлэг бий болгоход гаргасан зардлын тодорхой хэсгийг төрөөс нөхөн төлдөг тогтолцоотой болно." гэж, 2.4.7-д "Шинэ мэдлэгийг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, грант олгоно." гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.9-д "Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна." гэж заасны дагуу төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь мэдээллийн технологийн чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу хамтран ажиллаж, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан.
7.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардагдах	Тухайн төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа хүн, хуулийн

хөрөнгийг төсөвтөө багтаан шийдвэрлэх;	этгээдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвтөө тусгаж, зарцуулах талаар зохицуулсан.
7.1.4.хуульд заасан бусад.	Бусад хуульд төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагын мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотойгоор заасан үүргийг энэ хуулийн нэгэн адил хэрэгжилтийг хангахаар заасан.
7.2.Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлан таниулахад шаардагдах зардлыг төрөөс санхүүжүүлж болно.	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.5.8-д "Гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлд шаардлагатай технологийн инновацын талаарх мэдээлэл авах, олон улсын үзэсгэлэн, яармаг болон бизнес уулзалтууд зохион байгуулах замаар хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлнэ." гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.7 дахь заалтын 3-т "Инноваци, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх"-ийг хуучнаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт буюу тус газрыг өөрчлөн байгуулсан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд даалгасан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих талаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.8-д "Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ." гэж, 3.6.1.9-д "Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна." гэж тус тус заасны дагуу цахим хөгжил, харилцаа

	холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дотоодын мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулж экспортод гаргах боломжийг бүрдүүлэх боломжтой тул холбогдох зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн гадаад улсын туршлагаас харахад Турк Улсын Эдийн засгийн яам нь болж буй үзэсгэлэн худалдааг сурталчлахтай холбоотой зардлын 50 хувийг нөхөн төлдөг. Мөн яам нь олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцох, зах зээлийн судалгаа, гадаадад гарах, гадаадад брэндийг сурталчлах, экспорттой холбоотой бусад олон үйл ажиллагааг дэмжин ажилладаг байна.
7.3.Төрийн захиргааны төв байгууллага нь бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээнд нийцүүлэн салбарын онцлог бүхий сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулж, батлахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг авна.	Цахим хөгжлийн багц хууль батлагдаж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэгт “Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүх салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болох” талаар зохицуулалтууд тусаж, мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц тоон технологид шилжиж, манай улсын нийт 330 сум шилэн кабелийн сүлжээгээр холбогдсон бөгөөд бүх сум суурин газарт интернэтийн үйлчилгээг хүргээд байна. Хэдий дээрх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаа ч Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнд бүх нийтийн цахим ур чадварын үзүүлэлт эрэгтэйд 30%, эмэгтэйд 32%, дундаж үзүүлэлтээр 31% гэж тодорхойлогджээ. Харин Үндэсний Статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ” судалгаанд оролцогчдын сүүлийн 3 сард ашигласан мэдээллийн технологийн хэрэглээнд тулгуурлан үр дүнг гаргасан. Нийт судалгаанд оролцогчдын 43.8% нь мэдээллийн ур чадвартай, 38.8% нь харилцаа холбооны ур чадвартай, 27% нь асуудал шийдвэрлэх ур чадвартай, 9.8% нь программ

	хангамжийн ур чадвартай, 6.4% нь аюулгүй байдлын ур чадвартай гэж үнэлэгдсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 42%-тай байна. Иймд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүх нийтийн мэдээллийн технологийн хэрэглээ, цахим ур чадварыг бодитойгоор үнэлж, олон нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, тоон хуваагдлыг бууруулахад чиглэсэн соён гэгээрүүлэх сургалтын хөтөлбөр агуулгыг Төрийн захиргааны төв байгууллага боловсруулан батлахдаа цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг авахаар зохицуулсан.
7.4.Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааж, харилцан тохиролцоно.	Аль ч улсад мэдээллийн технологийн хамгийн том худалдан авагч нь төр байдаг. Төрийн дэмжлэгийн нэг хэлбэр нь төрийн худалдан авах ажиллагаа нь инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг аль болох худалдан авах, худалдан авах ажиллагаанд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг түлхүү дэмжих бодлоготой байх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмчийг үйлдвэрлэгчид хадгалуулах, мэдээллийн технологийн үйлчилгээг тогтвортой худалдан авах зэрэг байдаг.
7.5.Төсвийн байгууллага нь өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсад гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.	Монгол Улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэхэд нэлээдгүй асуудлууд тулгарсаар байгаа бөгөөд Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар "...инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй" гэсэн дүгнэлт гарсан. Турк улсад стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжүүдийн оюуны өмчийн эрхийг хадгалах арга хэмжээ авах, нээлттэй шинжлэх ухаан, нээлттэй инновац, нээлттэй эхийн программ хангамжийн хувьд оюуны өмчийн хууль тогтоомжийн дэд бүтцийг бий болгохоор, программ хангамж, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, брэнд болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор оюуны өмч, патентын эрхийн судалгааг хийхээр, их, дээд сургуулиудын оюуны өмчийн менежментийн чадавхыг нэмэгдүүлэх, оюуны өмчийг шилжүүлэх, лицензийн гэрээгээр ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор зохицуулалт хийж, үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохоор тусгасан байдаг.

	Иймд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.6-д "Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж, 2.4.21-д "Оюуны өмчийн хараат бус, кодлогдсон технологийн дагуу бүртгэж эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, оюуны өмчийн зуучлал, зөвлөх үйлчилгээ, арилжааг хөгжүүлнэ." гэж заасны дагуу цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах чиглэлээр анхаарч ажиллахаар тусгалаа. Мөн хуулийн төслийн 7.5-д Гадаад улс орнуудад дотоодын бүтээлийг эзэмшүүлэх замаар эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төсвийн байгууллага өөрийн ашиглаж буй программ хангамжийг гэрээний үндсэн дээр гадаад улс оронд шилжүүлж болохоор тусгасан.
8 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг	
8.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүргийг авч хэрэгжүүлнэ: 8.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар нийтээр дагаж мөрдөх стандарт, дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19 дэх заалтад "...харилцаа холбоо, сансар, мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудангийн бодлого, зохицуулалт"-ын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд хамаарахаар, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.7 дахь заалтын 3-т "Инноваци, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх"-ийг хуучнаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт буюу тус газрыг өөрчлөн байгуулсан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд даалгасан. Монгол Улсад

	мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэхэд нэлээдгүй асуудлууд тулгарсаар байгаа бөгөөд Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар "...гарааны бизнесийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжилтийг хангах төрийн байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй" гэсэн дүгнэлт гарсан. Иймд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангахын тулд энэ хүрээнд дагаж мөрдөх стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хууль, Стандартчилал, техникийн зохицуулалтын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангаж цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, батлах шаардлагатай тул энэ талаарх зохицуулалтыг тусгасан.
8.1.2. тухайн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стандарт, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоог оролцуулах, хамтран ажиллах, санал, зөвлөмж, дүгнэлтийг авах;	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19 дэх заалтад "...харилцаа холбоо, сансар, мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудангийн бодлого, зохицуулалт"-ын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд хамаарахаар, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.7 дахь заалтын 3-т "Инноваци, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх"-ийг хуучнаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт буюу тус газрыг өөрчлөн байгуулсан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд даалгасан. Мөн Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын хавсралтаар Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталдаг жишгийг харгалзан Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газрын шийдвэрээр тогтоож, үйл

	ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байхаар заасан.
8.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар оролцогч талуудын түншлэл, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19 дэх заалтад "...харилцаа холбоо, сансар, мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудангийн бодлого, зохицуулалт"-ын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд хамаарахаар заасан тул төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний уялдаа холбоо, оролцогч талуудын үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангаж, хэрэгжилтийг зохион байгуулахаар тусгасан.
8.1.4.бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;	Цахим хөгжлийн багц хууль батлагдаж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэгт "Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүх салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болох" талаар зохицуулалтууд тусаж, мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц тоон технологид шилжиж, манай улсын нийт 330 сум шилэн кабелийн сүлжээгээр холбогдсон бөгөөд бүх сум суурин газарт интернэтийн үйлчилгээг хүргээд байна. Хэдий дээрх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаа ч Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнд бүх нийтийн цахим ур чадварын үзүүлэлт эрэгтэйд 30%, эмэгтэйд 32%, дундаж үзүүлэлтээр 31% гэж тодорхойлогджээ. Харин Үндэсний Статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн "Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ" судалгаанд оролцогчдын сүүлийн 3 сард ашигласан мэдээллийн технологийн хэрэглээнд тулгуурлан үр

	дүнг гаргасан. Нийт судалгаанд оролцогчдын 43.8% нь мэдээллийн ур чадвартай, 38.8% нь харилцаа холбооны ур чадвартай, 27% нь асуудал шийдвэрлэх ур чадвартай, 9.8% нь программ хангамжийн ур чадвартай, 6.4% нь аюулгүй байдлын ур чадвартай гэж үнэлэгдсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 42%-тай байна. Иймд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүх нийтийн мэдээллийн технологийн хэрэглээ, цахим ур чадварыг бодитойгоор үнэлж, олон нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, тоон хуваагдлыг бууруулахад чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар тусгасан.
8.1.5.мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” зорилтын хүрээнд 2021-2030 он хүртэл мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар 2.1.28-д "Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ" гэж, 2.6.8-д "Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ" гэж, 7.5.5-д "Цахим мэдээллийг ангилах, тодорхойлох, үнэлэх, төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх талаар холбогдох хууль, дүрэм, журамд тусган онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудад цахим халдлагатай тэмцэх баг бий болгож мэргэшсэн хүний нөөц бэлтгэж, хөгжүүлнэ." гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн

	газрын 2020–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.3.12.7-д "Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх ажилд дэмжлэг үзүүлэх" гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19 дэх заалтад "мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал" нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд хамаарахаар заасан тул цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн технологийн боловсон хүчний нөөц, ажиллах хүчний зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг жил бүр хийж, хүний нөөцийн дутагдлыг багасгахад чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихээр тусгасан. Гадаад улс орны туршлагаас харахад Бүгд Найрамдах Турк Улс нь 2023 онд "Үндэсний технологи, хүчирхэг үйлдвэрлэл" гэсэн алсын хараатай стратегийн баримт бичгийг боловсруулсан ба тус баримт бичиг нь (i) Өндөр технологи ба инновац, (ii) Дижитал шилжилт ба аж үйлдвэрийн хөдөлгөөн, (iii) Бизнес эрхлэлт, (iv) Хүмүүн капитал, (v) Дэд бүтэц гэсэн хэсгээс бүрдэж, Турк улс даяар программ хангамж хөгжүүлэгчдийн тоог 140 мянгаас 500 мянгад хүргэх зорилт дэвшүүлж, хүний нөөцийн бодлогод анхаарч байна.
8.1.6.мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих;	Монгол Улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэхэд нэлээдгүй асуудлууд тулгарсаар байгаа бөгөөд Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар "...инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй" гэсэн дүгнэлт гарсан. Олон улсын туршлагаас харахад Бүгд Найрамдах Турк Улс нь 2023 онд "Үндэсний технологи, хүчирхэг үйлдвэрлэл" гэсэн алсын хараатай стратегийн баримт бичгийг боловсруулсан ба тус баримт бичиг нь (i) Өндөр технологи ба инновац, (ii) Дижитал шилжилт ба аж үйлдвэрийн хөдөлгөөн, (iii) Бизнес эрхлэлт, (iv) Хүмүүн капитал, (v) Дэд бүтэц гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд уг стратегийн баримт бичигт оюуны өмчийн эрх зүйн дэд бүтэц, хэрэгжилттэй холбоотой бүтцийг бэхжүүлнэ гэж онцолсон. Мөн

	Турк улсад стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжүүдийн оюуны өмчийн эрхийг хадгалах арга хэмжээ авах, нээлттэй шинжлэх ухаан, нээлттэй инновац, нээлттэй эхийн программ хангамжийн хувьд оюуны өмчийн хууль тогтоомжийн дэд бүтцийг бий болгохоор, программ хангамж, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, брэнд болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор оюуны өмч, патентын эрхийн судалгааг хийхээр, их, дээд сургуулиудын оюуны өмчийн менежментийн чадавхыг нэмэгдүүлэх, оюуны өмчийг шилжүүлэх, лицензийн гэрээгээр ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор зохицуулалт хийж, үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохоор тусгасан байдаг. Иймд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.6-д "Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж, 2.4.21-д "Оюуны өмчийн хараат бус, кодлогдсон технологийн дагуу бүртгэж эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, оюуны өмчийн зуучлал, зөвлөх үйлчилгээ, арилжааг хөгжүүлнэ." гэж заасны дагуу цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах чиглэлээр анхаарч ажиллахаар тусгалаа. Мөн Турк Улсын Технологийн хөгжлийн бүсийн хуульд их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрлэлийн салбарын хамтын ажиллагааг хангах талаар тусгасан байдаг тул энэ талаарх зохицуулалтыг тусгасан.
8.1.7.үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулахад дэмжлэг үзүүлэх;	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.5.8-д "Гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлд шаардлагатай технологийн инновацийн талаарх мэдээлэл авах, олон улсын үзэсгэлэн, яармаг болон бизнес

	уулзалтууд зохион байгуулах замаар хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлнэ." гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.7 дахь заалтын 3-т "Инноваци, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх"-ийг хуучнаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт буюу тус газрыг өөрчлөн байгуулсан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд даалгасан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих талаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.8-д "Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ." гэж, 3.6.1.9-д "Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон эдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна." гэж тус тус заасны дагуу цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дотоодын мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулж экспортод гаргах боломжийг бүрдүүлэх боломжтой тул холбогдох зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн гадаад улсын туршлагаас харахад Турк Улсын Эдийн засгийн яам нь болж буй үзэсгэлэн худалдааг сурталчлахтай холбоотой зардлын 50 хувийг нөхөн төлдөг. Мөн яам нь олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцох, зах зээлийн судалгаа, гадаадад гарах, гадаадад брэндийг сурталчлах, экспорттой холбоотой бусад олон үйл ажиллагааг дэмжин ажилладаг байна.
8.1.8.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.1.8-д "Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно." гэж, 7.3.17-д

	"Инновацад суурилсан техник, технологийн шинэчлэлийг сайжруулж, кибер гэмт хэргээс хамааралтай цахим нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэх, хиймэл оюун ухааныг ашиглах чадамжийг хөгжүүлж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ." гэж, 7.5.3-д "Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлж, кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын ба бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэнэ." гэж тус тус заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, нөгөө талаас мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, энэ чиглэлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг үүрэгжүүлэхээр тусгасан.
9 дүгээр зүйл.Мэдээлэл, технологийн үндэсний паркийн чиг үүрэг	
9.1.Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 9.1.1.дэвшилтэт технологийг хөгжүүлэх, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа хийх, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;	Монгол улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна. Үүний нэг арга зам нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэл буюу мэдээллийн технологийн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн орчныг бий болгох бөгөөд энэ нь шинэ мэдлэг, технологийг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглах замаар нийгмийн баялаг бүтээх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, мэдээллийн технологийн гарааны бизнес олноор бий болж шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа сайжруулах, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах,

	Монгол Улсад ажлын байр шинээр бий болгох, судалгаа ба хөгжүүлэлт, инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэ хүрээнд Мэдээллийн технологийн үндэсний парк нь өндөр технологийг нэвтрүүлэхтэй холбоотой судалгаа хийх, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулдаг байхаар тусгалаа.
9.1.2.гарааны компанийг бойжуулах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гарааны компаниудын үйл ажиллагааг уялдуулах;	Гарааны компанийг төлөвшүүлэх, бойжуулах талаар гадаад орны туршлагыг харвал өмнөд Солонгос нь дэлхийн шилдэг технологийн корпорацуудыг байгуулж, мөн Souprang цахим худалдааны сайт зэрэг технологийн тэрбум долларын үнэлгээтэй гарааны бизнес бий болгосон туршлагатай улс юм. Тус улсын хамгийн том давуу тал нь Samsung, LG зэрэг компаниуд нь тус улсыг үйлдвэрлэл, техник хангамжийн инженерчлэл шаарддаг салбаруудад тэргүүлэх байр суурь эзэлдэг. Мөн эдгээр томоохон компаниуд дотоодын бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалт, дэмжлэг үзүүлдэг. Жишээлбэл, 2023 онд Гванжу хотод хиймэл оюун ухааны гарааны бизнесийн инкубатор нээгдсэн ба үүнд Samsung компани дэмжлэг үзүүлсэн. Олон улсын компаниуд ч мөн Өмнөд Солонгосын гарааны бизнесийн чадавхыг хүлээн зөвшөөрч, Google Кампус, Facebook-ийн дэмжлэгтэй Солонгосын Инновацын лаборатори зэрэг санаачилгын үйл ажиллагааг эхлүүлээд байна. Нөгөөтэйгүүр, корпорацын соёл нь олон тооны өндөр чанартай, нэр хүндтэй ажлын байртай хослуулсан нь боломжит бизнес эрхлэгчдийг өөрсдийн гарааны бизнесийг бий болгохын оронд ажилтнаар ажиллуулах боломжийг олгодог. Засгийн газар энэ сорилтыг сайн мэдэж байгаа бөгөөд гарааны бизнест их хэмжээний хөрөнгө оруулалт хийхээс гадна бизнес эрхлэгчдийн хууль эрх зүйн эрсдэлийг бууруулах зохицуулалтын хамгаалагдсан хязгаарлагдмал орчныг бий болгож байна. Мөн бизнес эрхлэгчдийн бүтэлгүйтлийн зардлыг багасгах, инкубаторт бойжуулах, зөвлөн туслах замаар дэмжих зорилгоор хоёр дахь боломжийн гарааны санаачилгуудыг бий болгосон. Мөн Узбекистан Улсын төрийн захиргааны реформын хүрээнд Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн яам (МТХХЯ) 2015 онд байгуулагдсан бөгөөд 2019 онд программ хангамж,

мэдээллийн технологи үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд зориулсан мэдээллийн технологийн паркийг байгуулсан. Тус паркийн үйл ажиллагаагаар дамжуулан (i) мэдээллийн технологи (MT) салбарыг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх; (ii) түрээслэгчдийг шаардлагатай дэд бүтэц, зөвлөх үйлчилгээгээр хангах; (iii) инкубаторын болон хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан гарааны бизнесийг дэмжих; ба (iv) мэдээллийн технологийн чиглэлээр сургалт зохион байгуулах зорилготой ажиллаж байна. 2022 оны эцэс гэхэд МТХХЯ улс даяар 150 гаруй мэдээллийн технологийн төв байгуулж, 40,000 оюутанг дижитал ур чадварт сургажээ. Мөн татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлэх замаар мэдээллийн технологийн 450 компани байгуулахыг дэмжсэн. Түүнчлэн инкубаторын болон хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан 100 гаруй гарааны бизнес эрхлэгчдийг сургасан байна. Монгол улсын мэдээллийн технологийн гарааны бизнесийг үүсэл хөгжлийн хувьд авч үзвэл, 2003 онд Мэдээлэл технологийн үндэсний парк нь “Мэдээллийн технологийн салбарын шинэ санаа, санаачилгыг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ хэрэгцээг эрж олох, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниуд болон бизнес эхлэн эрхлэгчдэд урамшууллын таатай орчин бүрдүүлэн ололт амжилт, өсөлтийг нь хурдасгахад цаг хугацааны болон хөрөнгө оруулалт, менежментийн бусад иж бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон, дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болох эхний чадавхтай болтол нь торниулан бойжуулах” зорилготой, программ хангамжийн чиглэлээр бизнес эрхлэгчдийг элсүүлэх бодлого барьж, “Мэдээллийн технологийн инкубаторт элсэх иргэн ба компаниудыг сонгон шалгаруулах журам” боловсруулан баталсан. Тус журам батлагдсанаар анх 2003 оны 9 сард инкубаторын анхны элсэлтийг зохион байгуулж, нийт 23 аж ахуйн нэгж, хувь хүн хүсэлт гаргаснаас, 11 аж ахуйн нэгж болон 2 иргэнийг сонгон шалгаруулж элсүүлсэн. 2022 оны байдлаар инкубаторт бойжиж буй 12 компанийн үйл ажиллагааны чиглэлийн хувьд контент хөгжүүлэлт

	58%, сошиал маркетинг 23%, аппликэйшн хөгжүүлэлт 10%, систем хөгжүүлэлт 9% байна. Мэдээллийн технологийн үндэсний паркийн гарааны компанийг төлөвшүүлэх (бойжуулах), мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа чиг үүргийг хууль эрх зүйн орчны хувьд зохицуулахаар тусгалаа.
9.1.3.мэдээллийн технологийн тэмцээн, уралдаан зохион байгуулах, хүний нөөц бэлтгэх чиглэлээр дотоод, гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага болон хувь хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах;	Гарааны бизнес нь үе шатаар дамжин зах зээлд шинэ санаа санаачилга гаргаж, эдийн засгийн тогтвортой аж ахуйн нэгж болон тогтворждог. Томоохон аж ахуйн нэгжийн ашиг орлогыг нэмэгдүүлдэг зүйл бол шинэ гарааны компаниуд юм. Гарааны бизнесүүд жижиг байдаг учраас тэд материаллаг ба материаллаг бус нөөцийн дутагдалтай байдаг. Санхүүгийн болон хүний нөөцийн хувьд дутагдалтай байдал нь инновацийн шинэ процессыг хөгжүүлэхэд томоохон саад учруулдаг. Гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэхэд ур чадварыг төлөвшүүлэх буюу хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг ханган, өөр өөр ур чадвар, мэдлэг туршлага бүхий хүмүүсийг татан төвлөрүүлэх, хамтын ажиллагаа, харилцаа холбоо үүсгэх, хөгжүүлэх замаар урт хугацаанд хүмүүн капитал бий болгох, олон төрлийн бизнесийн төвлөрөл үүсгэх, бизнесийн зөвлөхүүдийн сүлжээг бий болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг салбарын талаарх ойлголт, мэдээллийг түгээх, эрдэмтэн судлаачдыг бизнес эрхлэгчидтэй холбо, хамтран ажиллах, гарааны бизнесийн соёлыг бий болгох, бизнес эрхлэгчдийн ур чадвар, хамтын ажиллагааг хөгжүүлж, амжилттай энтрепренерүүдийн жишээг олон нийтэд түгээж, уналт, алдаа нь гарааны бизнес эрхлэлтэд зайлшгүй тулгардаг зүйл гэдгийг ухамсарлуулан ойлгуулах, даван туулах арга зам байдгийг харуулах, Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдыг гарааны бизнесийн салбарт татан оруулж, баялгаа шилжүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх дэд бүтэц бий болох, гарааны бизнесийг хөрөнгөтэй холбох арга механизмыг илүү хялбар болгох, хөрөнгө оруулалтыг татаж, өндөр эрсдэл бүхий энэхүү салбарт капиталын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд татварын оновчтой тогтолцоог бий болгож, хууль

	эрх зүйн таатай орчныг бүрдүүлэн тогтвортой байдлыг хангах нь хөшүүргүүдийг онцлон тэмдэглэсэн байдаг тул эдгээр хөшүүргийг бий болгох талаар Мэдээллийн технологийн үндэсний паркийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан тусгасан.
9.1.4.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт татах;	Олон улсын туршлагаас харахад улс орнууд дижитал эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг төрөөс ихээхэн дэмжиж, тусгайлсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Жишээ дурдвал, Узбекистан Улсын Засгийн газар тунхаглал гаргах, стратеги боловсруулах, инновац, энтрепренёршипийг дэмжих чиглэлээр хууль тогтоомж гаргахаар идэвхтэй ажиллаж байна. Инновацийн ач холбогдлыг онцолж, 2018 оныг Засгийн газраас “Идэвхтэй энтрепренёршип, инновацлаг санаа, технологийг дэмжих жил” болгон зарласан. Мөн онд 2019-2021 оны Инновацийн хөгжлийн стратегийг баталсан юм. Стратегийн гол зорилго нь инновац, дэлхийн өрсөлдөх чадварыг тодорхойлоход гол хүчин зүйл болох хүмүүн капиталыг дэмжих, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Уг стратегийн үргэлжлэл болгон 2022 оны 7-р сард 2022-2026 оны Инновацийн хөгжлийн стратегийг баталсан. Уг стратеги нь дараах үндсэн зургаан чиглэлээр дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэж байна. Үүнд, нэгдүгээрт, 1413 ажлын байр бий болгох 122 гарааны бизнесийн төсөлд 75 тэрбум сумын санхүүжилт олгоно. Хоёрдугаарт, гарааны бизнесийг технологийн парк, эдийн засгийн тусгай бүсэд байршуулахыг дэмжиж, хувийн хэвшлийнхнийг шинжлэх ухааны хөгжлийг дэмжих сонирхлыг нэмэгдүүлж, хамтран санхүүжүүлэхийг дэмжинэ. Гуравдугаарт, инновацын технологийн парк, технологи дамжуулах төв, инновацын кластер, венчур байгууллага, инновацын төв, инкубатор, хурдасгуур зэрэг шинэлэг дэд бүтцийн төслүүдийн сүлжээг хэрэгжүүлнэ. Дөрөвдүгээрт, хурдасгуур хөтөлбөр, ложистик, санхүүжилтийн үйлчилгээ, зах зээлд нэвтрүүлэх, технологи дамжуулах төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх зэрэг инновацыг дэмжихэд дэмжлэг үзүүлнэ. Тавдугаарт, гарааны бизнест зориулсан орчин үеийн санхүүжилтийн механизмыг (венчур капитал, олон нийтийн санхүүжилт гэх мэт) хөгжүүлэх,

хялбаршуулсан санхүүжилтийн үйл ажиллагааг өрсөлдөөнт орчинд ("ирээдүйн эрдэмтэн", хакатон, технологийн марафон гэх мэт) өргөжүүлэхэд хүчин чармайлт гаргана. Зургаадугаарт, инновацлаг технологийн парк, эдийн засгийн чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрөл олгох журамтай хамт татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлнэ гэж тусгасан. Мөн дижитал Узбекистаныг хэрэгжүүлэх замын зураглал - 2030 стратегийн хүрээнд "Гарааны бизнесийн тухай" хуулийн төслийг боловсруулсан. Үүний гол зорилго нь гарааны бизнест үзүүлэх дэмжлэгийг зохицуулах, координац хийх явдал юм. Энэ нь гарааны бизнесийг бий болгох, экосистемийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй хөтөлбөр хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулах зэрэг гарааны бизнес буюу стартап гэсэн ойлголт, түүнийг дэмжих зарчим, чиглэлийг тодорхойлсон энэ улсын анхны хууль эрх зүйн баримт бичиг юм. Энэ хүрээнд гарааны бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэр, хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг тодорхойлсон ба гарааны бизнесийг үнэн зөв тоолоход туслах тодорхойлолтуудыг өгч, гарааны бизнес, инкубаторууд, хурдасгуур хөтөлбөрүүд, менторууд, сан, бизнесийн анжел хөрөнгө оруулагчдын талаар зохицуулсан. Тус улсын төрийн захиргааны реформын хүрээнд Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн яам (МТХХЯ) 2015 онд байгуулагдсан. Энэ нь 2019 онд программ хангамж, мэдээллийн технологи үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд зориулсан мэдээллийн технологийн паркийг байгуулжээ. МТХХЯ нь тус парк болон бусад үйл ажиллагаагаар дамжуулан (i) мэдээллийн технологи (МТ) салбарыг хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх; (ii) түрээслэгчдийг шаардлагатай дэд бүтэц, зөвлөх үйлчилгээгээр хангах; (iii) инкубаторын болон хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан гарааны бизнесийг дэмжих; ба (iv) мэдээллийн технологийн чиглэлээр сургалт зохион байгуулах зорилготой. 2022 оны эцэс гэхэд МТХХЯ улс даяар 150 гаруй мэдээллийн технологийн төв байгуулж, 40,000 оюутанг дижитал ур чадварт сургажээ. Мөн татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлэх замаар мэдээллийн технологийн 450 компани байгуулахыг дэмжив. Мөн инкубаторын болон хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан 100 гаруй гарааны бизнес эрхлэгчдийг

сургасан байна. Монгол улсын мэдээллийн технологийн гарааны бизнесийг үүсэл хөгжлийн хувьд авч үзвэл, 2003 онд Мэдээлэл технологийн үндэсний парк нь "Мэдээллийн технологийн салбарын шинэ санаа, санаачилгыг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ хэрэгцээг эрж олох, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниуд болон бизнес эхлэн эрхлэгчдэд урамшууллын таатай орчин бүрдүүлэн ололт амжилт, өсөлтийг нь хурдасгахад цаг хугацааны, менежментийн бусад иж бүрэн дэмжлэг тусалцаа үзүүлэх зэрэг биет болон биет бус хөрөнгө оруулалт татах замаар санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон, дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болох эхний чадавхтай болтол нь торниулан бойжуулах" зорилготой, программ хангамжийн чиглэлээр бизнес эрхлэгчдийг элсүүлэх бодлого барьж "Мэдээллийн технологийн инкубаторт элсэх иргэн ба компаниудыг сонгон шалгаруулах журам" боловсруулан баталсан. Тус журам батлагдсанаар анх 2003 оны 9 сард инкубаторын анхны элсэлтийг зохион байгуулж, нийт 23 аж ахуйн нэгж, хувь хүн хүсэлт гаргаснаас, 11 аж ахуйн нэгж болон 2 иргэнийг сонгон шалгаруулж элсүүлсэн. 2022 оны байдлаар инкубаторт бойжиж буй 12 компанийн үйл ажиллагааны чиглэлийн хувьд контент хөгжүүлэлт 58%, сошиал маркетинг 23%, аппликэйшн хөгжүүлэлт 10%, систем хөгжүүлэлт 9% байна. "Мэдээллийн технологийн үндэсний парк" төрийн өмчид аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 60 дугаар тогтоолын хавсралтаар баталсан байдаг хэдий ч практикт хэрэгжих боломж, эрх зүйн зохицуулалтын давуу хүчинтэй хэрэгжих боломжийг нь харгалзан технологийн гарааны бизнесийн экосистемийг дэмжих мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг төлөвшүүлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх байгууллагын үүргийг тодорхой болгож, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд биет болон

	биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлэх үүргийг тусгайлсан хуулиар зохицуулав.
9.1.5.үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, гадаад аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;	Гарааны бизнесийн амжилтын гол хүчин зүйлийн нэг бол гарааны бизнесийн санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэлэг байдал (инновац), ялгагдах онцлог, оновчтой сурталчилгаа, хөрөнгө оруулагч, хангалттай хэмжээний санхүүжилт олсон байдал, гарааны бизнесийн төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай, харилцан туслалцаж ажиллах түншүүд хэмээн тодорхойлсон байдаг. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.5.8-д “Гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлд шаардлагатай технологийн инновацын талаарх мэдээлэл авах, олон улсын үзэсгэлэн, яармаг болон бизнес уулзалтууд зохион байгуулах замаар хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлнэ.” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.7 дахь заалтын 3-т “Инноваци, мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дижитал эдийн засгийг хөгжүүлэх”-ийг хуучнаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт буюу тус газрыг өөрчлөн байгуулсан Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд даалгасан. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих талаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.8-д “Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ.” гэж, 3.6.1.9-д “Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон эдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.” гэж тус тус заасны дагуу цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн

	төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудлын хүрээн дэх Мэдээллийн технологийн үндэсний парк нь дотоодын мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулж экспортод гаргах боломжийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаадын аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр холбогдох зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн гадаад улсын туршлагаас харахад Турк Улсын Эдийн засгийн яам нь болж буй үзэсгэлэн худалдааг сурталчлахтай холбоотой зардлын 50 хувийг нөхөн төлдөг. Мөн яам нь олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцох, зах зээлийн судалгаа, гадаадад гарах, гадаадад брэндийг сурталчлах, экспорттой холбоотой бусад олон үйл ажиллагааг дэмжин ажилладаг байна.
9.1.6.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авахад шаардлагатай нэг цонхны бүртгэлийн системийг хариуцан ажиллуулах;	"Төрийн байгууллага нь төрийн бус байгууллагуудтай хамтран төсвийн хөрөнгөөр мэдээллийн технологийн худалдан авалт хийхдээ нэн тэргүүнд дотоодын компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор компаниудын хөгжүүлсэн программ хангамжийн бүтээгдэхүүний клауд орчинд ажиллах дэд бүтцийг бий болгох шаардлагатай www.mindgolia.mn платформыг бүтээсэн бөгөөд энэ талаарх суурь эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Уг нэг цонхыг төрийн худалдан авалтын www.tender.gov.mn системийн "цахим дэлгүүр"-тэй холбож, төрийн байгууллагад шаардлагатай зарим программ хангамжийг байршуулахаар зохицуулсан бөгөөд Мэдээллийн технологийн үндэсний парк нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах хүрээнд хүн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг уг нэг цонхонд бүртгэхээр тусгасан.
9.1.7.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдэд зориулан инкубатор, хамтын оффис ажиллуулах, инкубаторт элсэх хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох;	Монгол улсын мэдээллийн технологийн гарааны бизнесийг үүсэл хөгжлийн хувьд авч үзвэл, 2003 онд Мэдээлэл технологийн үндэсний парк нь "Мэдээллийн технологийн салбарын шинэ санаа, санаачилгыг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ хэрэгцээг эрж олох, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниуд болон бизнес эхлэн эрхлэгчдэд урамшууллын таатай орчин бүрдүүлэн ололт амжилт, өсөлтийг нь

	хурдасгахад цаг хугацааны болон хөрөнгө оруулалт, менежментийн бусад иж бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон, дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болох эхний чадавхтай болтол нь торниулан бойжуулах” зорилготой, программ хангамжийн чиглэлээр бизнес эрхлэгчдийг элсүүлэх бодлого барьж, “Мэдээллийн технологийн инкубаторт элсэх иргэн ба компаниудыг сонгон шалгаруулах журам” боловсруулан баталсан. Тус журам батлагдсанаар анх 2003 оны 9 сард инкубаторын анхны элсэлтийг зохион байгуулж, нийт 23 аж ахуйн нэгж, хувь хүн хүсэлт гаргаснаас, 11 аж ахуйн нэгж болон 2 иргэнийг сонгон шалгаруулж элсүүлсэн. 2022 оны байдлаар инкубаторт бойжиж буй 12 компанийн үйл ажиллагааны чиглэлийн хувьд контент хөгжүүлэлт 58%, сошиал маркетинг 23%, аппликэйшн хөгжүүлэлт 10%, систем хөгжүүлэлт 9% байна. "Мэдээллийн технологийн үндэсний парк" төрийн өмчид аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 60 дугаар тогтоолын хавсралтаар баталсан байдаг хэдий ч практикт хэрэгжих боломж, эрх зүйн зохицуулалтын давуу хүчинтэй хэрэгжих боломжийг нь харгалзан технологийн гарааны бизнесийн экосистемийг дэмжих мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг төлөвшүүлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх байгууллагын үүргийг тодорхой болгож, явуулах үйл ажиллагааны талаар тусгайлсан хуулиар зохицуулах шаардлагатай байна.
9.1.8.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;	Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн виртуал бүс байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалтын талаар тусгасан. Монгол улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн виртуал бүс байгуулах тоо, байршлыг Улсын Их Хурал тогтоох бөгөөд виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллахаар, Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтоож, Зөвлөлийн

	үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий орон тооны Ажлын албатай байхаар тусгаж, уг ажлын албаны чиг үүргийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихаар заасны дагуу нэмж бүтэц, орон тоо бий болгохгүйгээр Мэдээллийн технологийн үндэсний парк хариуцан гүйцэтгэхээр тусгасан.
9.1.9.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;	Хуулийн төслийн 9.1.8-д заасны дагуу Ажлын алба нь Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг гүйцэтгэхээр заасан бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Зөвлөлийн дарга, хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах, түүний хэрэгжилт, виртуал бүсийн үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтын талаар Зөвлөлд танилцуулахаар тусгасан. Мөн виртуал бүсийн үйл ажиллагаатай холбоотой иргэнийн эрх зүйн болон захиргааны гэрээ байгуулах, виртуал бүсийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, сайн туршлагыг нэвтрүүлэх талаар тогтмол судалж, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, хөрөнгө оруулагч, хүн, хуулийн этгээдтэй харилцах, хамтран ажиллах талаар зохицуулсан. Гэрээ, хэлцэл байгуулахад энэ хууль болон Иргэний хуулийн нийтлэг зарчим үйлчилнэ.
9.1.10.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	Гарааны компанийг төлөвшүүлэх, бойжуулах талаар гадаад орны туршлагыг харвал өмнөд Солонгос нь дэлхийн шилдэг технологийн корпорацуудыг байгуулж, мөн Courang цахим худалдааны сайт зэрэг технологийн тэрбум долларын үнэлгээтэй гарааны бизнес бий болгосон туршлагатай улс юм. Тус улсын хамгийн том давуу тал нь Samsung, LG зэрэг компаниуд нь тус улсыг үйлдвэрлэл, техник хангамжийн инженерчлэл шаарддаг салбаруудад тэргүүлэх байр суурь эзэлдэг. Мөн эдгээр томоохон компаниуд дотоодын бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалт, дэмжлэг үзүүлдэг. Жишээлбэл, 2023 онд Гванжу хотод хиймэл оюун ухааны гарааны бизнесийн инкубатор нээгдсэн ба үүнд Samsung компани дэмжлэг

	үзүүлсэн. Олон улсын компаниуд ч мөн Өмнөд Солонгосын гарааны бизнесийн чадавхыг хүлээн зөвшөөрч, Google Кампус, Facebook-ийн дэмжлэгтэй Солонгосын Инновацын лаборатори зэрэг санаачилгын үйл ажиллагааг эхлүүлээд байна. Мөн олон улсын компаниуд гарааны бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалт хийхдээ тухай хуулийн этгээдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон зах зээлийн үнэлгээг чухалчлан авч үздэг тул үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгасан.
9.1.11.гадаад болон дотоодын зах зээлд нийлүүлэх мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ангилал, төрөл, зориулалт, зохиогчийн эрх болон бусад нэмэлт мэдээллийн хамт бүртгэх.	
10 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэл	
10.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл санаачлах, хэрэгжүүлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.	Монгол улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна. Үүний нэг арга зам нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэл буюу мэдээллийн технологийн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн орчныг бий болгох бөгөөд энэ нь шинэ мэдлэг, технологийг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглах замаар нийгмийн баялаг бүтээх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа идэвхжин мэдээллийн технологийн гарааны бизнесийг олноор бий болж шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа сайжирч, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, Монгол Улсад ажлын байр шинээр бий болгох, судалгаа ба хөгжүүлэлт, инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэх юм.
10.2.Төрийн байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой дараах зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно: 10.2.1.төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах;	


Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “3.2 Эдийн засгийн аюулгүй байдал” болон “3.6.Мэдээллийн аюулгүй байдал” хэсгийн дараах зорилтуудыг хангах боломжийг бүрдүүлнэ. 3.2.1.2.Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. 3.2.1.5.Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ. 3.2.1.8.Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ. 3.6.1.9.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.” гэж тус тус тусгажээ. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Тус зорилгын хүрээнд 4.2 зорилтын 1-р үе шат буюу 2021-2030 онд онцлон хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгохоор 10 чиглэлийг “Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд” хэмээн тодорхойлсноос “5.Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт

оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.” гэж тусгажээ. Мөн түүнчлэн эдгээр 10 чиглэлд заасан салбаруудыг 2021 оноос 2030 оны хооронд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе гэж заасан. Харин 2.4-р зорилт нь “Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх алхмуудад: “1.Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна. 2. Шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна.” тус тус хүрэх үр дүнг тодорхойлжээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх 2 дугаар үе шат буюу 2031 оноос 2040 оны хооронд үндэсний шинжлэх ухаан, инновацыг дэлхийн зах зээлд гаргах тогтолцоог бүрдүүлэх үе бөгөөд “1.Нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэнэ.” гэсэн үр дүнг дэвшүүлжээ. Зорилт 2.6-д “Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн байх үр дүнд “2.Олон улсад оюуны бүтээл, мэдээллийн технологийн болон зөвлөх үйлчилгээг дэмжих зуучлагч компани, төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.” гэж, Зорилт 7.5-д “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.” гэж заасан бөгөөд тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн байх үр дүнд “1.Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг хөгжүүлэн, инновац нэвтрүүлж, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжсөн байна.”

	гэж, 3 дугаар үе шат буюу 2041 оноос 2050 онд хүрэх үр дүнд “Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацыг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе.” гэж тус тус заажээ
10.2.2.энэ хуулийн 8.1.5-д заасан бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;	Цахим хөгжлийн багц хууль батлагдаж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэгт “Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүх салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болох” талаар зохицуулалтууд тусаж, мэдээлэл харилцаа холбооны дэд бүтэц тоон технологид шилжиж, манай улсын нийт 330 сум шилэн кабелийн сүлжээгээр холбогдсон бөгөөд бүх сум суурин газарт интернэтийн үйлчилгээг хүргээд байна. Хэдий дээрх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж байгаа ч Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнд бүх нийтийн цахим ур чадварын үзүүлэлт эрэгтэйд 30%, эмэгтэйд 32%, дундаж үзүүлэлтээр 31% гэж тодорхойлогджээ. Харин Үндэсний Статистикийн хороо, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 онд хамтран хэрэгжүүлсэн “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ” судалгаанд оролцогчдын сүүлийн 3 сард ашигласан мэдээллийн технологийн хэрэглээнд тулгуурлан үр дүнг гаргасан. Нийт судалгаанд оролцогчдын 43.8% нь мэдээллийн ур чадвартай, 38.8% нь харилцаа холбооны ур чадвартай, 27% нь асуудал шийдвэрлэх ур чадвартай, 9.8% нь программ хангамжийн ур чадвартай, 6.4% нь аюулгүй байдлын ур чадвартай гэж үнэлэгдсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 42%-тай байна. Иймд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүх нийтийн мэдээллийн технологийн хэрэглээ, цахим ур чадварыг бодитойгоор үнэлж, олон нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, тоон хуваагдлыг

	бууруулахад чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар тусгасан.
10.2.3.энэ хуулийн 8.1.6-д заасан мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх.	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” зорилтын хүрээнд 2021-2030 он хүртэл мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх талаар 2.1.28-д “Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ” гэж, 2.6.8-д “Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж, 7.5.5-д “Цахим мэдээллийг ангилах, тодорхойлох, үнэлэх, төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх талаар холбогдох хууль, дүрэм, журамд тусган онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудад цахим халдлагатай тэмцэх баг бий болгож мэргэшсэн хүний нөөц бэлтгэж, хөгжүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.3.12.7-д “Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх ажилд дэмжлэг үзүүлэх” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19 дэх заалтад “мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал” нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудалд хамаарахаар заасан тул цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн

	төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн технологийн боловсон хүчний нөөц, ажиллах хүчний зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг жил бүр хийж, хүний нөөцийн дутагдлыг багасгахад чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихээр тусгасан. Гадаад улс орны туршлагаас харахад Бүгд Найрамдах Турк Улс нь 2023 онд “Үндэсний технологи, хүчирхэг үйлдвэрлэл” гэсэн алсын хараатай стратегийн баримт бичгийг боловсруулсан ба тус баримт бичиг нь (i) Өндөр технологи ба инновац, (ii) Дижитал шилжилт ба аж үйлдвэрийн хөдөлгөөн, (iii) Бизнес эрхлэлт, (iv) Хүмүүн капитал, (v) Дэд бүтэц гэсэн хэсгээс бүрдэж, Турк улс даяар программ хангамж хөгжүүлэгчдийн тоог 140 мянгаас 500 мянгад хүргэх зорилт дэвшүүлж, хүний нөөцийн бодлогод анхаарч байна.
ГУРАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ВИРТУАЛ БҮС	
11 дүгээр зүйл. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс	
11.1. Монгол Улс нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс (цаашид “виртуал бүс” гэх)-тэй байна.	Өнөөгийн эдийн засагт инновац болон мэдээллийн технологийн үйлдвэрлэл нь улс орны эдийн засгийн хөгжлийн тулгуур болж байна. Мэдээллийн технологийн хөгжил нь инновацыг идэвхжүүлж, тухайн салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ашиг тус, үр шимээ өгч дижитал эдийн засгийг бий болгон, энэ нь нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, бүтээмжийг нэмэгдүүлэн өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийг авчирч байна. Дотоодын 109 аж ахуйн нэгжээс авсан судалгаагаар хамрагдсан нийт компаниудын 90.8 хувь нь Монгол Улсад мэдээллийн технологийн гарааны бизнесийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулахыг дэмжсэн бол 2.5 хувь нь дэмжихгүй, 5.5 хувь нь сайн мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн байна. <i>График. Хуулийн төслийн санаачилгыг дэмжих байдал</i>



Бусад орны туршлагаас харвал, Бүгд Найрамдах Казахстан Улсын Мэдээлэл, харилцаа холбооны сайдын 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн "Астана хаб" олон улсын технологийн паркийн үйл ажиллагааны дүрмийг батлах тухай 415 дугаар тушаалд заасны дагуу хэрэгжилтийг хангах асуудлыг тус улсын Мэдээлэл, харилцаа холбооны дэд сайдад үүрэг болгосон. Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хуулийн Астанагийн олон улсын санхүүгийн төвийн удирдлагын тухай "Төвийн менежерийг Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө." гэж заасан. Түүнчлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжооос дурдвал, Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Монгол Улсад чөлөөт бүс байгуулах, түүний байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааны чиглэл, төрлийг тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ." гэж, Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д "Дагуул хотыг стратегийн ач холбогдол бүхий дараах нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулна:" гэж, мөн хуулийн 38.1-д "Нийслэл хот нь эдийн засгийн тусгай бүс /цаашид "тусгай бүс" гэх/-тэй байж болно. Тусгай бүсийг дагуул хотод Засгийн газрын шийдвэрээр байгуулна." гэж тус тус заасныг жишиг болгон Засгийн газраас мэдээллийн технологийн виртуал бүс байгуулах саналаа Улсын Их Хуралд мэдүүлж, шийдвэр гаргахаар тусгасан. Иймд ойролцоо төрлийн харилцаа зохицуулахдаа бусад

	хуульд хэрхэн тусгасан байдал болон бусад улс орны туршлагыг үндэслэн дээр дурдсан хууль тогтоомжид заасан чөлөөт бүс, дагуул хот, виртуал бүсэд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулж, Монгол Улсын Их Хурал уг виртуал бүсийн байршил, тоог тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан.
11.2.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.	Виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг ажиллуулах эрх зүйн үндэслэлийг тодорхойлохдоо олон улсын туршлагыг харгалзан үзэж, тэр дундаа Бүгд Найрамдах Казахстан улсын мэдээллийн технологийн салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээг судалж, “Бүгд Найрамдах Казахстан Улсын 2025 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө”-ний хүрээнд шинэ эдийн засгийн тулгуур суурийг бий болгох, технологийн шинэчлэл, үйлдвэрлэлийг цахимжуулах тэргүүлэх чиглэлийг тодорхойлж байгаа байдлыг хуулийн төслийн зохицуулалтад тусгахад чиглэсэн болно. Казахстан Улсын Астанагийн олон улсын санхүүгийн төвийн менежментийн зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 20-27/1814 дугаартай шийдвэрээр тус төвийн бүтцийг тодорхойлсон бөгөөд тус санхүүгийн төв нь менежментийн зөвлөлтэй байхаар заасан бөгөөд уг зөвлөл нь Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчөөр ахлуулсан байнгын ажиллагаатай хамтын удирдлагын байгууллага юм. Зөвлөл нь санхүүгийн төвийг хөгжүүлэх стратегийн чиглэлийг тодорхойлж, олон улсын санхүүгийн тэргүүлэх төв болгон байгуулах таатай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилладаг. Тус зөвлөл нь олон улсын санхүүгийн төвийн актуудыг батлах, байгууллагуудын бүтэц, төв дэх хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн бүрэлдэхүүн, олон улсын арбитрын төвийг байгуулах үндэслэлийг тодорхойлох, үйл ажиллагааны жилийн тайланг батлах зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг. Түүнчлэн Узбекистан Улсын Засгийн газар тунхаглал гаргах, стратеги боловсруулах, инновац, энтрепренёршипыг дэмжих чиглэлээр хууль тогтоомж гаргахаар идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд Инновацийн ач холбогдлыг онцолж, 2018 оныг Засгийн газраас “Идэвхтэй энтрепренёршип,

	инновацлаг санаа, технологийг дэмжих жил” болгон зарласан. Мөн онд 2019-2021 оны Инновацын хөгжлийн стратегийг баталсан юм. Стратегийн гол зорилго нь инновац, дэлхийн өрсөлдөх чадварыг тодорхойлоход гол хүчин зүйл болох хүмүүн капиталыг дэмжих, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Уг стратегийн үргэлжлэл болгон 2022 оны 7-р сард 2022-2026 оны Инновацын хөгжлийн стратегийг баталсан. Уг стратеги нь дараах үндсэн зургаан чиглэлээр дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэж байна. Үүнд, нэгдүгээрт, 1413 ажлын байр бий болгох 122 гарааны бизнесийн төсөлд 75 тэрбум сумын санхүүжилт олгоно. Хоёрдугаарт, гарааны бизнесийг технологийн парк, эдийн засгийн тусгай бүсэд байршуулахыг дэмжиж, хувийн хэвшлийнхнийг шинжлэх ухааны хөгжлийг дэмжих сонирхлыг нэмэгдүүлж, хамтран санхүүжүүлэхийг дэмжинэ. Гуравдугаарт, инновацын технологийн парк, технологи дамжуулах төв, инновацын кластер, венчур байгууллага, инновацын төв, инкубатор, хурдасгуур зэрэг шинэлэг дэд бүтцийн төслүүдийн сүлжээг хэрэгжүүлнэ. Дөрөвдүгээрт, хурдасгуур хөтөлбөр, ложистик, санхүүжилтийн үйлчилгээ, зах зээлд нэвтрүүлэх, технологи дамжуулах төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх зэрэг инновацыг дэмжихэд дэмжлэг үзүүлнэ. Тавдугаарт, гарааны бизнест зориулсан орчин үеийн санхүүжилтийн механизмыг (венчур капитал, олон нийтийн санхүүжилт гэх мэт) хөгжүүлэх, хялбаршуулсан санхүүжилтийн үйл ажиллагааг өрсөлдөөнт орчинд ("ирээдүйн эрдэмтэн", хакатон, технологийн марафон гэх мэт) өргөжүүлэхэд хүчин чармайлт гаргана. Зургаадугаарт, инновацлаг технологийн парк, эдийн засгийн чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрөл олгох журамтай хамт татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлнэ гэж тусгасан. Иймд виртуал бүсийг бий болгохтой холбоотой харилцааг хуулийн төсөлд тусгаж, хамтын удирдлагын байгууллага үйл ажиллагаандаа сайн засаглалыг нэвтрүүлэх, үр дүн тооцогдохуйц, ил тод байх зарчмыг бүрдүүлэх зорилгоор виртуал бүс нь орон тооны бус зөвлөлтэй байхаар зохицуулсан.
11.3.Зөвлөлийн дарга нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 19 дэх заалтад "...мэдээллийн технологийн бодлого, зохицуулалт,

Засгийн газрын гишүүн байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн болон мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

цахим засаглал, салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, мэдээллийн технологийн салбарын инновацыг хөгжүүлэх, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал" нь цахим хөгжил, харилцаа холбооны Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар заасан. Түүнчлэн Бүгд Найрамдах Казахстан Улсын Мэдээлэл, харилцаа холбооны сайдын 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн "Астана хаб" олон улсын технологийн паркийн үйл ажиллагааны дүрмийг батлах тухай 415 дугаар тушаалд заасны дагуу хэрэгжилтийг хангах асуудлыг тус улсын Мэдээлэл, харилцаа холбооны дэд сайдад үүрэг болгосон зэргийг харгалзан Зөвлөлийн дарга нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар тусгасан.

Хуулийн төслийн 12, 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу виртуал бүсэд визийн, хуулийн этгээдийн бүртгэлийн, валют зохицуулалтын, хөдөлмөр эрхлэлтийн, татварын болон бусад дэглэм үйлчлэхээр заасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 8 дахь заалтад "...төсвийн орлого, зарлага, гааль, татвар, даатгалын бодлого, төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа" нь Сангийн сайдын, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 7 дахь заалтад "...гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн талаарх хамтын ажиллагаа, гадаад эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа" нь Гадаад харилцааны сайдын, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 9 дэх заалтад "...энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал" нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 17 дахь заалтад "...хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын өртгийн талаарх асуудал, Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал" нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус тус хамаарахаар заасан тул Зөвлөлийн

	бүрэлдэхүүнд эрхлэх асуудлын хүрээнээс хамааруулан холбогдох байгууллагын төлөөллийг оруулсан болно.
11.4.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Зөвлөлийн шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.	Хуулийн төсөлд виртуал бүс нь хамтын удирдлагын байгууллага болох орон тооны бус зөвлөлтэй байхаар тусгасан бөгөөд Зөвлөлийн үйл ажиллагаанд сайн засаглалыг нэвтрүүлэх, үр дүнг тооцож, ил тод байх зарчмыг бүрдүүлэх үүднээс виртуал бүсийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө буюу хэрэгжүүлэх арга хэмжээ, виртуал бүсийн ирээдүйн хөгжлийг тодорхойлсон хөтөлбөр, виртуал бүсийн үйл ажиллагаанд зарцуулах төсвийн төслийг хэлэлцэх, батлах, мөн виртуал бүсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж гаргах, виртуал бүсийн дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг хэлэлцэж батлахаар, виртуал бүсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэхээр тусгасан. Зөвлөлийн шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байхаар зохицуулсан.
11.5.Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Зөвлөлийн гүйцэтгэж байгаа чиг үүргийн талаар гадаад орны туршлагаас дурдвал, Казахстан Улсын Астанагийн олон улсын санхүүгийн төвийн менежментийн зөвлөлийн 2016 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 20-27/1814 дугаартай шийдвэрээр тус төвийн бүтэц, үйл ажиллагааг тодорхойлсон бөгөөд тус санхүүгийн төв нь менежментийн зөвлөлтэй байхаар заасан бөгөөд уг зөвлөл нь Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчөөр ахлуулсан байнгын ажиллагаатай хамтын удирдлагын байгууллага юм. Зөвлөл нь санхүүгийн төвийг хөгжүүлэх стратегийн чиглэлийг тодорхойлж, олон улсын санхүүгийн тэргүүлэх төв болгон байгуулах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилладаг. Тус зөвлөл нь олон улсын санхүүгийн төвийн актуудыг батлах, байгууллагуудын бүтэц, төв дэх хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн бүрэлдэхүүн, олон улсын арбитрын төвийг байгуулах үндэслэлийг тодорхойлох, үйл ажиллагааны жилийн тайланг батлах зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг.
11.5.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэн батлах;	
11.5.2.виртуал бүсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, зөвлөмж гаргах;	
11.5.3.Ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, чиглэл өгөх.	
11.6.Зөвлөлийн бүрэлдэхүүн, Зөвлөлийн болон виртуал бүсийн ажиллах журмыг Засгийн газар тогтооно.	Хуулийн төслийн 11.3 дахь хэсэгт Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн болон мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн,

11.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байна.	хэрэглэгчийн төлөө газар, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэхээр заасан. Мөн Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын хавсралтаар Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталдаг жишгийг харгалзан Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газрын шийдвэрээр тогтоож, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй байхаар заасан.
12 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэх, бүртгэлээс хасах	
12.1.Ажлын алба нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд (цаашид “хуулийн этгээд” гэх)-ээс цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 өдрийн дотор хянаж, дараах шаардлагыг хангасан тохиолдолд виртуал бүсэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.6-д заасан Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр бүртгэж, хариу мэдэгдэнэ:	Гадаадын болон дотоодын хуулийн этгээд нь виртуал бүсэд мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтийг Зөвлөлийн Ажлын албанд буюу хуулийн төслийн 9.1-д заасан мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг төлөвшүүлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх байгууллага буюу Мэдээллийн технологийн үндэсний паркт ирүүлсний дагуу шаардлага хангасан хуулийн этгээдийг төрийн үйлчилгээний нэгдсэн системээр бүртгэж хариу мэдэгдэх зохицуулалтыг тусгасан.
12.1.1.хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл;	Хуулийн этгээд нь виртуал бүсэд мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэхдээ дэлгэрэнгүй танилцуулга буюу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасан хуулийн этгээдийн нэр, регистрийн болон хувийн хэргийн дугаар, хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг, хуулийн этгээдийг шинээр байгуулах, эсхүл өөрчлөн байгуулах, татан буулгах тухай, үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл, үүсгэн байгуулах баримт бичиг, өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын талаар, хуулийн этгээдийн
12.1.2.Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;	
12.1.3.эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлан.	

	мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр, компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, гадаадын иргэн бол паспортын хуулбар, хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын албан ёсны хаяг, эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээдийн эрх барих этгээдийн гишүүдийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл, бизнесийн үйл ажиллагааны зорилго, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг ирүүлэхээр тусгасан.
12.2.Ажлын алба нь виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр гэрээ байгуулна. Гэрээний загварыг Зөвлөл батална.	Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бусад улсын туршлагаас харвал тодорхой бүсийг сонгон авч, тус бүсэд онцгой дэглэм тогтоох замаар дэмжлэгийг хэрэгжүүлж, дотоодын зах зээл, чөлөөт өрсөлдөөнийг хамгаалж байна. Тодорхой бүс үүсгэх нь өндөр мэдлэг, ур чадвартай хүний нөөцийн төвлөрлийг бий болгож бизнес эрхлэгчид хамтрах, кластер болон хөгжихөд тустай. Гарааны бизнес буюу технологийн салбарын жижиг, дунд бизнесийг төрөөс дэмжих нь бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэхээс эхэлнэ. Өөрөөр хэлбэл компани байгуулах, компани өөрчлөх буюу хөрөнгө оруулагч нэмэх, хасах үйл ажиллагаа хялбар байхаас эхлээд холбогдох бүртгэл, зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, цуцлах зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээ хамгийн хялбар, шуурхай, хүнд сурталгүй, цахим хэлбэртэй байх шаардлагатай тул гэрээг цахимаар байгуулахаар, гэрээний загварыг Зөвлөл батлахаар зохицуулсан.
12.3.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн нэр, эцсийн өмчлөгчийн мэдээллийг нээлттэй, ил тод байршуулна.	Виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллахаар, Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтоож, Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэг бүхий орон тооны Ажлын албатай байхаар тусгаж, уг ажлын албаны чиг үүргийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд

	санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихаар заасан.
12.4.Ажлын алба нь бүртгэлтэй хуулийн этгээдийг дараах үндэслэлээр бүртгэлээс хасна:	Хуулийн төслийн 12.1.1-д заасны дагуу хуулийн этгээд нь виртуал бүсэд мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэхдээ дэлгэрэнгүй танилцуулга буюу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасан хуулийн этгээдийн нэр, регистрийн болон хувийн хэргийн дугаар, хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг, хуулийн этгээдийг шинээр байгуулах, эсхүл өөрчлөн байгуулах, татан буулгах тухай, үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл, үүсгэн байгуулах баримт бичиг, өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын талаар, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр, компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, гадаадын иргэн бол паспортын хуулбар, хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын албан ёсны хаяг, эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар, хуулийн этгээдийн эрх барих этгээдийн гишүүдийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл, хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл, бизнесийн үйл ажиллагааны зорилго, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг ирүүлэхээр тусгасан. Мөн Ажлын алба нь виртуал бүсийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл байгуулахаар заасны дагуу бүртгүүлсэн хуулийн этгээдтэй мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх этгээдтэй гэрээ байгуулж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх талаар тусгана. Иймд бүртгэлтэй хуулийн этгээд нь гэрээ, хуулийн
12.4.1.виртуал бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлээгүй;	
12.4.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс бусад төрлийн үйл ажиллагааг виртуал бүсээр дамжуулан эрхэлсэн;	
12.4.3.гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;	
12.4.4.Иргэний хуулийн 32.1-д заасны дагуу татан буулгасан.	


	этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон баримт бичигт дурдсан мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлээгүй, эсхүл бүртгүүлснээс хойш тодорхой хугацааны туршид мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон, мөн татан буулгах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд бүртгэлээс хасахаар тусгасан.
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ВИРТУАЛ БҮСЭД БҮРТГҮҮЛСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ	
13 дугаар зүйл.Татварын болон татварын бус дэмжлэг	
13.1.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээд нь санхүүгийн болон татварын тайланг холбогдох журмын дагуу гаргаж, Ажлын албанд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.	Хуулийн төсөлд виртуал бүс нь хамтын удирдлагын байгууллага болох орон тооны бус зөвлөлтэй байхаар тусгасан бөгөөд Зөвлөлийн үйл ажиллагаанд сайн засаглалыг нэвтрүүлэх, үр дүнг тооцож, ил тод байх зарчмыг бүрдүүлэх үүднээс виртуал бүсийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө буюу хэрэгжүүлэх арга хэмжээ, виртуал бүсийн ирээдүйн хөгжлийг тодорхойлсон хөтөлбөр, виртуал бүсийн үйл ажиллагаанд зарцуулах төсвийн төслийг хэлэлцэх, батлах, мөн виртуал бүсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж гаргах, виртуал бүсийн дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг хэлэлцэж батлахаар, виртуал бүсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэхээр тусгасан.
13.2.Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын дэмжлэгийг холбогдох хуульд заасны дагуу үзүүлнэ.	Гадаад улс орнуудын чөлөөт бүсийн зохицуулалтын туршлагаас харахад Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд Мэдээлэл, харилцаа холбооны сайдын 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 415 дугаар тушаалаар "Астана хаб" олон улсын технологийн паркийн үйл ажиллагааны дүрмийг баталж, тус улсын Үндсэн хуулийн хуулийн 9, 10 дугаар зүйлийг үндэслэн 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдөр "Астанагийн олон улсын санхүүгийн төвийн тухай" (АОУСТ) хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн ба үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг өөрийн дүрмээрээ зохицуулдаг. Уг Технопаркийн оролцогчоор бүртгүүлсэн өргөдөл гаргагч нь Бүгд Найрамдах Казахстан Улсын хуулийн Татвар ба төсөвт төлөх бусад төлбөрийн тухай хуулийн 461

	дүгээр зүйлд заасны дагуу онцгой албан татвар төлөгч болохгүй байхаар тогтоосон. Мөн Астанагийн олон улсын санхүүгийн төвд санхүүгийн болон бусад мэргэшлийн үйл ажиллагаа явуулснаас олсон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 50 жилийн хугацаанд чөлөөлөхөөр, мөн уг төвд арилжаалагдсан үнэт цаасны борлуулалтын хөрөнгийг 50 жилийн хугацаанд ашгийн татвараас чөлөөлөхөөр, түүнчлэн тус төвд арилжаалагдсан үнэт цаасны борлуулалтын ногдол ашгийн орлогоос хувь хүний орлогын албан татварыг 50 жилийн хугацаанд чөлөөлөх татварын хөнгөлөлтийг олгохоор тусгасан. Уг төвд татварын дэмжлэгээс гадна татварын бус бусад дэмжлэгийг санал болгодог бөгөөд зарим улс орноос тухайлбал, АНУ, Их Британи, Канад, Герман, Швейцарь, Нидерланд, Сингапур, Малайз зэрэг богино хугацаанд ирж байгаа иргэнийг 30 хоногийн хугацаанд визээс чөлөөлөх, Санхүүгийн төвд ажиллах гадаадын ажиллах хүчийг ажиллах хүчний төлбөрөөс чөлөөлөх, мөн 5 жилийн оршин суух визээс чөлөөлөхөөр тус тус зохицуулжээ. Бүгд Найрамдах Турк Улс нь "Технологийг хөгжүүлэх бүсийн тухай хууль"-ийг 2016-нд батлагдаж, 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд нарийвчилсан харилцааг "Технологийг хөгжүүлэх бүсийг хэрэгжүүлэх журам"-аар зохицуулж байна. Тус журмын зорилго нь Технологийн хөгжлийн бүс байгуулах, ажиллуулах, удирдах, хяналт тавих, тэдгээртэй холбоотой оролцогч тал, байгууллагын үүрэг, эрх, үүрэг болон Технологийг хөгжүүлэх бүсийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад журам, зарчмыг зохицуулж байна. Технологи хөгжүүлэлтийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг програм хангамжийн хөгжүүлэлт, судалгаа хөгжүүлэлт, дизайны үйл ажиллагаанаас олсон ашгийг 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр, чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн хэрэглээний программ хангамж (тодорхой судалгаа, хөгжлийн үйл ажиллагаанд зориулан)-ийг нийлүүлсэн тохиолдолд 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл НӨАТ-аас чөлөөлөхөөр, чөлөөт бүсэд ажиллаж буй судлаач, программ хангамж, судалгаа, хөгжүүлэлт, дизайны ажилтнуудын цалинг 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл
--	---

	хугацаанд хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөхөөр, ажил олгогч төрөөс нөхөн олговор авах боломжтой байхаар заасан. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Сайд нарын танхимын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Программ хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн технологийн парк байгуулах арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолд заасны дагуу технопаркийн оршин суугч нь Татварын хуулийн 297 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт заасан үйл ажиллагаанаас нийтээр тогтоосон татварыг төлж, хуулийн 1, 9, 16, 18 дугаар зүйлд заасны дагуу орлогын хувийг буцаан авах эрхтэй байхаар зохицуулсан. Мөн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд бүх татвараас чөлөөлөгдөхөөр заасан. Ийнхүү мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн виртуал бүсэд бүртгүүлсэн гадаадын болон дотоодын хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлж байгаа олон улсын туршлагыг жишгийн дагуу энэ талаарх зохицуулалтыг тусгалаа.
13.3.Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх дараах татварын бус дэмжлэг үзүүлнэ:	Гарааны бизнест зээл бус харин тэвчээртэй хөрөнгө оруулагчид чухал үүрэгтэй байдаг бөгөөд гарааны бизнесүүд эхний шатандаа бага эсвэл огт орлогогүй байдгаас олон жилийн турш алдагдалтай ажилладаг. Жишээ нь, Твиттер 2006 онд байгуулагдсан цагаасаа эхлээд 2017 оныг хүртэл алдагдалтай ажиллаж байсан. Тиймээс гарааны бизнесүүдэд зээл олгохоос илүүтэй өөрийн хөрөнгө, буцалтгүй тусламжийн санхүүжилт илүү тохиромжтой гэж улс орнууд үзэж байна. Өөрөөр хэлбэл, ирээдүйтэй санаануудыг эхний шатанд буцалтгүй тусламжаар дэмжих нь үр дүнтэй. Олон засгийн газрууд буцалтгүй тусламж хэлбэрээр гарааны бизнесийн үйл ажиллагааг дэмжиж байна. Монгол Улсын хувьд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат буюу 2021-2030 онуудад эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 10 үр дүнг
13.3.1.мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгох;	
13.3.2.экспортод чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн грант олгох;	

жагсаасны 5-д “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна” гэж, Монгол Улсын Их Хурал 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт дэвшүүлсний “Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ засаглалын бодлогын хүрээнд мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилт тодорхойлсон. Гарааны бизнес буюу технологийн салбарын жижиг, дунд бизнесийг төрөөс дэмжих нь бизнес эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэхээс эхлэнэ. Өөрөөр хэлбэл компани байгуулах, компани өөрчлөх буюу хөрөнгө оруулагч нэмэх, хасах үйл ажиллагаа хялбар байхаас эхлээд холбогдох бүртгэл, зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, цуцлах зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээ хамгийн хялбар, шуурхай, хүнд сурталгүй, цахим хэлбэртэй байх шаардлагатайг онцолсон. Технологийн салбарыг дэмжсэн таатай орчныг бүрдүүлснээр гарах үр дүн, хүлээлтийг тодорхойлохдоо,


График. Мэдээллийн технологийн салбарын бизнес эрхлэгчдийн хүлээлт



Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар Монгол Улс нь гарааны бизнесийн экосистемийн хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй, гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй, инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй гэж

дурдсан байна. Түүнчлэн мэдээллийн технологийн үйл ажиллагаа идэвхитэй явуулж байгаа аж ахуй нэгжийн нэгдсэн тоон мэдээлэл, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийн ангилал тодорхойгүй байгаатай холбогдуулан Стартап маркетинг спэйс төв, гарааны бизнес эрхлэгчдийн Дриймерс нэгдлийн мэдээллийн санд үндэслэн мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа идэвхитэй явуулдаг 304 бизнес эрхлэгчдийн мэдээлэлд үндэслэн судалгаа хийсэн. Тодруулбал, тус салбарыг төлөөлөх 109 бизнес эрхлэгчийг түүврийн аргаар сонгож 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд “Гүүгл форм” веб платформыг ашиглан цахимаар судалгаа авсан ба үр дүнг нэгтгэх замаар мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан нийт 109 компанийн 65.1 хувь нь технологи хөгжүүлэлтийн компани бөгөөд эдгээр технологи хөгжүүлэлтийн компанийн 33 хувь нь финтек буюу санхүүгийн, 30.3 хувь нь эдтек буюу боловсролын, 14.7 хувь нь бүх зүйлсийн интернэт, 11.4 хувь нь блокчэйн технологи хөгжүүлэгч байсан. Судалгаанд хамрагдсан нийт компаниуд мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг 73.2 хувь нь хүний нөөцийг чадавхижуулах, 63.3 хувь нь татварын орчин сайжруулах, 55 хувь нь дэд бүтцийг хөгжүүлэх, 54.1 хувь нь хөрөнгө оруулалт гэж ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна.

График. Судалгаанд хамрагдсан компаниудын тодорхойлсон тулгамдсан асуудал



	Иймд мэдээллийн технологийн салбарын гарааны бизнесийг дэмжиж мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардал болон олон улсын чанар стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд грант олгохоор тусгасан.
13.3.3.виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох;	Оросын Холбооны Улс нь Энэтхэг болон Ирланд улсын нэгэн адил мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудыг дэмжих зорилгоор 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр 265 дугаартай “Оросын Холбооны Улсын Татварын хуулийн II хэсэгт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдсөн. Тус хуулиар 1) Нэмэгдсэн өртгийн албан татвар; 2) Хувь хүний орлогын албан татвар – Татварын төлөгчийн бүртгэл; 3) Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар - Элэгдэл, хорогдол тооцох арга, журмын холбогдох хэсгийг хүчингүй болгосон; Татварын хувь хэмжээг бууруулсан; 4) Нийгмийн даатгалын шимтгэлийг зохицуулсан тул мэдээллийн технологийн салбарыг дэмжих хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны дэмжлэгийг оновчтой тодорхойлох энэ хэсэгт жишээлж дурдсан болно. Дээрх хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах мэдээллийн технологийн компаниудад тавигдах 1) Мэдээллийн технологийн компани нь улсын магадлан итгэмжлэлд хамрагдсан байх; 2) Нийт орлогын 90 хувиас доошгүй хувийг программ хөгжүүлэлтийн үйл ажиллагаанаас олсон байх; 3) Тус хуулиар тогтоосон нийт ажилчдын тоог хангасан байх үндсэн шаардлагыг тодорхойлсон. Сингапурт гарааны компаниуд эхний 3 жилд олсон 200,000 ам.доллар хүртэлх орлогод 125,000 доллар хүртэлх хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү татварын хөнгөлөлтийг авахын тулд Сингапурт үүсгэн байгуулагдсан байх, 20 хүртэлх хувьцаа эзэмшигчтэй байх гэсэн шаардлагыг тавьдаг.
13.3.4.хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгох;	Монгол Улс нь шинжлэх ухаан, инновацын хөгжилд 2022 онд 37.7 тэрбум төгрөг зарцуулж, энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.24 хувийг эзэлж байгаа бөгөөд шинжлэх ухаан, инновацын хөгжилд зарцуулж буй дэлхийн дундаж үзүүлэлтээс даруй 7 дахин бага буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.7 хувийг эзэлж байна. Улс орнууд хиймэл оюун

ухаанд суурилсан технологийг ашиглаж эхэлснээр дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлтүүдийг авчирч байгаагаас дурдвал хиймэл оюун ухааны тусламжтайгаар дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүн 7 орчим их наяд ам.доллараар өсгөж, зардлыг хэмнэж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж байгаа тоон мэдээллүүд байгаа бөгөөд 2022 оны байдлаар дэлхийн эдийн засгийн 7 хувийг эзэлж байна. Дэлхийн томоохон судалгааны Голдман Сакс, Маккензи зэрэг компаниудын хийсэн судалгаагаар хиймэл оюун ухаан 2030 он гэхэд дэлхийн эдийн засагт 13 их наяд ам.долларын хувь нэмэр оруулж, бизнес эрхлэгчдийн 70-аас доошгүй хувь нь ядаж нэг төрлийн хиймэл оюун ухааны технологийг нэвтрүүлэн, ажлын бүтээмжийг 1.5 хувиар нэмэгдүүлэх боломжтой гэж тодорхойлсон. Мөн хиймэл оюун ухаан нь банк санхүү, бизнесийн үйл ажиллагаа, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, ногоон эдийн засгийн хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлд ихээхэн нөлөө үзүүлж байна. Тухайлбал, АНУ нь банкны зээлээс үүдэлтэй алдагдлыг 23 хувиар бууруулж, зарим салбарын хөдөлмөрийн бүтээмжийг 40 хүртэл хувь нэмэгдүүлж, цаашид 2030 он гэхэд дэлхийн хүлэмжийн хийн ялгаралтыг 4 хүртэл хувиар бууруулах боломжтой гэсэн тооцоолол гарчээ. Бүгд Найрамдах Солонгос Улс 2022 оны 6-р сард “Дижитал инновац ба тархалтын стратеги”-ийг зарлаж, Солонгосын засгийн газар дотоодын технологийг судлах, өргөжүүлэхийн тулд зургаан томоохон инновацын технологийн салбарт (жишээлбэл, хиймэл оюун ухаан, хиймэл оюун ухаан, 5G-6G, квант, мета ертөнц, кибер аюулгүй байдал) ихээхэн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Зах зээлийг эхний шатанд бий болгож, маш сайн үр дүнд хүрэхийн тулд гарааны бизнес, технологи дамжуулалт, өсөлт, гадаадад тэлэх үйл ажиллагааг төрөөс дэмжиж байна. Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар Монгол Улс нь гарааны бизнесийн экосистемийн хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй, гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй гэж дурдсан. Мөн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд “мэдээллийн технологийн компаниуд”,

“мэдээллийн технологийн энтрепренер”, “хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн үндэсний компани” гэдгийг хэрхэн ойлгох, хэрэглэх хүрээ тодорхойгүй, хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн үндэсний компанид олгох урамшууллын зохицуулалт тодорхойгүй байгаагаас Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан дунд болон урт хугацааны бодлогын бичигт дурдсан зорилтуудыг хангахад хүндрэлтэй байна. Иймд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.3.17-д “Инновацад суурилсан техник, технологийн шинэчлэлийг сайжруулж, хиймэл оюун ухааныг ашиглах чадамжийг хөгжүүлж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолоор баталсан “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 2020-2025”-д “Мэдээллийн технологи”-ийг хиймэл оюун хөгжүүлэх, хиймэл оюунд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологиор 1 дүгээрт эрэмбэлсэн бөгөөд төрөөс ложистик, тээвэр холбоо, хууль зүйн тусламж, үйлчилгээ, санхүүгийн ухаалаг үйлчилгээний чиглэлээр ажиллах хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн үндэсний компаниудыг бий болгох, тэдэнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, гадаадад ажиллаж байгаа өндөр ур чадвартай ажиллах хүчнийг тусгайлсан бодлогоор дэмжих замаар хиймэл оюуныг хөгжүүлэх, тэдгээрт суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх, төрөөс ложистик, тээвэр холбоо, хууль зүйн тусламж, үйлчилгээ, санхүүгийн ухаалаг үйлчилгээний чиглэлээр ажиллах хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн үндэсний компаниудыг бий болгох, хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн үндэсний компаниудад захиалга өгөх, бүтээгдэхүүнийг худалдан авах дэмжлэгийг Засгийн газраас үзүүлэх зорилтыг дэвшүүлсний хүрээнд хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант, буцалтгүй тусламж олгохоор тусгасан.

13.3.5.дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгох;	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат буюу 2021-2030 онуудад эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 10 үр дүнг жагсаасны 5-д “мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна” гэж, Монгол Улсын Их Хурал 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилт дэвшүүлсний “Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ засаглалын бодлогын хүрээнд мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилт тодорхойлсон. Гарааны бизнес буюу технологийн салбарын жижиг, дунд бизнесийг төрөөс дэмжих нь бизнес эрхлэхэд таатай орчныг үрдүүлэхээс эхлэнэ. Өөрөөр хэлбэл компани байгуулах, компани өөрчлөх буюу хөрөнгө оруулагч нэмэх, хасах үйл ажиллагаа хялбар байхаас эхлээд холбогдох бүртгэл, зөвшөөрөл олгох, сунгах, өөрчлөх, цуцлах зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээ хамгийн хялбар, шуурхай, хүнд сурталгүй, цахим хэлбэртэй байх шаардлагатайг онцолсон. Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар Монгол Улс нь гарааны бизнесийн экосистемийн хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй, гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй, инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй гэж дурдсан. Шинэ санаа, санаачилгууд нь зөвхөн технологийн өөрчлөлтийг бий болгох төдийгүй дэлхийн аж үйлдвэр, эдийн засгийн бүтэц, хүн төрөлхтний нийгмийн орчинд асар их өөрчлөлтийг бий болгосон. 18-р зууны үеэс аж үйлдвэрийн хэд хэдэн хувьсгалаар дамжуулан түлшинд суурилсан өсөлтийн механизм нь хүн төрөлхтний материаллаг элбэг дэлбэг байдлыг
--	--

	нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдлоос болж хүн төрөлхтний оршин тогтноход саад учруулж байна. Энэ нөхцөлд, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьслын технологийн нэгдэл нь хиймэл оюун ухаан, зүйлсийн интернэт, том өгөгдөл, гар утасны сүлжээгээр танилцуулагдсан шинжлэх ухаан технологийн хурдтай хөгжилд суурилан аж үйлдвэрийн 4 дүгээр хувьслын технологийн нэгдлийн эрин үе эхэлж байна.БНСУ нь 2022 оны 6-р сард зарласан “Дижитал инновац ба тархалтын стратеги”-ийг баталж, дотоодын технологийг судлах, өргөжүүлэхийн тулд зургаан томоохон инновацийн технологийн салбарт (жишээлбэл, хиймэл оюун ухаан, хиймэл оюун ухаан, 5G-6G, квант, мета ертөнц, кибер аюулгүй байдал) ихээхэн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна. Зах зээлийг эхний шатанд бий болгож, маш сайн үр дүнд хүрэхийн тулд гарааны бизнес, технологи дамжуулалт, өсөлт, гадаадад тэлэх үйл ажиллагааг төрөөс дэмжиж байна. Иймд Монгол Улс нь бусад улс орнуудын баримталж байгаа жишгүүдийн нэгэн адил өндөр технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгохоор тусгасан.
13.3.6.Батлан даалтын сангийн тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу зээлийн батлан даалт гаргах;	Хөрөнгө оруулалтын тухай хуульд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын дэмжлэг нь татварын болон татварын бус дэмжлэгээс бүрдэхээр заасан бөгөөд татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгт газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах; чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх, дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох, инновацийн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтэд батлан


	даалт гаргах, Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох болон хуульд заасан бусад дэмжлэгийг үзүүлэхээр заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтыг Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийцүүлэн тусгасан.
13.3.7.экспортонд гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрт судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх 1 удаагийн дэмжлэгийг дотоодын мэдээлэл технологийн гарааны бизнест олгох;	Гадаад улс орнуудын чөлөөт бүсийн зохицуулалтын туршлагаас харахад Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд Мэдээлэл, харилцаа холбооны сайдын 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 415 дугаар тушаалаар "Астана хаб" олон улсын технологийн паркийн үйл ажиллагааны дүрмийг баталж, тус улсын Үндсэн хуулийн хуулийн 9, 10 дугаар зүйлийг үндэслэн 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдөр "Астанагийн олон улсын санхүүгийн төвийн тухай" (АОУСТ) хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн ба үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг өөрийн дүрмээрээ зохицуулдаг. Уг Технопаркийн оролцогчоор бүртгүүлсэн өргөдөл гаргагч нь Бүгд Найрамдах Казахстан Улсын хуулийн Татвар ба төсөвт төлөх бусад төлбөрийн тухай хуулийн 461 дүгээр зүйлд заасны дагуу онцгой албан татвар төлөгч болохгүй байхаар тогтоосон. Мөн Астанагийн олон улсын санхүүгийн төвд санхүүгийн болон бусад мэргэшлийн үйл ажиллагаа явуулснаас олсон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 50 жилийн хугацаанд чөлөөлөхөөр, мөн уг төвд арилжаалагдсан үнэт цаасны борлуулалтын хөрөнгийг 50 жилийн хугацаанд ашгийн татвараас чөлөөлөхөөр, түүнчлэн тус төвд арилжаалагдсан үнэт цаасны борлуулалтын ногдол ашгийн орлогоос хувь хүний орлогын албан татварыг 50 жилийн хугацаанд чөлөөлөх татварын хөнгөлөлтийг олгохоор тусгасан. Уг төвд татварын дэмжлэгээс гадна татварын бус бусад дэмжлэгийг санал болгодог бөгөөд зарим улс орноос тухайлбал, АНУ, Их Британи, Канад, Герман, Швейцарь, Нидерланд, Сингапур, Малайз зэрэг богино хугацаанд ирж байгаа иргэнийг 30 хоногийн хугацаанд визээс чөлөөлөх, Санхүүгийн төвд ажиллах гадаадын ажиллах хүчийг ажиллах хүчний төлбөрөөс чөлөөлөх, мөн 5 жилийн оршин суух визээс чөлөөлөхөөр тус тус зохицуулжээ. Бүгд Найрамдах Турк Улс нь "Технологийг хөгжүүлэх бүсийн тухай
13.3.8.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүний тодорхой хувийг санхүүжүүлэх;	
13.3.9.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж гарааны компанид эд хөрөнгийн түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцох;	
13.3.11.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын 50 хүртэлх хувийг санхүүжүүлэх.	
13.4.Энэ хуулийн 13.3-т заасан улсын төсвөөс санхүүжүүлэх татварын бус дэмжлэгийн хувь, хэмжээг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	

байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.	хууль"-ийг 2016-нд батлагдаж, 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд нарийвчилсан харилцааг "Технологийг хөгжүүлэх бүсийг хэрэгжүүлэх журам"-аар зохицуулж байна. Тус журмын зорилго нь Технологийн хөгжлийн бүс байгуулах, ажиллуулах, удирдах, хяналт тавих, тэдгээртэй холбоотой оролцогч тал, байгууллагын үүрэг, эрх, үүрэг болон Технологийг хөгжүүлэх бүсийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад журам, зарчмыг зохицуулж байна. Технологи хөгжүүлэлтийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг программ хангамжийн хөгжүүлэлт, судалгаа хөгжүүлэлт, дизайны үйл ажиллагаанаас олсон ашгийг 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр, чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн хэрэглээний программ хангамж (тодорхой судалгаа, хөгжлийн үйл ажиллагаанд зориулан)-ийг нийлүүлсэн тохиолдолд 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл НӨАТ-аас чөлөөлөхөөр, чөлөөт бүсэд ажиллаж буй судлаач, программ хангамж, судалгаа, хөгжүүлэлт, дизайны ажилтнуудын цалинг 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөхөөр, ажил олгогч төрөөс нөхөн олговор авах боломжтой байхаар заасан. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Сайд нарын танхимын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар "Программ хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн технологийн парк байгуулах арга хэмжээний тухай" 17 дугаар тогтоолд заасны дагуу технопаркийн оршин суугч нь Татварын хуулийн 297 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт заасан үйл ажиллагаанаас нийтээр тогтоосон татварыг төлж, хуулийн 1, 9, 16, 18 дугаар зүйлд заасны дагуу орлогын хувийг буцаан авах эрхтэй байхаар зохицуулсан. Мөн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд бүх татвараас чөлөөлөгдөхөөр заасан. ОХУ нь Энэтхэг болон Ирланд улсын нэгэн адил мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудыг дэмжих зорилгоор 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдөр 265 дугаартай "Оросын Холбооны Улсын Татварын хуулийн II хэсэгт өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-
--	--

ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдсөн. Тус хуулиар 1) Нэмэгдсэн өртгийн албан татвар; 2) Хувь хүний орлогын албан татвар – Татварын төлөгчийн бүртгэл; 3) Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар - Элэгдэл, хорогдол тооцох арга, журмын холбогдох хэсгийг хүчингүй болгосон; Татварын хувь хэмжээг бууруулсан; 4) Нийгмийн даатгалын шимтгэлийг зохицуулсан тул мэдээллийн технологийн салбарыг дэмжих хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны дэмжлэгийг оновчтой тодорхойлох энэ хэсэгт жишээлж дурдсан болно. Дээрх хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах мэдээллийн технологийн компаниудад тавигдах 1) Мэдээллийн технологийн компани нь улсын магадлан итгэмжлэлд хамрагдсан байх ; 2) Нийт орлогын 90 хувиас доошгүй хувийг програм хөгжүүлэлтийн үйл ажиллагаанаас олсон байх ; 3) Тус хуулиар тогтоосон нийт ажилчдын тоог хангасан байх үндсэн шаардлагыг тдэьодорхойлсон. Сингапурт гарааны компаниуд эхний 3 жилд олсон 200,000 ам.доллар хүртэлх орлогод 125,000 доллар хүртэлх хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү татварын хөнгөлөлтийг авахын тулд Сингапурт үүсгэн байгуулагдсан байх, 20 хүртэлх хувьцаа эзэмшигчтэй байх гэсэн шаардлагыг тавьдаг. БНХАУ 2016-2020 оны төлөвлөгөөний дагуу ахисан түвшний техник технологийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгжүүд буюу тодорхой хотуудад байрлах мэдээллийн технологи, аж үйлдвэрийн загварчлал зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн орлогын албан татварыг 25 хувь байсныг 15 хувь болгож бууруулсан. Мөн судалгаа шинжилгээний үйл ажиллагаа эрхэлдэг гарааны бизнесүүдэд зориулж жилийн туршид явуулах шаардлагатай судалгаа хөгжүүлэлтийн зардлын 150 хувьд татварын хөнгөлөлт үзүүлсэн. Эдгээр компаниудад 1-ээс илүү жил үйл ажиллагаагаа явуулсан байх; шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх; суурь технологийнхоо оюуны өмчийг эзэмшдэг байх; их хэмжээний зардлыг судалгаа хөгжүүлэлтэд зарцуулдаг байх; компанийн үйл ажиллагааны 60 хувиас илүү хэсэг нь өндөр технологи хөгжүүлэх үйл ажиллагаа байх; нийт ажилчдын 10-аас дээш хувь нь тухайн шинэ технологийн судалгаа хөгжүүлэлтийг хийдэг байх шаардлага тавьжээ. Монгол Улсын хувьд гарааны

бизнесийн экосистемийн талаарх нөхцөл байдлыг тодруулбал, Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар Монгол Улс нь хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй, гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй, инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй гэж дурдсан байна. Түүнчлэн мэдээллийн технологийн үйл ажиллагаа идэвхитэй явуулж байгаа аж ахуй нэгжийн нэгдсэн тоон мэдээлэл, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийн ангилал тодорхойгүй байгаатай холбогдуулан Стартап маркетинг спэйс төв, гарааны бизнес эрхлэгчдийн Дриймерс нэгдлийн мэдээллийн санд үндэслэн мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа идэвхитэй явуулдаг 304 бизнес эрхлэгчдийн мэдээлэлд үндэслэн судалгаа хийсэн. Тодруулбал, тус салбарыг төлөөлөх 109 бизнес эрхлэгчийг түүврийн аргаар сонгож 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд “Гүүгл форм” веб платформыг ашиглан цахимаар судалгаа авсан ба үр дүнг нэгтгэх замаар мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан нийт 109 компанийн 65.1 хувь нь технологи хөгжүүлэлтийн компани бөгөөд эдгээр технологи хөгжүүлэлтийн компанийн 33 хувь нь финтек буюу санхүүгийн, 30.3 хувь нь эдтек буюу боловсролын, 14.7 хувь нь бүх зүйлсийн интернэт, 11.4 хувь нь блокчэйн технологи хөгжүүлэгч байсан.

График. Судалгаанд хамрагдсан компаниудын хөгжүүлдэг технологийн төрлүүд



	Судалгаанд хамрагдсан нийт компаниуд мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг 73.2 хувь нь хүний нөөцийг чадавхижуулах, 63.3 хувь нь татварын орчин сайжруулах, 55 хувь нь дэд бүтцийг хөгжүүлэх, 54.1 хувь нь хөрөнгө оруулалт гэж ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна. Монгол Улсын татварын хувь, хэмжээ тогтоосон хууль, эрх зүйн орчныг тодруулбал: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт 0-6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулах нийтлэг хувь, хэмжээг тогтоосон. Харин тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалтад жилийн 300 сая төгрөг хүртэл үйл ажиллагааны орлого олсон ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах, согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох, газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулахаас бусад салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжид 1 хувиар татвар ногдуулахаар заасан. Татварын хөнгөлөлт: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт 1.5 тэрбум төгрөг хүртэлх үйл ажиллагааны орлоготой, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах, согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох, газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулахаас бусад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжид ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлөхөөр заасан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.4 дэх заалтад улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 3 жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр
--	--

	үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод хөнгөлөлт үзүүлэхээр заасан ба техник, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний жагсаалтыг Засгийн газар баталдаг. Тодруулбал, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 234 дүгээр тогтоолоор Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн бүтээгдэхүүний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт баталсан нь зөвхөн хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын 113 нэр төрлийн тоног төхөөрөмж байна. Татвараас чөлөөлөх: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт албан татвараас чөлөөлөх 14 төрлийн орлогыг жагсаасанд мэдээллийн технологийн үйл ажиллагааны орлого багтаагүй байна. Мөн Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр батлагдаж 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөх Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хуулийн 2 дугаар зүйлээр албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод нийтлэг хувь, хэмжээгээр болон 1 хувиар ногдуулан тайлагнасан орлогын албан татварыг чөлөөлсөн. Иймд хүчин төгөлдөр мөрдөж буй орлогын албан татварын хуулиар мэдээлэл технологийн компанийн үйл ажиллагааны 300 сая төгрөг хүртэлх орлогод 1 хувиар, 6 тэрбум төгрөг хүртэлх орлогод 10 хувиар татвар ногдуулах ба үйл ажиллагааны орлого 1.5 тэрбум төгрөг дотор байгаа бол ногдуулсан албан татварыг 90 хувиар хөнгөлж байна. Тус хувь хэмжээгээр ногдуулж, ногдуулсан татвараас хөнгөлж байгаа зохицуулалтыг мэдээллийн технологийн компани улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш эхний 3 жилд орлогын албан татвараас чөлөөлөх, 4 дэх жилээс
--	---

	ногдуулсан татварыг 50 хувиар хөнгөлөх, мэдээллийн технологийн компанид хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээдийн оруулсан хөрөнгийн өгөөж, ногдол ашигт ногдох орлогын албан татварыг чөлөөлөх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа. Мөн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ экспортонд гаргаж байгаа тохиолдолд тухайн гаргаж буй бүтээгдэхүүнийг 8 жилийн хугацаанд гаалийн татвараас 50 хувь чөлөөлөх, экспортонд гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрт судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх 1 удаагийн дэмжлэгийг дотоодын мэдээлэл технологийн гарааны бизнест олгох, алслагдсан суурин газар, орон нутагт мэдээлэл технологийн гарааны бизнес явуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг газар эзэмшиж, ашигласны төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн таван жилд 50 хувиар чөлөөлөх талаар тус тус зохицуулсан.
14 дүгээр зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих дэмжлэгийн эх үүсвэр	
14.1.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:	СтартапБлинкийн Гарааны бизнесийн экосистемийн дэлхийн индексээр 2023 онд Монгол Улс 100 орноос 79-р байранд жагсаж 2 байраар урагшилсан (2020 оноос хойш 7 байраар урагшилсан) амжилтыг үзүүлсэн боловч Монгол Улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэхэд нэлээдгүй асуудлууд тулгарсаар байна. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкагын хийсэн судалгаагаар гарааны бизнесийн экосистемийн хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй, мөн гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй гэсэн дүгнэлт гарсан. Мэдээллийн технологийн салбарын өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай, технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг нэн чухал бөгөөд дэлхийн улс орнууд гарааны бизнесийн санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх зохицуулалтыг хууль эрх зүйн орчны хувьд бүрдүүлж байна. Дижитал Узбекистаныг хэрэгжүүлэх замын зураглал - 2030 стратегийн хүрээнд “Гарааны бизнесийн тухай” хуулийн
14.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 50 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;	
14.1.2.гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж;	
14.1.3.энэ хуулийн 7.4-т заасны дагуу төсвийн байгууллагын өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсад ашиглуулснаас олсон орлого;	
14.1.4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5,	

5.3.10, 5.3.20-д Засгийн газрын сангийн хөрөнгийн тусгай доошгүй хувь.	төслийг боловсруулж, гарааны бизнест үзүүлэх дэмжлэгийг зохицуулах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гарааны бизнесийг бий болгох, экосистемийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтаас гадна "стратап" гэх тодорхойлолтыг өгсөн тус улсын анхны хууль эрх зүйн баримт бичиг юм. Мөн энэ хүрээнд гарааны бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэр, хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг тодорхойлсон ба гарааны бизнесийг үнэн зөв тоолоход туслах тодорхойлолтуудыг өгч, гарааны бизнес, инкубаторууд, хурдасгуур хөтөлбөрүүд, менторууд, сан, бизнесийн анжел хөрөнгө оруулагчдын талаар зохицуулсан. Хуулийн төсөлд төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэгийн санхүүжилтийн нэг хэлбэр нь улсын төсвийн хөрөнгө байхаар заасан. Аль ч улсад мэдээллийн технологийн хамгийн том худалдан авагч нь төр байдаг. Төрийн дэмжлэгийн нэг хэлбэр нь төрийн худалдан авах ажиллагаа байдаг ба инновац шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг аль болох худалдан авах, худалдан авах ажиллагаанд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг түлхүү дэмжих бодлоготой байх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмчийг үйлдвэрлэгчид хадгалуулах, мэдээллийн технологийн үйлчилгээг тогтвортой худалдан авах зэрэг байдаг. Төсвийн тухай хуулийн 4.1.6-д "улсын төсөв" гэж Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар болон улсын төсөвт харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсөв байхаар тусгасан. Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэгийн санхүүжилтийн өөр нэг хэлбэр нь Засгийн газрын бусад тусгай сангийн хөрөнгө байж болохоор тусгасан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан зэрэг Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн тодорхой хувийг гарааны бизнес эрхлэгч нарыг дэмжихэд зориулах боломжтой тул энэ талаарх зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн гадаад улс болон олон улсын байгууллагын зээл, тусламж, хандивын хөрөнгө, хуулиар хориглоогүй бусад
---	--

	хөрөнгийн эх үүсвэрээр мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих боломжтой юм.
ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ	
15 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	
15.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д "Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно." гэж, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;" гэж заасан тул хууль зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэлд ногдуулах хариуцлагыг ямар хуулиар зохицуулах талаар тусгасан.
15.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д "Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно." гэж, Зөрчлийн хуулийн 1.2 дугаар зүйлийн "1.Зөрчлийн шинжийг энэ хууль, бусад хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлно.", "2.Зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг энэ хуулиар тогтооно." гэж тус тус заасан тул хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага ногдуулах хуулийг тоочиж зохицуулсан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

/Анхдагч хуулийн төсөл/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар цахим эдийн засгийг дэмжихэд оршино.

2 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж

2.1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, зарчим, чиг үүргийг тодорхойлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцаанд үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гарааны компани” гэж Инновацийн тухай хуулийн 3.1.8-д заасныг;

4.1.2.“дэвшилтэт технологи” гэж шинжлэх ухааны судалгаа, мэдлэгт суурилсан мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх технологийг;

4.1.3.“мэдээллийн технологи” гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан тоон өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг;

4.1.4.“мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэж мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгох, хөгжүүлэх, түгээх, үйлчилгээ үзүүлэхийг;

4.1.5.“мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс” гэж мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэсний үндсэн дээр энэ хуульд заасан дэмжлэг үзүүлэх зорилготой албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг;

4.1.6.“хуулийн этгээд” гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэгдсэн хуулийн этгээдийг;

4.1.7.“сэндбокс орчин” гэж мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, бодит орчинд турших боломж олгох зорилго бүхий орчныг;

5 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах зарчим

5.1.Төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхэд дараах зарчмыг баримтлан ажиллана:

5.1.1.төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах;

5.1.2.төр мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзаж, худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх;

5.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь олон нийтэд ил тод, нээлттэй, шударга байх;

5.1.4.мэдээллийн технологийн үйлдвэрлэлд хүн, хуулийн этгээд тэгш эрхтэй, чөлөөтэй оролцох.

5.1.5.мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ

6 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах бүрэн эрхтэй байна:

6.1.1.энэ хуулийн 14.3.1, 14.3.2, 14.3.4, 14.3.5-д заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшуулал олгох, зээлийн батлан даалт гаргахад тавигдах шаардлага, грант, урамшуулал олгох, зээлийн батлан даалт гаргах, тэдгээрийг олгох, гаргахаас татгалзах нөхцөл, журмыг тогтоох;

6.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;

6.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тодорхойлох;

6.1.4.энэ хуулийн 4.1.7-д заасан дэвшилтэт технологийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

6.1.5.бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах;

6.1.6.хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндроксыг байгуулах, түүний журмыг батлах;

6.1.7.хөгжлийн тэргүүлэх болон дэвшилтэт технологийн жагсаалтад багтсан чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил, төсөл, хөтөлбөрийг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгэх.

7 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх үүрэг

7.1.Төрийн болон нутгийн өөрөөр удирдах байгууллага нь дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

7.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

7.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;

7.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардагдах хөрөнгийг төсөвтөө багтаан шийдвэрлэх;

7.1.4.хуульд заасан бусад.

7.2.Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлан таниулахад шаардагдах зардлыг төрөөс санхүүжүүлж болно.

7.3.Төрийн захиргааны төв байгууллага нь бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээнд нийцүүлэн салбарын онцлог бүхий сургалтын хөтөлбөр, агуулгыг

боловсруулж, батлахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг авна.

7.4.Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааж, харилцан тохиролцоно.

7.5.Төсвийн байгууллага нь өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсад гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.

8 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

8.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүргийг авч хэрэгжүүлнэ:

8.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар нийтээр дагаж мөрдөх стандарт, дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;

8.1.2.тухайн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, стандарт, шийдвэрийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий зөвлөл, хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоог оролцуулах, хамтран ажиллах, санал, зөвлөмж, дүгнэлтийг авах;

8.1.3.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар оролцогч талуудын түншлэл, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

8.1.4.бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

8.1.5.мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

8.1.6.мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих;

8.1.7.үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулахад дэмжлэг үзүүлэх;

8.1.8.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах.

9 дүгээр зүйл.Мэдээлэл, технологийн үндэсний паркийн чиг үүрэг

9.1.Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.дэвшилтэт технологийг хөгжүүлэх, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа хийх, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

9.1.2.гарааны компанийг бойжуулах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гарааны компаниудын үйл ажиллагааг уялдуулах;

9.1.3.мэдээллийн технологийн тэмцээн, уралдаан зохион байгуулах, хүний нөөц бэлтгэх чиглэлээр дотоод, гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага болон хувь хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах;

9.1.4.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт татах;

9.1.5.үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, гадаад аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах;

9.1.6.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авахад шаардлагатай нэг цонхны бүртгэлийн системийг хариуцан ажиллуулах;

9.1.7.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдэд зориулан инкубатор, хамтын оффис ажиллуулах, инкубаторт элсэх хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох;

9.1.8.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;

9.1.9.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;

9.1.10.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

9.1.11.гадаад болон дотоодын зах зээлд нийлүүлэх мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ангилал, төрөл, зориулалт, зохиогчийн эрх болон бусад нэмэлт мэдээллийн хамт бүртгэх.

10 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэл

10.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл санаачлах, хэрэгжүүлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

10.2.Төрийн байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой дараах зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно:

10.2.1.төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах;

10.2.2.энэ хуулийн 8.1.5-д заасан бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;

10.2.3.энэ хуулийн 8.1.6-д заасан мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ВИРТУАЛ БҮС

11 дүгээр зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс

11.1.Монгол Улс нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс (цаашид “виртуал бүс” гэх)-тэй байна.

11.2.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.

11.3.Зөвлөлийн дарга нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн болон мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

11.4.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Зөвлөлийн шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.

11.5.Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.5.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэн батлах;

11.5.2.виртуал бүсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, зөвлөмж гаргах;

11.5.3.Ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, чиглэл өгөх.

11.6.Зөвлөлийн бүрэлдэхүүн, Зөвлөлийн болон виртуал бүсийн ажиллах журмыг Засгийн газар тогтооно.

11.7.Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байна.

12 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэх, бүртгэлээс хасах

12.1.Ажлын алба нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд (цаашид “хуулийн этгээд” гэх)-ээс цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 өдрийн дотор хянаж, дараах шаардлагыг хангасан тохиолдолд виртуал бүсэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.6-д заасан Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр бүртгэж, хариу мэдэгдэнэ:

12.1.1.хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл;

12.1.2.Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;

12.1.3.эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлан.

12.2.Ажлын алба нь виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр гэрээ байгуулна. Гэрээний загварыг Зөвлөл батална.

12.3.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн нэр, эцсийн өмчлөгчийн мэдээллийг нээлттэй, ил тод байршуулна.

12.4.Ажлын алба нь бүртгэлтэй хуулийн этгээдийг дараах үндэслэлээр бүртгэлээс хасна:

12.4.1.виртуал бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлээгүй;

12.4.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс бусад төрлийн үйл ажиллагааг виртуал бүсээр дамжуулан эрхэлсэн;

12.4.3.гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;

12.4.4.Иргэний хуулийн 32.1-д заасны дагуу татан буулгасан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ВИРТУАЛ БҮСЭД БҮРТГҮҮЛСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

13 дугаар зүйл.Татварын болон татварын бус дэмжлэг

13.1.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээд нь санхүүгийн болон татварын тайланг холбогдох журмын дагуу гаргаж, Ажлын албанд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.

13.2.Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын дэмжлэгийг холбогдох хуульд заасны дагуу үзүүлнэ.

13.3.Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх дараах татварын бус дэмжлэг үзүүлнэ:

13.3.1.мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгох;

13.3.2.экспортод чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн грант олгох;

13.3.3.виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох;

13.3.4.хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгох;

13.3.5.дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгох;

13.3.6.Батлан даалтын сангийн тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу зээлийн батлан даалт гаргах;

13.3.8.экспортод гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрт судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх 1 удаагийн дэмжлэгийг дотоодын мэдээлэл технологийн гарааны бизнест олгох;

13.3.9.мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүний тодорхой хувийг санхүүжүүлэх;

13.3.10.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж гарааны компанид эд хөрөнгийн түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцох;

13.3.11.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын 50 хүртэлх хувийг санхүүжүүлэх.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан улсын төсвөөс санхүүжүүлэх татварын бус дэмжлэгийн хувь, хэмжээг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

14 дүгээр зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих дэмжлэгийн эх үүсвэр

14.1.Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

14.1.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;

14.1.2.гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж;

14.1.3.энэ хуулийн 7.4-т заасны дагуу төсвийн байгууллагын өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсад ашиглуулснаас олсон орлого;

14.1.4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.10, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувь.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

15 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

15.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

15.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд доор дурдсан агуулга бүхий дараах хэсэг нэмсүгэй:

1/29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дахь хэсэг:

“29.4.Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө энэ хуулийн 29.5-д заасан ангилалд хамаарах системд техник, эдийн засгийн үндэслэлийг хийлгэж ирүүлнэ.

29.5.Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн гишүүн хамтран тогтооно.”

2 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө” гэсний өмнө “энэ хуулийн 29.4-т зааснаас бусад” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ
ТУХАЙ НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.2¹ дахь хэсэг:

“5.2¹. Энэ хуулийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу харилцагчийг таньж мэдэх, холбогдох арга хэмжээг авахдаа нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан таньж, баталгаажуулж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээдээс цахим баримт бичгийг гаргуулан авч болно.”

2 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “мэдээллийн эх үүсвэр” гэсний дараа “, нийтийн мэдээллийн дэд бүтцийг” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.15.б, 6.1.15.в, 6.1.15.г, 6.1.15.д дэд заалт, 6.1.17 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.2.8 дахь заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийн” гэснийг, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.15.а дэд заалт, 6.1.16 дахь заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан” гэснийг, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр” гэснийг, мөн зүйлийн 6.1.14 дэх заалтын “харилцаа холбоо, мэдээллийн технологитой холбогдсон” гэснийг “харилцаа холбооны” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалт, 5.1.5 дахь заалт, 6¹ дүгээр зүйл, 30¹ дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.1.16 дахь заалт:

“15.1.16. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 10.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдэд өгсөн тусламж.”

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.4 дэх заалтын “Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;” гэснийг “Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг;” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.2.15 дахь заалт:

“7.2.15.мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд, бүтээгдэхүүн, үйлчилгээнд үнэлгээ хийх журам, аргачлалыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага”

2 дугаар зүйл.Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН
ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	1
1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ	1
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд	20
1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл	20
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО	22
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН.....	23
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ.....	25
4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	25
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	25
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	25
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	25
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх	25
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	26
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН	27
6.1. Бүгд Найрамдах Казахстан улсын туршлага	27
6.2. Бүгд Найрамдах Солонгос улсын туршлага	36
6.3. Бүгд Найрамдах Турк улсын туршлага	43
6.4. Узбекистан улсын туршлага	52
6.5. Харьцуулсан судалгаа	61
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ.....	85
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	87
ХАВСРАЛТ	89

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ

Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал ба мэдээлэл технологийн хөгжлийн тухай

Шинэ санаа, санаачилгууд нь зөвхөн технологийн өөрчлөлтийг бий болгох төдийгүй дэлхийн аж үйлдвэр, эдийн засгийн бүтэц, хүн төрөлхтний нийгмийн орчинд асар их өөрчлөлтийг бий болгосон. 18-р зууны үеэс аж үйлдвэрийн хэд хэдэн хувьсгалаар дамжуулан түлшинд суурилсан өсөлтийн механизм нь хүн төрөлхтний материаллаг элбэг дэлбэг байдлыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдлоос болж хүн төрөлхтний оршин тогтноход саад учруулж байна. Энэ нөхцөлд, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьслын технологийн нэгдэл нь хиймэл оюун ухаан, зүйлсийн интернэт, том өгөгдөл, гар утасны сүлжээгээр танилцуулагдсан шинжлэх ухаан технологийн хурдтай хөгжилд суурилан аж үйлдвэрийн 4 дүгээр хувьслын технологийн нэгдлийн эрин үе эхэлж байна.

Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал нь 1950-иад оноос 2000-аад оны эхэн үе хүртэл өрнөж, бидэнд компьютер, бусад төрлийн электроник, интернэт болон бусад зүйлийг авчирсан аж үйлдвэрийн 3-р хувьсгал буюу дижитал хувьсгалын шинэ бүтээлүүд дээр суурилдаг. Аж үйлдвэр 4.0 нь эдгээр шинэ бүтээлүүдийг өмнөх боломжоос давж, өртгийн гинжин хэлхээний бүх хэсэгт хэрэглэж болох дөрвөн үндсэн төрлийн шинэ технологийн авчирдаг. Үүнд:

1. Холболт, өгөгдөл, тооцоолох чадвар: үүлэн технологи, интернэт, блокчейн, мэдрэгч;
2. Аналитик ба оюун ухаан: дэвшилтэт аналитик, машин сургалт, хиймэл оюун ухаан;
3. Хүн-машины харилцан үйлчлэл: виртуал бодит байдал (VR) ба өргөтгөсөн бодит байдал (AR), робот техник ба автоматжуулалт, бие даасан удирдлагатай тээврийн хэрэгсэл;
4. Дэвшилтэт инженерчлэл: нэмэлт үйлдвэрлэл (3-D хэвлэл), сэргээгдэх эрчим хүч, нано.

Аж үйлдвэрийн 4.0 нь компаниудын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сайжруулах, түгээх аргад хувьсгал хийж байна. Үйлдвэрлэгчид зүйлсийн интернэт (IoT), үүлэн тооцоолол ба аналитик, хиймэл оюун ухаан, машин сургалт зэрэг шинэ технологийг үйлдвэрлэлийн байгууламж болон үйл ажиллагааныхаа явцад нэгтгэж байна.

Эдгээр ухаалаг үйлдвэрүүд мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, илүү сайн шийдвэр гаргах боломжийг олгодог дэвшилтэт мэдрэгч, суурилагдсан программ хангамж, робот техникээр тоноглогдсон байдаг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны өгөгдлийг ERP, ханган нийлүүлэлтийн сүлжээ, харилцагчийн үйлчилгээ болон бусад аж ахуйн нэгжийн системүүдийн үйл ажиллагааны өгөгдөлтэй хослуулж, өмнөх хаалттай мэдээллээс харагдах байдал, ойлголтын цоо шинэ түвшинг бий болгосноор илүү өндөр үнэ цэнийг бий болгодог.

Энэхүү дижитал технологиуд нь автоматжуулалтыг нэмэгдүүлэх, урьдчилан таамаглах засвар үйлчилгээ, үйл явцын сайжруулалтыг өөрөө оновчтой болгох, юуны түрүүнд үйлчлүүлэгчдэд урьд өмнө боломжгүй байсан үр ашиг, хариу үйлдэл үзүүлэх боломжтой шинэ түвшинд хүргэж байна.

Аж үйлдвэрийн 4.0-ийн үзэл баримтлал, технологийг бүх төрлийн аж үйлдвэрийн компаниуд, түүний дотор салангид болон процессын үйлдвэрлэл, түүнчлэн газрын тос, байгалийн хий, уул уурхай болон бусад үйлдвэрлэлийн сегментүүдэд ашиглаж болно. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал нь үнэ цэнийн сүлжээн дэх бизнес, хэрэглэгчид, оролцогч талуудад бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү хялбар хүртээмжтэй, дамжуулах боломжтой болгож чадна. Урьдчилсан мэдээллээс харахад 4IR технологийг амжилттай өргөжүүлэх нь нийлүүлэлтийн сүлжээг илүү үр ашигтай, ажлын цагийг илүү бүтээмжтэй болгож, үйлдвэрийн хог хаягдлыг багасгаж, ажилчид, оролцогч талууд болон хэрэглэгчдэд тоо томшгүй олон давуу талтай болохыг харуулж байна.

Хөгжиж буй орнууд үйлдвэрлэл сул байвал Аж үйлдвэрийн 4.0-ийг өргөнөөр нэвтрүүлэх боломжгүй. Улс орнууд илүү технологийн дэвшилтэт салбар руу үйлдвэрлэлээ төрөлжүүлэх хэрэгтэй. Боломжит салбаруудыг дэмжих, инновацын тогтолцоог бэхжүүлэх, шинжлэх ухаан, мэдээллийн технологийн бодлого болон нийгэм, эдийн засгийн бусад бодлого хоорондын уялдаа холбоог бий болгох, энэ үйл явцад оролцооны хандлагыг хангахад төр чухал үүрэгтэй. Мөн засгийн газрууд интернэтийн хямд, өндөр чанартай хандалтыг дэмжиж, бизнесийн салбарт, тэр дундаа ЖДҮ-д дижитал ур чадварыг хөгжүүлэх ёстой. Тэд мөн аж үйлдвэрийн 4.0-ийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Үүнд, Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалыг уялдуулан нэвтрүүлэхэд чиглэсэн үндэсний стратеги боловсруулах, технологийг хөгжүүлэхэд оролцоотой хандлагыг институцижүүлэх олон талт механизмыг бий болгох, технологи, ноу-хаугийн дамжуулалтыг хурдасгах олон улсын хамтын ажиллагааг бий болгох зэрэг мөн багтана. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалыг нэвтрүүлэхийн тулд засгийн газар хувийн хэвшлийн мэдлэгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, өндөр технологийг нэвтрүүлэх санхүүжилтийг хөнгөвчлөх ёстой. Мөн бодлого боловсруулагчид худалдааны хэв маяг, дэлхийн нэмүү өртгийн сүлжээн дэх өөрчлөлтүүд болон тэдгээр нь тэдний ажиллах хүчинд хэрхэн нөлөөлж байгааг харгалзан үзэх ёстой [1].

Мэдээллийн технологийн салбарт жижиг, дунд бизнесийн гүйцэтгэх үүрэг

Сүүлийн жилүүдэд технологид суурилсан гарааны бизнесүүд олноор төрөн гарч байна. Эдгээр нь дижитал эриний аж ахуйн нэгжүүд бөгөөд дотоодын төдийгүй дэлхийд гарах томоохон компаниудын эхлэл байдгаараа онцлогтой. Жишээлбэл Google, Amazon, Alibaba гэх мэт. Гарааны бизнесүүдийн онцлог нь эрч хүчтэй, шинэлэгч байдаг. Тэд жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) болж үйл ажиллагаагаа үргэлжлүүлдэг боловч уламжлалт ЖДҮ-ээс ялгаатай тул засгийн газар болон бусад тоглогчдоос тодорхой дэмжлэг шаарддаг.

Технологийн гарааны бизнес нь шинэ, шинэлэг технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргаж ирдэг залуу бизнес эрхлэгчид юм. Тэд хэрэглэгчид болон бизнесүүдэд шийдлийг санал болгодог ба ихэвчлэн бидний мэдэхгүй, анзаараагүй байсан асуудлууд руу ордог. Гаргаж ирсэн бизнесийн загвар нь ихэвчлэн өргөжүүлэх боломжтой байдаг тул бий болгосон шийдлүүдийг интернэтээр санал болгож, үйлчлүүлэгчдийн өргөн хүрээг хамарч чаддаг тул үйл ажиллагаа хурдан өргөжиж болно гэсэн үг юм. Австрийн эдийн засагч “Шумпетерийн хэллэг”-ээр бол гарааны бизнесүүд бүтээлч сэтгэлгээгээр хандаж шинэлэг үйлчилгээ, бизнесийн шинэ загваруудаар дамжуулан бизнесийн ертөнцийг хувьсган өөрчилдөг.

Tesla, SpaceX зэрэг хувьсгал хийсэн гарааны бизнесийг эс тооцвол гарааны бизнесүүд нь биет бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй, харин илүү ур чадварт тулгуурласан, биет хөрөнгөгүй шахам байдаг. Гарааны бизнес эрхлэгчид үнэ цэнтэй ур чадвартай, сэргэлэн цовоо, шинийг санаачилж, аж ахуйн нэгжид үнэ цэнэ нэмэх боломжийг бүрдүүлдэг. Энтрепренёрууд буюу үүсгэн байгуулагчид нь том сэтгэж, санаагаа хөгжүүлэхийн төлөө тууштай байдаг.

Гарааны бизнесүүд нь ЖДҮ эрхлэгчдийн маш бага хувийг бүрдүүлдэг. 2020 онд дэлхийн хэмжээнд 213 сая ЖДҮ үйл ажиллагаа явуулж байгаагаас 1.35 сая (1%-иас бага) нь технологийн гарааны бизнес байжээ. Гэсэн хэдий ч томрох боломж, авчирсан шинэлэг зүйлийнхээ ачаар тэд бодлого боловсруулагчдын анхаарлыг татдаг. Эдгээр нь уламжлалт ЖДҮ-ээс ялгаатай бөгөөд засгийн газар болон гарааны бизнесийн өргөн хүрээний экосистемээс тодорхой бодлого, хөтөлбөрийн дэмжлэг шаарддаг.

Гарааны бизнес болон ЖДҮ-ийн хооронд бодлогын түвшинд авч үзэхүйц таван том ялгаа байдаг. Үүнд:

Нэгдүгээрт, Ихэнх технологийн гарааны бизнесүүд дижитал бөгөөд интернэт болон платформ технологид анхаарлаа төвлөрүүлж, финтек, цахим худалдаа, агротехник, ногоон технологи болон бусад олон шинэ салбаруудыг бий болгосон. Саяхан Ковид-19 цар тахал нь эрүүл мэндийн технологи (телемедицин, эрүүл мэнд), edutech (онлайн сургалт) болон бизнесийн харилцаа холбоог (телемедицина, хурал хийх) дэмждэг шийдлүүдэд томоохон түлхэц өгсөн. Бодлогын хувьд засгийн газар хувийн хэвшлийн тоглогчдыг хүртээмжтэй, хямд өртөгтэй бөгөөд хувийн нууц, оюуны өмчийг хамгаалсан хүчирхэг дижитал дэд бүтцийг бий болгох, дэмжих шаардлагатай.

Хоёрдугаарт, Гарааны бизнест зээл бус харин тэвчээртэй хөрөнгө оруулагчид хэрэгтэй. Оруулсан хөрөнгө нь хүү, эргэн төлөлтөөр төлөгдөх ёстой боловч гарааны бизнесүүд эхний шатандаа бага эсвэл огт орлогогүй байдаг. Тэд загварчлал гаргах, хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж, амжилтад хүрсэн эсэхээс үл хамааран олон жилийн турш алдагдалтай ажилладаг. Жишээ нь, Твиттер 2006 онд байгуулагдсан цагаасаа эхлээд 2017 оныг хүртэл алдагдалтай ажиллаж байв. Эсрэгээрээ уламжлалт ЖДҮ нь үйлдвэрлэлийг (хөрөнгийн тоног төхөөрөмж, хангамж, бараа материал) шууд дэмжих санхүүжилтийг шаарддаг бөгөөд энэ нь эргээд орлого бүрдүүлдэг. Тиймээс гарааны бизнесүүдэд өөрийн хөрөнгө, буцалтгүй тусламжийн санхүүжилт илүү тохиромжтой. Өгөөжөө илүү урт хугацаанд олгодог тул илүү "тэвчээртэй" гэж тодорхойлдог. Энэ ялгааг хүлээн зөвшөөрснөөр засгийн газрууд венчур болон анжел хөрөнгө оруулагчдад ойлгомжтой, дэмжлэг үзүүлэх, татвар багатай зохицуулалтын орчныг бүрдүүлж чадна. Тэд мөн хамтарсан хөрөнгө оруулалт хийх хувийн венчур хөрөнгийг нөхөж болно. Нэмж дурдахад, ирээдүйтэй санаануудыг эхний шатанд буцалтгүй тусламжаар дэмжих боломжтой. Олон засгийн газрууд буцалтгүй тусламж олгодог боловч энэ нь сайн арга эсэх талаар маргаантай байдаг.

Гуравдугаарт, Гарааны бизнес эрхлэгчдэд эрт үед нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хэрэгтэй. Цахиурын хөндий, Нью-Йорк, Лондон, Бээжин, Бостон нь дижитал дэд бүтэц, венчурын санхүүжилтээр хангаад зогсохгүй хууль эрх зүй, нягтлан бодох бүртгэл, хүний нөөцийн удирдлага болон бусад салбарт хялбар нэвтрэх боломжийг дэмждэгээрээ дэлхийн шилдэг таван гарааны бизнесийн экосистем юм. Гарааны бизнесүүд бизнесээ явуут дундаа гэж болохоор, шуурхай бүртгүүлдэг бөгөөд хурдан өргөжин тэлэхийн тулд дээрх бүртгэлүүдийг эрт шийдвэрлэх шаардлагатай байдаг.

Бүтээгдэхүүний ангилал хараахан гараагүй байгаа шинэлэг шийдлүүдийг бүртгэхэд хууль эрх зүйн дэлгэрэнгүй зөвлөмж шаардлагатай.

Дөрөвдүгээрт, Гарааны бизнес эрхлэгчдийн технологийн авьяасыг инкубатор болон хурдасгуур хөтөлбөрүүдээр бизнес болгон хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Гарааны бизнес нь технологид бүтээлчээр ханддаг үүсгэн байгуулагчдын шинэлэг санаанаас эхэлдэг. Гэсэн хэдий ч тэд бизнесээ хэрхэн явуулах талаар ихэвчлэн туршлагагүй байдаг. Уг санааг зах зээлд борлуулах боломжтой бүтээгдэхүүн, ашиг орлоготой аж ахуйн нэгж болгон төлөвшүүлэх хэрэгтэй. Үүний тулд инкубатор, хурдасгуур чухал байдаг. Эдгээр нь зөвлөгөө өгөх, сургалт явуулах, танилын сүлжээ үүсгэх, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг, заримдаа ажлын байраар хангадаг хөтөлбөрүүд юм. Зарим нь “seed” (эхлэлийн) санхүүжилтийг санал болгодог бол зарим нь боломжит хөрөнгө оруулагчидтай холбож өгдөг. Инкубаторууд болон хурдасгуурууд нь гарааны бизнес эрхлэгчдэд туршилт хийх, технологийн талаар санал авах, зах зээлд илүү тохиромжтой шинэ хувилбаруудыг хурдан, олон дахин туршихад тусалдаг. Засгийн газар инкубатор, хурдасгууруудыг байгуулж (эсвэл санхүүгийн хувьд дэмжиж) эдгээр нь ЖДҮ-д шаардлагатай бизнес хөгжүүлэх үйлчилгээнээс ялгаатай гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай.

Тавдугаарт, технологийн гарааны бизнест чадварлаг авьяас хэрэгтэй. Дижитал шинж чанартай учраас гарааны бизнесүүд шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн (STEM) чиглэлээр мэргэшсэн ажилтнуудыг шаарддаг. Авьяастай чадварлаг хүмүүсийг олж авах нь гарааны бизнес эрхлэгчдэд тулгарч буй гол сорилт бөгөөд засгийн газрууд чадварлаг төгсөгчдийн урсгалыг бий болгох боловсролын боломжоор хангах үүрэгтэй. Энэ хүний нөөцийн дутагдал нь зөвхөн нийлүүлэлтийн тал дээр биш. Цагаачлалын хатуу дүрэм, том фирмүүдтэй хүний нөөцийн төлөөх ширүүн өрсөлдөөн, технологийн төвүүдэд амьдрах өндөр өртөг зэрэг нь бас асуудал юм. Технологийн гарааны бизнес эрхлэгчдэд чадварлаг хүний нөөц татахад хялбар болгодог цагаачлалын хууль тогтоомж, ажилчдын нийгмийн халамж, татварын таатай зохицуулалт гэх мэт шинэлэг бодлого нь гарааны бизнесийг дэмжих экосистемийг бий болгох бүтээлч арга зам юм.

Засгийн газар ЖДҮ-ийг эдийн засагт оруулж буй чухал хувь нэмрийг нь дэмжих зорилгоор бодлого боловсруулагчид технологийн гарааны бизнесүүдэд тулгардаг өвөрмөц сорилтуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх экосистемийг бий болгож чадна [2].

Гарааны бизнесийн үндсэн шинж:

- Гарааны бизнес гэдэг нь дөнгөж эхэлж буй шинэ бизнес. Гарааны зарим бизнес амжилттай хөгждөг бол нөгөө хэсэг нь оршин тогтнож чадалгүй, үйл ажиллагаагаа зогсоодог.
- Гарааны бизнес нь юуны өмнө шинэ санаан дээр тулгуурладаг. Гарааны бизнес эрхлэгчид нь гол төлөв тухайн салбартаа ямар нэг шинэ санааг бизнес болгон хөгжүүлдэг.
- Гарааны бизнесийн бүхий л үйл ажиллагаа эхлэлийн шатандаа оршиж байдаг.
- Хөрөнгө оруулагчид хайх, түүнийг олох эсэхээс гарааны бизнесийн цаашдын амжилт ихээхэн хамааралтай.
- Богино хугацаанд шинэ санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлдэг. Энэ нь гарааны бизнесийн амжилтын нэг гол нөхцөл юм. Хөрөнгө оруулагчид гарааны бизнесийн тодорхой төслөөс богино хугацаанд ашиг хүртэхийг эрмэлздэг. Нөгөө талаар, бизнес нь удаан хугацаагаар гарааны бизнес хэвээр байх боломжгүй.

Гарааны бизнесийн амжилтын гол хүчин зүйл:

- Үүсгэн байгуулагчдын шинэ санаа, түүнийг бизнес болгон хөгжүүлэх чин эрмэлзэл, хүсэл тэмүүлэл, мэдлэг;
- Гарааны бизнес эрхлэхэд сайтар бэлтгэсэн байдал, үндэслэлтэй бизнес төсөл;
- Гарааны бизнес эрхлэх баг, хамт олны хөдөлмөр зүтгэл, нэгдэл, нягтрал;
- Гарааны бизнесийн төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх чадвартай, харилцан туслалцаж ажиллах түншүүд;
- Гарааны бизнесийн санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэлэг байдал (инноваци), ялгагдах онцлог, оновчтой сурталчилгаа;
- Хөрөнгө оруулагч, хангалттай хэмжээний санхүүжилт олсон байдал.

Гарааны бизнесийн хөгжлийн үе шат:

- Эхлэлийн үе шат. Бизнесийн шинэ санааг хөгжүүлэх, зах зээлийн судалгаа хийх, техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, бүтээгдэхүүний загвар, үйлчилгээний концепц гаргах, бизнес төлөвлөгөө бэлтгэх, хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэр олох гэх зэрэг үйл ажиллагаа явагддаг.
- Эхэн үе шат. Бизнесийн шинэ санааг туршин хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд эхлэн гаргаж бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх үе шат.
- Дунд шат. Бизнес тогтвортой болж, компанийн үйл ажиллагаа жигдрэн, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэж, зах зээлд эзлэх байр суурь бэхжинэ.
- Сүүлийн шат. Компанийн үйл ажиллагаа бүрэн тогтворжиж, гарааны бизнесийн шатнаас гарна. Цаашид хөрөнгийн зах зээлд нээлттэй хувьцаа гаргах боломжтой [32].

Гарааны бизнес нь үе шатаар дамжин зах зээлд шинэ санаа санаачилга гаргаж, эдийн засгийн тогтвортой аж ахуйн нэгж болон тогтворждог. Томоохон аж ахуйн нэгжийн ашиг орлогыг нэмэгдүүлдэг зүйл бол шинэ гарааны компаниуд юм. Гарааны бизнесүүд жижиг байдаг учраас тэд материаллаг ба материаллаг бус нөөцийн дутагдалтай байдаг. Санхүүгийн болон хүний нөөцийн хувьд дутагдалтай байдал нь инновацийн шинэ процессыг хөгжүүлэхэд том саад болдог [32].

Гарааны бизнесийн экосистем нь ур чадвар, нягтрал, соёл, хөрөнгө, хууль, эрх зүй гэсэн үндсэн таван орцоос бүрддэг. Экосистемийн орцыг тус бүрээр авч үзвэл:

- *Ур чадвар.* Хөдөлмөрийн зах зээлийн уян хатан байдлыг ханган, өөр өөр ур чадвар, мэдлэг туршлага бүхий хүмүүсийг татан төвлөрүүлэх, хамтын ажиллагаа, харилцаа холбоо үүсгэх, хөгжүүлэх замаар урт хугацаанд хүмүүн капитал бий болгох
- *Нягтрал.* Олон төрлийн бизнесийн төвлөрөл үүсгэх, бизнесийн зөвлөхүүдийн сүлжээг бий болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр уг салбарын талаарх ойлголт, мэдээллийг түгээх, эрдэмтэн судлаачдыг бизнес эрхлэгчидтэй холбох гэх мэт.
- *Соёл.* Гарааны бизнесийн өвөрмөц соёлыг бий болгох, бизнес эрхлэгчдийн ур чадвар, хамтын ажиллагааг хөгжүүлж, амжилттай энтрепренерүүдийн жишээг олон нийтэд түгээж, уналт, алдаа нь гарааны бизнес эрхлэлтэд зайлшгүй тулгардаг зүйл гэдгийг ухамсарлуулан ойлгуулах, даван туулах арга зам байдгийг харуулах нь гарааны бизнес ирээдүйн амжилтад хүрэх нэг гол нөхцөл бодлог.
- *Капитал.* Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдыг гарааны бизнесийн салбарт татан оруулж, баялгаа шилжүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх дэд бүтэц бий болох, гарааны бизнесийг хөрөнгөтэй холбох арга механизмыг илүү хялбар болгож өгөх шаардлага тавигдана.

- *Хууль, эрх зүй.* Хөрөнгө оруулалтыг татаж, өндөр эрсдэл бүхий энэхүү салбарт капиталын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд татварын оновчтой тогтолцоог бий болгож, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэн тогтвортой байдлыг хангах шаардлагатай.

Дижитал эдийн засгийн тухай

Мэдээллийн салбар, ялангуяа мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар нь дижитал шилжилтийн үндэс суурь болдог. Энэ үзүүлэлт нь хөдөө аж ахуйн бус бизнесийн салбарын бусад үйл ажиллагаатай харьцуулахад мэдээллийн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг хэмждэг. Энэ нь эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвар, амьжиргааны түвшинд мэдээллийн салбаруудын харьцангуй нөлөөллийн үзүүлэлт юм.

Технологийг хэрхэн зохицуулах, дижитал дэд бүтцэд хэдий хэмжээний татаас олгох, бизнес эрхлэгчид ямар төрлийн шинэ дижитал саналуудыг бий болгох зэрэг асуултын хариулт нь дижитал эдийн засгаас олж авсан жинхэнэ үр өгөөжийг ойлгохоос хамаарна.

Дижитал эдийн засаг гэдэг нь дижитал мэдээлэл, мэдлэгийг үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болгон ашигладаг өргөн хүрээний эдийн засгийн үйл ажиллагааг хэлнэ. Интернэт, үүлэн тооцоолол, том өгөгдөл, финтек болон бусад шинэ тоон технологийг дижитал хэлбэрээр мэдээлэл цуглуулах, хадгалах, дүн шинжилгээ хийх, хуваалцах, нийгмийн харилцааг өөрчлөхөд ашигладаг. Дижитал технологи нь инновацыг идэвхжүүлж, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд эдийн засгийг дижиталчилснаар ашиг тус, үр ашгийг бий болгодог. Дижитал эдийн засаг нь нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, хүмүүсийн харилцан үйлчлэлд нөлөөлж, социологийн өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийг авчирдаг.

Азийн дижитал өөрчлөлт аль хэдийн бүс нутгийн эдийн засагт асар их нөлөө үзүүлж байна. Ази тивийн цахим худалдааны гүйлгээ нь Алибаба, Тенсент зэрэг компаниуд хурдацтай хөгжиж байгаа Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) тэргүүтэй дэлхийн бизнесээс хэрэглэгч рүү (B2C) зах зээлийн 25 хувийг эзэлдэг. БНХАУ-ын жижиглэн худалдааны цахим худалдааны зах зээлийн гүйлгээний хэмжээ 2013 онд 1.32 их наяд юань байсан бол 2016 онд 5.33 их наяд юань болж, 2017 онд 7.57 их наяд юань болж өссөн байна.

Санхүүгийн технологи нь Азид санхүүгийн үйлчилгээг хүргэх, ялангуяа төлбөр, зээлийг хөнгөвчлөх шинэ арга замыг бий болгосон. Энэ нь хөгжиж буй Азийн олон оронд санхүүгийн хүртээмжийг бий болгосон. 2015 онд Ази дахь финтект суурилсан зээлийн хэмжээ 102.8 тэрбум ам.долларт хүрч, технологийн тархалт нь төлбөрийн системийн үр ашгийг улам дээшлүүлж, дэлхийн хамгийн том төлбөрийн зах зээл болох Азийн байр суурийг бэхжүүлсэн. Цаашлаад дижитал, сүлжээ, ухаалаг мэдээлэл, харилцаа холбооны технологи нь орчин үеийн эдийн засгийн үйл ажиллагааг илүү уян хатан, ухаалаг болгох боломжийг олгодог.

Улс орнууд энэхүү дижитал шилжилтээс ашиг хүртсээр байгаа ч дижитал эдийн засгийг ойлгох нь нарийн төвөгтэй байдлаасаа болоод бэрхшээлтэй хэвээр байна. Дижитал шилжилт нь зөвхөн том өгөгдөл, дижитал платформууд төдийгүй эдгээр дэвшилтэт технологийг инновац, шинэ бизнесийн загвар, процесс, ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээний боломжийг нэмэгдүүлэхийн тулд хэрхэн ашиглах тухай юм. Цаашлаад дижитал эдийн засаг нь зах зээлийг либералчлах, худалдааны саад

тотгорыг багасгах урт хугацааны чиг хандлагын дагуу бүс нутгийн бизнесүүдэд орон нутгийн бизнесээс холдож, дэлхийн хэмжээнд шилжих боломжийг олгож байна.

Гэсэн хэдий ч дижитал ур чадварын зөрүүтэй байдал нэмэгдэж, зохицуулалтын түвшин, дэд бүтцийн ялгааг харгалзан дижитал эдийн засгийн давуу талыг бүрэн ашиглаж чадахгүй байна. Иргэд дижитал төхөөрөмж дутагдалтай, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн танилт баталгаажуулалтын хэлбэр, нийгэм эдийн засгийн саад бэрхшээл зэргээс шалтгаалж үндсэн онлайн данс руу нэвтрэх боломжгүй байсаар байна. Дижитал эдийн засагт илүү их оролцоог бий болгохын тулд хүн амын хүртээмж, хүлээн авах чадварын ялгааг нарийн ойлгох хэрэгтэй. Дижитал шилжилт эрчимжиж байгаа энэ үед итгэлцэл, нууцлал, ил тод байдалтай холбоотой шинэ асуудлуудыг мөн шийдвэрлэх хэрэгтэй байдаг [3].

Монголын мэдээлэл технологийн үйлдвэрлэлийн хөгжил олон улсад

НҮБ-аас 2 жил тутамд “Цахим засаглалын хөгжлийн индекс”-ийг шинэчлэн гаргадаг. Монгол Улсын хувьд 2018, 2020 онуудад зарлагдсан индексээр НҮБ-ын гишүүн 193 орноос 92 дугаар байранд орж байсан бол 2022 онд энэ байр урагшилж 74 дүгээр байранд орж, цахим засаглалын хөгжлийн индексээр 18 байр урагшилсан.

Дэлхийн 190 сонгогдсон хотуудад үндэсний болон бүс нутгийн түвшинд бизнес эрхлэлтийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийг бодитойгоор хэмждэг Дэлхийн банкны “Бизнес эрхлэлт”-ийн 2020 оны тайланд манай улс 81-р байранд жагссан.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг улс орнуудын инновацын чадавх, амжилтаар нь эрэмбэлдэг “Дэлхийн инновацын индекс”-ээр 2023 онд 132 улсаас 68-р байранд жагсаж, 3 байр урагшилсан. Инновацын дүр зургийг аль болох бүрэн дүүрэн гаргахаар төлөвлөх тус индекс нь эдийн засаг бүрийн улс төрийн орчин, боловсрол, дэд бүтэц, мэдлэгийн бүтээн байгуулалт зэрэг 80 орчим үзүүлэлтийг багтаасан байдаг ба манай улсын хувьд хүмүүн капитал, дэд бүтэц, бизнесийн боловсронгуй байдал зэрэг үзүүлэлтээрээ дундаж байгаа хэдий ч, хамгийн доогуур жагсаж буй үзүүлэлт нь зах зээлийн боловсронгуй байдал буюу зээл, хөрөнгө оруулалт, худалдаа, төрөлжилт, зах зээлийн цар хүрээгээрээ 101-т жагсаж байна. Энэ нь манай улс инновац, нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн таатай орчин бүрдээгүй байгаатай холбон ойлгож болох юм.


Дэлхийн өрсөлдөх чадварын төв болон Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан-2023”-т Монгол улс Монгол Улс өрсөлдөх чадварын үзүүлэлтээр тайланд хамрагдсан 64 улсаас 62-т эрэмбэлэгдэж, өмнөх оноос 0.64 оноогоор буурч 1 эрэмбэ ухарсан. Тус тайланг 64 улсын өрсөлдөх чадварыг эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа, дэд бүтэц гэсэн үндсэн 4 хүчин зүйл, 20 дэд бүлэг, нийт 335 шалгуур үзүүлэлтээр харьцуулан хэмжсэн, хамгийн дэлгэрэнгүй, нарийвчилсан судалгаа юм.

Монголын гарааны бизнесийн экосистемийн өнөөгийн байдал

Гарааны бизнесийн экосистемийн зорилго нь дэлхийн өртгийн сүлжээнд өрсөлдөх чадвар бүхий технологид суурилсан гарааны бизнесийг гаргах, хөгжүүлэх юм. Дэлхий даяар гарааны бизнесийг үүсгэн байгуулагчид болон хөрөнгө оруулагч нар тэрбум долларын үнэлгээтэй гарааны бизнес болох боломжыг нэмэгдүүлсэн хамгийн шилдэг экосистемийг хайж байдаг. Ийм шилдэг гарааны бизнесийн экосистемийн

бодлого боловсруулагчид гарааны бизнесийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын таатай орчныг бүрдүүлэхээр хоорондоо өрсөлдөж байдаг.

Монгол улсын мэдээллийн технологийн гарааны бизнесийг үүсэл хөгжлийн хувьд авч үзвэл, 2003 онд Мэдээлэл технологийн үндэсний парк нь “Мэдээллийн технологийн салбарын шинэ санаа, санаачилгыг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ хэрэгцээг эрж олох, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниуд болон бизнес эхлэн эрхлэгчдэд урамшууллын таатай орчин бүрдүүлэн ололт амжилт, өсөлтийг нь хурдасгахад цаг хугацааны болон хөрөнгө оруулалт, менежментийн бусад иж бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон, дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болох эхний чадавхтай болтол нь торниулан бойжуулах” зорилготой, программ хангамжийн чиглэлээр бизнес эрхлэгчдийг элсүүлэх бодлого барьж, “Мэдээллийн технологийн инкубаторт элсэх иргэн ба компаниудыг сонгон шалгаруулах журам” боловсруулан баталсан. Тус журам батлагдсанаар анх 2003 оны 9 сард инкубаторын анхны элсэлтийг зохион байгуулж, нийт 23 аж ахуйн нэгж, хувь хүн хүсэлт гаргаснаас, 11 аж ахуйн нэгж болон 2 иргэнийг сонгон шалгаруулж элсүүлсэн. 2022 оны байдлаар инкубаторт бойжиж буй 12 компанийн үйл ажиллагааны чиглэлийн хувьд контент хөгжүүлэлт 58%, сошиал маркетинг 23%, аппликэйшн хөгжүүлэлт 10%, систем хөгжүүлэлт 9% байна.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 1. МХХТ-ийн үйлчилгээ үзүүлж буй идэвхтэй бизнес эрхлэгчдийн тоо

Өнөөгийн мэдлэгийн эдийн засагт инновац болон мэдээллийн технологийн үйлдвэрлэл нь улс орны эдийн засгийн хөгжлийн тулгуур болж байна. Гарааны буюу технологийн гарааны бизнес нь хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байр бий болгож, бизнесийн орчинд эрчимтэй өрсөлдөөн үүсгэж буйгаараа орчин үеийн эдийн засгийн хамгийн чухал ойлголт юм. Сүүлийн жилүүдэд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд мэдлэгийн эдийн засгийг амжилттай хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг хурдасгах,


инновацийн үйл ажиллагаанд оролцогчдын үр дүнтэй нягт хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөгжүүлж, инновац, өндөр технологид суурилсан, нэмүү өртөг шингээсэн, мэдлэгт суурилсан мэдээллийн технологийн үйлдвэрлэл болон үр ашигтай энрепренёршипыг дэмжих тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн анхаарч байна. Өнөөдөр Монгол улсад мэдээллийн технологийн бизнес эрхлэлт болон энтрепренёруудын тоо хурдтай нэмэгдэж байгааг үйл ажиллагаа идэвхтэй эрхэлж буй хуулийн этгээдийн тоо хэмжээнээс харах боломжтой (Зураг 1).



2023 оны СтартапБлинкийн Гарааны бизнесийн экосистемийн дэлхийн индэксээр Монгол Улс шилдэг 100-д багтаж 79-р байранд жагсаж 2 байраар урагшилсан (2020 оноос хойш 7 байраар урагшилсан) амжилтыг үзүүлээд байна.

Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн зургаан улс 51-100-д багтаж, Гүрж, Казахстан, Монгол, Азербайжан, Киргиз улс энэ онд ахиц дэвшил гаргасан нь энэ бүс нутагт ихээхэн эерэг өөрчлөлтүүд гарч буйг тус тайланд онцолжээ.

- 2023 онд Монгол Улс байр сууриа 2 шат ахиулж, дэлхийн хэмжээнд 79-т жагсаж, Азидаа 16-р байраа хадгаллаа.
- Монгол Улс Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны бизнесийн бүс дэх хамгийн өндөр чансаатай тав дахь орон хэвээр байна.
- Улаанбаатар хот 24 шат ахиж 448-д бичигдэж, гурав дахь жилдээ эерэг эрч хүчээ хадгалсаар байгаа Монгол улсын цорын ганц хот юм.
- Улаанбаатар Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны бизнесийн бүс нутагт Хятадаас бусад хотуудын жагсаалтын 8-д ордог.



Монголын гарааны бизнесийн экосистем хөгжиж байгаа ч орон нутгийн эдийн засагт томоохон нөлөө үзүүлж, өөрчлөх боломжтой бөгөөд хөрөнгө оруулалт, хүмүүн капитал, дижитал холболтын өсөлт нь Зүүн Азийн энэ улсад хөдөө аж ахуй, уул уурхайгаас олсон ашгаа бататгаж, мэдээллийн технологийн эрэлт хэрэгцээг ашиглан Улаанбаатар хотод


гарааны бизнесийн экосистемийг бий болгох боломжийг бүрдүүлж байна. Монголын гарааны бизнесийн чанар тун удахгүй инновацаараа тэргүүлэх улс болох талаар тус тайланд онцолжээ.

Түүнчлэн, Ковид-19 цар тахал гарахаас өмнө дижитал реформыг эхлүүлж байсан бол хямралын үеэр энэхүү үйл явц хурдсаж, үүний үр дүнд Эстони улсын цахим засаглалын загварыг дагаж E-Mongolia платформыг олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус шинэчлэл нь хүнд суртлыг багасгах, ил тод байдлыг сайжруулах, илүү хурдан үйлчилгээ үзүүлэхэд чиглэгддэг бөгөөд гарааны бизнесийн үйл ажиллагаанд ч ашигтай байж болох талаар тайланд дурдсан байна.

Нийслэл Улаанбаатар хотод хүн амын дийлэнх нь амьдардаг бөгөөд гарааны бизнесийг дэмжигч хэд хэдэн байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд shopru.mn, TomYo Edtech, Chimege-г онцлох гарааны бизнесүүд амжилттай үйл ажиллагаагаа эрхэлж байна. Монголын гарааны бизнесийн экосистемд биет дэд бүтэц, санхүүгийн хүртээмжийн хувьд хэд хэдэн сорилт тулгарсан хэвээр байгаа хэдий ч, Монголын засгийн газар бизнес эрхлэлтийн өсөлтийг идэвхтэй дэмжиж, инновацыг улс орны өсөлтийн томоохон хөдөлгүүр гэж нэн тэргүүнд тавьж буйг СтартапБлинк тайландаа шигтгэжээ [4].


2022 онд Жайка, KITE, MMCG байгууллагуудаас гаргасан Монголын гарааны бизнесийн экосистемийн судалгааны тайланд гарааны бизнес эрхлэгчдээс судалгаа авч үр дүнг нэгтгэн танилцуулсан. Тус тайланд Монгол улсын гарааны бизнесийн экосистемийн нийт үнэлгээ дунджаар дор хаяж 452 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийт 96 тэрбум төгрөгийн хөрөнгийг гарааны бизнес эрхлэгчид босгосон байна. Судалгаанд оролцсон гарааны бизнес эрхлэгчид нийт 60 тэрбум төгрөгийн орлого олсон бөгөөд 1318 ажлын байрыг бий болгосны 717 нь бүтэн цагийн ажлын байр байна.

Монгол улсын гарааны бизнесийн экосистем нь харьцангуй залуу бөгөөд гарааны бизнесүүд дунджаар 3.6 жил үйл ажиллагаа явуулж байгаагийн 63% нь сүүлийн 3 жилд үйл ажиллагаагаа эхлүүлжээ. 90% нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлтэй байна. Гарааны бизнесүүд нийт 137 оюуны өмч бүртгүүлснээс 10 нь олон улсад бүртгэгдсэн ба бүгд зах зээлд нэвтэрсэн байна. Гарааны бизнесийн үүсгэн байгуулагчид нь маш сайн боловсрол эзэмшсэн байгаагаас 48% нь дээд боловсролтой, 44.6% нь STEM-н чиглэлтэй байна. Үүсгэн байгуулагчид дунджаар 2.4 гарааны бизнес үүсгэн байгуулсан бөгөөд хангалттай мэргэжлийн ур чадвар, туршлагатай байна. Гэсэн хэдий ч гарааны бизнес экосистемийн хувьд цаашид хөгжихийн тулд асуудлуудыг шийдэх шаардлагатай ба эдгээрийн ихэнх нь хууль эрхзүйн орчныг өөрчлөх, төрөөс тогтвортой дэмжлэг үзүүлэхтэй холбоотой байна.



Эх сурвалж: Жайка, Монголын гарааны бизнесийн экосистемийн судалгааны тайлан, 2022

Зураг 2. Гарааны бизнесийн тулгамдсан асуудлууд



Эх сурвалж: Жайка, Монголын гарааны бизнесийн экосистемийн судалгааны тайлан, 2022

Зураг 3. Гарааны бизнесүүдийн хэрэгцээт дэмжлэг

Гарааны бизнес эрхлэгчид Монгол улсын экосистемийг хөгжиж байгаа гэж үзэж байгаа бөгөөд экосистемийн хөгжилд нөлөөлөх топ-5 хүчин зүйлийг тодорхойлсон. Үүнд боловсролтой ажиллах хүчин (68%), эдийн засгийн тогтвортой орчин (59%),

инновацийн түвшин (41%), хүн амын худалдан авах чадвар (34%), болон багийн гишүүдийн хүрэлцээ (29%) зэргийг нэрлэж байна.

Төрийн байгууллага инновацыг дамжуулах, кластераар хөгжих, бодлогын хувьд сайжруулах хэрэгтэй. Мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдын тоо цөөн байгаа нь гарааны бизнесийн хөгжилд тушаа болж байна. Гарааны бизнесийг хөгжүүлэхэд төрөөс тууштай дэмжих нь хамгийн чухал хүчин зүйл юм. Мөн төрийн оролцоо нь илүү таатай бодлогын орчныг бий болгож, сайн судалгааны үндсэн дээр хийгдэх ёстой гэж гарааны бизнес эрхлэгчид үзэж байна.

Түүнчлэн хөрөнгө оруулагчдын хомсдол нь гарааны бизнесийг хөгжүүлэхэд саад болж байна. Хандивлагчдын өнцгөөс харахад гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх засгийн газрын амлалт нь гарааны бизнесийн өсөлтийг хурдасгах гол хүчин зүйл юм. Мөн нааштай, сайтар судлагдсан бодлого, зохицуулалтыг бий болгох замаар төрийн үүрэг оролцоо чухал байх ёстой гэж үзэж байна. Засгийн газар гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэхдээ хувийн хэвшлийн туршлагад тулгуурлан олон улсын хөрөнгө оруулагчдыг Монголд оруулж ирэхэд гол үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

Монголд гарааны бизнесийг Инновацийн тухай хуульд тодорхойлсон бөгөөд гарааны бизнесийн тухай ойлголтыг хязгаарлагдмал байдлаар тусгасан байна. Энэ хуульд байгаа гарааны бизнесийн тодорхойлолт хуучирсан, шинэчлэн найруулах шаардлагатай гэдгийг гарааны бизнес эрхлэгчид, судалгаа шинжилгээ болон төрийн байгууллагууд хүлээн зөвшөөрч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Технологи хурдацтай хөгжиж байгаа өнөө үед хуульд заасан тайлбар хэтэрхий хоцрогдсон байна. Цаашилбал, гарааны бизнесийг дэмжихэд туслах инновацын тэргүүлэх чиглэл болон салбаруудыг хараахан тодруулаагүй байна. Энэ нь аль хэдийн бие даан үйл ажиллагаа явуулж буй болон Засгийн газрын аливаа нэг бүтцэд тусгайлан оролцоогүй эсвэл орох хүсэлгүй гарааны бизнес эрхлэгчдийг хязгаарлах үр дагавартай юм.

Нэмж дурдахад гарааны бизнес гэсэн ойлголтыг захиргааны болон хууль тогтоомжийн түвшинд шинээр орж ирж буй бизнестэй андуурах явдал байна. “Стартап” гэдэг үг нь монгол хэл дээр ерөнхийдөө бүх анхан шатны бизнесийг илэрхийлдэг. Төрөөс гарааны бизнесийг дэмжих боломжийн талаарх асуудлыг хэлэлцэхэд энэ нь ихэвчлэн залуучуудын эрхэлж буй бизнес эсвэл өрхийн бизнесийг дэмжих асуудалтай холбогддог. Иймд бизнес эрхлэлт, инновац/технологид тулгуурласан гарааны бизнес гэсэн тодорхойлолтыг судалгаа, инновац, гарааны бизнесийг дэмжих чиглэлээр төрөөс баримталж буй тэргүүлэх чиглэлийн дагуу хууль тогтоомж, төрийн бодлогод тусгайлан оруулах шаардлагатай байна. Тодорхойлолтыг ингэж салгаж тодорхой болгосноор уламжлалт болон технологийн гарааны бизнесүүдэд зорилтот дэмжлэг үзүүлэх боломжтой болох юм [5].

Мөн түүнчлэн, гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэхэд засгийн газрын үүргийг тодорхой болгож, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг дэмжих зорилгоор тусгайлсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн нэр томъёоны тухай

Олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй доорх нэр томъёонууд Монгол Улсын хууль тогтоомжид тусаагүй эсвэл тухайн хууль тогтоомжийнхоо хүрээнд

хязгаарлагдмал тодорхойлогдсон байгаа тул олон улсын жишгийн дагуу шинээр тодорхойлох нь чухал байна.

Хүснэгт 1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн нэр томъёоны тайлбар

Нэр томъёо	Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан байдал	Олон улсын ойлголт
Мэдээллийн технологи	Харилцаа холбооны тухай хуульд "3.1.14."мэдээллийн технологи" гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан цахим өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг	"компьютерт суурилсан мэдээллийн системийг судлах, зохион бүтээх, хөгжүүлэх, хэрэглэх, хэрэгжүүлэх, дэмжих, удирдах" (Information Technology Association of America (Comptia))
Стартап (цаашид "Гарааны бизнес" гэх)	Инновацийн тухай хуульд 3.1.8."гарааны компани" гэж инновацын бүтээгдэхүүн шинээр үйлдвэрлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компанийг;	Стартап гэдэг нэр томъёо нь үйл ажиллагааны эхний үе шатанд байгаа компанийг хэлдэг. Гарааны бизнесийг эрэлт байгаа гэж үзэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхийг хүсдэг нэг буюу хэд хэдэн бизнес эрхлэгчид үүсгэн байгуулдаг. Эдгээр компаниуд ихэвчлэн өндөр зардалтай, хязгаарлагдмал орлоготой ажилладаг тул венчур хөрөнгө оруулагчид гэх мэт янз бүрийн эх үүсвэрээс хөрөнгө хайж байдаг. (Investopedia толь бичиг)
Инновац	Инновацийн тухай хуульд 3.1.1."инновац" гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдлийг;	
Инновацийн бүтээгдэхүүн	Инновацийн тухай хуульд 3.1.4."инновацийн бүтээгдэхүүн" гэж энэ хуулиар тогтоосон шаардлага, нөхцөлийг хангасан, зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс техник, эдийн засгийн үзүүлэлт, шинжлэх ухааны багтаамж, нэмүү өртөг бий болгох болон өрсөлдөх чадвараар илүү инновацын үйл ажиллагааны үр дүнг;	
Грант	3.1.7."инновацийн грант" гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилан нөхцөл, болзол тавьсны	

	үндсэн дээр инновацын тодорхой төсөлд буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг;	
Энтрепренёр		Энтрепренёр гэдэг нь ихэнх эрсдэлийг үүрч, үр шимийг нь хүртэж, шинэ бизнесийг бий болгож буй хувь хүн юм. (Investopedia толь бичиг)
Unicorn (цаашид “тэрбум долларын үнэлгээтэй гарааны бизнес” гэх)		Венчур хөрөнгийн салбарт Unicorn гэдэг нэр томъёо нь 1 тэрбум долларын үнэлгээтэй аливаа гарааны бизнесийг хэлдэг. (Investopedia толь бичиг)
Emerging technologies		Шинээр гарч ирж буй технологи гэдэг нь ерөнхийдөө шинэ технологийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томъёо боловч одоо байгаа технологийн тасралтгүй хөгжлийг илэрхийлж болно. Энэ нь хэвлэл мэдээлэл, бизнес, шинжлэх ухаан, боловсрол гэх мэт өөр өөр салбарт ашиглахад арай өөр утгатай байж болно. Энэ нэр томъёо нь ихэвчлэн одоо хөгжиж байгаа эсвэл ойрын 5-10 жилийн дотор бэлэн болох гэж буй технологиудыг хэлдэг бөгөөд ихэвчлэн нийгэм, эдийн засагт чухал нөлөө үзүүлж байгаа эсвэл бий болгохоор хүлээгдэж буй технологид зориулагдсан. (W&S хуулийн фирм)
Венчур капитал (цаашид “венчур хөрөнгө оруулалт” гэх)		Венчур капитал (VC) нь хувийн өмчийн нэг хэлбэр бөгөөд хөрөнгө оруулагчид урт хугацаанд өсөх боломжтой гэж үздэг гарааны компаниуд болон жижиг бизнесүүдэд олгодог санхүүжилтийн нэг төрөл юм. Венчур капитал нь ерөнхийдөө чинээлэг хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын банкнууд болон бусад санхүүгийн байгууллагаас ирдэг. (Investopedia толь бичиг)
Анжел хөрөнгө оруулалт		“Angel” хөрөнгө оруулагч нь гарааны бизнест зориулж анхны эхлэлийн мөнгийг өгдөг бөгөөд үүнийг ихэвчлэн компанийн өмчлөлийн хөрөнгийн оронд

		өгдөг. (Investopedia толь бичиг)
Краудфандинг		“Crowdfunding” гэдэг нь шинэ бизнесийг санхүүжүүлэхэд олон тооны хувь хүмүүсийн бага хэмжээний хөрөнгийг ашиглах явдал юм. Crowdfunding нь хөрөнгө оруулагчид болон бизнес эрхлэгчдийг нэгтгэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн санхүүжилтийн вэбсайтуудаар дамжуулан хөрөнгө оруулагчдын нөөцийг эзэмшигчид, хамаатан садан, венчур хөрөнгө оруулагчдын уламжлалт хүрээллээс илүү өргөжүүлэх замаар бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжтой.

Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн үйл ажиллагааны салбар чиглэлийг мэдээллийн технологи, харилцаа холбоо гэж ялгаж нарийвчлан тогтоогүйн улмаас статистикийн тоо баримт, эдийн засгийн үр нөлөө нь “мэдээлэл, холбоо” гэсэн ангилалд хамаарч, холбогдох статистикийг ялгаж гаргах боломжгүй байдал үүсдэг.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Бүх нийтийн үүргийн сан, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Монгол Улсын их сургууль хамтран эрхлэн гаргасан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэр томъёоны толь бичигт Мэдээллийн технологи гэсэн үгийг тайлбарлаагүй байна.

Түүнчлэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлээс гадна мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрийн ангиллыг нарийн тогтоож өгөх шаардлагатай. Учир нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс тодорхой чиглэсэн орчин үеийн, нарийн мэргэжлийн дэд салбаруудыг сонгон дэмжих үзэгдэл олон улсад хүчтэй өрнөж байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн бодлогын тухай

Монгол улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна. Үүний нэг арга зам нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэл буюу мэдээллийн технологийн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн орчныг бий болгох бөгөөд энэ нь шинэ мэдлэг, технологийг бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглах замаар нийгмийн баялаг бүтээх үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа идэвхжин мэдээллийн технологийн гарааны бизнесийг олноор бий болж шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа сайжирч, чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө

оруулалтыг татах, Монгол Улсад ажлын байр шинээр бий болгох, судалгаа ба хөгжүүлэлт, инновацыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэх юм.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “3.2 Эдийн засгийн аюулгүй байдал” болон “3.6.Мэдээллийн аюулгүй байдал” хэсгийн дараах зорилтуудыг хангах боломжийг бүрдүүлнэ. 3.2.1.2.Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ. 3.2.1.5.Монгол орны цэвэр байгаль, оюуны нөөц, газар зүйн давуу талд түшиглэсэн, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, агаарын тээвэр, мэдээллийн технологи ашиглан экспортлох боломжтой өндөр өртөг бүхий бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ. 3.2.1.8.Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхыг хөгжүүлнэ. 3.6.1.9.Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулна.” гэж тус тус тусгажээ [6].

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Тус зорилгын хүрээнд 4.2 зорилтын 1-р үе шат буюу 2021-2030 онд онцлон хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгохоор 10 чиглэлийг “Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд” хэмээн тодорхойлсноос “5.Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.” гэж тусгажээ. Мөн түүнчлэн эдгээр 10 чиглэлд заасан салбаруудыг 2021 оноос 2030 оны хооронд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе гэж заасан. Харин 2.4-р зорилт нь “Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх алхмуудад: “1.Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна. 2. Шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлэх дэд бүтцийг өргөжүүлж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоотой болсон байна.” тус тус хүрэх үр дүнг тодорхойлжээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх 2 дугаар үе шат буюу 2031 оноос 2040 оны хооронд үндэсний шинжлэх ухаан, инновацыг дэлхийн зах зээлд гаргах тогтолцоог бүрдүүлэх үе бөгөөд “1.Нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэнэ.” гэсэн үр дүнг дэвшүүлжээ. Зорилт 2.6-д “Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.” гэж заасан байна. Тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн байх үр дүнд “2.Олон

улсад оюуны бүтээл, мэдээллийн технологийн болон зөвлөх үйлчилгээг дэмжих зуучлагч компани, төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.” гэж, Зорилт 7.5-д “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.” гэж заасан бөгөөд тус зорилтыг хэрэгжүүлэх 2 дүгээр үе шат буюу 2021 оноос 2030 онд хүрсэн байх үр дүнд “1.Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг хөгжүүлэн, инновац нэвтрүүлж, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл хөгжсөн байна.” гэж, 3 дугаар үе шат буюу 2041 оноос 2050 онд хүрэх үр дүнд “Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацыг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе.” гэж тус тус заажээ [7].

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.9-д “Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.” хэмээн тусгасан [8].

Монгол Улсын Засгийн газраас 2020 онд “Цахим үндэстэн” болох санаачилгыг дэвшүүлж, (1) Дижитал дэд бүтэц, (2) Цахим засаглал, (3) Мэдээллийн аюулгүй байдал, (4) Тоон бичиг үсгийн чадавх, (5) Инновац, үйлдвэрлэл, (6) Үндэсний хөгжлийн хурдасгуур гэх стратегийн зургаан зорилтыг баталсан [9]. Үүний үр дүнд сүүлийн гурван жилийн хугацаанд цахим засаглалыг бий болгохоор төрийн үйлчилгээний цахим систем “E-Mongolia” платформыг олон нийтэд танилцуулж өдгөө 1.6 сая иргэн ашиглаж байна. Мөн цахим хөгжлийн багц хуулиудыг батлуулж, одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Өнөөдрийн байдлаар 1600 орчим багийн 80 хувьд 4G сүлжээ оржээ. Үр дүнд нь 600 мянган айл өрх, гурван сая хүмүүс, үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж буй бүх байгууллагууд интернэт сүлжээнд холбогдсон ба интернэтийн хэрэглээ өмнөхөөсөө 14 дахин нэмэгдсэн байна.

Инновацын хуулийн тухай

Гарааны бизнесийн экосистем өндөр хөгжсөн улс болох АНУ, Англи, Сингапур, Герман, Израйль зэрэг улсууд гарааны бизнесийг татварын бодлогоор дэмжиж, амжилттай ажиллахад ихээхэн тусыг үзүүлж байна. Монгол Улсад мөн үүний эхлэл тавигдаж, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас гарааны бизнесийн хурдасгуур, хамтын оффис, технологи дамжуулах төвүүдээр дамжуулан инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж байгаа гарааны бизнесийн татварын хөнгөлөлт болон чөлөөлт олгохоор болсон.

2012 онд батлагдсан Монгол улсын “Инновацын тухай” хуульд “гарааны компани” гэсэн нэр томъёог тодорхойлсон ба Инновацын тухай хуулийн 16.4.1-д заасны дагуу технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид төрөөс татварын дэмжлэг үзүүлэх [10], түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулах зорилгоор Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоолоор “Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам”-ыг баталснаар гарааны бизнес эрхлэгчид доорх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн [11].

Хүснэгт 2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татварын хөнгөлөлт болон чөлөөлт	Татварын хөнгөлөлт болон чөлөөлтөд	Татварын хөнгөлөлт болон чөлөөлтөд хамрагдах үе шат
----------------------------------	------------------------------------	---

	хамрагдах боломжтой гарааны бизнес	
-Инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хөнгөлөх; -Инновацийн бүтээгдэхүүнд хамааралтай түүхий эд, материал, урвалж бодисыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх; -Бүтээгдэхүүнд хамаарах гаалийн татвараас чөлөөлөх.	-Инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа; -Бүтээгдэхүүн, үйлчилгээг эхлүүлээд 5 жил болоогүй байгаа; - Хамтын оффис болон гарааны бизнесийн хурдасгуур төвд бүртгэлтэй.	1. Инновацийн төслөө бичиж, онлайн системд хүсэлт гаргана. 2. БШУЯ-ны шинжээчид хүсэлтийг судлан дүгнэлт гаргаж, төслийг бүртгэнэ. 3. Улсын бүртгэлийн ерөнхий газарт төслийн болон компанийн мэдээллийг хүргүүлнэ. 4. Татварын ерөнхий газар болон гаалийн ерөнхий газарт холбогдох мэдээллийг хүргүүлж, татварын хөнгөлөлт болон чөлөөлөлтөд хамрагдах боломжтой.

Дээрх татварын хөнгөлөлт, дэмжлэг нь гарааны бизнесийг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч, 2022 онд Жайка, KITE, MMCG байгууллагуудаас гаргасан Монголын гарааны бизнесийн экосистемийн судалгааны тайланд дурдснаар Инновацийн тухай хуульд бүх гарааны бизнесийг төрийн байгууллагад бүртгүүлж, бүтээгдэхүүнийг нь инновацтай эсэхийг төрөөс шийдвэрлэдэг байхаар заасан. Энэ нь аливаа ач холбогдолгүй, зөвхөн хүнд суртлыг үүсгэж байна хэмээн тусгажээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуулийн тухай

Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр батлагдсан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг улсын бүртгэлд бүртгүүлсэн ашиг олох зорилго бүхий дотоодын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид үйлчлэх бөгөөд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэнэ.

Уг хуулийн нэр томъёоны тодорхойлолтод зааснаар “жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг хэлэх бөгөөд дараах 3 ангилалд хуваагдана:

- "бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;
- "жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;
- "дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг.

Хуулийн үйлчлэх хүрээнд хамрахгүй салбарыг хуулийн 7 дугаар зүйлд дараах байдлаар тогтоосон:

- барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ;
- зуучлалын үйлчилгээ;
- хууль зүйн зөвлөх үйлчилгээ;
- худалдаа, үйлчилгээний сүлжээ;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.4, 13.5-д заасан үйл ажиллагаа;
- ашигт малтмал хайх, газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, боловсруулах.
- тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт;
- төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа;
- банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгалын үйлчилгээ.

Жижиг дунд, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулиар төрөөс баримтлах бодлогын чиглэлийг тогтоож, кластераар хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зэрэг бусад дэмжлэгийн төрлүүдийг дурдсан байна [12].

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн тухай

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан сүүлийн 14 жилд нийт 8403 төсөлд 1,011 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Үүнээс энэ оны 4 дүгээр сарын 23-ны байдлаар нийт зээлдэгч ААН-ийн 85 хувь нь 735,3 тэрбум төгрөгийн зээлээ бүрэн төлж барагдуулсан байна. Мөн 4 дүгээр сарын 23-ны байдлаар ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас шууд зээл авсан 912, банкаар дамжуулан зээл авсан 346 зээлдэгчийн 210.2 тэрбум төгрөгийн 1,258 идэвхтэй зээлдэгч байна.

Эдгээр 1,258 идэвхтэй зээлдэгчийн 438 буюу 34.8% нь муу зээлдэгчийн ангилалд байна. Тодруулбал, сангаас шууд зээл авсан 374 төслийн 107 тэрбум төгрөг, банкаар дамжуулсан 64 төслийн 43,4 тэрбум төгрөгийн зээл уг ангилалд байна. Үүнийг оноор харьцуулбал:

- 2020 оноос өмнө 317 ААН-ийн 145,7 тэрбум төгрөг
- 2020 оноос хойш 57 ААН-ийн 4,7 тэрбум төгрөг

Хүснэгт 3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

	2017	2018	2019	2020	2021
Бүгд	44,608	47,863	49,982	51,235	53,931
Мэдээлэл, холбоо	957	1,056	1,170	1,354	1,594
Эзлэх хувь	2%	2%	2%	3%	3%

Хүснэгт 4. ЖДҮ-ийн нийт экспорт, импортын дунд эзлэх хувь

	2017	2018	2019	2020	2021
Экспорт	4.3	4.1	2.9	3.4	2.4

Импорт		14.5	23.6	15	13.7
--------	--	------	------	----	------

Үндэсний статистикийн хорооноос 2022 онд эрхлэн гаргасан “Эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр 2021” тайланд дурдсанаар Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 2.1 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бий болгосон нь ДНБ-ий 5.5 хувийг бүрдүүлсэн байна. Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 2021 онд 493.4 тэрбум төгрөг болж, үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөгт ЖДҮ 3.1 хувийг эзэлж байна.

Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 1353.0 тэрбум төгрөг болж, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөгт 8.7 хувийг эзэлж байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 621.0 тэрбум төгрөгийн бараа экспортолж, 1894.0 тэрбум төгрөгийн бараа импортолсон нь нийт барааны экспортын 2.4 хувь, импортын 9.7 хувийг эзэлж байна. Экспортын 89.2 хувийг БНХАУ-д гаргасан бол импортын 53.7 хувийг БНХАУ-аас оруулж ирсэн байна.

Экспортын барааны 52.4 хувь нь мал, амьтны ноос, ноолуур, 29.4 хувь нь эрдэс бүтээгдэхүүн, 4.9 хувь нь мах, мал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн байна. Импортын барааны 18.5 хувь нь машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 15.2 хувь нь үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлс байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн 11.0 хувийг хөдөө аж ахуйн салбар, 23.8 хувийг үйлдвэрлэлийн салбар, 65.2 хувийг үйлчилгээний салбар тус тус эзэлж байна [14].

Дээрх тоон мэдээлэл, бусад үзүүлэлтээс харвал Жижиг, дунд үйлдвэрлэлийн хууль тогтоомж, сангууд нь мэдээллийн технологийн гарааны бизнесийг мэдэгдэхүйц дэмжихгүй байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

Монгол Улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болсноор үндэсний аюулгүй байдлын эдийн засгийн аюулгүй байдал хангагдаж, тээвэр ложистик, дэд бүтцийн нөхцөл байдлаас үл хамаарах экспортын үйлдвэрлэл хөгжих шууд үр ашигтай бөгөөд боловсролын бүх шатны байгууллагын хүний нөөц бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг болж, гадаадын шууд болон шууд бус хөрөнгө оруулалтыг татаж, бүс нутгийн технологийн экосистем болон хөгжих боломж бүрдэнэ.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжсөнөөр, шууд болон шууд бусаар Монгол Улсын төсвийн орлого, өрхийн орлогод эергээр нөлөөлөх бөгөөд гадагшаа чиглэсэн ур чадвартай хүний нөөцийн урсгал (braindrain)-ыг сааруулна. Тус салбарын эрдэмтэд, багш оюутнууд, бизнес эрхлэгчид, энтрепренёр, хөрөнгө оруулагчдыг хөгжүүлэх, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжсөнөөр программ хангамж, техник хангамжийн импортыг орлох, нийгэм эдийн засгийн тухайлбал хөдөө аж ахуй, уул уурхай, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын бүтээмж нэмэгдэнэ.

1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх зорилтыг хангалттай дэвшүүлсэн.

Мэдээллийн технологийн салбар нь мэдлэгт тулгуурласан, бүх шатны боловсролын чанар, тогтвортой санхүүгийн хүртээмж шаарддаг бөгөөд хөгжүүлэхэд бусад орны туршлага, хөрөнгө оруулалтыг татах замаар үсрэнгүй хөгжих боломжтой.

Монгол дахь арилжааны банкны бизнесийн зээлийн дийлэнх хувь нь өндөр хүүтэй, барьцаа хөрөнгө шаарддаг, богино хугацааны зээлүүд байдаг тул үндэсний жижиг дунд, бичил бизнес эрхлэгчид өсөн дэвжихэд бэрхшээлтэй байна.

Инновацын тухай хууль, Жижиг, дунд, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулиудаар тодорхой хэмжээнд инновац үйлдвэрлэл, жижиг дунд бизнесийг дэмжсэн боловч хязгаарлагдмал хүрээтэй, нөгөө талаас мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, тэр дундаа үйлчилгээ нь заавал инновац бүтээх албагүй байдаг тул уг хуулийн хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй.

Инновацын тухай хууль болон бусад хууль, тогтоомжид олон улсад түгээмэл хэрэглэгдэж байгаа мэдээллийн технологийн салбар, гарааны бизнесийн хөгжлийн нэр томьёонууд тусаагүй эсвэл тухайн хууль тогтоомжийнхоо хүрээнд хязгаарлагдмал тодорхойлогдсон байгаа тул олон улсын жишгийн дагуу шинээр тодорхойлох шаардлагатай байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрөөс бодлогоор дэмжих шаардлагатай байгааг бусад улсын туршлага, олон улсын байгууллагын зөвлөмж, судалгаанууд харуулж байна. Мэдээлэл, технологийн салбар нь бусад салбар буюу уул уурхай, хөдөө аж ахуй зэргийг бодвол цоо шинэ салбар бөгөөд хэдийгээр хөрөнгө оруулалт, түүхий эд, дэд бүтэц бага шаардах боловч ур чадвартай хүний нөөц, тогтвортой ажиллах хүч, тусгай санхүүгийн дэмжлэг шаардлагатай.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай эрх зүйн орчны зохицуулалт нь дараах зорилготой байна, үүнд:

- Мэдээллийн технологи, гарааны бизнес, энтерпренёршип зэрэг салбарын онцлог холбоотой нэр томъёог агуулгын хувьд өөрөөр томъёолсныг дахин, олон улсын жишигт нийцүүлэн томъёолох;
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагаа, тогтолцоог төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөгжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, хэмжээг нэмэгдүүлэх
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, баталгаагаар хангах
- Ур чадвартай хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвортой ажиллахад таатай орчныг санхүүгийн болон бусад хэлбэрээр бүрдүүлэх
- Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаадын болон хамтарсан компани байгуулах, үйл ажиллагаа явуулахад таатай орчныг бүрдүүлэх, гадаадын өндөр ур чадвартай мэргэжилтнүүд ирж ажиллах зэрэг үйл ажиллагааг хялбар, хүнд сурталгүй болгох
- Бизнес эрхлэх, компани байгуулах, өөрчлөх, татвар, нийгмийн даатгал, оюуны өмч болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахад цахимаар, хурдан шуурхай бүртгэх боломжийг бүрдүүлэх
- Мэдээллийн технологийн гарааны компанийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг нь зах зээлд нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт олоход дэмжлэг үзүүлэх боломжийг тусгах
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, гарааны бизнесийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа дундын оффис, инкубатор, санхүү, технологийн болон бусад зөвлөх үйлчилгээг дэмжих, эдгээр үйл ажиллагааг уялдуулан зохицуулах бүтцийг тогтоож өгөх.
- Хувь хүн, хуулийн этгээдийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, экспортын татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ялгаатай тогтоох замаар гарааны бизнес, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид учрах санхүүгийн ачааллыг хөнгөвчлөх арга замыг тусгах.

**ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН
ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Энэхүү тайланд дурдсан асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудыг тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 5. Зохицуулах хувилбаруудыг харьцуулсан байдал

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Эерэг тал	Сөрөг тал
“тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Зорилгод бүрэн хүрэх боломжгүй.	Зардал гарахгүй, үр өгөөжгүй	Давуу тал байхгүй	Инновацийн тухай хууль, бусад хууль тогтоомжид их хэмжээний өөрчлөлт оруулж, ойлгомжгүй байдал үүсгэнэ
Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Зорилгод бүрэн хүрэх боломжгүй.	Зардал бага буюу зөвхөн хэвлэл мэдээллийн зардал гарах боловч үр өгөөжгүй.	Тусгай хууль тогтоомжийн өөрчлөлт шаардахгүй, зардал бага шаардагдана.	Бусад улсуудтай харьцуулахад өрсөлдөх чадваргүй эко системтэй тул эсрэг нөлөө үзүүлэх, үргээх магадлалтай.
Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Зорилгод бүрэн хүрэх боломжгүй.	Зардал их гарна, асуудлыг сууриар нь шийдэхгүй тул үр өгөөж муу.	Тусгай хууль тогтоомжийн өөрчлөлт шаардахгүй	Тогтвортой хөгжих орчин, хөгжлийн үе шатанд тохирох дэмжлэгүүд байхгүй тул үргүй зарцуулагдах магадлал өндөр.
Төрөөс санхүүгийн интервенц хийх	Зорилгод бүрэн хүрэх боломжгүй.	Зардал их гарна, асуудлыг сууриар нь шийдэхгүй тул үр өгөөж муу.	Тусгай хууль тогтоомжийн өөрчлөлт шаардахгүй	Тогтвортой хөгжих орчин, хөгжлийн үе шатанд тохирох дэмжлэгүүд байхгүй тул үргүй зарцуулагдах магадлал өндөр.
5.	<u>Хилийн чанад дахь хурдасгуур дэмжлэг хөтөлбөр</u>	Манай улсад судалгаа шинжилгээ, инновацын үйл ажиллагаа явуулж буй технологийн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд гаргах	- Бизнес нь Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх байгууллагад өргөдөл гаргах, хянаж үзсэний үр дүнд өргөдлийг батлах	Сарын хэрэгцээ, оролцоо, боловсон хүчин, байр, өдөр тутмын зардал, тээврийн зардал зэрэг янз бүрийн мөнгөн дүнгээр дэмжлэг үзүүлдэг.
6.	<u>ЖДУ-ийн технологийн бүтээгдэхүүний хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр</u>	Судалгаа хөгжүүлэлт, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн болон дунд-өндөр, өндөр технологийн салбарт экспортыг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих	- Инновацын төслөөрөө төрийн байгууллага болон олон улсын байгууллагуудын сангуудаас дэмжлэг авсан, патентын гэрчилгээ гэх мэт үр дүн гарч, прототипийн ажил амжилттай дууссан байх нь чухал юм.	Энэ нь бага, дунд-бага технологийн бүс дэх бүтээгдэхүүн, дунд-өндөр, өндөр технологийн бүсийн бүтээгдэхүүнд үзүүлэх янз бүрийн дэмжлэгийг хамардаг.

4. Туркийн Шинжлэх ухаан, технологийн судалгааны зөвлөл /ШУТСЗ/-өөс төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд байдаг ба эдгээр хөтөлбөрүүд нь дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Туркийн ШУТС3-н дэмжлэг, хөтөлбөрүүд

Дэмжлэг, хөтөлбөр	Дэмжлэг, хөтөлбөрийн зорилго	Дэмжлэг, хөтөлбөр ийн урьдчилсан нөхцөл	Дэмжлэг, хөтөлбөрийн хамрах хүрээ
1. <u>ТШУТС3 ЖДҮ-ийн судалгаа ба хөгжүүлэлтийн гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр</u>	ЖДҮ-үүд технологийн хөгжил, инновацын үйл ажиллагаагаар бүтээмжээ нэмэгдүүлж, нэмүү өртөг өндөртэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд хандуулах	- ЖДҮ байх нөхцөлийг хангах; - компанийн түвшинд нэмүү өртөг бий болгодог турк улсад үүсгэн байгуулагдсан компани байх;	Дэмжлэгийн хугацааг дээд тал нь 18 сар, дэмжлэгийн дээд хязгаарыг дээд тал нь 500,000 турк лир гэж тодорхойлсон бөгөөд судалгаа ба хөгжүүлэлтийн шаардлага хангасан төслийн зардал, урамшууллын шагналыг багтаасан байна.
2. <u>ТШУТС3 тэргүүлэх чиглэлийн судалгааны технологийн хөгжил, инновацын төслийг дэмжих хөтөлбөр</u>	Турк улсад төвтэй байгууллагуудын үндэсний тэргүүлэх чиглэлүүдийг уриалан нэмүү өртөг бий болгох судалгаа, боловсруулалт, шинэлэг төслүүдийг дэмжих.	Компанийн түвшинд нэмүү өртөг бүтээдэг турк улсад байгуулагдсан компаниуд төсөлд хамрагдах боломжтой.	Дэмжлэгийн үргэлжлэх хугацаа, хэмжээг хязгаарлаагүй боловч үүнд судалгаа ба хөгжүүлэлтийн шаардлага хангасан төслүүдийн хувьд янз бүрийн хэмжээний буцалтгүй тусламжийн дэмжлэг, түүнчлэн гадаадад үйлчилгээ худалдан авах, ерөнхий зардлын дэмжлэг орно.
3. <u>ТШУТС3 Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр</u>	Хувь хүний гарааны бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг санааны шатнаас зах зээлд нийлүүлж, технологи, инновацад чиглэсэн бизнес санаагаа нэмүү өртөг бий болгох, мэргэшсэн ажлын байр бий болгох өндөр чадамжтай аж ахуйн нэгж болгон хувиргах.	Албан ёсны их, дээд сургуулийн аль ч бакалаврын хөтөлбөрийг жилийн дараа төгсөх боломжтой оюутан, магистр, докторант, эсвэл өргөдөл гаргасан өдрөөс хамгийн ихдээ 5-жилийн өмнө бакалавр, магистр, докторын зэрэг хамгаалсан бизнес эрхлэгч байх.	Үүсгэн байгуулах гэж буй компанид олгох нэг удаагийн дээд хэмжээ 100000 турк лирийн дэмжлэгийг үзүүлэх.


4.	<u>ТШУТС3 олон улсын аж үйлдвэрийн судалгаа</u> <u>хөгжүүлэлтийн төслүүдийг дэмжих хөтөлбөр</u>	Олон улсын хамтарсан дэмжлэгийн хөтөлбөрт (EUREKA, EUROSTARS, Европын Холбооны хүрээний хөтөлбөрийн хүрээнд хамтарсан төсөл хэрэгжүүлэхийг уриалсан хөтөлбөрүүд болон ижил төстэй олон улсын хөтөлбөр, төслүүд) хамрагдсан Турк улсад төвтэй байгууллагуудын судалгаа, хөгжлийн болон шинэлэг төслүүдийг дэмжих.	Турк улсад байгуулагдсан, түвшинд нэмүү өртөг бий болгодог компаниудын нэг үүсгэн	Дэмжлэгийн хугацаа, хэмжээг хязгаарлахгүй бөгөөд томоохон байгууллагуудад 60%, ЖДҮ-д 75% буцалтгүй тусламж үзүүлнэ.
5.	<u>ТШУТС3 ЖДҮ-ийн судалгаа</u> <u>хөгжүүлэлтийн гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр</u>	ЖДҮ эрхлэгчдийн техник технологи хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлчилгээнд шилжихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор эхний 5 төсөлд давуу талтай дэмжлэг үзүүлэх.	- ЖДҮ байх нөхцөлийг хангах; - Компанийн түвшинд нэмүү өртөг бүтээдэг турк улсад байгуулагдсан компаниуд	Дэмжлэгийн хугацааг дээд тал нь 18 сар, дээд хязгаар нь 500,000 турк лир байхаар тогтоогдсон бөгөөд үүнд судалгаа ба хөгжүүлэлтийн шаардлага хангасан төслийн зардлын 75% буцалтгүй тусламж, амжилттай төсөлд 7,500 турк лирийн урамшууллын шагнал багтсан болно.

5. Эдгээр хөтөлбөрүүдээс гадна Үйлдвэр, технологийн яаманд хүсэлт гаргасны үр дүнд Үйлдвэр, технологийн яамны “Судалгаа хөгжүүлэлтийн төв”-ийн гэрчилгээг авсан тохиолдолд орлогын албан татвар суутгалын урамшуулал, даатгалын шимтгэлийн урамшуулал, улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх зэрэг төрөл бүрийн урамшуулал/дэмжлэгүүдийг авах боломжтой.
6. Худалдааны яамнаас бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн дэмжлэг, барааны тэмдгийн гадаад бүртгэл, хамгаалалт, шударга оролцоог дэмжих, дотоод сурталчилгаа-сургалтын дэмжлэг, зөвлөх үйлчилгээний дэмжлэг зэрэг олон төрлийн дэмжлэг үзүүлж, ялангуяа экспортыг хөгжүүлэх, олон улсын брэнд болгох, зах зээлд тогтвортой байдлыг хангах зэрэг хөтөлбөрүүдэд яамны Дэмжлэгийн удирдлагын системээр дамжуулан авах боломжтой [23].


Туркийн финтекийн гарааны бизнесийн экосистемийн хөгжлийн тухай

2022 онд финтек компаниудын хөрөнгө оруулалт дээд амжилт тогтоосон жилийн дараа 2023 оны есдүгээр сарын байдлаар 14 Финтек компанид 9 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Туркийн финтекийн экосистемд идэвхтэй 656 финтек компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд блокчэйн болон крипто хөрөнгө, санхүүжилт, төлбөрийн босоо чиглэлүүд онцгой анхаарал татаж байна [24].


ФИНТЕК КОМПАНИУД



СТАРТАПУУДЫН ДАТА




ФИНТЕК КОМПАНИУД, ЧИГЛЭЛЭЭР




ФИНТЕК КОМПАНИУД, ЧИГЛЭЛЭЭР, ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАН ОН

TOP 5	2018	2019	2020	2021	2022	2023*
1	Блокчейн, крипто, технологийн	Төлбөр	Блокчейн, технологийн	Төлбөр	Төлбөр	Блокчейн, крипто, технологийн
2	Төлбөр	Төлбөр	Блокчейн, технологийн	Блокчейн, крипто, технологийн	Блокчейн, крипто, технологийн	Блокчейн, крипто, технологийн
3	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн
4	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн
5	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн	Блокчейн, технологийн


ФИНТЕК АНЖЕЛ, ВЭНЧУР КАПИТАЛ ХЭЛЦЭЛ




ФИНТЕК КОМПАНИЙН ХУДАЛДАЛАЛТ



ФИНТЕКТИЙН* ХҮЙСЭМ АНЖЕЛ БОЛОН ВЭНЧУР КАПИТАЛИСТ ХЭЛЦЭЛ



ФИНТЕКТИЙН ЗҮГЭЭС ХИЙГДСЭН ХУДАЛДАН АВАЛТ



Эх сурвалж: Турк Улсын Ерөнхийлөгчийн Санхүүгийн судалгаа 2023

Зураг 7. Туркийн финтек стартапын өнөөгийн байдал

6.4. Узбекистан улсын туршлага

2016 оноос хойш Узбекистан эдийн засгийн хэд хэдэн чухал реформыг хэрэгжүүлсэн. Түүхий эдийн экспортын үнэ ихээхэн хэлбэлзэж, дотоодын тогтворгүй байдлыг бий болгодог тул тус улс байгалийн хий, алт, хөвөн, зэс зэрэг бүтээгдэхүүнээс ихээхэн хамааралтай байдлаа багасгахыг эрэлхийлж эхэлжээ. Засгийн газар эдийн засгийг төрөлжүүлэх, хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар илүү тогтвортой эдийн засгийн суурийг бий болгохыг зорив.

Засгийн газар бизнес эрхлэлт, одоо мөрдөгдөж буй зохицуулалтууд болон бусад улс орнуудын стратегид дүн шинжилгээ хийсний үндсэн дээр 2017-2021 оны үйл ажиллагааны стратегийг баталж, банк санхүү, татвар, худалдаа, төрийн өмчит үйлдвэрийн хувьчлал зэрэг олон салбарт реформ хийв. Үүний үр дүнд эдийн засаг илүү нээлттэй, зах зээлийн хандлагатай болсон.

Эдийн засгийн хөгжилд инновац, технологи, тэр дундаа дижитал технологийн үүрэг нь дэлхий дахинд улам бүр хүлээн зөвшөөрөгдөж байх үед тус реформ хийгдэж, тухайн үед шинэ төрлийн бизнесийн байгууллага буюу технологид суурилсан гарааны бизнесүүд бий болжээ.

Засгийн газар технологийн инновац, энтерпренёршипийн хосолсон үйл ажиллагаа, тэр дундаа технологийн гарааны бизнесийн үүрэг оролцоог дэмжихийг эрмэлзэж байв. 2015 онд Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн яамыг, 2 жилийн дараа Инновацийн хөгжлийн яамыг байгуулсан ба 2018 оныг "Идэвхтэй энтерпренёршип, инновацлаг санаа, технологийг дэмжих жил" болгон зарлаж, инновац, технологийн гарааны бизнесийг дэмжих шинэ бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулав. Эдгээр арга хэмжээ нь технологийн гарааны бизнесүүдэд чанартай экосистемийг бий болгох үйл явцыг эхлүүлэхэд тусалсан юм.

Узбекистаны гарааны бизнес ба экосистемийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд

Узбекистан дахь гарааны бизнесийн коммюнити хөгжиж байгаа ч эхэн үедээ байна. Ихэнх гарааны бизнес эхний үе шатыг давж амжаагүй байгаа бөгөөд багахан хувь нь өргөжин тэлэх хэмжээнд хүрсэн байна. Экосистем нь мөн хөгжиж байгаа ч гарааны бизнест үзүүлж буй дэмжлэгийн чанарыг сайжруулж, хөгжүүлэхэд цаг хугацаа хэрэгтэй. Тухайлбал, гарааны бизнесийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах шаардлагатай юм.

Узбекистан улсад гарааны бизнес болон экосистемийн талаар мэдээлэл цуглуулах системтэй механизм дутмаг. Жижиг, дунд үйлдвэрүүдэд зориулсан тайлагналын маягт нь технологид суурилсан, технологид суурилдаггүй, гарааны бизнес болон уламжлалт бизнес гэж ялгахгүйгээр бүх төрлийн бизнесийг хамардаг.

2020 оны эхээр Дижитал Узбекистаныг хэрэгжүүлэх замын зураглал - 2030 стратегийн хүрээнд "Гарааны бизнесийн тухай" хуулийн төслийг боловсруулав. Үүний гол зорилго нь гарааны бизнест үзүүлэх дэмжлэгийг зохицуулах, координац хийх явдал юм. Энэ нь гарааны бизнесийг бий болгох, экосистемийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй хөтөлбөр хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулах зэрэг гарааны бизнесийн тухай ойлголтыг тодорхой болгож, дэмжих зарчим, чиглэлийг тодорхойлсноос гадна "стратап" гэсэн нэр томъёоны нарийн тодорхойлолтыг өгсөн тус улсын анхны хууль эрх зүйн баримт бичиг юм. Мөн гарааны бизнесийг санхүүжүүлэх эх үүсвэр, хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг тодорхойлсон ба гарааны бизнесийг үнэн зөв тоолоход шаардлагатай тодорхойлолтуудыг өгөхөд туслах юм.

Үүнээс гадна гарааны бизнес, инкубаторууд, хурдасгуур хөтөлбөрүүд, менторууд, сан, бизнесийн анжел хөрөнгө оруулагчид зэрэг мэдээллийг агуулсан нэгдсэн платформтой болох нь ашигтай байх болно. Энэхүү мэдээллийг экосистем болон тодорхой салбаруудын чанарын болон тоон ахиц дэвшил, үзүүлсэн дэмжлэгийн өөрчлөлтийн динамикийг харуулахад ашиглаж болох юм [25].

Засгийн газрын стратеги, хууль тогтоомж, холбогдох арга хэмжээ

2015 оноос хойш Укбекстаны Засгийн газар тунхаглал гаргах, стратеги боловсруулах, инновац, энтрепренёршипийг дэмжих чиглэлээр хууль тогтоомж гаргахаар идэвхтэй ажиллаж байна. Эдгээр арга хэмжээнүүд нь гарааны бизнесийн илүү сайн экосистемийг дэмждэг бөгөөд одоогоор үүний нөлөөллийг тодорхойлоход хэцүү юм.

Инновацын ач холбогдлыг онцолж, 2018 оныг Засгийн газраас “Идэвхтэй энтрепренёршип, инновацлаг санаа, технологийг дэмжих жил” болгон зарласан. Мөн онд 2019-2021 оны Инновацын хөгжлийн стратегийг баталсан юм. Стратегийн гол зорилго нь инновац, дэлхийн өрсөлдөх чадварыг дэмжих гол хүчин зүйл болох хүмүүн капиталыг дэмжих явдал байв. Энэхүү стратеги нь боловсролын чанарыг сайжруулах, нийт хүн амыг хамрах хүрээг өргөжүүлэх, инновацт төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой байв. Оны эцэс гэхэд Энтрепренёршип, инновацын салбарын төслүүдийг санхүүжүүлэх механизмыг боловсронгуй болгох тухай Ерөнхийлөгчийн зарлиг гарав.

Дараагийн жилүүдэд нэмэлт арга хэмжээ авсаар байв. Тухайлбал, 2019 оны тавдугаар сард “Хөрөнгө оруулалт, менежментийн компаниудын үйл ажиллагааны тухай” Засгийн газрын тогтоол, 2020 онд “Инновацын үйл ажиллагааны тухай” хууль тус тус батлагдав. 2022 оны эцэс гэхэд өөр хоёр хуулийн төслийг боловсруулж, одоогоор хэлэлцүүлгийн шатанд байна. Хязгаарлагдмал түншийн тухай хуулийн төсөл нь менежментийн компаниудад (“ерөнхий түншүүд” гэж нэрлэгддэг) хөрөнгө оруулагчдын (“хязгаарлагдмал түншүүд” гэх) хөрөнгийг удирдах боломжийг олгох бөгөөд энэ нь венчур хөрөнгө оруулалт болон холбогдох сангийн үндэс суурь болох юм. Түүнчлэн гарааны бизнесийн тухай хуулийн төсөлд хувийн хэвшлийг санхүүгийн хөшүүрэг болгох замаар гарааны бизнест хөрөнгө оруулахыг дэмжих төрийн арга хэмжээг авахаар тусгасан. Энэ хоёр хууль батлагдсанаар венчур хөрөнгө оруулалтын сан болон гарааны бизнесийг дотоодын санхүүжилтээр хөгжүүлэхэд түлхэц болно. Одоогийн байдлаар зарим гарааны бизнесүүд венчур хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн бүтэц илүү хөгжсөн бусад улс орнуудаас санхүүжилт хайж, хүлээн авч байна.

Өмнөх стратегийн ажлыг үргэлжлүүлэх, өргөжүүлэх зорилгоор 2022 оны 7-р сард 2022-2026 оны Инновацын хөгжлийн стратегийг баталсан. Уг стратеги нь дараах үндсэн зургаан чиглэлээр дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэж байна. Үүнд, нэгдүгээрт, 1413 ажлын байр бий болгох 122 гарааны бизнесийн төсөлд 75 тэрбум сумын санхүүжилт олгоно. Хоёрдугаарт, гарааны бизнесийг технологийн парк, эдийн засгийн тусгай бүсэд байршуулахыг дэмжиж, хувийн хэвшлийнхнийг шинжлэх ухааны хөгжлийг дэмжих сонирхлыг нэмэгдүүлж, хамтран санхүүжүүлэхийг дэмжинэ. Гуравдугаарт, инновацын технологийн парк, технологи дамжуулах төв, инновацын кластер, венчур байгууллага, инновацын төв, инкубатор, хурдасгуур зэрэг шинэлэг дэд бүтцийн төслүүдийн сүлжээг хэрэгжүүлнэ. Дөрөвдүгээрт, хурдасгуур хөтөлбөр, ложистик, санхүүжилтийн үйлчилгээ, зах зээлд нэвтрүүлэх, технологи дамжуулах төвүүдийн үйл

ажиллагааг өргөжүүлэх зэрэг инновацыг дэмжихэд дэмжлэг үзүүлнэ. Тавдугаарт, гарааны бизнест зориулсан орчин үеийн санхүүжилтийн механизмыг (венчур капитал, олон нийтийн санхүүжилт гэх мэт) хөгжүүлэх, хялбаршуулсан санхүүжилтийн үйл ажиллагааг өрсөлдөөнт орчинд ("ирээдүйн эрдэмтэн", хакатон, технологийн марафон гэх мэт) өргөжүүлэхэд хүчин чармайлт гаргана. Зургаадугаарт, инновацлаг технологийн парк, эдийн засгийн чөлөөт бүсэд оршин суух зөвшөөрөл олгох журамтай хамт татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлнэ гэж тусгажээ [25].

Засгийн газрын бүтэц, хөтөлбөрүүд

Засгийн газар шинэ хууль тогтоомж, стратегиас гадна инновац, технологийн дэвшлийг дэмжих шинэ бүтэц, хөтөлбөрүүдийг бий болгосон. Эдгээрийн зарим нь технологийн гарааны бизнесийг дэмжих зорилгоор тусгайлан боловсруулагдсан байна. Тус улсын Засгийн газар дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдээс гадна технологийн парк, бизнес инкубатор ба хурдасгуур, коворкинг төв гэх мэт инновацтай холбоотой 19 дэд бүтцийн байгууламж барьжээ.

Төрийн захиргааны реформын хүрээнд Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн яам (МТХХЯ) 2015 онд байгуулагдсан. Энэ нь 2019 онд программ хангамж, мэдээллийн технологи үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдэд зориулсан мэдээллийн технологийн паркийг байгуулжээ. МТХХЯ нь тус парк болон бусад үйл ажиллагаагаар дамжуулан (i) мэдээллийн технологи (МТ) салбарыг хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх; (ii) түрээслэгчдийг шаардлагатай дэд бүтэц, зөвлөх үйлчилгээгээр хангах; (iii) инкубаторын болон хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан гарааны бизнесийг дэмжих; ба (iv) мэдээллийн технологийн чиглэлээр сургалт зохион байгуулахаар зорьж байна.

2022 оны эцэс гэхэд МТХХЯ улс даяар 150 гаруй мэдээллийн технологийн төв байгуулж, 40,000 оюутанг дижитал ур чадварт сургажээ. Мөн татвар, гаалийн хөнгөлөлт үзүүлэх замаар мэдээллийн технологийн 450 компани байгуулахыг дэмжив. Мөн инкубаторын болон хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан 100 гаруй гарааны бизнес эрхлэгчдийг сургасан байна. 2022 оны сүүлээр МТХХЯ нь Дижитал технологийн яам болов.

Инновацын хөгжлийн яам (ИХЯ) 2017 онд байгуулагдаж, улсын гарааны бизнесийн экосистемийг бүрдүүлэн хөгжүүлэх ажлыг эхлүүлэв. Тус яам нь улс орны оюуны болон технологийн чадавхыг нэмэгдүүлэх инновацын хөгжлийн чиглэлээр нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд чиглэдэг ба засгийн газрын буцалтгүй тусламжид үндэслэн гарааны бизнесийг уралдаанд оролцуулах замаар санхүүжүүлэх журмыг нэвтрүүлэв. Тус яамны бодлого, чиглэл болох (i) төрийн байгуулалт, нийтийн хөгжилд инновацыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх; (ii) хөдөө аж ахуйн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн салбарт инновацыг нэвтрүүлэх; (iii) инновац болон технологийг нэвтрүүлэх зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох зэргийг Инновацын хөгжлийн газар хэрэгжүүлдэг байна.

ИХЯ нь дараах гурван чухал хөтөлбөрийг эхлүүлжээ. Үүнд, нэгдүгээрт, Инновацын хөгжил, инновацлаг санааг дэмжих санг таван сая ам.долларын хишигтэй байгуулсан. Хоёрдугаарт, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан инкубатор, хурдасгуур хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Технологийн шилдэг төвийг байгуулсан. Гуравдугаарт, Яшнобод инновацын технологийн парк баригдаж, түрээслэгчдэд татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээл, газар болон бусад боломжуудыг олгов. 1988-2022 онуудад тус инновацын технологийн паркад бизнес

эрхлэгчид 84 сая ам.долларын бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэсэн бөгөөд үүний 10 гаруй хувийг экспортод гаргаж, 357 орчим ажлын байр бий болгожээ.

Инновацийн хөгжил, инновацлаг санааг дэмжих сан нь шинжлэх ухаан, шинжлэх ухааны судалгааны хөгжлийг санхүүжүүлэх зорилготой тул гарааны бизнесийн экосистемд үзүүлэх эерэг нөлөөг зах зээл хараахан мэдрээгүй байна.

Засгийн газар инновацын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй залуу бизнес эрхлэгчдийг дэмжихэд онцгой анхаарч ирсэн. Бүгд Найрамдах Каракалпакстан Улс болон Андижан, Самарканд, Сырдарья, Ташкент, Навои зэрэг бүс нутагт нийтдээ 40,8 тэрбум сумын өртөгтэй залуучуудын технологийн паркуудыг байгуулжээ. Эдгээр залуучуудын технологийн паркуудад 1500 орчим залуус шинжлэх ухаан, инновацын үйл ажиллагаанд хамрагдаж, хурдасгуур хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Бухара, Жиззах, Кашкадарья, Наманган, Фергана, Хорезм, Сурхандарья зэрэг 7 бүс нутагт тус бүр нэг залуучуудын технологийн парк байгуулахаар төлөвлөж байна.

2021 онд Ташкент хотын оюутны хотхонд 2 га талбайд 114 тэрбум сумын өртөгтэй, барилга, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр бүрэн хангагдсан, 4000 орчим залуучуудыг хүлээн авах хүчин чадалтай Инно хэмээх инновацлаг боловсрол, үйлдвэрлэлийн технологийн парк баригдав. Энд залуучууд 54 туршилтын загварыг боловсруулж, 11 гарааны компани байгуулж, 84 ажлын байр бий болгожээ [25].

Төрөөс гарааны бизнесийг дэмжих шинэ арга замууд

Узбекистаны гарааны бизнесийн экосистемийг бий болгоход засгийн газраас дэмжлэг үзүүлэх боломжтой өөр дөрвөн арга зам бий. Эдгээр нь төрийн худалдан авалт, нэгж, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулах, томоохон компаниудыг гарааны бизнестэй холбох хөшүүргийг бий болгох, төрийн албан хаагчдыг гарааны бизнес болон тэдний хэрэгцээ шаардлагын талаар сургах явдал юм.

Нэгдүгээрт, худалдан авалт нь төрөөс гарааны бизнесийг дэмжих боломжтой боловч одоогоор дэмжихгүй байгаа салбар юм. Сургууль, эмнэлэг, засгийн газрын агентлагууд, яамд зэрэг байгууллагуудаараа дамжуулан засгийн газар зарцуулалтын асар их эрх мэдэлтэй байдаг. Үүнийг төрийн үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх шинэ шийдлүүдийг боловсруулахын тулд гарааны бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллахад ашиглаж болно. Бүр энгийнээр хэлбэл, засгийн газар гарааны бизнес эрхлэгчдийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах боломжтой. Одоогоор төрийн байгууллагууд дотоодын гарааны бизнестэй хамтран ажиллахаас илүүтэй гадаадаас бэлэн шийдлүүдийг худалдаж авах эсвэл дотооддоо шинэ шийдлүүдийг боловсруулахыг илүүд үзэж байна.

Төрийн захиргаанд зориулж шинэ дижитал инновацыг боловсруулж болно. Агротехнологийн шийдлүүдийг Хөдөө аж ахуйн яаманд нэвтрүүлж, тариаланчдад сурталчлах боломжтой. Дотоодын боловсролын технологийн инновацыг сургуулиудад нэвтрүүлэх боломжтой бол эрүүл мэндийн технологийн шийдлүүдийг эмнэлэг, сувилалд ашиглах боломжтой. Төрийн өмчит олон аж ахуйн нэгж, банк байсаар байгаа тул бизнесээс бизнес рүү (B2B) үйл ажиллагааны нэг хэсэг болгон гарааны бизнес эрхлэгчдээс шийдлийг худалдан авахыг дэмжих боломжтой. Гарааны бизнес эрхлэгчдийн инновацын худалдан авалт нэмэгдэж байгаа нь гарааны бизнес болон жижиг бизнесүүдийн худалдан авалтыг урамшуулах төрийн худалдан авах ажиллагааны орчин үеийн бодлогыг шаарддаг. Бусад улс орнууд ийм бодлого аль хэдийн нэвтрүүлжээ.

Хоёрдугаарт, гарааны бизнесийг хөгжүүлэх (болон экосистем) талаар төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо одоогоор түр зуурынх бөгөөд үүнийг сайжруулах боломжтой. Агентлаг, аж ахуйн нэгж бүр санаа гаргахаас эхлээд өргөжүүлэх, гадаад зах зээлд гарах хүртэлх гарааны бизнесийн хөгжлийн бүх үе шатыг хамрахыг хичээдэг. Энэхүү хүчин чармайлтын давхардал нь тодорхой үе шатанд оролцогчдын онцгой хэрэгцээнд бага анхаарал хандуулахад хүргэдэг. Хэдийгээр ИХЯ нь экосистемийг хөгжүүлэх гол зохицуулагч байх ёстой ч голчлон шинжлэх ухаан, биотехнологийн гарааны бизнесийн үйл ажиллагаанд чиглэдэг бөгөөд тэдгээр нь цөөн тооны, цаг хугацаа, дэмжлэг их шаарддаг. Дэмжлэгийн хөтөлбөр бүр нь гарааны бизнесийг хөгжүүлэх тодорхой үе шат эсвэл үе шатанд төвлөрдөг тодорхой стратеги боловсруулж, батлах нь ашигтай байж болох юм. Салбарын тусгай хөтөлбөрүүд нь төвлөрсөн, тусгайлсан зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд тустай байх болно.

Гуравдугаарт, томоохон хувийн компаниудад гарааны бизнесийг дэмжихэд нь засгийн газар илүү их үүрэг гүйцэтгэх боломжтой. Жишээ нь, томоохон бизнес эрхлэгчдийг салбарын онцлогт тохирсон инкубатор болон хурдасгуур хөтөлбөрүүдийг бий болгох, дэмжихийг урамшуулж болно. Мөн тэд салбарын туршлагатай менторуудаар хангаж чадна. Томоохон компаниуд бусад улс орнуудад түгээмэл байдаг шиг корпорацын венчур хөрөнгийн сан байгуулж болно. Эцэст нь томоохон бизнесүүд гарааны бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл болж чаддаг.

Дөрөвдүгээрт, төрийн албан хаагчид бизнесийн хүрээнийхэн болон гарааны бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлага, тулгамдаж буй бэрхшээлийн талаар сайн ойлголттой байвал илүү үр дүнтэй ажиллах боломжтой. Гарааны бизнестэй холбоотой албан тушаалтнуудыг энэ талаар илүү сайн сургаж, хувийн хэвшилд ажиллаж байсан туршлагатай хүмүүсийг хөтөлбөрийг удирдахад ажиллуулж болно. Урт хугацаанд төрийн дэмжлэгийн хөтөлбөрүүдэд туршлага, чадавхыг бий болгох шаардлагатай [25].

Экосистемийг бий болгоход хувийн хэвшлийн үүрэг оролцоо

Итали, Латви, Сенегал, Испани зэрэг бусад орны туршлагыг тоймлон үзэхэд гарааны бизнесийн хууль тогтоомж нь экосистемийн хөгжилд хувийн хэвшлийн тоглогчдыг татан оролцуулахад чиглэх ёстойг харуулж байна. Хууль (болон бодлого) нь төрийн байгууллагуудад хувийн хэвшлийн экосистемийг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлт, татаас олгохыг үүрэгжүүлж чадна. Эдгээр төрийн урамшуулал нь хувийн хэвшлийн инкубатор, хурдасгуур хөтөлбөрийг бий болгох, хувийн менежменттэй хамтын оффис, инновацын төвүүдийг бий болгоход түлхэц болно. Урамшуулал нь ихээхэн хөрөнгөтэй хүмүүсийг бизнесийн анжел хөрөнгө оруулагч болгох, илүү олон корпорац, хөрөнгө оруулагчдыг хувийн венчур хөрөнгө оруулалтын сан байгуулахад түлхэц болно.

Узбекистан улсад дээрх арга замыг хэрэгжүүлснээр засгийн газар гарааны бизнесийн хөгжилд дэвшил, парадигмын өөрчлөлтийг хийж чадах юм.

Санхүүжилт

Санхүүгийн хүртээмж хязгаарлагдмал байгаа нь Узбекистан дахь гарааны бизнесийг хөгжүүлэхэд саад болж байгаа гол бэрхшээл хэвээр байна. Одоогийн байдлаар хэд хэдэн төрлийн санхүүжилт байгаа ч ихэнхийг нь өргөжүүлж, сайжруулах шаардлагатай байна.

Бусад улс оронд гарааны бизнес (мөн жижиг дунд үйлдвэрүүд) эхлүүлэхийн тулд үүсгэн байгуулагч нь өөрийн хөрөнгөөрөө босгох нь түгээмэл байдаг. Узбекистан дахь гарааны бизнесүүд мөн ижил төстэй байдаг буюу тэд өөрсдийн хуримтлал, цалингаасаа хөрөнгө оруулалтыг хийдэг бөгөөд гэр бүл, найз нөхдөөсөө мөнгө авдаг. Энэ нь дунджаар 2000-5000 ам.доллар байдаг ба гарааны бизнесийг эхлүүлэх үндэс суурь болж өгдөг хэдий ч, эцсийн бүтээгдэхүүнийг бий болгож зах зээлд гаргахад нэмэлт хөрөнгө шаардлагатай байдаг.

Хүснэгт 9. Гарааны бизнесийг хөгжүүлэх үе шатаар санхүүжилтийн эх үүсвэр

	Эхэн үе шат	Хөгжүүлэлтийн үе шат	Өргөжих үе шат
Эх үүсвэр	Өөрийн хөрөнгө, гэр бүл, найз нөхөд Засгийн газар, хандивлагчдын буцалтгүй тусламж Бизнесийн анжлел хөрөнгө оруулагч, Краудфандинг	Венчур хөрөнгө оруулагчид, анжлел хөрөнгө оруулагч, олон нийтээс мөнгө зээлэх, краудфандинг	Венчур хөрөнгө оруулагчид, банкны зээл
Үйлчилгээ үзүүлэгчдийн жишээ	Засгийн газар, хандивлагчид UzAngels	Засгийн газар: UzVC, Uzcard VC, Aloqa VC Хувийн: SEMURG VC	Олон улсын Венчур хөрөнгө оруулагчид: Sturgeon Capital (Их Британи) Battery Road Digital (Сингапур)
Гарааны бизнесийн тоо	1,000	150	20
Бүтээгдэхүүн	Прототип	Хамгийн бага өртөгөөр бүтсэн бүтээгдэхүүн	Бүтээгдэхүүний зах зээлд нийцсэн байдал
Онцлог шинж чанарууд	Санаа	Баталгаажуулалт	Зах зээлээ өргөжүүлэн тэлэх

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, Узбекистаны технологийн стартапын экосистемийн тайлан, 2023

Банкнууд бизнесийн зээл олгодог бөгөөд засгийн газраас банкнуудын зээлийг жижиг, дунд үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр дамжуулах хэд хэдэн санхүүжилтийн хөтөлбөрүүдийг санал болгодог. Гэсэн хэдий ч зээл нь барьцаа хөрөнгөөр баталгаажсан байх ёстой бөгөөд үүнийг эхэн үеийн гарааны бизнес ихэвчлэн гаргах боломжгүй байдаг. Цаашилбал, зээлийн үйлчилгээ (үндсэн зээлийн эргэн төлөлт, хүү) шаардлагатай боловч эхний шатандаа ажиллаж байгаа бизнес эрхлэгчдэд орлогын урсгал байдаггүй.

Буцалтгүй тусламжийг засгийн газар, хандивлагчид болон ашгийн бус байгууллагууд олгодог бөгөөд өөрийн хөрөнгийг нөхөх санхүүжилтийн чухал эх үүсвэр болдог. Грантуудыг IT Park Uzbekistan, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Залуучуудын бизнес эрхлэлтийг дэмжих төвөөс олгодог. Узбекистаны хэд хэдэн гарааны бизнес эрхлэгчид тэтгэлэг авсан хэдий ч, зарим буцалтгүй тусламжийн хөтөлбөрүүд нь түр зуурын эсвэл нэг удаагийн үйл ажиллагаа байдаг. Зарим тохиолдолд хатуу нөхцөл тавих нь гарааны бизнес эрхлэгчдийг өргөдөл гаргахад нь төвөгтэй байдлыг бий болгож болох тул илүү тогтвортой буцалтгүй тусламжийн хөтөлбөрүүдийг

боловсруулж, өргөдөл гаргах үйл явц нь хүнд хэцүү биш гэдгийг баталгаажуулах нь зүйтэй.

Гарааны бизнес хөгжихийн хэрээр анжел хөрөнгө оруулагчид болон венчур хөрөнгө оруулагчид, өөрийн хөрөнгийн санхүүжилт хэрэгтэй болно. Гэсэн хэдий ч санхүүгийн системийн эдгээр сегментүүд хөгжөөгүй хэвээр байна. Узбекистанд анжел хөрөнгө оруулагчид байдаг ч тэдний тоо хязгаарлагдмал, бизнесийн анжел хөрөнгө оруулагчдын коммюнити хараахан хөгжөөгүй байна. Бусад улс орнууд боломжит анжел хөрөнгө оруулагчдад сургалт орж, татварын хөнгөлөлт үзүүлж, хөрөнгө оруулалтад татаас олгох замаар дээрх коммюнити бий болгосон.

Узбекистанд венчур хөрөнгө оруулалт нь эхэн шатандаа байна. Энэ нь органик байдлаар хөгжөөгүй бөгөөд тусгайлан хувийн венчур сангийн хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс саад болж байна. Засгийн газар 2020 онд ИХЯ-наас UzVC Үндэсний венчурын санг байгуулснаар 1.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх боломжтой сан бий болсон. 2022 оны сүүлчээр санг удирдах хувийн менежментийн компанийн сонгон шалгаруулалт үргэлжилж байгаа тул хараахан үйл ажиллагаагаа эхлээгүй байна. Харин төсвийн хөрөнгийг хувийн менежментийн компани удирдаж байгаа нь зах зээлд сайн дохио юм. Цаашилбал, төрийн өмчит төлбөрийн компани Uzcard 2021 онд 1 сая ам.долларын корпорацын венчур хөрөнгө оруулалтын сан байгуулсан. Санхүүжилтийг финтек хурдасгуур дахь гарааны бизнесүүдэд хуваарилах юм. ИХЯ нь бүх бүс нутаг дахь гарааны бизнест санхүүжилт олгосон. Aloqabank мөн 2021 онд Aloqaventures нэртэй 25 тэрбум (300 сая ам.доллар) сумын дүрмийн сантай венчур хөрөнгө оруулалтын сан байгуулжээ. Түүнээс гадна SEMURG VC нэр бүхий дотоодын хувийн венчур хөрөнгийн сан байдаг ба Их Британийн Sturgeon Capital, Сингапурын Battery Road Digital зэрэг олон улсын зарим сангууд тус улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Нөгөөтэйгүүр, Төв банкны хөрөнгийн хөдөлгөөний тухай журамд хөрөнгө оруулалтад шилжүүлсэн хөрөнгийн хэмжээ 10,000 ам.доллараас давсан тохиолдолд Ерөнхийлөгчийн зарлиг эсвэл ЗГХЭГ-ын шийдвэр шаардлагатай байдаг. Бусад улс орнуудад өөрийн венч хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан гарааны бизнест төрөөс шууд хөрөнгө оруулалт хийсэн нь ерөнхийдөө амжилттай үр дүнд хүрээгүй байна. Албан тушаалтнуудад ямар гарааны бизнес эсвэл технологи бий болох, түүнийг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх чадвар дутмаг байна. Үүний оронд төр нь гарааны бизнесүүдийн эрсдэлийг үнэлэх чадвартай хувийн венчур хөрөнгө оруулалтын сангуудад (эсвэл дамжуулан) хөрөнгө нийлүүлэх замаар “сангийн санхүүжүүлэгч”-ийн үүрэг гүйцэтгэх ёстой. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулагчдын (анжел хөрөнгө оруулагчид, венчур хөрөнгө оруулагчид болон бусад) гарааны бизнесийн талаарх мэдлэг, эрсдэлийг үнэлэх чадвар нь хязгаарлагдмал байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэ түвшинг дээшлүүлэхийн тулд сургалт шаардлагатай.

Одоогоор Узбекистан улсад хэрэглэгдэхгүй байгаа гурван боломжит санхүүжилтийн механизм бий. Тэдний хувьд хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин байхгүй. Нэгдүгээрт, олон нийтээс мөнгө босгох нь бусад орны гарааны бизнес өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалт авахын тулд ашигладаг. Хоёрдугаарт, хөрвөх боломжтой зээлийг бусад улс орнуудад ч ашигладаг бөгөөд гарааны бизнес эрхлэгчид эхлээд хөрөнгөө зээлж, дараа нь өөрийн хөрөнгө болгон хувиргадаг (ингэснээр гарааны бизнес нь зээлийн үйлчилгээ үзүүлэх шаардлагагүй). Гуравдугаарт, хувьцааны опционы схемийг бусад орны гарааны бизнесийн ажилтнуудад ашигладаг. Ийм схемийн хувьд ажилтны цалин хөлс (бэлэн мөнгө) болон компанийн хувьцаа

(ханш) зэргээс бүрддэг. Энэ нь гарааны бизнесийн (цалин) төлбөрийг бууруулж, эхний шатанд ихэвчлэн хүнд байдаг эргэлтийн хөрөнгийн хязгаарлалтыг хөнгөвчилдөг [25].

Инкубатор ба хурдасгуур хөтөлбөрүүд

Инкубатор болон хурдасгуур хөтөлбөр нь гарааны бизнес эрхлэгчдэд санаагаа боловсронгуй болгох, бизнесийн загвараа хөгжүүлэх, зах зээлд хүчээ татахад тусалдаг. Одоогоор Узбекистан улсад хэд хэдэн хөтөлбөр хэрэгжиж байна. Дээр дурдсан ихэнх гарааны бизнес эрхлэгчдийн нас нь гарааны бизнес эрхлэгчдэд эдгээр хөтөлбөрүүдийн заавар, практик зөвлөгөө (болон ментор) үнэхээр хэрэгтэй байгааг харуулж байна. Санхүүжилтийн боломж хязгаарлагдмал байгаагаас гадна чанартай хөтөлбөр байхгүй байгаа нь гарааны бизнес эрхлэгчдэд хамгийн том саад болж байна.

Гарааны бизнесийн экосистемийг дэмжих, хөгжүүлэх анхны санаачилгууд 2013-2015 онд гарч ирсэн. Арга хэмжээ, дэмжлэгийн хөтөлбөрүүдэд Startup Mix Conference, Startup Factory, Startup Accelerator болон бусад зүйлс багтсан. Ихэнхийг Brand.uz15 (одоогийн Tech4Impact16) зэрэг хувийн байгууллагууд Узбекистаны Худалдаа аж үйлдвэрийн танхим, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр зэрэг төрийн бус болон хандивлагч байгууллагуудтай хамтран зохион байгуулжээ.

Сүүлийн 5 жилийн хугацаанд ИХЯ нь 15 хурдасгуур хөтөлбөр, 100 гаруй семинар, сургалтын үйл ажиллагаа, мэдээллийн өгөх уулзалт, олон улсын уулзалтуудыг дэмжин зохион байгуулсан. Эдгээр санаачилгын үр дүнд 2018 оноос хойш тэмцээнд оролцох гарааны бизнес эрхлэгчдийн бүртгэл (жишээ нь, питчинг, хакатон) хэд дахин нэмэгдэж, гарааны бизнесийн санхүүжилт ч нэмэгдсэн байна.

Узбекстанд одоогийн байдлаар хоёр алдартай хөтөлбөр байдаг. Эхнийх нь Узбекистаны залуучуудын холбоо төрийн бус байгууллагаас үүсгэн байгуулсан Залуучуудын бизнес эрхлэлтийг дэмжих төв бөгөөд гарааны бизнест зориулсан инкубаторын болон бусад үйл ажиллагаа явуулдаг. Хоёр дахь нь төлбөрийн системийн Uzcard компанийн 2021 онд гаргасан корпорацийн финтек хурдасгуур хөтөлбөр юм. Энэ нь нэг сая ам.долларын хөрөнгө оруулалттай корпорацийн венчур сантай холбоотой. Энэхүү хурдасгуур нь дотоод болон гадаадын гарааны компаниудын шийдлүүдийг Uzcard системд нэгтгэх замаар Uzcard-ын сүлжээ, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилготой бөгөөд үүнд дотоод процессыг автоматжуулах шийдлүүд багтана. 6 сарын хурдасгуур хөтөлбөрийг дуусгасны дараа гарааны бизнес эрхлэгчид санхүүгийн болон бизнесийн бусад салбарыг хамарсан Uzcard-ийн венчур хөрөнгө оруулалтын сангаас хөрөнгө оруулалтад хамрагдах боломжтой. Одоогийн байдлаар хурдасгуур болон түүнтэй холбоотой сангийн үр дүнг үнэлэхэд эрт байна.

Одоогийн хөтөлбөрүүд нь эхлэл боловч инкубатор болон хурдасгуурыг илүү үр дүнтэй болгохын тулд хэд хэдэн сайжруулалт хийж болно. Нэгдүгээрт, илүү тодорхой салбар хөтөлбөрүүд байж болно. Одоогийн байдлаар ихэнх хөтөлбөрүүд бүх салбарын гарааны бизнесийг хүлээн авдаг бөгөөд салбарын гол асуудлууд эсвэл зах зээлийн асуудлуудын талаар бага эсвэл огт зааварчилгаа өгдөггүй. Хоёрдугаарт, ихэнх хөтөлбөрүүд өндөр чанартай менторуудаар хангах, холбогдох боломжгүй байдаг. Цаашилбал, бэлэн байгаа менторууд нь гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан салбарын туршлагатай байх нь ховор. Асуудал нь орон нутгийн амжилттай бизнес эрхлэгчид ментороор ажиллахгүй байгаа явдал юм. Энэ нь менторууд цаг зав, зөвлөгөөнийхөө төлөө мөнгө авахыг хүсдэг тул санхүүгийн урамшуулал дутмаг байгаатай холбоотой байж болох юм. Хэрэв засгийн газар эсвэл инкубаторууд дээрх төлбөрийг санхүүжүүлсэн бол энэ нь тус болж магадгүй юм. Өөр нэг сонголт бол

гарааны бизнес эрхлэгчдэд зөвлөхөд хувь нийлүүлэх замаар "төлөөс төлөх" явдал юм. Гуравдугаарт, өндөр түвшний мэргэжилтэн, менторуудыг авчрах гадаадын хөтөлбөрүүд цөөхөн байна. Гадаадын иргэдэд зориулсан хөтөлбөрүүд нь гарааны бизнес эрхлэгчдэд илүү өргөн хүрээг хамарч, дотоодын зах зээлээс гадна гадаад зах зээлийг судлахад түлхэц болно [25].

Авьяас, ур чадвар

Чадварлаг бизнес эрхлэгчид болон ажилтнууд нь амьдрах чадвартай гарааны бизнесийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай юм. Ялангуяа үүсгэн байгуулагч нь хөрөнгө оруулалт татах, ажилчдыг ажилд авах, технологийг сайжруулах, бизнесийн загвар зохион бүтээх, борлуулалтыг нэмэгдүүлэх маркетинг зэрэг олон ажлыг нэгэн зэрэг хийх ёстой. Сүүлийн үеийн судалгаагаар Узбекистан дахь гарааны бизнес эрхлэгчдэд тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг нь боловсролтой, ур чадвартай, бусад мэргэшсэн ажилчдын дутагдал юм.

Ялангуяа их өгөгдөл, блокчэйн, хиймэл оюун ухаан зэрэг шинэ технологийн салбарт тохирох мэргэжилтнүүдийг олох нь гарааны бизнес эрхлэгчдийн хувьд томоохон сорилт юм. Эдгээр мэргэжлээр төгсөгч бэлтгэх чадвартай багш нар дутагдаж байгаа тул эдгээр мэргэжлийг их, дээд сургуулиуд хараахан олгоогүй байна. 2020 оны 1-11 дүгээр сард мэдээллийн технологийн салбарын сул орон тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76%-иар өссөн байна.

Их, дээд сургуулиуд бол авъяас чадварыг бий болгох чухал эх үүсвэр юм. Одоогоор тус улсад 117 их, дээд сургууль байгаагаас гадаадын 21 их, дээд сургууль, хувийн хэвшлийн 20 их сургууль үйл ажиллагаа явуулж байна. 2017 онд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 9 орчим хувь нь их, дээд сургуульд элсэн орсон боловч өргөтгөсөн элсэлтийн улмаас 2020 он гэхэд энэ тоо 20 хувь болж өсөх төлөвтэй байна.

Засгийн газраас боловсролын салбарт шинэчлэл хийж, хувийн сургууль, их дээд сургуулиудыг нээхийг дэмжиж байгаа хэдий ч, тэд бүгд газрааны бизнесийн салбарт шаардлагатай авъяас чадварыг бий болгоход дэмжлэг үзүүлдэггүй. Жишээлбэл, сүүлийн жилүүдэд бизнес эрхлэх ур чадвараар мэргэшсэн ганцхан хувийн их сургууль нээгдсэн. Зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахын тулд бизнес эрхлэх ур чадвар олгох сургалтыг илүү сайн зохион байгуулах шаардлагатай байна.

Вестминстерийн олон улсын их сургууль, Ташкент улсын эдийн засгийн их сургууль, TEAM их сургууль зэрэг зарим их дээд сургуулиуд саяхан бизнес инкубатор байгуулсан хэдий ч, тохирсон багш, ментор байхгүйн улмаас эдгээр хөтөлбөрт хамрагдсан гарааны бизнес эрхлэгчид бизнесийн практик ур чадвар багатай байдаг. Дотоодын их дээд сургуулиудад гадаадын мэргэжилтнүүдийг оролцуулсан "Дипломын гарааны бизнес" хөтөлбөрийг нэвтрүүлснээр залуучуудыг технологийн бизнес эрхлэхэд илүү идэвхтэй татан оролцуулж, сургах боломжтой. Энэ аргыг одоогоор Энэтхэгт туршиж байна [25].

6.5. Харьцуулсан судалгаа

Хүснэгт 10. Олон улсын харьцуулсан судалгаа

Венчур бизнесийг дэмжих тусгай арга хэмжээний тухай хууль [26], Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль [27] (Солонгос Улс)	Үндсэн хууль [28], Шинжлэх ухаан ба шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагааны үр дүнг арилжааны зорилгоор ашиглах тухай хууль [29] (Казахстан Улс)	Технологийн хөгжлийн бүсийн хууль [22] (Турк Улс)	“Програм хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн технологийн парк байгуулах арга хэмжээний тухай” засгийн газрын тогтоол [30] (Узбекистан Улс)
Хуулийн зорилт			
Венчур бизнесийг дэмжих тусгай арга хэмжээний тухай хуулийн зорилго нь одоо байгаа аж ахуйн нэгжүүдийг венчур бизнес болгон хувиргах, венчур бизнесийг бий болгох замаар салбарын бүтцийн өөрчлөлтийг хөнгөвчлөх, түүнчлэн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахад оршино.	Тус улсад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн тусгайлсан хууль байхгүй хэдий ч, салбарын бодлого стратеги, салбарын сайдын тушаалаар зохицуулагдаж байна.	- Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрлэлийн салбарын хамтын ажиллагааг хангах; - Улс орныхоо аж үйлдвэрийг олон улсад өрсөлдөх чадвартай, экспортын баримжаатай болгох; - Технологийн мэдлэгийг бий болгох; -Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргад инновацыг хөгжүүлэх; - Бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах; - Үр ашгийг нэмэгдүүлэх; - Үйлдвэрлэлийн зардлыг бууруулах; - Технологийн мэдлэгийг арилжаалах; - Технологийн эрчимжсэн үйлдвэрлэл, бизнес эрхлэлтийг дэмжих; - Жижиг, дунд бизнесийг шинэ	Энэхүү журам нь программ хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн паркийн үйл ажиллагааг зохион байгуулах, хуулийн этгээдийг бүртгэх, оршин суугчийн статусаас хасах, оршин суугчдад олгосон татвар, гаалийн хөнгөлөлт, түүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажилтанд татварын хөнгөлөлт үзүүлэх, оршин суугчид, түүнчлэн ирээдүйтэй гарааны төслүүдийг сонгох, санхүүжүүлэх журмыг тогтооно.
Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зорилго нь иргэн бүр бүтээлч санаа, инновацын технологид суурилсан бизнес эрхлэх, гарааны бизнесийг дэлхийн тэргүүлэгч аж ахуйн нэгж болгон хөгжүүлэх, улмаар дижитал эдийн засгийн эрин үед үндэсний эдийн засгийн өсөлтийн шинэ хөдөлгөөр, ажлын байрыг бий болгох гарааны бизнес эрхлэгч			

үндэстэнг бий болгох бизнес эрхлэх экосистемийг бий болгоход оршино.		дэвшилтэт технологид дасан зохицох үйл ажиллагааг хангах; - Шинжлэх ухаан, технологийн дээд зөвлөлийн шийдвэрийг харгалзан техник, технологи ихтэй бүс нутагт хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх; - Судлаач, мэргэшсэн хүмүүсийг ажлын байраар хангах; - Технологи дамжуулахад дэмжлэг үзүүлэх; - Өндөр/дэвшилтэт технологиор хангасан гадаадын хөрөнгө оруулалтыг түргэсгэх технологийн дэд бүтцийг бий болгох.	
Хуулийн нэр томъёо			
"Венчур бизнес" гэсэн нэр томъёо нь 2-2-т заасан шаардлагыг хангасан бизнесийг хэлнэ. 2.2. Венчур бизнес нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. 1.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан жижиг, дунд үйлдвэрүүдийн нэг байх; 2.Энэ нь дараах зүйлсийн аль нэгэнд хамарсан байна. (а) Дараах хүмүүсийн аль нэгнийх нь оруулсан хөрөнгө оруулалтын нийт дүн болон нийт хөрөнгө оруулалтад ногдох	Стартап компани - Бүгд Найрамдах Казахстан Улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, жижиг, дунд бизнес эрхэлдэг, тавигдсан шаардлагын аль нэгийг хангасан хувиараа бизнес эрхлэгч эсвэл хуулийн этгээд. - дээд ба (эсвэл) төгсөлтийн дараах боловсролын байгууллагууд, үйл ажиллагаа нь шинжлэх ухаан, (эсвэл) шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагааны үр дүнг арилжаалахад чиглэсэн шинжлэх ухааны байгууллагуудын оролцоотойгоор байгуулагдсан; - инновацыг хөгжүүлэх.	Энтерпренёр - Тухайн бүс нутагт үйлчилгээ, боломжоос ашиг хүртэх хүсэлтэй эсвэл ашиг хүртэж буй бодит болон хуулийн этгээд; Технологийн бүтээгдэхүүн - Нийгмийн хэрэгцээг хангах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор шинжлэх ухааны мэдлэг, технологийн судалгааг ашиглан мэргэшсэн боловсон хүчнээр бүтээгдсэн, одоо байгаа бүтээгдэхүүнээс эрс ялгаатай, нэмүү өртөг өндөртэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн юм.	Бизнес төлөвлөгөө - компани, бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл, үзүүлж буй үйлчилгээ, борлуулалтын боломжит зах зээл, маркетингийн стратеги, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны зохион байгуулалт, тэдгээрийн үр ашгийн үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг агуулсан бизнесийн үйл ажиллагаа, компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр; Стартап төсөл - ашиг нь тодорхойгүй, санхүүгийн өндөр эрсдэлтэй нөхцөлд програм

харьцааны хувьд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон стандартад нийцсэн аж ахуйн нэгж нь тус тус: (i) Венчурын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан жижиг, дунд бизнесийг шинээр эхлүүлэх хөрөнгө оруулалтын компани; (ii) Венчурын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасан венчурын хөрөнгө оруулалтын холбоо; (iii) Зээлийн санхүүжилтийн бизнесийн тухай хуульд заасан шинэ технологийн эрсдэлийн капиталын бизнес; (iv) Зээлийн санхүүжилтийн бизнесийн тухай хуульд заасан шинэ технологийн венчурын хөрөнгө оруулалтын холбоо; (v) Венчур хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулийн 66 дугаар зүйлд заасан Солонгосын Венчер хөрөнгө оруулалтын корпорац; (vi) Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу жижиг, дунд үйлдвэрүүдэд технологийн үнэлгээ хийж, хөрөнгө оруулалт хийдэг; (vii) Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, карьер, мэргэшлийн шаардлага зэрэг стандартыг хангасан хувь хүн;		хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох төсөл; Програм хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн технологийн парк (цаашид Технопарк гэх) - Бүгд Найрамдах Узбекистан Улсын нутаг дэвсгэрт харьяалагдах зарчмаар үйл ажиллагаа явуулдаг, Технопаркийн оршин суугчдыг бүгд найрамдах улсын хэмжээнд байршуулж, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хамгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилготой зохион байгуулалт, эрх зүйн нэгдэл юм.
---	--	--

б) Эрдэм шинжилгээний ажлын жилийн зардал, судалгааны ажлын зардлын нийлбэрийг жилийн нийт эргэлтэд эзлэх харьцааны хувьд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон жишигт нийцсэн, үйл ажиллагаагаараа өндрөөр үнэлэгдсэн аж ахуйн нэгж. 25-3 (1)-д заасан венчурын бизнесийг баталгаажуулах асуудал эрхэлсэн байгууллагын бизнесийн гүйцэтгэл: Судалгааны нийлбэрийн эзлэх хувьтай холбоотой стандартыг хангасан байх.	Байгуулагдсанаас хойш гурван жил болоогүй аж ахуйн нэгжүүдэд жилийн нийт эргэлтийн бүтээн байгуулалтын зардал хамаарахгүй. (i) Суурь судалгааг дэмжих, технологийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 14-2 (1) зүйлийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа, боловсруулалтын ажлыг дангаар хариуцдаг бизнесийн харьяа судалгааны хүрээлэн эсвэл хэлтэс; (ii) Соёлын үйлдвэрлэлийг дэмжих үндсэн хуулийн 17-3 (1) зүйлийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн компанид харьяалагддаг бүтээлч судалгааны хүрээлэн эсвэл бүтээлийг хариуцсан хэлтэс; (iii) Венчур бизнесийг
--	---

баталгаажуулах нь үүрэгтэй байгууллага нь шинэлэг технологи, бизнесийн өсөлтийн чадамжийг нь өндрөөр үнэлдэг аж ахуйн нэгж; (2) (1) 2 (b) ба (c) хэсгийн заалтын дагуу үнэлгээ хийх стандарт, арга, бусад зүйлд шаардлагатай асуудлуудыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.			
"Шинэ технологид суурилсан бизнесийн гарааны бизнесийн чиглэлээр мэргэшсэн компани" гэсэн нэр томъёо нь их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эзэмшиж буй технологийг үйлдвэржүүлэх, тус үйлдвэржилтээр дамжуулан бизнес эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан компанийг хэлнэ.			
"Шинэ технологид суурилсан бизнесийн кластерын бүс" гэдэг нь Жижиг, дунд, венчур бизнесийг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гарааны бизнес эрхлэгчдэд бизнесийн орон зай олгох зорилгоор тогтоосон их сургууль, судалгааны хүрээлэнгийн эзэмшиж буй газрыг хэлнэ.			

"Шинэ үйлдвэрлэлийн бизнес эхлүүлэх" гэсэн нэр томъёо нь одоо байгаа үйлдвэрүүдийг нэгтгэх буюу зах зээлд илүү сайн байх, илүү их үр нөлөөг бий болгох, боломжит өсөлтийг харуулах, үндэсний эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц үйлдвэрлэлд түшиглэн бизнес эхлүүлэхийг; "Технологийн стартап" гэсэн нэр томъёо нь бүтээлч санаа, шинэ технологи, шинжлэх ухааны технологи, мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан соёл зэрэг янз бүрийн салбаруудтай нэгдэх үйл ажиллагааг хөнгөвчлөх замаар бизнесийн шинэ чиглэлийг хөгжүүлэх буюу судлах бизнес эхлүүлэхийг хэлнэ.		
Зээлийн батлан даалтын тухай зохицуулалт		
5 дугаар зүйл. Хөнгөлөлтэй зээлийн баталгаа олгох Солонгосын Технологийн Санхүүгийн Корпорацийн тухай хуулийн дагуу Солонгосын Технологийн Санхүүгийн Корпорац нь зээлийн баталгаа гаргахдаа венч бизнес болон шинэ технологид суурилсан бизнес эхлүүлэх чиглэлээр мэргэшсэн компанид давуу эрх		Тусгайлсан хуулийн зохицуулалт байхгүй болно. Тусгайлсан хуулийн зохицуулалт байхгүй болно. Тусгайлсан хуулийн зохицуулалт байхгүй болно.

ОЛГОНО.			
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн зохицуулж буй хууль			
Тусгайлсан хууль тогтоомж байхгүй ба мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг венчур бизнес, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиар зохицуулдаг.	Тусгайлсан хууль тогтоомж байхгүй хэдий ч, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 269 тоот тогтоолоор батлагдсан “2023-2029 онуудад дижитал өөрчлөлт, мэдээлэл, харилцаа холбооны технологи, кибер аюулгүй байдлын салбарыг хөгжүүлэх үзэл баримтлал”-аар зохицуулагдаг.	Анх 2001 онд батлагдаж, 2005 онд хамгийн сүүлд өөрчлөгдсөн, 4691 дугаар бүхий “Технологийг хөгжүүлэх бүсийн тухай хууль”-иар зохицуулсан байдаг.	Бүгд Найрамдах Узбекистан Улсын Сайд нарын танхимын 2019 оны “Програм хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологи, технологийн парк байгуулах арга хэмжээний тухай” тогтоолоор зохицуулагдаг.
Зохицуулалтын байгууллага (эрх, үүрэг)			
Венчур бизнесийг мэдээллээр хангах (1) Засгийн газар венчур бизнесийг үүсгэн байгуулах, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалт, сан, хүн хүч, технологи, зах зээл, байршил гэх мэт мэдээллээр хангах, эсхүл венчур бизнесийг мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлж болно. (2) ЖДҮ, гарааны бизнес эрхлэгчид Төрийн байгууллагын удирдлагын тухай хуулийг дагаж мөрдсөн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагын даргаас нэгдүгээр хэсгийн дагуу	- Бүгд Найрамдах Казахстан Улсын Мэдээлэл, харилцаа холбооны сайдын 2018 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн “Астана хаб” олон улсын технологийн паркийн үйл ажиллагааны дүрмийг батлах тухай 415 дугаар тушаалд заасны дагуу хэрэгжилтийг хангах асуудлыг тус улсын Мэдээлэл, харилцаа холбооны дэд сайдад үүрэг болгосон. - Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хуулийн Астанагийн олон улсын санхүүгийн төвийн удирдлагын тухай “Төвийн менежерийг Бүгд	- Аж үйлдвэр, технологийн яам болон Худалдааны яам - Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх байгууллага (“KOSGEB”) Зорилго: ЖДҮ, бизнес эрхлэгчдэд үр дүнтэй дэмжлэг, үйлчилгээгээр инновац, технологи, өрсөлдөх чадвар бүхий бүтэц зохион байгуулалтад хүрэх боломжийг олгох замаар эдийн засаг, нийгмийн хөгжилд эзлэх хувийг нэмэгдүүлэх; - Туркийн Шинжлэх ухаан, технологийн судалгааны зөвлөл	“Програм хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн парк байгуулах арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүгд Найрамдах Узбекистан Улсын Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн сайд, ЗГХЭГ-ын Харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацыг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн Хэрэг эрхлэх газарт тус тус даалгасан.

мэдээллээр хангахад шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхийг хүсч болно. (3) ЖДҮ болон гарааны бизнест хувь хүн эсвэл хувийн хөрөнгө оруулалтын нийгэмлэгийн хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд ЖДҮС-н сайдын тушаалаар хөрөнгө оруулалтын үнэ гэх мэт венчур бизнестэй холбоотой шаардлагатай мэдээллийг хувь хүнд өгч болно.	Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.” гэж заасан. Мөн Төвийн захиргаа нь Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний банкнаас үүсгэн байгуулсан, Төвийн байгууллага, тэдгээрийн байгууллага, оролцогчид, түүнчлэн тэдгээрийн ажилтнуудын үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлж, тэдгээрийн ашиг сонирхлыг төрийн бус байгууллагын хүрээнд төлөөлдөг ашгийн бус байгууллага юм. 2. Төвийн захиргаа нь Бүгд Найрамдах Казахстан Улсын төсвийн хууль тогтоомжийн дагуу зорилтот шилжүүлгийн хэлбэрээр улсын төсвийн хөрөнгөөс бүрдүүлсэн өөрийн төсөв, Төвд оролцогчдын төлсөн хураамж, төлбөр, түүнчлэн Төвийн актаар хориглоогүй бусад эх үүсвэр болно. Төвийн захиргаа нь энэ хэсэгт заасан хөрөнгийг хэмнэх замаар нөөц бүрдүүлэх эрхтэй. Нөөц бүрдүүлэх журам, нөхцөл, түүнчлэн тэдгээрийг ашиглахыг төвийн актаар тогтоодог.	Зорилго: ТҮБИТАК Суурь Шинжлэх Ухааны Судалгааны Хүрээлэнгийн эрхэм зорилгыг дэлхийн суурь шинжлэх ухааны салбарт гарч буй хөгжил, улсын стратегийн зорилтуудыг харгалзан дараах байдлаар тодорхойлсон. Суурь шинжлэх ухааны салбарт анхдагч судалгаа хийж, эдгээр судалгааг салбар дундын чиглэлээр түгээн дэлгэрүүлэх, олон улсын түвшинд шинжлэх ухаанд томоохон хувь нэмэр оруулах; Хүрээлэнгийн дээвэр дор гадаад, дотоодын тэргүүлэх эрдэмтдийг нэгтгэн, шинжлэх ухааны өндөр түвшний орчин бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг эх орондоо авчрах; - Ахисан, өргөн хүрээтэй судалгаа, сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээний зуны сургууль, дадлагын сургалтуудыг зохион байгуулж, олон улсын жишигт нийцсэн магистрант, докторант бэлтгэхэд томоохон хувь нэмэр оруулах; - Нийгэмд чиглэсэн шинжлэх ухааны хөтөлбөр боловсруулж, шинжлэх ухааны соёлыг түгээн дэлгэрүүлэх, шинжлэх ухааны уламжлалыг эх орондоо
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх нөлөө:	Үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
			Тийм	Үгүй	
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах		3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй



**ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ.....	4
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	5
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	5
3.2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:.....	6
3.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	6
ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ.....	8
4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:.....	8
4.2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	18
4.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	23
ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	35
5.1. Үр дүнг баримтжуулах	35
5.2. Үнэлэх.....	35
5.3. Зөвлөмж.....	37
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	39

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад “энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх,” гэж заасны дагуу Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн зарим зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зарим зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв.

1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;

1.2.Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;

1.3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;

1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Үр нөлөөний үнэлгээ хийсэн хуулийн төслийн хувилбарыг энэхүү тайланд хавсаргав.

¹ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны 25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн.

² Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Харилцан уялдаа;
- 3.Практикт хэрэглэх боломж.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ. Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ буюу зохицуулалтыг сонгож авсан болно.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцдог тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие даасан үнэлгээгээр тооцох болно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх бөгөөд хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд дурдсан асуултад хариулт өгөх байдлаар үнэлгээг хийхээр сонгов.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлнэ.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэж, зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан чухал, ач холбогдолтой дараах зүйл, хэсэг, заалтыг сонгон авч хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр тусгалаа:

Хүснэгт 1. Хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг сонгон үнэлэх

Зорилгод хүрэх байдал /Үзэл баримтлалаас/	Сонгосон бүлэг, зүйл, хэсэг, заалт
Мэдээллийн технологийн салбарын нэр томъёог шинээр тодорхойлох, ойлголтын зөрүүтэй байдлыг арилгах.	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
Төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх.	5 дугаар зүйл. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах зарчим 9 дүгээр зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэл
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах.	12 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэх виртуал бүс
Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг тодорхойлох, дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэхтэй.	13 дугаар зүйл.Татварын болон татварын бус дэмжлэг 14 дүгээр зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих дэмжлэгийн эх үүсвэр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах.	6 дугаар зүйл 6.4.Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.9-д заасны дагуу программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл

	гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заан, харилцан тохиролцоно. 5 дугаар зүйл 5.1.3.Засгийн газар хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээний журам, нөхцөлийг тогтоох; 13 дугаар зүйл 13.3.1.мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгох;
Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэх.	5 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газрын бүрэн эрх 6 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх үүрэг 7 дугаар зүйл.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ 8 дугаар зүйл.Мэдээлэл, технологийн үндэсний парк

3.2.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төсөл нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар тогтоох юм. Уг шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэхдээ тодорхой стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй тул хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхээр сонгосон болно.

3.3.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/Төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой заалтууд, 2/Мэдээллийн технологийн

үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулахтай холбоотой заалтууд, 3/Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэхтэй холбоотой заалтууд, 4/ Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалахтай холбоотой заалтуудыг сонгон авч “Практикт хэрэгжих боломж”-ыг тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2. Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг сонгон үнэлэх

д/д	Практикт хэрэгжих боломж	Сонгосон бүлэг, зүйл, хэсэг, заалт
1	Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх.	Хуулийн төслийн 2 дугаар бүлэг
2	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах.	Хуулийн төслийн 3 дугаар бүлэг
3	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэх.	Хуулийн төслийн 4 дүгээр бүлэг
4	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах.	6 дугаар зүйл 6.4.Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.9-д заасны дагуу программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заан, харилцан тохиролцоно. 5 дугаар зүйл 5.1.3.Засгийн газар хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээний журам, нөхцөлийг тогтоох; 13 дугаар зүйл 13.3.1.мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгох;

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэл

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод хүрэх байдлын дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Харилцан уялдаа	Харилцан уялдааг шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.
3	Практикт хэрэгжих боломж	Практикт хэрэгжих боломжийг шалгах: Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг аргачлалын 4.6-д заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгах ба хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр бүлэг. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт хийсэн заалтууд нь мэдээллийн технологийн салбарын нэр томъёог шинээр тодорхойлж жигдлэн, ойлголтын зөрүүтэй байдлыг арилгасан эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн үзэл баримтлалд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн баримт бичигт мэдээллийн технологи, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлт, мэдээллийн технологийн компани, дэвшилтэт технологийн талаарх ойлголт тодорхойгүй байгаагаас Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын

баримт бичгүүдэд төрөөс дэмжихээр заасан “мэдээллийн технологийн компаниуд”, “мэдээллийн технологийн энтрепренер”, “хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн үндэсний компани”, “сэндбокс орчин” зэргийг хэрхэн ойлгох, хэрэглэх хүрээ тодорхойгүй байна. Одоогоор Харилцаа холбооны тухай хуульд “мэдээллийн технологи” гэсэн нэр томъёог тодорхойлсон хэдий ч энэ төрлийн харилцааг цаашид дэлгэрүүлэн зохицуулаагүй, мөн “харилцаа холбоо” гэдэг нэр томъёоны агуулгад “мэдээллийн технологи” гэсэн томъёолол багтахгүй байгаа зэргээс тус хуулийн үйлчлэх хүрээнд хамааруулан зохицуулахад хүндрэлтэй байгаа талаар дурджээ.

Хуулийн төслийн “Нийтлэг үндэслэл” гэх Нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд “мэдээллийн технологи”, “мэдээллийн технологийн үйлдвэрлэл”, “хуулийн этгээд”, “гадаад улсын хуулийн этгээд”, “гарааны компани”, “сэндбокс орчин”, “дэвшилтэт технологи” зэрэг нэр томъёонуудыг тодорхойлсон байна.

Хуулийн төсөлд “мэдээллийн технологи” гэсэн ойлголтыг тодорхойлохдоо Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар мэдээллийн технологитой холбоотой зохицуулалтыг уг хуулийн үйлчлэх хүрээнээс гаргаж зохицуулсан, мөн хуулийн төслийн зорилго нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжиж, уг үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэж байгаатай холбогдуулан “мэдээллийн технологийн үйлдвэрлэл”-ийг хэрхэн, яаж ойлгох нь тодорхойгүй нөхцөл үүсгэж болзошгүй гэж үзэн үүнээс сэргийлж мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, түгээх болон тэдгээрийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэсэн өргөн агуулгаар нэр томъёог тодорхойлсон нь үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилгод нийцэж байна. Харин “үйлдвэрлэл” гэх агуулгад мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг шинээр бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, түгээхээс гадна “үйлчилгээ” гэсэн томъёоллыг оруулан тодорхойлсон нь хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад хууль зүйн нэр томъёоны зөрчил үүсгэж болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим хуулиудыг жишээ болгон дурдвал, 2019 онд Улсын Их Хурлаас Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хүчингүй болгож, түүний шинэчилсэн найруулгыг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль нэршлээр баталсан байна. Мөн 2019 онд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай анхдагч хуулийн төслийг баталж, “үйлдвэрлэл” болон “үйлчилгээ” гэсэн нэр томъёог ялгамжтай байдлаар зохицуулж, “үйлдвэрлэл” гэсэн агуулгад “үйлчилгээ”-г агуулгын

хувьд оруулж тодорхойлоогүй байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад хуулийн төслийн хэл зүй, найруулгыг хийхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх нийтлэг шаардлагыг хангасан байхаар заасантай нийцүүлэн боловсруулах нь зүйтэй.

Хуулийн төсөлд “хуулийн этгээд” гэснийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэгдсэн хуулийн этгээд гэж, “гарааны компани” гэснийг Инновацийн тухай хуулийн 3.1.8-д заасныг гэж томьёолсон нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.7-д заасан хуулийн төсөлд бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх шаардлагатай нийцэж байна. Харин Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрөөс дэмжихээр заасан “мэдээллийн технологийн компаниуд”, “мэдээллийн технологийн энтрепренер”, “хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн үндэсний компани” гэснийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байгаагаас нэр томьёоны тодорхойлолт хийхээр үзэл баримтлалд тодорхойлсон зорилготой хуулийн төслийн зохицуулалт хир хэмжээнд нийцэж байгаа эсэхийг тодруулж үзье. Хуулийн төсөлд компани, энтрепренер, үндэсний компани зэргийг тодорхойлоогүй бөгөөд харин “хуулийн этгээд” гэдэг томьёоллыг эш татан тодорхойлсон. Иргэний хуулийн 25 дугаар зүйлд “хуулийн этгээд” гэснийг өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэж ойлгохоор, хуулийн этгээд нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус зорилготой байх ба ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулж болохоор зохицуулсан. Иймд хуулийн төсөлд “хуулийн этгээд” гэдэг томьёолол хэрэглэсэн нь өргөн утга агуулгыг илэрхийлж, хуулийн этгээд доторх бүхий л төрөл, хэлбэрүүдийг хамааруулж ойлгохоор, хуулийн этгээдийн хэлбэрүүдтэй холбоотой нэр томьёоны зөрүүтэй, ойлгомжгүй байдал үүсвэл Иргэний хуулийн зохицуулалтаас эш татан харах боломжийг бүрдүүлсэн байна. Нөгөө талаар хуулийн төсөлд “компани”, “энтрепренер” зэрэг нэр томьёог тухайлан хэрэглэх нь Иргэний хуульд заасан бусад хуулийн этгээдийн хэлбэрүүдэд хуулийн зохицуулалт үйлчлэхгүй байх үр дагаврыг

үүсгэж, тэдгээрийн үйл ажиллагааг хязгаарлах, улмаар хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэх талтай. Харин хуулийн төсөлд “гадаад улсын хуулийн этгээд”, “сэндбокс орчин”, “дэвшилтэт технологи” зэрэг томъёоллуудыг тодорхойлсон нь хууль зүйн хувьд ач холбогдолтой төдийгүй үзэл баримтлалд дурдсан бодлогын баримт бичгүүдэд хэрэглэсэн салбарын шинэ, ойлгомжгүй нэр томъёоллыг тодорхой болгон, ойлголтын зөрүүтэй байдлыг арилган, нэр томъёоны тодорхойгүй байдлаас үүсэх бэхшээлийг шийдвэрлэхэд үр дүнтэй гэж үзэж байна.

Төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 5.1.2-т төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх зарчмыг баримтлахаар, уг зарчмын хэрэгжилтийг хангах хүрээнд 6.1.5-д Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоохоор, 7.1.2-т төрийн болон нутгийн өөрөөр удирдах байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авах, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр, 8.1.3-т Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх, системийг ашиглан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулахаар тус тус зохицуулснаар төрийн бүх шатны байгууллага мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авч, хамтран ажиллах үүрэгтэй байхаар хуульчилсан байна.

Мөн хуулийн төслийн 9 дүгээр зүйлд төрийн байгууллага нь төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах, хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх, системийг ашиглан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажлыг

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах, бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих ажлыг гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болохоор зааж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг ямар үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж болохыг тодорхойлсноор үзэл баримтлалаар тогтоосон зорилгод нийцсэн байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс, түүний зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Хуулийн төслийн 5.1.4-т Засгийн газар нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах бөгөөд түүний ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор батлахаар тусгажээ. Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй байхаар, Зөвлөл нь эдийн засгийн, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэхээр, Зөвлөлийн дарга нь мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар, Мэдээлэл, технологийн үндэсний парк нь Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхээр тус тус зохицуулжээ. Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тухайн хуулиар зохицуулвал зохих нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгаж, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах, түүний үйл ажиллагааг тогтмолжуулахтай холбоотой зохион байгуулалтын шинжтэй бусад асуудлыг зохицуулсан нь үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна.

Хуулийн төслөөр зохицуулсан мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс нь Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулсан чөлөөт бүсийн зохицуулалтаас ихээхэн ялгаатай байх бөгөөд виртуал бүсийг байгуулах үйл явц нь чөлөөт бүсийг байгуулах, байршлыг тодорхойлж, үйл ажиллагаа явуулах процесстой харьцуулахад ихээхэн хялбар, чөлөөт бүсэд дагаж мөрдөх гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн зэрэг тусгай дэглэм үйлчлэхгүй байхаар зохицуулалтыг хийж, онлайн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжтой байхаар тогтоосон нь хуулийн төслийн үзэл санааг бусад хуулийн зохицуулалтаас ялгагдах онцлогийг илэрхийлж, хэрэгжих боломжийг тодорхойлсон байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг тогтоох, дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэхтэй холбоотой зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Татварын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг дагаж боловсруулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгаж, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдэд өгсөн буцалтгүй тусламжийг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохоор, мөн виртуал бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд тус бүсэд бүртгэлтэй этгээдийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүнд албан татварын хөнгөлөлт үзүүлэхээр, түүнчлэн виртуал бүсэд бүртгүүлснээс хойш 5 хүртэлх жилийн хугацаанд тус бүсэд бүртгэлтэй этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн үйл ажиллагаанаас олсон орлого болон виртуал бүсэд хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээдийн ногдол ашиг албан татвараас чөлөөлөхөөр зохицуулсан.

Татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгаж, мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэх болон экспортод чиглэсэн


мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн грант олгох, дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгох, виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох, хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгох, Батлан даалтын сангийн тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу зээлийн батлан даалт гаргах, хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад багтсан мэдээллийн технологийн чиглэлээр бакалаврын түвшинд суралцаж байгаа оюутныг сургалтын төлбөрөөс хөнгөлөх, хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад багтсан мэдээллийн технологийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэргээр суралцаж төгссөн хүний эхний 1 жилийн үндсэн цалингийн 50 хувийг төрөөс олгох, экспортод гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрт судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх 1 удаагийн дэмжлэгийг дотоодын мэдээлэл технологийн гарааны бизнест олгох, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүний тодорхой хувийг санхүүжүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж гарааны компанид эд хөрөнгийн түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцох, виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын 50 хүртэлх хувийг санхүүжүүлэхээр зохицуулсан байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг ерөнхий агуулгаар томъёолсон байх ба харин хуулийн төсөлд дэмжлэгүүдийг нэг бүрчлэн тоочих байдлаар тодорхойлж, хуулийн төслийн 6.1.3-т хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээ, зээлийн батлан даалт гаргах журам, нөхцөлийг Засгийн газар тогтоохоор заасан нь үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод нийцсэн байна.

Мөн хуулийн төслийн тандан судалгаанд дурдсан Стартап маркетинг спэйс төв, гарааны бизнес эрхлэгчдийн Дриймерс нэгдлийн мэдээллийн санд үндэслэн мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа идэвхитэй явуулдаг 304 бизнес эрхлэгчдийн мэдээлэлд үндэслэн, тус салбарыг төлөөлөх 109 бизнес эрхлэгчийг

түүврийн аргаар сонгож 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд “Гүүгл форм” веб платформыг ашиглан цахимаар судалгаа авсан ба үр дүнг нэгтгэх замаар мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Судалгаанд хамрагдсан нийт 109 компанийн 65.1 хувь нь технологи хөгжүүлэлтийн компани бөгөөд эдгээр технологи хөгжүүлэлтийн компанийн 33 хувь нь финтек буюу санхүүгийн, 30.3 хувь нь эдтек буюу боловсролын, 14.7 хувь нь бүх зүйлсийн интернэт, 11.4 хувь нь блокчэйн технологи хөгжүүлэгч байсан. Судалгаанд хамрагдсан нийт компаниуд мэдээллийн технологийн салбарын тулгамдсан асуудлыг 73.2 хувь нь хүний нөөцийг чадавхижуулах, 63.3 хувь нь татварын орчин сайжруулах, 55 хувь нь дэд бүтцийг хөгжүүлэх, 54.1 хувь нь хөрөнгө оруулалт гэж ач холбогдлоор нь эрэмбэлсэн байх ба хуулийн төслийн зохицуулалт нь мэдээллийн технологийн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн татварын болон татварын бус дэмжлэгтэй холбоотой олон улсын жишигт баримталж байгаа зарим жишиг зохицуулалтуудыг тусгахад зорьсон гэж дүгнэж байна.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан компаниудын тодорхойлсон тулгамдсан асуудал



Харин хуулийн төсөлд тусгасан татварын болон татварын бус дэмжлэгтэй холбоотой зохицуулах шаардлагатай харилцаануудыг тусгахдаа мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй этгээдийн үйлдвэрлэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх талаар дурдаагүй байх бөгөөд энэ зохицуулалтын талаар тодруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагатай харилцан зөвшилцсөний үндсэн дээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, энэ талаар тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Хуулийн төсөлд Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж, энэ хуулийн 7.4-т заасны дагуу төсвийн байгууллагын өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсын хуулийн этгээдэд эзэмшүүлснээс орсон орлого, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.10, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувиас бүрдэхээр тогтоосноор хуулийн этгээдэд үзүүлэх татварын бус дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг тодорхойлсон байна.

Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах талаар зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 6.4-т “Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заан, харилцан тохиролцоно.” Гэж зохицуулсан. Гадаад улс орнууд тэр дундаа Турк, Япон, Солонгос, Казахстан зэрэг орнууд нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн оюуны өмчийн эрхийг баталгаажуулж, өөрийн баталсан стратегийн баримт бичигт оюуны өмчийн эрх зүйн дэд бүтэц, хэрэгжилттэй холбоотой бүтцийг бэхжүүлэхийг онцлон зааж, аж ахуйн нэгжүүдийн оюуны өмчийн эрхийг хадгалах арга хэмжээ авах, программ хангамж, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, брэнд болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор оюуны өмч, патентын эрхийн судалгааг хийх, их, дээд сургуулиудын оюуны өмчийн менежментийн чадавхыг нэмэгдүүлэх, оюуны өмчийг шилжүүлэх, лицензийн гэрээгээр ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор зохицуулалт хийж, үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохоор зорьж байгаа олон улсын жишиг зарчмыг дээрх зохицуулалтын хүрээнд бүрдүүлсэн гэж дүгнэж байна.

Мөн хуулийн төслийн 13.3.1, 13.3.5-д Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын

холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгох, дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгох зэрэг татварын бус дэмжлэг олгохоор, мөн төслийн 5.1.3-т Засгийн газар хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээг тогтоохоор зохицуулсан зэргээс харахад оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг тусгаснаар оюуны өмчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэх зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд төр нь мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зарчмыг үйл ажиллагаандаа баримтлан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхээр зааж, хуулийн төслийн 9 дүгээр зүйлд зохицуулснаар мэдээлэл, технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн дэвшилтэт технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага нь Мэдээлэл, технологийн үндэсний парк байхаар тогтоожээ.

Тус парк нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд гарааны компанийг бойжуулах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гарааны компаниудын үйл ажиллагааг уялдуулах, мэдээллийн технологийн тэмцээн, уралдаан зохион байгуулах, хүний нөөц бэлтгэх чиглэлээр дотоод, гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага болон хувь хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт татах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хариуцах, үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, гадаад аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авахад шаардлагатай нэг цонхны бүртгэлийн системийг хариуцан ажиллуулах, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн

этгээдэд зориулан инкубатор, хамтын оффис ажиллуулах, инкубаторт элсэх хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг тодорхойлох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Түүнчлэн хуулийн төслийн 8.1.7, 8.1.8-д Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулахад дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах талаар арга хэмжээ авахаар зохицуулсан зэргээс дүгнэхэд хуулийн төсөлд үзэл баримтлалаар тогтоосон зорилтыг илүү нарийвчлан зохицуулалт болгон тусгаж, хэрэгжүүлэх этгээдийг хэд хэдэн этгээд байхаар тогтоож гарааны бизнес эрхлэгч нарын үйл ажиллагааг дэмжих боломжийг тодорхойлсон байна.

4.2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

Хүснэгт 4. Хуулийн уялдаа холбоог тогтоосон байдал

Д/д	Асуултууд	Хариулт
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зорилт нь төсөлд тусгаснаар “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар цахим эдийн засгийг дэмжихэд оршино.” гэж заасан байна. Хуулийн төсөлд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газар, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүлээх үүргийг тодорхойлж, мэдээлэл, технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн дэвшилтэт технологи,

		экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Мэдээлэл, технологийн үндэсний паркийн үйл ажиллагааг зохицуулж, төрийн байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой хуульд заасан зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болохоор, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулж, тус бүсэд бүртгүүлсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих дэмжлэгийн эх үүсвэрийг тогтоож, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн оюуны өмчийн эрхийг хамгаалахаар заасан зэрэг нь хуулийн төслөөр дэвшүүлсэн зорилтод нийцэж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм. Хуулийн төслийн 2.1-д “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.” гэж тодорхойлжээ. Монгол Улсын Үндсэн хууль нь иргэний үндсэн эрхийг баталгаажуулж, ардчилсан эрх зүйт төрийн суурь зарчмуудыг тодорхойлсон эрх зүйн дээд хүчин чадал бүхий баримт бичиг тул хууль тогтоомж хэсэгт дурдаж, Үндсэн хууль болон мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан тухайн хууль болон тэдгээрт нийцсэн бусад хуулиудаас бүрдэхээр заасан нь хууль зүйн хувьд үндэслэлтэй бөгөөд тухайн харилцаанд хамаарах холбогдох хуулиудыг тодорхойлон хуульчилсан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд нийт 7 төрлийн нэр томьёог тодорхойлсон бөгөөд “мэдээллийн технологи” гэсэн томьёоллыг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.14-т заасан агуулгаар тодорхойлж, тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж дээрх нэр томьёог хасахаар тусгасан байна. Тухайн хуулийн төсөлд “мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэсэн нэр томьёо хэрэглэгдэж байгаатай холбогдуулан мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, түгээх болон

		тэдгээрийг ашиглан үйлчилгээ үзүүлэхийг хамааруулан ойлгохоор тодорхойлсон бөгөөд өөрөөр хэлбэл “үйлдвэрлэл” гэх агуулгад мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг шинээр бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, түгээхээс гадна “үйлчилгээ” гэсэн томъёоллыг оруулан тодорхойлсон байна. Энэ нь хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад хууль зүйн нэр томъёоны зөрчил үүсгэж болзошгүйг анхаарах шаардлагатайг өмнөх хэсэгт дурдсан билээ. Хуулийн төсөлд хэрэглэсэн “хуулийн этгээд”, “гарааны компани” зэрэг томъёоллыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Инновацийн тухай хуулийг эш татаж тодорхойлсон нь Хууль тогтоомжийн тухай хуультай нийцсэн байна. Мөн “сэндбокс орчин”, “дэвшилтэт технологи” зэрэг нэр томъёог бусад хуулиудад тодорхойлоогүй байх ба олон улсын жишгийг харгалзан нэр томъёоны тодорхойлолт хийсэн нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудын зохицуулалтай зөрчил үүсгэхээргүй байна.
4	Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм. Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь харьцуулж дүгнэхэд хоорондоо зөрчилтэй зохицуулалт байхгүй хэдий ч зарим зохицуулалт нь бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөхөөр байгааг анхаарах шаардлагатай. Хуулийн төслийн 8.1.6-д мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг байхаар заасныг Оюуны өмчийн тухай хуулийн 12.2.2-т “Оюуны өмчийн байгууллага нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах,” гэж заасантай нийцүүлж, зохицуулалтыг зөрчил үүсгэхгүй байхаар тусгах.
5	Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай давхардсан эсэх;	Үгүй. Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь тухайн хуулийн төслийн заалттай давхцалгүй байна. Гэхдээ хуулийн төслийн 8.1.1-д мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батлахыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр заасан байх ба тушаал гаргах агуулга нь тухайн байгууллагаас гаргах шийдвэрийн нэг хэлбэр тул хуулийн төслөөс хасах.

6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм. Хуулийн төслийн 6, 7, 8, 9 дүгээр зүйлд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газар, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх нийтлэг үүрэг, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсноор хуулийн хэрэгжилтийг хангах эрх бүхий этгээдийг тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй. Хуулийн төсөлд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэгийн эх үүсвэрийг хаана бүрдүүлж, хэрхэн зарцуулах нь тодорхойгүй байх ба энэ хүрээнд улсын төсвийн санхүүжилтээс бүрдэх Засгийн газрын тусгай сан, эсхүл Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын сан байгуулах эсэх хэлбэрүүдийг тодруулах.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй. Хуулийн төслийн 6, 7, 8, 9 дүгээр зүйлд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газар, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх нийтлэг үүрэг, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байх ба төслийн 8.1-д “Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 6.1-д заасан нийтлэг үүргийг гүйцэтгэхээс гадна” гэж төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хүлээх үүргээс ялгамжтай байхаар зохицуулалтын давхардлыг арилгасан байна.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм. Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд төрийн байгууллага нь төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах, хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх, системийг ашиглан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах, бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл

		дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих ажлыг гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болохоор заасан байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй. Хуулийн төслийг дагаж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдэд өгсөн буцалтгүй тусламж өгсөн, виртуал бүсэд бүртгүүлснээс хойш 5 хүртэлх жилийн хугацаанд тус бүсэд бүртгэлтэй этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн үйл ажиллагаанаас олсон орлого, виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээдийн ногдол ашиг зэргийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр, виртуал бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд тус бүсэд бүртгэлтэй этгээдийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөхөөр тус тус зохицуулсан байна.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй. Хуулийн төслийн хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд заасан хүрээний асуудал хөндөгдөөгүй байх тул энэ талаарх зохицуулалт тусгаагүй байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй. Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан шинжтэй зохицуулалт байхгүй байна.
13	Хуулийн төслийн хэсэг, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм. Хуулийн төслийн 3.1-д төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, зарчим, чиг үүргийг тодорхойлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа бүхий л хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцаанд

		үйлчлэхээр зааж, жендерийн ялгамжтай байдлыг тусгаагүй байна.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй. Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй. Хуулийн төслийн зорилт болон холбогдох зохицуулалтын хувьд мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдийг дэмжихэд чиглэн, төрийн байгууллагын хүлээх үүргийг тусгасан байх ба авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалт байхгүй байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм. Холбогдох хуульд заасны дагуу хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэхээр заасан байх боловч Зөрчлийн тухай хуульд зөрчлийг тусгах талаар дагах хуулийн төсөл боловсруулаагүй байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалын 4.10-т заасан шалгуурт нийцүүлэн боловсруулсан асуултад хариулах байдлаар хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо зөрчил, давхардал үүсгэсэн эсэхийг шалгасан бөгөөд хуулийн төслийн зохицуулалт давхардал, зөрчилгүй байна. Хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, зөрчлийг шалгах эрх бүхий этгээдийн асуудал тодорхойгүй байх тул Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулж, хуулийн төслийг уялдуулах шаардлагатай байна.

4.3. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ хэсэгт Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн зохицуулалт нь шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэллээ.

Хуулийн төслийг практикт дээр турших нь тухайн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой байна уу, хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд түүнийг хүлээн зөвшөөрч байна уу, бусад этгээдэд хэрхэн нөлөөлж байгаа болон тухайн зохицуулалтад байгаа хийдэл, дутагдалтай зүйлийг тогтооход чухал ач холбогдолтой хэдий ч энэ нь маш их цаг хугацаа, хүн хүч, зардал шаардах тул одоо

болж байгаа үйл явц, хуулийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх замаар боловсруулсан. Ингэхдээ дараах хоёр асуултад хариулах байдлаар тус шалгуур үзүүлэлтийг үнэлсэн.

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх

Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт тусгасан зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

4.3.1.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд Төр нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах, төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх, мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зарчмыг баримтлахаар заасан нь уг зохицуулалтын хэрэгжилтийг хангах суурь эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна. Дээр дурдсанаар уг зарчмын хэрэгжилтийг хангах этгээдийг “Төр” хэмээн томъёолж, хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийг Засгийн газар, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэдээлэл, технологийн үндэсний парк зэрэг байгууллагад хамааруулан тодорхойлсон байна.

Тус бүлэгт зохицуулсан зохицуулалтыг нарийвчлан судалж үзвэл, төслийн 6 дугаар зүйлд Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулахаар тусгажээ. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл нь санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх бөгөөд энэ зохицуулалтыг тусгаснаар Засгийн газар жил бүрийн улсын төсвийг төлөвлөж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ мэдээллийн технологийн үйлдвэрлэл буюу уг үйлдвэрлэлийг

эрхэлж байгаа этгээдийг дэмжихэд анхаарч тодорхой хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэж байхыг даалгасан байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд төрийн бүх шатны байгууллага, нутгийн өөрөөр удирдах байгууллагад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авах, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх нийтлэг үүргийг тогтоож, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлан таниулахад шаардагдах зардлыг төрөөс санхүүжүүлж байхаар заасан байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын асуудлыг хариуцан ажилладаг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар оролцогч талуудын түншлэл, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх, системийг ашиглан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах, үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад таниулахад дэмжлэг үзүүлэх зэргийг хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Мөн хуулийн төслийн 9 дүгээр зүйлд Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт татах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хариуцах, үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, гадаад аутсорсингийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэхээр тусгасан байна.

4.3.2.Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Өмнөх хэсэгт дурдсанаар төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх этгээдийг хуулийн төслийн зохицуулалтад нарийвчлан тодорхойлж, түүний гүйцэтгэх үүргийг тогтоосон.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болохоор заасан. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2022 онд нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор баталсан хэдий ч одоог хүртэл тус хуульд тусгасан түншлэлийг хэрэгжүүлэх нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбар, чиглэлийг Засгийн газраар батлуулаагүй байна. Практик дээр тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулиудад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх чиг үүрэг, чиглэлийг нарийвчлан тодорхойлдоггүйгээс төр, хувийн түншлэлийг хэрэгжүүлэх боломжгүйд хүрч байна.

Иймд хуулийн төслийн 10 дугаар зүйлд төрийн байгууллага нь төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах, хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх, системийг ашиглан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах, бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих ажлыг гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болохоор заасан төр, хувийн хэвшлийн түншлэл аль чиглэлд хэрэгжүүлэхийг ойлгомжтой

болгон тодорхойлсон хуулийн хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой болсон байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах

Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт тусгасан зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

4.3.3.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс, түүний зохицуулалт, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж байна.

Мэдээллийн технологийн салбар хурдацтай хөгжиж, блокчэйн, виртуал хөрөнгө, метавэрс зэрэг шинэ тутам ойлголтууд бий болж улс орнуудад уян хатан бодлого, хурдтай зохицуулалтын орчин шаардаж байна. Уламжлалт систем энэхүү технологийн өөрчлөлтийг цаг үед нь тохируулан шингээж, зохицуулахад хүндрэлтэй юм. Нөгөө талаас зохицуулалтгүй байлгах нь тухайн улс оронд болон иргэдэд санхүүгийн болоод мэдээллийн аюулгүй байдлын олон төрлийн шинэ эрсдлүүд бий болгодог. Гэтэл мэдээллийн технологийн гарааны компаниуд оюуны чадавхиараа өрсөлдөж, өдөр бүр шинэ суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж байгаа нь зохицуулалтын цоо шинэ, уян хатан орчин шаардлагатайг улс орнууд илэрхийлж, сүүлийн жилүүдэд цахим шилжилт эрчимжих тусам улс орнууд “IT – Specialized Zone” буюу мэдээллийн технологийн тусгай бүс үүсгэж, хэрэгжүүлж байна. Цахим орчинд үйл ажиллагаа явуулж, үйлдвэрлэл эрхлэх, хууль эрх зүйн ялгамжтай нөхцөл үйлчлэх нь энэхүү санаачлага амжилттай хэрэгжихэд түлхэц болдог байна. Тусгай бүсийг тухайн улсын бизнесийн, хууль эрх зүйн ялгаатай дэглэм бүхий, оновчтой удирдлагатай бүс бий болгох замаар худалдааны тэнцлийг хангах, ажлын байр нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор байгуулдаг байна.

Хуулийн төслийн 5.1.4-т Засгийн газар нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулах бөгөөд түүний ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор батлахаар тусгажээ. Мөн мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлтэй байхаар, Зөвлөл нь эдийн засгийн, мэдээллийн технологийн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэхээр, Зөвлөлийн дарга нь мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байхаар, Мэдээлэл, технологийн үндэсний парк нь Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхээр зохицуулж хэрэгжүүлэх этгээдийг тодорхойлон заасан байна.

4.3.4.Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Монгол Улсын хууль тогтоомжуудад татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүс байгуулж, Монгол Улсын хууль тогтоомжоос ялгамжтай нөхцөл буюу тусгай дэглэм үйлчлэхээр зохицуулан хэрэгжилтийг зохион байгуулж байгаа хэдий ч практик дээр хэрэгжилт хангалтгүй байгаа тухай шүүмжлэлүүд байна. Чөлөөт бүсийн тухай хуульд зааснаар чөлөөт бүс байгуулах Монгол Улсад чөлөөт бүс байгуулах, түүний байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааны чиглэл, төрлийг тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэж, Чөлөөт бүсийг хилийн зурвас дахь газарт болон Засгийн газрын санал болгосон бүс нутагт байгуулахаар тусгасан байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийслэл хот нь эдийн засгийн тусгай бүстэй байж болохоор, тусгай бүсийг нийслэлийн нутаг дэвсгэр, дагуул хот болон бусад орон нутагт тухайн засаг захиргааны нэгжтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрээр байгуулахаар зааж, тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ, байршлыг Засгийн газар тогтоохоор зохицуулсан байдаг.

Харин Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд виртуал бүс нь тодорхой нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй онлайн орчинд мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарыг бүртгэхээр тусгаж, одоо ажиллаж байгаа бүтцийг ашиглан шинэ зохион байгуулалтын хэлбэр бий болгохгүйгээр, улмаар улсын төсөвт ачаалал үүсгэлгүйгээр Мэдээлэл, технологийн үндэсний парк виртуал бүсийн ажлын албаны чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэхээр зохицуулсан нь виртуал бүсийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулахад үүсэх бэрхшээлийг шийдвэрлэхэд ач холбогдолтой бөгөөд хуулийн зохицуулалтыг практикт хэрэгжих боломжтой гэж дүгнэж байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх

Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт тусгасан зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

4.3.5.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Татварын дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг дагаж боловсруулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгаж, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдэд өгсөн буцалтгүй тусламжийг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохоор, мөн виртуал бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд тус бүсэд бүртгэлтэй этгээдийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүнд албан татварын хөнгөлөлт үзүүлэхээр, түүнчлэн виртуал бүсэд бүртгүүлснээс хойш 5 хүртэлх жилийн хугацаанд тус бүсэд бүртгэлтэй этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн үйл ажиллагаанаас олсон орлого болон виртуал бүсэд хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээдийн ногдол ашиг албан татвараас чөлөөлөхөөр зохицуулсан. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 8 дахь заалтад татварын бодлого нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул виртуал бүсэд бүртгэлтэй мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхтэй холбоотой асуудлыг хариуцан хэрэгжүүлэх этгээдийг тус хуулиас тодорхой харах боломжтой байна.

Татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгаж, төслийн 5.1.3-т Засгийн газар хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээ, зээлийн батлан даалт гаргах журам, нөхцөлийг тогтоохоор заасан байна. Хэдийгээр цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төслийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан боловч татварын бус дэмжлэг үзүүлэх талаар арга хэмжээ

авч ажиллах, хэрэгжүүлэгч этгээдийг тодорхой тусгаагүй байх тул энэ талаарх зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй.

4.3.6.Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Гадаад улс орнууд татварын болон татварын бус дэмжлэгээ хэрхэн үзүүлж, зохицуулалтыг хэрэгжүүлж байгаа туршлагаас харахад Бүгд Найрамдах Казахстан Улс Мэдээлэл, харилцаа холбооны сайдын 2018 оны 415 дугаар тушаалаар "Астана хаб" олон улсын технологийн паркийн үйл ажиллагааны дүрмийг баталж, тус улсын Үндсэн хуулийн хуулийн 9, 10 дугаар зүйлийг үндэслэн 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдөр "Астанагийн олон улсын санхүүгийн төвийн тухай" (АОУСТ) хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн ба үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг өөрийн дүрмээрээ зохицуулдаг байна. Уг Технопаркийн оролцогчоор бүртгүүлсэн өргөдөл гаргагч нь Бүгд Найрамдах Казахстан Улсын хуулийн Татвар ба төсөвт төлөх бусад төлбөрийн тухай хуулийн 461 дүгээр зүйлд заасны дагуу онцгой албан татвар төлөгч болохгүй байхаар тогтоосон. Мөн Астанагийн олон улсын санхүүгийн төвд санхүүгийн болон бусад мэргэшлийн үйл ажиллагаа явуулснаас олсон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 50 жилийн хугацаанд чөлөөлөхөөр, мөн уг төвд арилжаалагдсан үнэт цаасны борлуулалтын хөрөнгийг 50 жилийн хугацаанд ашгийн татвараас чөлөөлөхөөр, түүнчлэн тус төвд арилжаалагдсан үнэт цаасны борлуулалтын ногдол ашгийн орлогоос хувь хүний орлогын албан татварыг 50 жилийн хугацаанд чөлөөлөх татварын хөнгөлөлтийг олгохоор тусгасан.

Уг төвд татварын дэмжлэгээс гадна татварын бус бусад дэмжлэгийг санал болгодог бөгөөд зарим улс орноос дурдвал, АНУ, Их Британи, Канад, Герман, Швейцарь, Нидерланд, Сингапур, Малайз зэрэг улс орнууд нь богино хугацаанд ирж байгаа иргэнийг 30 хоногийн хугацаанд визээс чөлөөлөх, Санхүүгийн төвд ажиллах гадаадын ажиллах хүчийг ажиллах хүчний төлбөрөөс чөлөөлөх, мөн 5 жилийн оршин суух визээс чөлөөлөхөөр тус тус зохицуулжээ. Бүгд Найрамдах Турк Улс нь "Технологийг хөгжүүлэх бүсийн тухай хууль"-ийг 2016-нд баталж, 2022 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Технологи хөгжүүлэлтийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг программ хангамжийн хөгжүүлэлт, судалгаа хөгжүүлэлт, дизайны үйл ажиллагаанаас олсон ашгийг 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр, чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн хэрэглээний программ хангамж (тодорхой судалгаа, хөгжлийн үйл

ажиллагаанд зориулан)-ийг нийлүүлсэн тохиолдолд 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл НӨАТ-аас чөлөөлөхөөр, чөлөөт бүсэд ажиллаж буй судлаач, программ хангамж, судалгаа, хөгжүүлэлт, дизайны ажилтнуудын цалинг 2028 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөхөөр, ажил олгогч төрөөс нөхөн олговор авах боломжтой байхаар заасан. Бүгд Найрамдах Узбекистан Улсын Сайд нарын танхимын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Программ хангамжийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологийн технологийн парк байгуулах арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолд заасны дагуу технопаркийн оршин суугч нь Татварын хуулийн 297 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт заасан үйл ажиллагаанаас нийтээр тогтоосон татварыг төлж, хуулийн 1, 9, 16, 18 дугаар зүйлд заасны дагуу орлогын хувийг буцаан авах эрхтэй байхаар зохицуулсан. Мөн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд бүх татвараас чөлөөлөгдөхөөр заажээ.

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэх этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхээр зааж, татварын дэмжлэгтэй холбоотой зохицуулалтыг энэ хуулийн төслийн хүрээнд бус тухайн харилцааг илүү нарийвчлан зохицуулсан хууль буюу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж тусгасан нь хуулийн хэрэгжилтийг хангахад ач холбогдолтой юм.

Харин татварын бус дэмжлэгтэй холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байх ба мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэх болон экспортод чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн грант олгох, дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон патент эзэмшигчид шагнал, урамшуулал олгох, виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох, хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгох, Батлан даалтын сангийн тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу зээлийн батлан даалт гаргах, хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад багтсан мэдээллийн технологийн чиглэлээр бакалаврын түвшинд суралцаж байгаа оюутныг сургалтын төлбөрөөс хөнгөлөх, хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад

багтсан мэдээллийн технологийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэргээр суралцаж төгссөн хүний эхний 1 жилийн үндсэн цалингийн 50 хувийг төрөөс олгох, экспортонд гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрт судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх 1 удаагийн дэмжлэгийг дотоодын мэдээлэл технологийн гарааны бизнест олгох, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүний тодорхой хувийг санхүүжүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж гарааны компанид эд хөрөнгийн түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцох, виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын 50 хүртэлх хувийг санхүүжүүлэхээр зохицуулжээ. Эдгээр дэмжлэгийн хэлбэрүүдийг тодорхойлохдоо олон улсын туршлагыг харгалзан тусгасан нь хуулийн төслийг Засгийн газарт танилцуулах болон Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулахад ихээхэн ач холбогдолтой юм. Татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл хуулийн хэрэгжилт нь тухайн жилийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай бөгөөд төслийн 5.1.5-д Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоож, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах нь хуулийн хэрэгжилтийг хангах үндэс суурь юм.

**Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч,
зохиогчийн эрхийг хамгаалах**

Хуулийн төслийн 6.4, 5.1.3, 13.3.1 дэх заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

4.3.7.Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 6.4-т “Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.9-д заасны дагуу программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заан, харилцан тохиролцоно.” гэж, 5.1.3-т Засгийн газар хүн, хуулийн этгээдийн мэдээллийн

технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээний журам, нөхцөлийг тогтоохоор зааж хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна. Төсвийн тухай хуулийн 4.1.34-т зааснаар "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг ойлгохоор тодорхойлсон. Харин хуулийн төслийн 13.3.1-д Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгохоор заасан хэдий ч аль байгууллага хариуцан хэрэгжүүлэх нь тодорхойгүй байгааг анхаарах шаардлагатай.

4.3.8.Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Монгол Улсын гарааны бизнесийн экосистемийн талаарх нөхцөл байдлыг тодруулбал, Японы олон улсын Жайка байгууллагын хийсэн судалгаагаар Монгол Улс нь хууль, эрх зүйн тусгайлсан орчин байхгүй, механизм тодорхойгүй, гарааны бизнесийн санхүүжилт, урамшууллын хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, зээл тусламж олгодоггүй, инновац, оюуны өмчийг хамгаалах бодлого тодорхойгүй байгааг онцолсон байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.6-д "Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж, 2.4.21-д "Оюуны өмчийн хараат бус, кодлогдсон технологийн дагуу бүртгэж эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, оюуны өмчийн зуучлал, зөвлөх үйлчилгээ, арилжааг хөгжүүлнэ." гэж заасан боловч одоог хүртэл программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авах тохиолдолд программ хангамжийн эх кодыг гүйцэтгэгч эзэмших боломжийг хууль, эрх зүйн орчны хувьд тодорхойлоогүй, энэ төрлийн зохицуулалт ойлгомжгүй байгаа учир хуулийн төсөлд тендер шалгаруулалтын баримт бичигт захиалагч, гүйцэтгэгч харилцан тохиролцож эзэмшигч этгээдийг тодорхойлохоор заасан нь төр бодлогын хувьд бусад улс орнуудын туршлагыг харгалзан мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны

өмчийг үйлдвэрлэгчид хадгалуулахыг дэмжих, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх, энэ төрлийн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлнэ гэж дүгнэж байна. Харин программ хангамжийн эх кодыг гүйцэтгэгчид эзэмшүүлж, оюуны өмчийн эрхийг хамгаалахад тухайн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч байгаа төрийн бүх шатны байгууллагын дэмжлэг ихээхэн чухал бөгөөд тэдгээрийн ойлголт, хандлагыг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангахад цахим хөгжил, харилцаа холбооны төрийн захиргааны төв байгууллага анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн хуулийн төсөлд мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагуудад патентжуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгон татварын бус дэмжлэг үзүүлэхээр заасан байх бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Засгийн газар нь энэ төрлийн зардлыг улсын төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх нь чухал бөгөөд улсын төсөвт шаардлагатай санхүүжилтийг тусгаагүй тохиолдолд хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах боломжгүй, улмаар жил бүрийн эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байна. Мөн төслийн 5.1.3-т заасны дагуу Засгийн газар нь хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээний журам, нөхцөлийг тогтоох тул зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулах нь зүйтэй.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг аргачлалын 5-д заасны дагуу дараах дарааллаар хийлээ:

5.1.үр дүнг баримтжуулах;

5.2.үнэлэх;

5.3.зөвлөмж өгөх.

5.1. Үр дүнг баримтжуулах

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг холбогдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн бөгөөд холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл зэрэг бусад материалыг ашиглаж, ашигласан материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргаснаас гадна үнэлгээ хийсэн хуулийн төслийг хавсаргасан болно.

5.2. Үнэлэх

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зорилго, зорилт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж үзлээ. Энэ хүрээнд үзэл баримтлалд тодорхойлсон мэдээллийн технологийн салбарын нэр томъёог шинээр тодорхойлох, ойлголтын зөрүүтэй байдлыг арилгах, төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг тодорхойлох, дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэх гэсэн зорилтыг хуулийн төсөлд хэрхэн томъёолсон, тухайн харилцаанд хамаарах бүх асуудлыг бүрэн хамарч зохицуулсан эсэхийг тодорхойлохыг зорьлоо.

Дээрх зорилтуудын хүрээнд хуулийн төсөлд тусгавал зохих харилцаануудыг олон улсын туршлага, практикт тулгамдаад байгаа бэрхшээлүүдийг харгалзан өөрийн орны онцлогт тохируулан үзэл баримтлалаар тодорхойлсон шаардлагад нийцүүлэн оновчтойгоор тодорхойлсон гэж дүгнэж байна. Тухайлбал, Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, дэмжлэгийн эх үүсвэрийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байх ба мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч гарааны компаниудаас авсан судалгааны дүнд үндэслэн мэдээллийн технологийн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн дэмжлэгүүдийг олон улсын туршлагыг баримтлан холбогдох зохицуулалтуудыг тусгасан байна.

Мөн төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх зорилгын хүрээнд төрийн байгууллагаас төр, хувийн хэвшлийн түншлэлээр шилжүүлж болох төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэхэд ашиглах дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, түүний засвар, арчлалт, үйлчилгээ, аюулгүй байдлыг хангах, хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх, бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх зэрэг чиг үүргийг нарийвчлан тодорхойлсноор үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн, зорилгод хүрэх арга замыг оновчтойгоор зохицуулсан байна.

Гэхдээ анхаарвал зохих зарим зохицуулалтууд байгаа энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тодорхойлсон бөгөөд энэ талаар зөвлөмж хэсэгт дурдах болно.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зорилгод хүрэх байдал, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд зохицуулалтуудын ойлгомжтой байдлыг хамтатган судалж байгаа тул ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийг сонгон авч давхардуулан судлах шаардлагагүй гэж үзсэн.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтээр:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд аж ахуйн байгууллагад үүрэг хүлээлгэсэн, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэхэд хүндрэл үүсгэх

зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзсэн.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ уг хуулийг хэрэгжүүлэх байгууллага болох Улсын бүртгэлийн ерөнхий газраас санал авсан бөгөөд тус байгууллага тоон гарын үсгийн гэрчилгээ олгох байгууллагаар ажиллах боломжтой талаар хариу ирүүлж тухай бүр дэмжиж байгаа талаар саналаа илэрхийлж оролцсон байна. Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд хуулийн этгээдэд тоон гарын үсэг болох цахим тамга олгоход хүндрэл үүсэхгүй талаар саналаа өгчээ.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтээр:

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу холбогдох зардлыг тодорхой тооцсон тул энэхүү үнэлгээний тайланд дүгнэлтийг тусгаагүй болно.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан бөгөөд хуулийн төслийг тухайн хуулийн зорилтод нийцүүлж боловсруулсан, хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцсэн, давхардаагүй, хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцсэн, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан, хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй, хуулийн төсөлд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгасан, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалтыг тусгаагүй, шударга өрсөлдөөнийг хязгаарлах, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалтыг тусгаагүй, одоо үйлчилж байгаа хуулийн бүтэц, зохицуулалтыг илүү ойлгомжтой байдлаар тусгаж, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгасан зохицуулалтыг тусгасан гэж үзэж байна.

Түүнчлэн хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагад нийцсэн байна.

5.3. Зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх явцад анхаарах шаардлагатай, хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг

сайжруулвал зохих дараах зохицуулалтын талаар зөвлөмж боловсруулан хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

✓ Хуулийн төслийн нэр томъёоны тодорхойлолтод “мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэх агуулгад мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг шинээр бий болгох, хөгжүүлэх, сайжруулах, түгээхээс гадна “үйлчилгээ” гэсэн томъёоллыг оруулан тодорхойлсон нь хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад хууль зүйн нэр томъёоны зөрчил үүсгэж болзошгүйг анхаарах;

✓ Хуулийн төсөлд тусгасан татварын болон татварын бус дэмжлэгтэй холбоотой зохицуулах шаардлагатай харилцаануудыг тусгахдаа мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй этгээдийн үйлдвэрлэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх талаар дурдаагүй байх бөгөөд энэ зохицуулалтын талаар тодруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харилцан зөвшилцсөний үндсэн дээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах;

✓ Хуулийн төсөлд мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг байхаар заасныг Оюуны өмчийн тухай хуулийн 12.2.2-т “Оюуны өмчийн байгууллага нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах,” гэж заасантай нийцүүлж, зохицуулалтыг зөрчил үүсгэхгүй байхаар тусгах;

✓ Хуулийн төсөлд татварын бус дэмжлэг үзүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах, хэрэгжүүлэгч этгээдийг тодорхой тусгаагүй байгааг анхаарч зохицуулалтыг нэмж тусгах;

✓ Холбогдох хуульд заасны дагуу хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэхээр заасан байх боловч Зөрчлийн тухай хуульд зөрчлийг тусгах талаар дагах хуулийн төсөл боловсруулаагүй байгааг анхаарах;

✓ Татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахтай холбогдуулан авах арга хэмжээний талаарх зохицуулалт бүхий хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

---o0o---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Иргэний хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Инновацийн тухай хууль
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Оюуны өмчийн тухай хууль
- Чөлөөт бүсийн тухай хууль
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

- Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020
- Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, 2017
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020

Гурав. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

Дөрөв. Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага

- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл, 2022

- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, 2023

Тав. Интернэт эх сурвалж

- www.legalinfo.mn

---oOo---



**ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2024 он**

УДИРТГАЛ

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалд заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцсон болно.

Иймд хуулийн төслийн зардлыг урьдчилан тооцохдоо түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллага болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг тоймлон гаргах, хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа үүргийн хүрээнд зардал үүсгэх боломжтой зүйл, заалтуудыг авч үзэн зардал тус бүрээр тооцож, мөн эдгээр байгууллагад үүсэх зардал, ачааллыг бууруулах боломжтой эсэхийг судлан, боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно. Үүнд:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Нэг.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Энэхүү хуулийн төслийн төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараах үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй.

Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200¹ өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана.

1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар тодорхой бүрэн эрхтэй байхаар хуулийн холбогдох зүйл, заалтуудад тусгасан. Иймд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт үүсэх хүний нөөцийн зардлыг доор дурдсан заалтуудыг сонгон авч тооцох болно.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт /5 дугаар зүйл/
Төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөгөө, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;

¹Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

Хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээ, зээлийн батлан даалт гаргах журам, нөхцөлийг тогтоох;
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;
Энэ хуулийн 4.1.7-д заасан дэвшилтэт технологийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;
Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах;
Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын журмыг батлах.

Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн
төрийн захиргааны төв байгууллага

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар холбогдох чиг үүргийг гүйцэтгэхээр хуулийн холбогдох зүйл, заалтуудад тусгасан. Иймд тус байгууллагад үүсэх хүний нөөцийн зардлыг доор дурдсан заалтуудыг сонгон авч тооцох болно.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт /7 дугаар зүйл/
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батлах;
Бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;
Мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх, хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, бодлогын судалгаа шинжилгээ хийх;

Хуулийн төсөлд тусгасан “Хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх” чиг үүргийн хүрээнд программ хангамжийн их дэлгүүр буюу “Mindgolia.mn” системийг хөгжүүлж, ашиглагдаж байгаа тул зардал тооцох шаардлагагүй гэж үзэж хассан болно.

Мэдээлэл, технологийн үндэсний парк

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт Мэдээлэл, технологийн үндэсний парк мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар холбогдох чиг үүргийг гүйцэтгэхээр хуулийн холбогдох зүйл, заалтуудад тусгасан байна. Тус паркийн хэрэгжүүлэх чиг үүргийг хуулийн төсөлд тусгахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 60 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмээс авсан байх тул одоо хэрэгжүүлж байгаа зарим чиг үүрэгт зардал тооцох шаардлагагүй гэж үзлээ. Тус байгууллагад шинээр бий болгосон чиг үүргийн хүрээнд үүсэх хүний нөөцийн зардлыг доор дурдсан заалтуудыг сонгон авч тооцох болно.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт /8 дугаар зүйл/
мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;
мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;

2.Хүний нөөцийн хэрэгцээг тогтоох

2.1.Хуулийн төсөлд тусгагдсан Засгийн газарт нэмэлт эрх, үүрэг үүсгэж байгаа онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
5.1.1.төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөгөө, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдэд татварын болон	Хууль тогтоомжийн төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хууль тогтоомжийн төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	2 өдөр /16 цаг/ 960 мин	2	1920 мин
		Хууль тогтоомжийн төслийг хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	2	480 мин

татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	боловсруулалтыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
5.1.2.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;	Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалтыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.	Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	5 /Хуулийн төслийн хүрээнд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх журам, жагсаалтын тоо/	2400 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	5	1200 мин
5.1.3.хүн, хуулийн этгээдийн мэдээллийн технологийн үйлдвэрлэлд олгох грант, урамшууллын хэмжээ, зээлийн батлан даалт гаргах журам, нөхцөлийг тогтоох;	Журмын төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Журмын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин

	боловсруулалт ыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
5.1.4.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах;	Виртуал бүс байгуулах Засгийн газрын шийдвэрийн төслийн боловсруулалт ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалт ыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.	Шийдвэрийн төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин
5.1.6.энэ хуулийн 4.1.7-д заасан дэвшилтэт технологийн жагсаалтыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;	Жагсаалтын төслийн боловсруулалт ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалт ыг хийж, ЗГХЭГ-	Жагсаалтын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин

	т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
5.1.7.бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээг батлах;	Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээний төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалтыг хийж, ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.	Бүтцийн хүрээний төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин
5.1.8.хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндроксын журмыг батлах.	Журмын төслийн боловсруулалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан хийхгүй бөгөөд мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулалтыг хийж,	Журмын төсөлтэй танилцах, мэдээллээ үнэлэх	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	1	480 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	1	240 мин

	ЗГХЭГ-т хүргүүлэн, батлах үйл явцыг ЗГХЭГ хариуцан ажиллахаар байх тул зардлыг тус агуулгаар хийх нь зүйтэй.				
Нийт					9600 мин

2.2.Хуулийн төсөлд тусгагдсан цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэмэлт чиг үүрэг үүсгэж байгаа онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батлах;	Стандарт, дүрэм, журмын төсөл боловсруулах, батлах	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	7 өдөр /56 цаг/ 3360 мин	10	33600 мин
		Боловсруулалт хийх	30 өдөр /240 цаг/ 14400 мин	10	144000 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	10	2400 мин
	Тушаал, шийдвэрийн төсөл боловсруулах, батлах	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	3 өдөр /24 цаг/ 1440 мин	10	14400 мин
		Боловсруулалт хийх	7 өдөр /56 цаг/ 3360 мин	10	33600 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	10	2400 мин
Бүх нийтийн цахим ур чадварын түвшинг үнэлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах	Сургалт зохион байгуулах, үнэлэх	Сургалтад хамрагдах этгээдийг үнэлэх	30 мин	100 /21 аймаг, 9 дүүрэг, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад /	3000 мин
		Сургалтын бэлтгэл ажлыг хангах	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	100	48000 мин

		Сургалт зохион байгуулах	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	100	48000 мин
Мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийх	Мэдээллийн технологийн салбарын мэдээлэл цуглуулах, судалгаа хийх	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	14 өдөр /112 цаг/ 6720 мин	1	6720 мин
		Судалгааны материал боловсруулах	30 өдөр /240 цаг/ 14400 мин	1	14400 мин
Мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, бодлогын судалгаа шинжилгээ хийх	Бодлогын судалгаа, шинжилгээ хийх	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	7 өдөр /56 цаг/ 3360 мин	2	6720 мин
		Гадаад улс орнуудын туршлага судлах, орчуулах	30 өдөр /240 цаг/ 14400 мин	2	28800 мин
		Судалгааны материал боловсруулах	60 өдөр /480 цаг/ 28800 мин	2	57600 мин
Нийт					442,440 мин

2.3.Хуулийн төсөлд тусгагдсан Мэдээлэл, технологийн үндэсний паркт нэмэлт чиг үүрэг үүсгэж байгаа онцлогоос хамаарч давтамжийг өөр өөрөөр тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;	Тушаал, шийдвэрийн төсөл боловсруулах, батлах	Мэдээллээ цуглуулах, үнэлэх	1 өдөр /8 цаг/ 480 мин	10	4800 мин
		Боловсруулалт хийх	3 өдөр /56 цаг/ 3360 мин	10	33600 мин
		Албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	10	2400 мин
	Сургалт зохион байгуулах	Сургалтын бэлтгэл ажлыг хангах	1,0 өдөр /8 цаг/ 480 мин	4	1920 мин
		Сургалт зохион байгуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	4	9600 мин

	Гомдол шийдвэрлэх	Хариуг боловсруулж хүргүүлэх	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	450	108000 мин
	Зөвлөгөө өгөх	Биечлэн	10 мин	150	1500 мин
		Утсаар	2 мин	150	3000 мин
		Цахимаар	5 мин	150	750 мин
Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;	Хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах;	Хуулийн этгээдийн баримт бичигтэй танилцах, судлах	120 мин	450	54000 мин
		Хуулийн этгээдийг системд бүртгэх	30 мин	450	13500 мин
		Хуулийн этгээдийг виртуал бүсэд бүртгэсэн талаар мэдэгдэх	15 мин	450	6750 мин
Нийт					239,820 мин

3.Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох

3.1.Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	9600 мин	96000	0.1

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
ТЗ-1	2,562,000
ТЗ-2	2,440,000

T3-3	2,302,000
T3-4	2,171,000
T3-5	2,048,000
T3-6	1,933,000
T3-7	1,757,000
Дундаж цалин	2,173,285

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ажлын хөлсийг тогтоохдоо “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-ээс дундаж цалингийн хэмжээг тооцож, холбогдох нэмэгдлүүдийг тооцохгүйгээр **сарын дундаж цалинг 2,173,285 төгрөг** байхаар тооцов.

Хүний нөөцийн зардал

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
ЗГХЭГ	2,173,285	0.1	12	2,607,942
Нийт хүний нөөцийн зардал жилд				2,607,942

3.2.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрд зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	442,440 мин	96000	4.6

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ
T3-1	2,562,000
T3-2	2,440,000
T3-3	2,302,000
T3-4	2,171,000
T3-5	2,048,000
T3-6	1,933,000
T3-7	1,757,000
Дундаж цалин	2,173,285

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажлын хөлсийг тогтоохдоо “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-ээс дундаж цалингийн хэмжээг тооцож, холбогдох нэмэгдлүүдийг тооцохгүйгээр **сарын дундаж цалинг 2,173,285 төгрөг** байхаар тооцов.

Хүний нөөцийн зардал

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
ЗГХЭГ	2,173,285	4.6	12	9,997,111
Нийт хүний нөөцийн зардал жилд				9,997,111

3.3.Мэдээлэл, технологийн үндэсний паркийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрд зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараах байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Мэдээлэл, технологийн үндэсний парк	239,820 мин	96000	2.5

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр Мэдээлэл, технологийн үндэсний паркад үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Хүний нөөцийн зардал

Нэгж	Цалингийн зардал /төг/	Орон тооны ачаалал	Сар	Хүний нөөцийн нийт зардал /төг/
Мэдээлэл, технологийн үндэсний парк	1,700,000 /МТҮП дахь цалингийн дундаж хэмжээ/	2.5	12	4,250,000
Нийт хүний нөөцийн зардал жилд				4,250,000

4.Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. Тухайлбал албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, шаардлагатай бусад зардлыг энд тооцох хэрэгтэй. Ингэхдээ дээрх зардлуудын дийлэнхийг, тухайлбал урсгал зардлыг /халаалт, цэвэр, бохир ус, цахилгаан, урсгал засвар гэх зэрэг/ үйлчилгээний байр тус бүрээр ерөнхий байдлаар гаргадаг тул 1 ажилтанд зарцуулах материаллаг зардлыг нарийвчлан тооцож гаргах боломжгүй юм. Иймд “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”-д жишээ болгон авсан нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав.

Нийт дүнг тооцохдоо төрийн байгууллагаас гарах нийт зардлыг тооцох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

**Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай
хуулийн төслийн хүрээнд гарах материаллаг зардлын тооцоо**

№	Зардлын нэрс	Хуулийн хэрэгжилттэй холбоотой гарах нэмэлт зардал нэгжээр	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Бичиг хэргийн материал	1,016,445	1	1,016,445
2	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	180,734	1	180,734
3	Хангамжийн материал	543,331	1	543,331
4	Бусад зардал	48,766	1	48,766
Дүн		1,789,276		1,789,276

Үүнээс харахад улсын бүртгэлийн нэг ажилтанд гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,789,276 /нэг сая долоон зуун наян есөн мянга хоёр зуун далан зургаа/ төгрөг бөгөөд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний паркард шаардлагатай хүний нөөц /7.1/-д үржүүлэн тооцвол нийт дүн 12,703,859 төгрөг болохоор байна.

Төрийн байгууллага, түүний чиг үүргийг гүйцэтгэгч этгээдэд үүсэх нийт зардлыг тооцоход жилд:

$$16,855,053 + 12,703,859 = 29,558,912 \text{ төгрөг байна.}$$

5.Хувилбарыг нягтлах

Хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, төсвийн зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтооно.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар
1.	Боловсруулан, батлах журмын тоог багасгах	Боломжгүй	Хуулиар үүрэгжүүлсэн.
2.	Судалгааны мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Судалгаа ач холбогдолгүй болно.
3.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Боломжтой	Өмнө нь хийгдэж байсан ажлууд бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар хуульчлагдсан.
4.	Зарим баримт бичгийг боловсруулах хугацааг багасгах боломжтой эсэх	Боломжтой	
5.	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Боломжгүй	Мэдээллийн хүртээмж буурна.

Дүгнэлт

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад жилд нийт 29,558,912 төгрөгийн зардал гарахаар тооцов.

Хуулийн төсөлд тусгагдсан зарим үүргүүд нь одоо хийгдэж байгаа ажиллагааг нарийвчлан хуульчилж өгсөн тул нэмэлтээр үүсэх зардал буурах боломжтой. Түүнчлэн гомдол гаргах, зөвлөгөө авах, виртуал бүсэлд бүртгэл хийлгэх тохиодлын тоог статистик тоон мэдээнээс өндрөөр тооцсон тул энэ тохиолдлын тоо буурч зардал буурах боломжтой байна.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгдэх үйл ажиллагаануудыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний парк нь өөрийн үйл ажиллагаанд зохион байгуулалт хийх, албан тушаалын тодорхойлолтод зарим өөрчлөлт хийх замаар төсөвт ачаалал үүсгэхгүйгээр хийх боломжтой гэж дүгнэлээ.

Харин хуулийн төсөлд Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний парсад үүсэх хүний нөөцийн зардал, материаллаг зардал болон бусад зардлаас гадна мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт үзүүлэх дэмжлэгийн эх үүсвэрийг санхүүжүүлэхтэй холбоотой зардлыг тооцох шаардлагатай.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж, энэ хуулийн 7.4-т заасны дагуу төсвийн байгууллагын өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсын хуулийн этгээдэд эзэмшүүлснээс орсон орлого, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.10, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувийг виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийг дэмжихэд зарцуулахаар тусгасан байна.

Эдгээр зардлаас мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө нь улсын төсвөөс санхүүжих зардал байх ба харин хандив, тусламж, өөрийн эзэмшиж байгаа программ хангамжийн эх кодыг гадаад улсын хуулийн этгээдэд эзэмшүүлснээс орсон орлого нь улсын төсөвт ачаалал үүсгэхээргүй байна. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5-д заасан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, 5.3.10-д заасан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан, 5.3.20-д заасан Шинжлэх ухаан, технологийн сангуудын хөрөнгө нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт буюу гарааны компаниудыг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох, өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэг, бусад дэмжлэг үзүүлэх, мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт, мэргэшүүлэх сургалтын зардал, инновацийн төсөл хэрэгжүүлэх, гарааны санхүүгийн дэмжлэг олгох, технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд дэмжлэг үзүүлэх зэрэгт зарцуулахаар зохицуулсан тул Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувийг виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийг дэмжихэд зарцуулахаар тусгасан зохицуулалтын хүрээнд зардал тооцох

шаардлагагүй болно. Өөрөөр хэлбэл виртуал бүсэд бүртгэгдэх хуулийн этгээд нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч, шинэ технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх компаниуд байх тул дээрх сангуудаас явуулж байгаа үйл ажиллагааны хүрээнд дэмжлэг авах боломжтой учир төсвөөс нэмж мөнгөн хөрөнгө тусгах шаардлагагүй байна.

Харин дээр дурдсан мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө нь хэдий хэмжээний зардал үүсгэхээр байгааг тооцож үзье. Сангийн яамнаас улсын төсөвт тодорхой салбараас төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг нарийвчлан тооцоолоход хүндрэлтэй байдаг тухай тодруулсан тул мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс орж байгаа орлогын талаарх дүн мэдээнд үндэслэн түүнээс татвар тооцож улсын төсөвт цугларсан мөнгөн хөрөнгийг уг зардал байхаар тооцооллоо. Үндэсний статистикийн газрын <https://www.1212.mn/> сайтаас мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлогын талаарх дүн мэдээг тодруулахад Компьютер программчлал, зөвөлгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаанаас сүүлийн 3 жилийн хугацаанд буюу 2021 онд 144 тэрбум, 2022 онд 130 тэрбум, 2023 онд 222 тэрбум төгрөгийн орлого олсон байх ба дунджаар 165 тэрбум төгрөг байна. Улсын төсөвт нийт төвлөрүүлсэн хөрөнгө нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасны дагуу мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарын үйл ажиллагаанд ногдуулж байгаа албан татварын орлогоос бүрдэх тул энэ талаарх эрх зүйн орчныг тодруулж, зохих тооцооллыг хийх нь зүйтэй.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.7-д тус хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар, 20.1-д зааснаар тус хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулахаар тус тус зохицуулсан байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл бүрт ногдуулж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг нэг бүрчлэн тооцох боломжгүй бөгөөд үзэл баримтлалд дурдсанаар мэдээллийн технологийн бизнес эрхлэгчдийн ихэнх нь гарааны

компаниуд байх тул тухайн үйл ажиллагааны орлого нь 300 сая төгрөг хүртэлх гэж тооцох шаардлагатай. Иймд мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарын ихэнх буюу 80 гаруй хувь нь гарааны бизнес хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа гэж үзэн өмнө дурдсан 165 тэрбум төгрөгийн орлогын 80 хувьтай тэнцэх хэмжээний буюу 132 тэрбум төгрөгийн орлогоос 1 хувийн татвар тооцоход 1,3 тэрбум төгрөг, харин 165 тэрбум төгрөгийн орлогын 20 хувьтай тэнцэх хэмжээний буюу 33 тэрбум төгрөгийн орлогоос 10 хувийн татвар тооцоход 3,3 тэрбум төгрөг болж нийтдээ улсын төсөвт 4,6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн гэж үзэхээр байна. Мөн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11.1-д тус хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын үнэлгээнд 10 хувиар ногдуулахаар заасан бөгөөд 165 тэрбум төгрөгийн орлогоос 10 хувийн татвар тооцоход 16,5 тэрбум төгрөг байхаар байна. Иймд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас нийтдээ 21 орчим тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн гэж үзвэл 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө нь 8.4 тэрбум төгрөг байхаар тооцоолол гарч байна. Энэ зардал нь тухайн жилийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан бусад хууль тогтоомжийн нэгэн адил улсын төсвөөс шийдвэрлэгдэхгүй байх магадлалтайг харгалзан хууль хэрэгжсэнээр төрийн байгууллага, төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа байгууллагад үүсэх хүний нөөцийн зардал, материаллаг зардал болон бусад зардалд оруулан тооцоогүй болно.

Хоёр.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардал

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлэхдээ улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэл, ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт, эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг ирүүлэх үүргийг тодорхойлсон байх ба гэхдээ улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэл, ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс татаж харах боломжтой тул энэ төрлийн мэдээллийг давхардуулан ирүүлэхгүй шаардлагагүй байна. Харин өмнөх жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг ирүүлэх хэрэгцээ шаардлага байна. Хуулийн этгээд нь виртуал бүсэд бүртгүүлэх, гэрээ байгуулах зорилгоор ирж, буцах зардлаас бусад тохиолдолд зардал тооцохгүй болно.

Хүсэлт гаргагчийн байрладаг байршил, ашиглах тээврийн хэрэгслийн хэлбэр түүний зарцуулах зардал харилцан адилгүй байна. Тухайлбал, нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж Мэдээлэл, технологийн үндэсний паркт очих болон буцах зардалд 500Х2 буюу 1000 төгрөг, харин таксины үйлчилгээ авсан тохиолдолд зардлыг зах зээлийн дундаж үнэлгээгээр тооцвол 10000Х2 буюу 20000 төгрөг гарах магадлалтай байна. Харин бүртгэлийг цахим хэлбэрээр хийлгэх, гэрээг цахим хэлбэрээр байгуулах тохиолдолд хуулийн этгээдэд ямар нэгэн зардал үүсэхээргүй байна.

№	Зардлын нэрс	Хуулийн хэрэгжилттэй холбоотой гарах нэмэлт зардал нэгжээр	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Ирж, буцах зардал /нийтийн тээвэр/	1000	450	450,000
2	Ирж, буцах зардал /Такси/	20000	450	9,000,000

Гурав.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардал

Хуулийн төсөлд иргэний гүйцэтгэх үүргийг тусгаагүй, үүрэгжүүлсэн зохицуулалт байхгүй тул зардал тооцох шаардлагагүй болно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хэмжигдэхүйц зардлыг тооцсон болно. Үүнд:

1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага, төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх байгууллага болох Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэдээлэл, технологийн үндэсний паркийн хариуцах нэмэлт чиг үүргийг тусгасан. Иймд эдгээр заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг аргачлалын 4.3.3-т заасны дагуу хэмжих боломжтой ажлыг тооцсон бөгөөд хуулийн төслийн заалтуудад заасан ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тооцоход нийт төрийн байгууллага, төрийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа байгууллагад жилд нийт **29,558,912 төгрөгийн** зардал үүсэхээр байна.

2.Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн заалттай холбоотой хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцохдоо мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгүүлэх, гэрээ байгуулах зорилгоор Мэдээлэл, технологийн үндэсний паркт ирж, буцахад шаардлагатай унаанд мэдээллийн технологийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 450 компани гэж зардлыг тооцоход нийтийн тээврээр үйлчлүүлсэн тохиолдолд 450,000 төгрөгийн буюу нэг компанид 1000 төгрөгийн, таксины үйлчилгээ авсан тохиолдолд дунджаар 9,000,000 төгрөгийн буюу нэг компанид 20000 төгрөгийн зардал үүсэхээр байна. Гэхдээ бүртгэл, гэрээ байгуулах ажлыг цахим хэлбэрээр хийх боломжтойг хуулийн төсөлд тусгасан бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдэд ямар нэгэн зардал үүсэхгүй болно.

3.Хуулийн төсөлд тусгагдсан хуулийн заалттай холбоотой иргэнээс гарах зардал үүсэхээргүй байна.

Тус хуулийн төсөл батлагдсанаар гарах зардал нь үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг зардлын харьцаа өндөр байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. *Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"*;
3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал";
4. <https://mddc.gov.mn/mn/>
5. <https://itpark.mn/>
6. [Статистикийн мэдээллийн нэгдсэн сан \(1212.mn\)](#)

---oOo---

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТУХАЙ

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага болон Монгол Улсын хамтын ажиллагааны хүрээнд “Японы буцалтгүй тусламжаар ЖАЙКА-гийн дэмжлэгийн хөтөлбөрүүдэд зөвлөмж гаргах зорилгоор мэдээлэл цуглуулах болон туршилтын 5 төсөлд төвлөрсөн судалгаа хэрэгжүүлэх” ажлын хүрээнд Нээлттэй өгөгдлийн платформын талаар хэлэлцүүлэх арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Мэдээлэл, технологийн үндэсний парк ААТӨУҮГ-т зохион байгуулсан.

Уг хэлэлцүүлгийн үеэр тус яамны зөвлөх С.Тэнгис “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хууль”-ийн төслийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлэгт оролцогсад хуулийн төслийг боловсруулж буйд талархал илэрхийлэн дэмжиж буйгаа илэрхийлсэн.

Нэг. Хэлэлцүүлгийн үеийн зураг







Хоёр. Хэлэлцүүлэгт оролцсон хүмүүсийн жагсаалт

№	Хэлэлцүүлэгт оролцогчдын нэр	Байгууллагын нэр	Албан тушаал
1	Л.Ариунаа	Интек ХХК	Захирал
2	Тэмүүжин Ганзориг	Интек ХХК	Менежер
3	Золжаргал	Мобиком	М оффисын менежер
4	Наранчулуун	ТАНУСОФТ	Захирал
5	Чинбат	Наша Тек ХХК	Захирал
6	Азаа Алтангэрэл	Экспоненциал Зайсан Партнерс	Managing Partner
7	Буянжаргал Ширнэн	Шинжлэх ухаан, боловсролын сайдын зөвлөх	Зөвлөх
8	Мөнхжаргал	KITE Монголиа	Үүсгэн байгуулагч
9	З.Сэргэлэн	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Ахлах мэргэжилтэн
10	Анар	Интелмайнд	Дэлхийн өсөлтийн ахлах менежер
11	Ж.Золжаргал	Мэдээлэл, технологийн үндэсний парк	Захирал
12	Дариймаа Чинбат	Мэдээлэл, технологийн үндэсний парк	Гадаад харилцааны мэргэжилтэн
13	Тунгалаг	Тунгаахуй	Менежер
14	Шиничи Танака	ЖАЙКА Монголиа оффис	Тэргүүн төлөөлөгч
15	Кэйго Накамура	ЖАЙКА Монголиа оффис	Төлөөлөгч

16	Ц.Хоролсүрэн	ЖАЙКА Монголиа оффис	Хөтөлбөрийн мэргэжилтэн
17	Ацуши Ямакана	ЖАЙКА Монголиа оффис	Ахлах зөвлөх
18	Акане Мияажима	ЖАЙКА Монголиа оффис	Дэд захирал
19	Шосэй Ямамото	Делойт Япон	Ахлах дэд ерөнхийлөгч
20	Масаюки Саката	Делойт Япон	Менежер
21	Жин Ёшида	Делойт Япон	Дэд ерөнхийлөгч
22	Томоми Окамото	Делойт Япон	Ахлах шинжээч
23	Брэндон Саффелл	Делойт Япон	Ахлах шинжээч
24	Болормаа Буян	Делойт Япон	Төслийн зохицуулагч
25	Ундрал	Гэрэгэ системс	
26	Батбаяр Нямтайсүрэн	Поверед ХХК	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
27	Төгөлдөр Баярсайхан	Поверед ХХК	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
28	Жавхлан Ренцэндорж	Поверед ХХК	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
29	Монужара	Startup Challenge Mongolia	
30	Б.Баттамир	Хонмоно Комикс ХХК	
31	Д.Хулан	Экспоненциал Зайсан Партнерс	
32	Хатанжаргал	Рокки системс	
33	Хатан-Эрдэнэ	One Day Job	
34	Сайханбаяр	One Day Job	
35	Мандхай хатан	Төрийн бус байгууллага	
36	Ангараг	Мэдээлэл, технологийн үндэсний парк	
37	Пүрэвбазар Пүрэвжаргал	Фибо клауд	
38	Ганбаяр	Мэдээлэл, технологийн үндэсний парк	
39	Лхагвасүрэн	Мэдээлэл, технологийн үндэсний парк	
40	Н.Энхжаргал	Гэрэгэ системс	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН НЭГТГЭЛ

Д/д	Санал ирүүлсэн байгууллагын нэр	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан байдал
1	Батлан хамгаалахын яам 2024.04.30 16/1621	1.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д “Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтоох” гэсний найруулгад анхаарч, хуулийн төсөлд ямар чиг үүрэг бүхий зөвлөл байх талаар тодорхой тусгах;	Хуулийн төслийн 11.2 дахь хэсэгт “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.” гэж заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тогтоохоор заасан.
		2.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Төсвийн байгууллага нь ... нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заан, ...” гэснийг “Төсвийн байгууллага нь ... нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичиг зааж, ...” гэж өөрчлөн найруулах;	Саналыг тусгаж, томъёоллыг өөрчилсөн болно.
		3.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд “Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинтэй холбоотой мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахгүй байж болно.” гэж нэмж тусгах;	Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинтэй холбоотой аливаа худалдан авалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4-т заасан журмаар зохицуулагдах тул энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй.
		4.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой стандарт, ..., батлах” гэж цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх арга	Саналыг тусгаж, 8.1.1 дэх заалтыг “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар нийтээр дагаж мөрдөх стандарт, дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах,” гэж өөрчилсөн болно.

		хэмжээнд заасан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д “эрхэлсэн асуудлаар стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасан стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний хэрэгжилттэй холбогдох зохицуулалт Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд тусгагдаагүй байгааг анхаарах.	хэмжээнд заасан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д “эрхэлсэн асуудлаар стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасан стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний хэрэгжилттэй холбогдох зохицуулалт Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд тусгагдаагүй байгааг анхаарах.
2	Гадаад харилцааны яам 2024.04.25 08/2139	Тусгайлан өгөх саналгүй болно.	Дэмжсэн.
3	Монгол Улсын Шадар сайд 2024.04.25 ЗГ-2/300	Хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэх шаардлагыг анхааран үзнэ үү.	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийн чиг баримжаа бүхий шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх замаар үндэсний өрсөлдөх чадварыг сайжруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгыг дэвшүүлсэн бөгөөд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл нь шинжлэх ухаан, технологийн нэг чиглэл болох мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэх, түүнийг төрөөс татварын болон татварын бус бодлогоор дэмжих, энэ талаар төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн

		орчныг боловсронгуй болгох, цахим эдийн засгийг дэмжих зорилготой болно.
4	Зам, тээврийн хөгжлийн яам 2024.04.29 01/1862	1.Хуулийн төслийн 5 дугаар зүйлд “Төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хүн, хуулийн этгээдийг нээлттэй мэдээлэл, нээлттэй өгөгдлөөр хангаж, дэмжлэг үзүүлэх” гэж нэмэх;
		Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.” гэж заасан бөгөөд тус хуулиар нээлттэй өгөгдөл бий болгох, төрийн байгууллагад цугларсан зарим мэдээллийг нээлттэй, ил тод болгохтой холбоотой харилцааг зохицуулж байгаа тул энэ хуулийн төслийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй болно.
		2.Хуулийн төслийн 8 дугаар зүйлд “Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ангилал, төрөл, зориулалт, зохиогчийн эрхийн түвшин, хамрах хүрээ, хэрэглээний түвшин зэргээр нь төрөлжүүлэн мэдээллийн сан бүрдүүлэх” гэж нэмэх;
		Саналыг тусгаж, хуулийн төсөлд 9.1.11 дэх заалт нэмж, “Гадаад болон дотоодын зах зээлд нийлүүлэх мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ангилал, төрөл, зориулалт, зохиогчийн эрх болон бусад нэмэлт мэдээллийн хамт бүртгэх.” гэж тусгасан болно.
		Оюуны өмчийн тухай хуулиар оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тогтоох, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжихтэй холбогдсон

	түүнчлэн оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан бүтээл, санааг хамгаалах чиглэлээр нэмэлт заалтуудыг тусгах.	нийтлэг харилцааг зохицуулж байгаа тул тус хуульд заасны дагуу оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх болно.
	1.Хуулийн төслийн 7.1.3-т "хөрөнгийг" гэснийг "зардлыг" гэж өөрчлөх;	Саналыг тусгаж, хуулийн 7.1.3-т " ... хөрөнгийг ..." гэснийг "... зардлыг ..." гэж өөрчилсөн.
	2.Хуулийн төслийн 14.3.8-д заасныг хасах;	Саналыг тусгаж, хуулийн төслийн "14.3.8.хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад багтсан мэдээллийн технологийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэргээр суралцаж төгссөн хүний эхний 1 жилийн үндсэн цалингийн 50 хувийг төрөөс олгох," гэснийг хассан.
5	Соёлын яам 2024.04.25 1/1128	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.4.6.хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх;" гэж заасан бөгөөд уг хуулийн төслөөр нарийвчлан зохицуулсан болно.
	4.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу "бусад хуультай уялдах, нийцсэн байх" гэсэн шаардлагыг хангуулахад анхаарах.	Бусад хуулийн зохицуулалттай нийцүүлсэн бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах

			тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан болно.
6	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2024.04.26 02/939	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг дагалдан боловсруулсан Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлээс “3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалт,” гэснийг хасах. Учир нь Харилцаа холбооны тухай хуульд 32 удаа дурдагдсан “мэдээллийн технологи” гэсэн үгийн нэр томъёоны тодорхойлолтыг хасвал уг хуулийг нэр мөр ойлгож зөв хэрэглэх боломжгүй болохыг анхаарна уу.	Хуулийн төслийн 4.1.1 дэх заалтад “мэдээллийн технологи” гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан тоон өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг, хэлэхээр заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.7 дахь заалтад Хуулийн төслийн агуулга нь бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх шаардлагыг хангахаар заасан”-ы дагуу Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тохиолдолд уг хуулийн зохицуулалтыг эш татан харах боломжтой.
7	Эрүүл мэндийн яам 2024.04.30 1a/1819	Хуулийн төслийн үг үсгийн алдааг нягтлах шаардлагатай байна. Зарчмын хувьд дэмжиж байна.	Саналыг тусгасан.
8	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2024.04.29 ХЭГ/840	1.Хуулийн төслийн 4.1.11-д “мэдээллийн технологи” гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан тоон өгөгдлийг үүсгэх боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг ойлгохоор заасан байх бөгөөд үүнтэй холбогдуулан Харилцаа холбооны тухай хуульд заасан мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай холбогдсон харилцааг хасахаар төсөлд тусгажээ. Энэ нь	Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.10 дахь заалтад “харилцаа холбоо” гэж цахилгаан холбоо, радио холбоо, өргөн нэвтрүүлэг, шуудангийн бүх төрлийг,” хэлнэ гэж тодорхойлон уг нэр томъёоны хүрээнд мэдээллийн технологи гэсэн агуулгыг оруулан тодорхойлоогүй байна. Өөрөөр хэлбэл хуулийн нэршил нь “Харилцаа холбооны тухай хууль” бөгөөд уг нэршилтэй

	Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтэд сөрөг үр дагавар үүсэх эсэхийг эргэн нягталж, энэ талаар Харилцаа холбооны зохицуулах хороотой нэгдсэн санал дүгнэлтэд хүрэх нь зүйтэй;	Холбоотойгоор нэр томъёоны тодорхойлолтод дурдсан харилцааг зохицуулах шаардлагатай юм. Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.3 дахь заалтад хуулийн төслийн агуулга нь тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх шаардлагыг хангасан байхаар заасан тул уг хуулийн зохицуулалтад нийцүүлж зохицуулалтуудыг тусгасан болно. Мөн мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэйгээр хангахтай холбогдсон харилцааг Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслөөс эш татан харах боломжтой. Монгол Улсын Их Хурлын эрх хэмжээний асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай зэрэг хуулиудаар зохицуулагдаж байгаа тул энэ хуулийн зохицуулах боломжгүй болно. Саналыг тусгаж, 6.1.1 дэх заалтын "мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах," гэснийг хассан болно.
	2.Хуулийн төсөлд Улсын Их Хурлын эрх хэмжээг орхигдуулсан байх тул нэмж тусгах;	
	3.Хуулийн төслийн 6.1.2-т Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах эрх хэмжээтэй байхаар тусгасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2-т "Засгийн газар хуулиар тусгайлан эрх	

	олгосон тохиолдолд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд хэм хэмжээний акт гаргаж болох бөгөөд тогтоол хэлбэртэй байна” гэж, Захиргааны ерөнхий хуулийн 59.1-д Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байх тул Засгийн газрын батлах дүрэм, журмын нэрийг тодорхой төсөлд тусгах;	
	4.Хуулийн төслийн 6.1.9-д Засгийн газар ямар Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах нь ойлгомжгүй байгааг анхаарах;	Хуулийн төслийн 11.2 дахь хэсэгт “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллана.” гэж заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тогтоохоор заасан.
	5.Хуулийн төслийн 9.1-д Мэдээлэл, технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн дэвшилтэт технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага /Мэдээлэл, технологийн үндэсний парк/-тай байхаар заасан бөгөөд уг байгууллагын хэлбэр /аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон улсын төсөвт үйлдвэрийн газрын аль нь болох/-ийг тодорхой тусгах;	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад Засгийн газар нь хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлахаар заасан тул уг хуулийн хүрээнд тус байгууллагын хэлбэрийг тогтоох зохицуулалт үйлчлэх болно. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хүрээнд

		Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд хамаарах хэсгийг зохицуулсан болно.
	6.Хуулийн төслийн 9.2.4-д Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт татах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хариуцахаар заажээ. Энэ нь Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагуудын бүрэн эрхийг зөрчиж байгааг анхаарч, хуульд нийцүүлэх; 7.Хуулийн төслийн 9.2.9-д Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд хуулийн этгээдийг бүртгэх, хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасах чиг үүргийг хэрэгжүүлэхээр зааж, төслийн 13 дугаар зүйлд энэ талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгажээ. Гэвч уг асуудалд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрхэн оролцох эсэх нь тодорхойгүй байгааг нягтлах;	Саналыг тусгаж, хуулийн төслийн 9.1 дэх хэсгийг "Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасан болно.
		Хуулийн төслийн 12.1 дэх хэсэгт Ажлын алба нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд (цаашид "хуулийн этгээд" гэх)-ээс цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 өдрийн дотор хянаж, холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд виртуал бүсэд бүртгэж, хариу мэдэгдэхээр заасан. Өөрөөр хэлбэл мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч "хуулийн этгээд" буюу нэгэнт Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлж үйл ажиллагаа

		явуулж байгаа этгээдийг виртуал бүсэд бүртгэхтэй холбоотой зохицуулалт болно. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тус хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг ханган боловсруулсан болно. Ирүүлсэн саналд "хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нийтлэг шаардлагад нийцээгүй, хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцээгүй" гэсэн нь ойлгомжгүй, нийтлэг байдал гэдэгт юуг хамааруулж ойлгох нь тодорхойгүй, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн аль бүлэг, зүйл, хэсэг, заалттай, түүнчлэн ямар хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа талаарх үндэслэл бүхий тайлбарыг дурдаагүй байгаа болно.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн 11.9 дэх хэсэгт "Бараа, ажил, үйлчилгээний үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана." гэж заасан бөгөөд "түүний нэр заасан этгээд" гэдэгт гүйцэтгэгчийг оруулж ойлгохоор зохицуулсан байна.
	8.Хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нийтлэг шаардлагад нийцээгүй, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөж байгааг анхаарч, төслийг дахин боловсруулж, бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай байна.	1.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт "Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заан, харилцан тохиролцоно." гэж заасантай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйл (Тендер шалгаруулалтын баримт бичиг)-д нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулах;	Эрчим хүчний яам 2024.04.29 a/1285
9			

	2.Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоол батлагдсан байх тул хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Төрийн байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой дараах зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, ...” гэснийг “Төрийн байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой дараах зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж ...” гэж нэр томъёог өөрчлөх;	Саналыг тусгаж, хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг “Төрийн байгууллага нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлтэй холбоотой дараах зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно.” гэж өөрчилсөн болно.
	3.Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Монгол Улс нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүстэй байх бөгөөд түүний ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор батална.” гэж заасан байх тул хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.4 дэх хэсгүүдэд заасан зөвлөлийн чиг үүрэг, зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэрийг дээрх журмаар зохицуулагдах боломжтой байх тул хуулийн төслөөс хасах;	Саналыг тусгасан.
	4.Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хуулийн этгээдтэй цахимаар байгуулах гэрээний загварыг батлах эрх бүхий этгээд тодорхойгүй байх тул дахин нягтлах саналтай байна.	Саналыг тусгасан. Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Ажлын алба нь виртуал бүсэд бүртгүүлэхийг хүссэн хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр гэрээ байгуулна.” гэсний дараа “Гэрээний загварыг зөвлөл батална.” гэж нэмж оруулсан.

10	Хууль зүй, дотоод хэргийн яам 2024.04.29 1/2162	1.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад хэт ерөнхий агуулгаар нийтээр дагаж мөрдөх журам, дүрэм батлах эрх олгохоор заасан байна. Иймд хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны зорилго, агуулга, цар хүрээг нарийвчлан тодорхойлж тусгах;	Саналыг тусгаж, 6.1.2 дахь заалтыг “энэ хуулийн 14.3.1, 14.3.2, 14.3.4, 14.3.5-д заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэлд грант, урамшуулал олгох, зээлийн батлан даалт гаргахад тавигдах шаардлага, грант, урамшуулал олгох, зээлийн батлан даалт гаргах, тэдгээрийг олгох, гаргахаас татгалзах нөхцөл, журмыг тогтоох,” гэж өөрчилсөн болно.
		2.Хууль тогтоомжийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхтэй холбогдсон харилцааг Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулж байх тул хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад “төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, стратеги төлөвлөгөө, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,” гэснийг хасах;	Саналыг тусгасан. Төслийн 6.1.1 дэх заалтыг хассан болно.
		3.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтад тодорхойлсон Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах үндсэн зарчим, журмыг хуулийн төслийн холбогдох хэсэгт тусгах;	Саналыг тусгасан. Төслийн 12.5 дахь хэсэгт “Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар тогтооно.” гэж тусгасан.
		4.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад заасан төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад хамаарах төрийн бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг нь заавал	Саналыг тусгаж, төслийн 7.1.1 дэх заалтыг “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаарх бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

	тухайлан заах шаардлагагүй нийтлэг хэрэгжүүлдэг үүрэг тул дахин томъёолох;	байгууллагатай хамтран ажиллах;" гэж өөрчлөн найруулсан.
	5.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг Өрсөлдөөний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэхийг анхаарах;	Хуулийн төслийн үзэл баримтлалд мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, программ хангамжийн эх код эзэмших эрх, хүн, хуулийн этгээдээс худалдан авах мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэг цонхны системийг бүрдүүлэх, системийг ашиглан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах асуудлаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харилцан тохиролцож үзэл баримтлалыг хамтран баталсан болно.
	6.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт хийсэн эшлэл нь ач холбогдолгүй байх тул хасах;	Саналыг тусгаж, 8.1 дэх хэсгийг хассан болно.
	7.Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан Зөвлөлийн бүрэлдэхүүнд аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий тагнуул, цагдаагийн байгууллага, өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын төлөөллийг нэмэх;	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч компаниудыг мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэж мэдээллийн технологи, инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх боломжийг олгох, тэдгээрт татварын болон татварын бус

		дэмжлэг үзүүлэх бөгөөд Зөвлөл нь цахим эдийн засгийг дэмжиж, уул уурхайн салбараас бусад салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, энэ талаарх суурь харилцаа нь иргэний эрх зүйн харилцаанд тулгуурлах тул тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага зэргийг Зөвлөлийн бүрэлдэхүүнээр ажиллуулах нь эдгээр байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй нийцэхгүй учир Зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах шаардлагагүй гэж үзсэн болно. Төслийн 12.2 дахь хэсгийг “Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засгийн болон мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.” гэж өөрчлөн найруулсан.
	8.Хуулийн төслийн 13 дугаар зүйлд заасан Ажлын албыг хаанаас хариуцан ажиллуулах нь тодорхойгүй байгааг анхаарах;	Төслийн 9.2.8 дахь заалтад Мэдээлэл, технологийн үндэсний парк нь “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх,” гэж тусгасан байгаа болно.
	9.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт хуулийн этгээдэд үзүүлэх татварын бус дэмжлэгийг тодорхойлсон байх тул хувь хүнд хамаарах дэмжлэг	Саналыг тусгаж хассан болно.

		болох төслийн 14.3.7, 14.3.8 дахь заалтыг хасаж, холбогдох хуульд тусгах. 1.Хуулийн төсөлд дурдагдсан “Виртуал бүс”-ийн тодорхойлолтыг нэр томьёоны тодорхойлолт хэсэгт нэмж оруулж, дахин нягтлах;	Саналыг тусгаж, хуулийн төслийн 4.1.5 дахь “Виртуал бүс” гэж нэр томьёоны тодорхойлолтыг дараах байдлаар нэмж тусгав. “Виртуал бүс” гэж мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэсний үндсэн дээр энэ хуульд заасан дэмжлэг үзүүлэх зорилготой албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг,” гэж тодорхойлсон болно.
Сангийн яам 2024.04.30 01/3277	11	2.Хуулийн төслийн 5.1.2-т “төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх” гэж тусгажээ. Одоо ашиглаж буй төрийн мэдээлэл технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг хүн, хуулийн этгээдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр солих шаардлага үүсэх эсэх нь тодорхойгүй байгаа тул “төр мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзах, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авдаг байх” гэж өөрчлөх;	Саналыг тусгаж, хуулийн төслийн 5.1.2 дахь заалтыг “төр мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзаж, худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх,” гэж өөрчилсөн болно.
		3.Хуулийн төслийн 7.2-т мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлан танилцуулахад шаардагдах зардлыг төсвөөс санхүүжүүлэхээр, 8.1.8-д үндэсний мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад танилцуулахад дэмжлэг үзүүлэхээр, 9 дүгээр зүйлд “Мэдээлэл, технологийн үндэсний парк” нэртэй төсвөөс санхүүжилт авдаг байгууллага шинээр нэмэхээр, 14.3.1-	Хуулийн төсөлд 13.4 дэх хэсэг нэмж, “Энэ хуулийн 13.3-т заасан улсын төсвөөс санхүүжүүлэх татварын бус дэмжлэгийн хувь, хэмжээг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасан болно.

	Д мэдээлэл технологийн бүтээгдэхүүнийг патентлуулах зардлыг санхүүжүүлэхэд грант олгохоор, 14.3.2-т экспортод чиглэсэн мэдээллийн технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар стандартын баталгаажуулалтын зардлыг санхүүжүүлэхэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн грант олгохоор, 14.3.4-т хиймэл оюун ухаанд суурилсан төсөл, арга хэмжээний нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсэгт грант олгохоор, 14.3.8-д хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад багтсан мэдээллийн технологийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэргээр суралцаж төгссөн хүний эхний 1 жилийн үндсэн цалингийн 50 хувийг төрөөс олгохоор, 14.3.9-д экспортод гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг олгохоор, 14.3.10-т мэдээлэл технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүгийн тодорхой хувийг төрөөс санхүүжүүлэхээр, 14.3.12-т мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын 50 хүртэлх хувийг төсвөөс санхүүжүүлэхээр тус тус заасан байна. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар төсөвт орон тоо, урсгал зардлын их хэмжээний ачаалал үзүүлэхээр байгаа нь дунд хугацаанд шинээр бүтэц, орон тоо, урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх Засгийн газрын зарчим, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд бүх шатны төсөвт байгууллага хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа,
--	--

	арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх, аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх, зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах замаар төсвийг хэмнэхээр, мөн хуулийн 15 дугаар зүйлд бүх шатны төсөвт байгууллага байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж зардлыг хэмнэхээр заасантай тус тус зөрчилдөж байна. Мөн хуулийн төслийн хамт төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоолол, судалгааг ирүүлээгүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа төсөлд туссан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг хийхээр, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтад Улсын Их Хурлын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байхаар тус тус заасантай зөрчилдөж байх тул хуулийн төслөөс 8 дугаар зүйлийг бүхэлд нь, 7.2, 8.1.8, 14.3.1, 14.3.2, 14.3.4, 14.3.8, 14.3.9, 14.3.10, 14.3.12 дахь заалтуудыг хасах эсвэл төсөвт ачаалал үзүүлэхгүйгээр өөрчлөх;	
	4.Хуулийн төслийн 7.4-т “Төсвийн байгууллага нь программ хангамжийг хүн, хуулийн этгээдээс худалдан авахдаа программ хангамжийн эх кодыг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд, эсхүл гүйцэтгэгч эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заан, харилцан тохиролцоно” гэж тусгажээ. Оюуны өмчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх	Инновацийн тухай хуулийн 27 дугаар зүйл нь Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах тухай дурдсан бөгөөд тухайлбал, “27.1.Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт,

	заалтад заасан оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтад бараа, ажил, үйлчилгээг нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэхээр заасан. Түүнчлэн Патентын тухай хуулийн 13 дугаар зүйлд Засгийн газрын захиалгаар, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр зохион бүтээсэн шинэ бүтээл, ашигтай загварт патент авах зохицуулалтыг тусгайлан заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэгт "Бараа, ажил, үйлчилгээний үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана." гэж заасан бөгөөд гүйцэтгэгч гэж тусгайлан заах шаардлагагүй юм. Засгийн газрын захиалгаар, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний эх кодыг гүйцэтгэгч эзэмших зохицуулалт нь өнгөрсөн хугацаанд захиалагч байгууллагад мэдээллийн технологийн бараа, ажил, үйлчилгээнд гарсан саатал, гэмтлийг түргэн хугацаанд засварлах, шинэчлэл хийх зэрэгт бэрхшээл үүсгэж, төрийн ажил, үйлчилгээг сааталгүй явуулахад хүндрэлтэй нөхцөл үүсгэж байсан бодит тохиолдол байдаг. Иймд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн бүтээгдэхүүнд холбогдох эх кодыг захиалагч захиран зарцуулах эрхтэй байх нь чухал байдаг.	зохион бүтээх ажлын явцад бий болсон оюуны өмчийг шинжлэх ухаан, технологийн төсөл санхүүжүүлэх гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн ажлыг гүйцэтгэсэн иргэн болон хуулийн этгээд эзэмшиж болох бөгөөд өмчлүүлэх, эзэмшүүлэх журмыг Засгийн газар батална." гэж заасан нь үндэсний өндөр технологийн хөгжил, үйлдвэрлэлийг дэмжсэн зохицуулалт юм. Харин Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэгт "Бараа, ажил, үйлчилгээний үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана." гэж төрийн байгууллага нь мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний оюуны өмчийн эрхийг шийдвэрлэхээр заасан нь технологийн компаниудад төрд өндөр технологи, мэдлэг оюун шингэсэн бүтээгдэхүүн нийлүүлэхээс зайлсхийхэд хүргэж, чанаргүй худалдан авалт хийж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулахад хүргэх эрсдэлтэй байна. Учир нь программ хангамжийн эх код нь бүтээгдэхүүн бүрт дахин давтагдахгүй байх боломжгүй, цоо шинээр бичигддэггүй бөгөөд харин ч дахин ашиглах боломж бүхий гадаадын framework, library зэргийг ашигласан байх нь бүтээмжийг дэмжсэн зөв жишиг тул
--	--	--

	Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан гэрээ шууд байгуулах аргаас бусад тендер шалгаруулалтад гэрээний нөхцөлийн талаар аж ахуй эрхлэгчтэй харилцан тохиролцох боломжгүй тул хуулийн төслийн 7.4 дэх хэсгийн “эсхүл гүйцэтгэгч”, “харилцан тохиролцоно” гэснийг тус тус хасах;	тухайн программ хангамжийн бүтээгдэхүүний эх кодыг хэн нэг этгээд дангаар эзэмшиж, захиран зарцуулах боломжгүй онцлогтой байна.
	5.Хуулийн төслийн 8.1.1-д заасны дагуу мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой стандарт, дүрэм, журмыг боловсруулахад бүтээгдэхүүн, үйлчилгээний ашиглалтын хугацаан дахь тусламж, үйлчилгээ, нэмэлт хөгжүүлэлтийн зохицуулалт, төрийн мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийн сан хаана байрших тухай зохицуулалт, хувийн хэвшлүүд төрийн датаг ашиглах, хадгалах, хамгаалах, алдахаас урьдчилан сэргийлэх талаар нарийвчлан тусгах;	Тус санал нь зарчмын хувьд зүйтэй санал байх бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-т заасан “Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө дараах асуудлаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулна: 29.1.1.нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа; 29.1.2.нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашигтай байдал; 29.1.3.хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал; 29.1.4.аюулгүй, найдвартай байдлын шийдэл; 29.1.5.бусад шаардлагатай асуудал.” , болон мөн хуулийн 27 дугаар зүйл “Нийтийн мэдээллийн сан”-д нарийвчлан зохицуулжээ. Мөн төрийн мэдээлэл, датаг ашиглах, хадгалах, хамгаалах харилцаа нь Төрийн болон албаны нууцын тухай хууль,

	Кибер аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсан харилцаа байна.
6.Хуулийн төслийн 12.2-т “Зөвлөлийн дарга нь цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засгийн, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ” гэж тусгажээ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас төлөөлөл байх нь зүйтэй юм. Иймд хуулийн төслийн 12.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмэх;	Саналыг тусгаж, 11.3 дахь хэсгийг “Зөвлөлийн бүрэлдэхүүн нь эдийн засаг, санхүү, төсвийн болон мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.” гэж өөрчилсөн болно.
7.Хуулийн төслийн 14.3.3-т мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгохоор тусгажээ. Гэвч Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна” гэж заасан тул хуулийн төслөөс 14.3.3 дахь заалтыг хасах;	Хуулийн төсөлд 13.4 дэх хэсэг нэмж, “Энэ хуулийн 13.3-т заасан улсын төсвөөс санхүүжүүлэх татварын бус дэмжлэгийн хувь, хэмжээг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасан болно.
8.Хуулийн төслийн 15.1.1-д мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих	Хуулийн төслийн зохицуулалтыг мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн “40-өөс доошгүй хувьтай” гэснийг “40 хүртэлх

	дэмжлэгийн эх үүсвэр байхаар заасан байна. Уг эх үүсвэр дотор Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орон нутгийн төсөвт хамаарах орлого багтахаар байна. Улмаар хуулийн төсөл батлагдсанаар орон нутгийн төсвийн орлого буурах, тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй тул тус заалтыг хасах;	хувьтай" гэж өөрчиллөө. Өөрөөр хэлбэл хэдэн хувьтай байхыг Сангийн яам өөрөө шийднэ. Заавал "доошгүй" гэж хатуу тогтоосон байсныг "хүртэл" болгож хэд ч байж болохоор заасан.
	9.Хуулийн төслийг дагалдуулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг "15.1.16.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 10.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдийг дэмжих зорилгоор тухайн татварын жилд өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив" гэж өөрчлөх;	Саналыг тусгаж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг "15.1.16.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 10.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдийг дэмжих зорилгоор тухайн татварын жилд өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив" гэж өөрчилсөн.
	10.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт засан виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдийн үйл ажиллагааны орлогыг эхний 5 жилийн хугацаанд татвараас чөлөөлөх заалт нь мөн энэ хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй агуулгын хувьд давхцаж байгаа тул 2 дугаар зүйлийг "22.5.4. улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш таван жилийн хугацаанд Инновацийн тухай хуульд заасан болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн	Саналыг тусгаж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс "1 дүгээр зүйлийн 2/21 дүгээр зүйлийн 21.1.16 дахь заалтыг хасахаар, мөн 2 дугаар зүйлийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.4 дэх заалтын "Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод

	инновацийн болон мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг,” гэж өөрчлөх;	ногдох албан татварыг,” гэснийг “Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг,” гэж өөрчилсөн болно.
	11.Засгийн газраас хэрэгжүүлж буй урт болон дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор татварын хувь хэмжээг сүүлийн жилүүдэд үе шаттай буулгаж байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад заасны дагуу нээлттэй хувьцаат компанийн хувьцаа худалдаж авсан татвар төлөгчийн ногдол ашиг, хүүгийн орлогод ногдох албан татварыг 2023 оны 01 дүгээр сараас эхлэн 10 хувиас 5 хувь болгон бууруулсан. Иймд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт виртуал бүсэд бүртгүүлсэн этгээдэд хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээдийн ногдол ашгийг чөлөөлөхөөр тусгасныг хасах;	Саналыг тусгаж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс “1 дүгээр зүйлийн 2/21 дүгээр зүйлийн 21.1.16 дахь заалтыг хассан болно.
	12.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр нэмж буй 29 дүгээр зүйлийн 29.5 дахь	Саналыг тусгаж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1

		хэсэгт “Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.” гэж өөрчлөх.	дүгээр зүйлээр нэмж буй 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийг “Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.” гэж өөрчилсөн.
12	Боловсрол, шинжлэх ухааны яам 2024.04.30 1а/1735	1.Хуулийн төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийг “... ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ” гэснийг “... ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ” гэж өөрчлөх;	Хуулийн төслийн үзэл баримтлалыг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталж, хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Засгийн газар, төрийн болон нутгийн өөрөөр удирдах байгууллагын хүлээх нийтлэг үүргийг тодорхойлох гэж тусгасан тул хуулийн төслийн үзэл баримтлалд тусгаснаас өөрөөр буюу “... ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ” гэж тусгах боломжгүй байна.
		2.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн гарчгийн “Мэдээлэл, технологийн үндэсний парк” гэснийг “Мэдээлэл, технологийн үндэсний паркийн үүрэг” гэж нэмэх;	Саналыг тусгаж, Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн гарчгийг “Мэдээлэл, технологийн үндэсний паркын чиг, үүрэг” гэж өөрчлөв.
		3.Хуулийн төслийн гуравдугаар бүлгийн гарчигт буй “ВИРТУАЛ БҮС” гэсэн агуулгыг нэр томьёоны тодорхойлолтод тусгах;	Хуулийн төслийн 4-т “Виртуал бүс” гэж нэр томьёоны тодорхойлолтыг нэмж тусгав.
		4.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч компаниудыг боловсон хүчний мэдээлэл болон ажлын туршлага зэрэг чадавхаар нь ангилал тогтоох түүнийг	Саналыг дэмжсэн бөгөөд хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасан журмаар зохицуулах илүү нарийн зохицуулах

		дагасан хариуцлагын тогтолцоог буй болгох чиглэлээр хуулийн төсөлд нарийн тусгах.	боломжтой харилцаа байх тул хуулийн төсөлд нарийвчлан тусгаагүй болно.
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 2024.04.25 01/1426	Тусгайлан өгөх саналгүй болно.	Дэмжсэн.
14	Эдийн засаг, хөгжлийн яам 2024.04.30 02/894	1.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Засаглалын бодлого”-д тусгасан “... гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.” Гэж тусгасны дагуу төслийн 3 дугаар бүлэг 14 дүгээр зүйлд заасан “Виртуал бүс”-ийн нэр томьёо, тавигдах шаардлагыг тодорхой болгох; 2.Хуулийн төслийн 2 дугаар бүлэг 6.1.7, 8.1.5 дахь заалтыг Боловсролын ерөнхий хуульд тусгах; 3.Төслийн 5.1.2, 7.4 дэх хэсгийг “Инновацын тухай хууль”-ийн 27.1, 27.2, 27.3, 27.6 дахь заалтуудад тус тус нийцүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.	Саналыг тусгаж, хуулийн төслийн 4.1.5 дахь “Виртуал бүс” гэж нэр томьёоны тодорхойлолтыг дараах байдлаар нэмж тусгав. “Виртуал бүс” гэж мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг цахим хэлбэрээр бүртгэсний үндсэн дээр энэ хуульд заасан дэмжлэг үзүүлэх зорилготой албан ёсны хаяг, байршил бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийг,” гэж тодорхойлсон болно. Цахим ур чадвар олгох үйл ажиллагаа олон улсад зөвхөн боловсролын тогтолцоогоор биш олон төрлийн сувгаар хүргэдэг онцлогтой тул Боловсролын ерөнхий хуулиар зохицуулахад учир дутагдалтай, мөн ерөнхий хуулиар тодорхой нэг салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлох боломжгүй тул саналыг тусгах боломжгүй байна. Хуулийн төслийн холбогдох заалтууд нь Инновацын тухай хуулийн дурдсан заалтуудтай нийцэж байна.
15	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан саналгүй болно.

	2024.04.29 01/1973			
16	Барилга, хот байгуулалтын яам 2024.04.24 01/1331	Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан саналгүй болно.	
17	Олимп нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хороо 2024.04.24 01/240	Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан саналгүй болно.	
18	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хороо 2024.04.26 01/272	Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан саналгүй болно.	
19	Нийслэлийн засаг дарга 2024.04.30 01/2407	Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан саналгүй болно.	
20	Боомтын сэргэлтийн үндэсний хороо 2024.04.29 01/368	Тусгайлан өгөх саналгүй болно.	Тусгайлан саналгүй болно.	
21	Мэдээлэл, технологийн үндэсний парк 2024.04.22 01/155	1.Хуулийн төслийн бүлэг, зүйл, хэсэг, заалтын “мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэсний дараа “хөгжүүлэлт” гэсэн томъёоллыг нэмж тусгах.	Хуулийн төслийн үзэл баримтлалыг “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлал” гэж Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан тул хуулийн төслийн нэршлийг өөрчлөх	

		боломжгүй байна. Мөн хуулийн төслийн 4.1.2 дахь заалтад “мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэсэн томъёололд мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх гэсэн агуулгыг багтаасан тул нэмж тусгах шаардлагагүй гэж үзсэн болно.
	2.Хуулийн төслийн 4.1.2 дахь заалтын “... сайжруулах, түгээх,” гэсний дараа “борлуулах,” гэж нэмж, “болон тэдгээрийг ашиглан үйлчилгээ үзүүлэх” гэснийг хасах.	Хуулийн төслийн 4.1.2 дахь заалтыг ““мэдээллийн технологийн үйлдвэрлэл” гэж мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгох, хөгжүүлэх, түгээх, үйлчилгээ үзүүлэхийг,” гэж өөрчлөн найруулсан болно.
	3.Хуулийн төслийн 4.1.4 дэх заалтыг “гадаад улсын хуулийн этгээд” гэж Монгол улсаас бусад аль нэг улсад бүртгэлтэй, зөвхөн Мэдээллийн болон дэвшилтэт технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр ажилладаг, эсвэл дээрх технологиудад шууд хөрөнгө оруулалт хийх, Монгол улсын виртуал бүсэд бүртгүүлж, үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг; гэж өөрчлөх	Хуулийн төслийн 4.1.4 дэх заалтыг хассан болно.
	4.Хуулийн төслийн нэр томъёоны тодорхойлолтод ““Виртуал бүс” гэж зөвхөн Мэдээллийн болон дэвшилтэт технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлт үйл ажиллагаа явагддаг цахим орчныг,” гэж нэмэх.	Хуулийн төслийн 11.1 дэх хэсэгт “Монгол Улс нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс (цаашид “виртуал бүс” гэх)-тэй байх бөгөөд түүний ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор батална.” гэж зохицуулсан тул

		нэр томьёоны тодорхойлолт хийх шаардлагагүй болно. Мөн хуулийн төслийн 9.2.8 дахь заалтад "Мэдээлэл, технологийн үндэсний парк нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэх;" гэж заан виртуал бүс нь зөвхөн цахим орчинд байх агуулгыг илэрхийлээгүй болно.
5.Хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолтод "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд хөрөнгө оруулагч" гэж зөвхөн Мэдээллийн болон дэвшилтэт технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүн, хуулийн этгээдэд хөрөнгө оруулах этгээдийг; гэж нэмэх.		Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.2 дахь заалтад "хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагч байхаар нэр томьёоны тодорхойлолт хийсэн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.7 дахь заалтад Хуулийн төслийн агуулга нь бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх шаардлагыг хангахаар заасан" шаардлагад нийцүүлсэн болно.
6.Хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолтод "“Экспат” гэж виртуал бүсэд ажиллах мэдээллийн технологи, үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр мэргэшсэн гадаад хүнийг хэлнэ” гэж нэмэх.		Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 5.1.1 дэх заалтад "гадаад ажилтан" гэж Монгол Улсад хөдөлмөр эрхэлж, эсхүл дадлагажиж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгохоор заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай

		хуулийн 29.1.7 дахь заалтад Хуулийн төслийн агуулга нь бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх шаардлагыг хангахаар заасан” шаардлагад нийцүүлсэн болно.
	7.Хуулийн төслийн 5.1.2 дахь заалтын “...хүн, хуулийн этгээдээс худалдан авах,” гэсний дараа “лицензээр ашигладаг байх, гэж нэмэх.	Хуулийн төслийн 5.1.2 дахь заалтыг “төр мэдээллийн технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзаж, худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх,” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн өөрчилсөн. Тус хуулийн 4.1.23 дахь заалтад “худалдан авах ажиллагаа” гэдэгт бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах агуулгыг тусгасан бөгөөд лицензээр ашиглахтай холбоотой агуулга нь уг томъёололд багтсан болно.
	8.Хуулийн төслийн 7.1.2 дахь заалтын “...хүн, хуулийн этгээдээс худалдан авах” гэсний дараа “лицензээр ашиглах төсөл...” гэж нэмэх.	Хуулийн төслийн 7.1.2 дахь заалтыг “мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх,” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

		ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн өөрчилсөн. Тус хуулийн 4.1.23 дахь заалтад "худалдан авах ажиллагаа" гэдэгт бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах агуулгыг тусгасан бөгөөд лицензээр ашиглахтай холбоотой агуулга нь уг томъёололд багтсан болно.
	9.Хуулийн төслийн 8.1.3 дахь заалтын "... нэг цонхны системийг бүрдүүлэх" гэх үгийг хасаж, "үйлчилгээний нийтийн мэдээллийн дэд бүтцийн системийг бүрдүүлэх..." гэх үг нэмэх, "...худалдан авах" гэсний дараа "лицензээр ашиглах" гэх үг нэмэх.	Хуулийн төслийн 8.1.3 дахь заалтыг хассан болно.
	10.Хуулийн төслийн 8.1.6 дахь заалтын "... хамгаалах" гэх үгийг хасч, "...эдийн засгийн эргэлтэнд оруулах..." гэх үг нэмэх.	Саналыг тусгаж, 8.1.6 дахь заалтыг "мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын судалгаа шинжилгээ хийх, дэвшилтэт технологийн судалгаа хөгжүүлэлтийг дэмжих," гэж өөрчилсөн болно.
	11.Хуулийн төсөлд хэрэглэсэн "Мэдээлэл, технологийн үндэсний парк" гэснийг "Мэдээллийн технологийн үндэсний парк" гэж өөрчлөх.	Хуулийн төслийн үзэл баримтлалыг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан бөгөөд үзэл баримтлалд "Мэдээлэл, технологийн үндэсний парк" гэсэн томъёолол хэрэглэсэн тул өөрчлөх боломжгүй. Гэхдээ уг нэршлийг хуулийн этгээдийн оноосон нэр болгож тусгаагүй тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын

	дагуу хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулах боломжтой болно.
12.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд “Мэдээллийн технологийн үндэсний парк нь өөрт олгогдсон эд хөрөнгийн болон үйл ажиллагааны үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх, улсын төсвөөс дэмжлэг авах зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд оролцдог төрийн өмчит парк байна.” гэж нэмэх.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа тул энэ хуульд давхардуулан заах шаардлагагүй үзсэн болно.
13.Хуулийн төслийн 9.1 дэх хэсгийг “Мэдээллийн технологийн үндэсний парк нь Мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн дэвшилтэт технологи, экспортын чиг баримжаатай үндэсний техник хангамжийн үйлдвэрлэл, программ хангамжийг хөгжүүлэх, гарааны компанийг бойжуулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалт, шалгалтыг зохион байгуулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий өөрийн эзэмшлийн хөрөнгөтэй байгууллага байна.” гэж өөрчлөх.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихээс бусад төрийн өмчит аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ хуульд давхардуулан заах шаардлагагүй.

		дээрх хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан дүрмийн дагуу зохицуулагдана.
14.Хуулийн төслийн 9.3.3 дахь заалтын “тэмцээн, уралдаан,” гэсний дараа “шалгалт, сургалт” гэж нэмэх.		Хуулийн төслийн 3.1 дэх заалтад “Энэ хууль нь төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, зарчим, чиг үүргийг тодорхойлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцаанд үйлчилнэ.” гэж заасан тул шалгалт, сургалт зохион байгуулах нь уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан дүрмийн дагуу зохицуулагдана.
15.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд “Мэдээллийн технологийн үндэсний парк нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх, Орлогын албан татвараас, Нийгмийн даатгалын шимтгэлээс хөнгөлүүлэх” гэж нэмэх.		Хуулийн төслийн 3.1 дэх заалтад “Энэ хууль нь төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, зарчим, чиг үүргийг тодорхойлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцаанд үйлчилнэ.” гэж заасан бөгөөд энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй. Мөн саналд дурдсан татваруудаас чөлөөлөгдөх харилцаа нь татварын харилцааг зохицуулж байгаа бусад хуулиудаар зохицуулагдах харилцаа болно.

	16.Хуулийн төслийн 10.1 дэх хэсгийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл санаачлах, хэрэгжүүлэхтэй холбоотой энэ хуульд зааснаас бусад харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу зохицуулна.” гэж өөрчлөх.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой бөгөөд эдгээр хуулиар тухайн төр, хувийн хэвшлийн түншлэлийн нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй тул эш татаж заахгүй болно.
	17.Хуулийн төслийн 12.4 дэх хэсгийг “Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд гаргасан шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.” гэж өөрчлөх.	Саналыг тусгаж, хуулийн төслийн 12.4 дэх хэсгийг “Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд Зөвлөлийн шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.” гэж тусгасан болно.
	18.Хуулийн төслийн 13.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөх: 13.1 Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн виртуал бүсэд бүртгүүлэгчид тавигдах ерөнхий шаардлага: 13.1.1. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл; 13.1.2. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн ажилтны нийгмийн даатгалд хамруулсан	Хуулийн төслийн 13.1.1 дэх заалтыг “Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл” гэж, 13.1.2 дахь заалтыг “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн ажилтныг нийгмийн даатгалд хамруулсан эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт,” гэж тус тус өөрчилсөн болно. Хуулийн төсөлд 13.1.4 дахь заалт

		эсэх тухай нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт; 13.1.3. Эхлэлтийн баланс, эсхүл өмнөх жилийн санхүүгийн тайлан. 13.1.4 Хуулийн этгээд нь шүүхийн шийдвэрээр тогтоосон ямар нэг өр төлбөргүй байх: 13.1.5 Зөвхөн мэдээллийн технологи, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд уг бүсэд хамаарна: 13.1.6 Цахим гарын үсэгтэй байна. 13.1.7 Монгол Улсад болон аль нэг улсад албан ёсны төв, салбар, төлөөлөгчийн газартай байна.	нэмж, хуулийн этгээд нь шүүхийн шийдвэрээр тогтоосон ямар нэг өр төлбөргүй байх гэж тусгах нь ач холбогдолгүй бөгөөд өөрөөр хэлбэл шинээр хуулийн этгээд байгуулан виртуал бүсэд бүртгүүлэх боломжтой юм. Хуулийн төслийн 13.1 дэх хэсэгт Ажлын алба нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд (цаашид “хуулийн этгээд” гэх)-ээс цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхээр заасан тул төслийн 13.1.5 дахь заалтад “Зөвхөн мэдээллийн технологи, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд уг бүсэд хамаарна” гэж нэмж тусгах шаардлагагүй болно. Мөн цахим гарын үсэг хэрэглэхтэй холбоотой зохицуулалт нь Цахим гарын үсгийн тухай хуулиар зохицуулж байгаа тул тавигдах шаардлагад 13.1.6 дахь заалт нэмж “Цахим гарын үсэгтэй байна.” гэж нэмж тусгах шаардлагагүй. Гадаадын хуулийн этгээд нь виртуал бүсэд бүртгүүлэн мэдээллийн технологийн үйлдвэрлэх эрхлэх агуулгаар хуулийн төсөл боловсруулагдаж байгаа бөгөөд хуулийн төсөлд 13.1.7 дахь заалт нэмж, Монгол Улсад болон аль нэг улсад албан ёсны төв, салбар, төлөөлөгчийн газартай байна гэсэн шаардлага нэмж тусгах шаардлагагүй.
--	--	--	--

	19.Хуулийн төслийн 13.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөх: 13.2 Ажлын алба нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээдээс цахим хэлбэрээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 хоногийн дотор хянаж, дараах шаардлагыг хангасан тохиолдолд виртуал бүсэд бүртгэж, хариу мэдэгдэнэ: 13.2.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчөөгүй байх, 13.2.2 Зөвхөн виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд уг бүсээр дамжуулан хөрөнгө оруулах: 13.2.3 Хууль болон журам заасан бусад:	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг тус хуульд заасан эрх бүхий этгээд хэрэгжүүлэх тул хуулийн төсөлд Ажлын албан хэрэгжүүлэхээр заах нь хууль хоорондын зөрчил үүсгэхээр байна. Мөн виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд уг бүсээр дамжуулан хөрөнгө оруулах боломжгүй бөгөөд хөрөнгө оруулагч нь тухайн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөрөнгө оруулж байгаа тул Ажлын албаар хөрөнгө оруулалт дамжих нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн агуулга, үзэл баримтлалтай нийцэхгүй болно.
	20.Хуулийн төслийн 13.3 дахь хэсгийг “Виртуал бүсэд бүртгүүлэхийг хүссэн хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч Зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлнэ.” гэж өөрчлөх.	Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээдийг бүртгэх чиг үүргийг Ажлын алба гүйцэтгэж, харин хуулийн төсөлд 12.3.4 дэх заалт нэмж “Зөвлөл нь Ажлын албаны үйл ажиллагаанд хяналт тавих, чиглэл өгөх.” гэж тусгасан болно.
	21.Хуулийн төслийн 13.4 дэх хэсгийг “Зөвлөлийн шийдвэрийн дагуу Ажлын алба нь бүртгэгдэх хуулийн этгээдтэй цахимаар гэрээ байгуулна.” гэж өөрчлөх.	Хуулийн төслийн 13.2 дахь хэсгийг “Ажлын алба нь виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр гэрээ байгуулна.” гэж өөрчилсөн болно.
	22.Хуулийн төслийн 13.6 дахь хэсгийг “Виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээд нь гэрээ байгуулснаас хойш	Хуулийн төслийн 11.1 дэх хэсэгт “Монгол Улс нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс

	ажлын 5 өдрийн дотор тухайн бүсэд албан ёсны хаяг, байршилтай болсон байна.” гэж өөрчлөх.	(цаашид “виртуал бүс” гэх)-тэй байх бөгөөд түүний ажиллах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор батална.” гэж заасан тул уг журмын хүрээнд үйл ажиллагааны талаар зохицуулахаар тусгана.
	23.Хуулийн төслийн 13.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөх: 13.7. Зөвлөлийн шийдвэрийн дагуу ажлын алба бүртгэлтэй хуулийн этгээдийг дараах үндэслэлээр бүртгэлээс хасна: 13.7.1. Виртуал бүсэд бүртгүүлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлээгүй; 13.7.2. Гэрээ, дүрэмд заасан мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон; 13.7.3. Татан буулгах тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон. 13.7.4. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтээс бусад төрлийн үйл ажиллагааг виртуал бүсээр дамжуулан явуулсан нь тогтоогдсон бол; 13.7.5. Үндэстэн дамжсан гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан; 13.7.6. Дотоодын зах зээлд монопол болж, зах зээлийг дангаараа үйл ажиллагаа явуулахаар завдсан бол;	Хуулийн төсөлд 13.4.2 дахь заалт нэмж, “мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс бусад төрлийн үйл ажиллагааг виртуал бүсээр дамжуулан эрхэлсэн,” гэж нэмсэн. Хуулийн төслийн 13.4.4 дэх заалтыг “Иргэний хуулийн 32.1-д заасны дагуу татан буулгасан.” гэж өөрчилсөн бөгөөд Иргэний хуулийн 32.1.2 дахь заалтад хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн, хуульд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан гэсэн агуулгад үндэстэн дамжсан гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа явуулсан, мөн дотоодын зах зээлд монопол болж, зах зээлийг дангаараа үйл ажиллагаа явуулахаар завдсан гэсэн хуулийг зөрчсөн агуулгууд багтаж байгаа тул нэмж тусгах шаардлагагүй болно.

	24.Хуулийн төслийн 14.3.9 дахь заалтын “экспортод” гэсний өмнө “Оюуны өмчөөр баталгаажуулж” гэж нэмэх. 25.Хуулийн төслийн 14.3.12 дахь заалтыг “Мэдээллийн технологийн виртуал бүсэд бүртгэгдсэн дотоодын гарааны бизнес эрхлэгчийн үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн зардлын 50 хүртэлх хувийг санхүүжүүлэх.” гэж өөрчлөх.	Хуулийн төслийн 14.3.9 дэх заалтыг хассан болно. Хуулийн төслийн 3.1 дэх заалтад “Энэ хууль нь төрөөс мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар баримтлах бодлого, зарчим, чиг үүргийг тодорхойлж, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцаанд үйлчилнэ.” гэж хуулийн үйлчлэх хүрээг заасан тул зохицуулалтыг “дотоодын гарааны бизнес эрхлэгч” гэж хязгаарлаж заах боломжгүй болно.
--	--	---

---000--

Төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

1. Б.Батцэцэг (Тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, 90009899)
2. С.Тэнгис (Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, 99022202)
3. Х.Сүрэнхорол (Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, 99003245)
4. М.Солонго (Тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Цахим хөгжлийн бодлого хариуцсан ахлах шинжээч, 99018275).